



# ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ, НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХОХИРОГЧИД НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ ТАЛААР ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГЫГ СУДАЛЖ, ӨӨРИЙН УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИСТОЙ АРГА, ХЭЛБЭРИЙГ ТОДОРХОЙЛОХ, САНАЛ ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛАХ

(Судалгааны тайлан)



2024 он



## МЭДЭГДЭЛ

---

Энэхүү судалгааны тайланг Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн болно. Энд дурдагдсан үзэл бодол, үр дүн, мэдээлэл, дүгнэлт нь зөвхөн зохиогчийнх бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын болон Азийн сангийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

Хэрэв та бүхэн судалгааны тайланд санал хүсэлт илгээх бол доорх хаягаар бидэнтэй холбогдоорой.

Монгол Улс,

Улаанбаатар хот 211238

Шуудангийн хайрцаг-321,

Утас/факс: 976-11-311512

Итгэлийн утас: 1800-1903

Нүүр хуудас: Mongolia Gender Equality Center

И-мэйл: [gendereqcen@gmail.com](mailto:gendereqcen@gmail.com) [info@stoptrafficking.mn](mailto:info@stoptrafficking.mn)

Вэб хуудас: [www.stoptrafficking.mn](http://www.stoptrafficking.mn)

## ТАЛАРХАЛ

---

Та бүхэндээ энэхүү судалгааны тайланг толилуулж байгаадаа туйлын баяртай байна. Энэхүү бүтээл нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид, ялангуяа насанд хүрээгүй хохирогчдод нөхөн олговор олгох асуудлыг олон улсын сайн туршлагын хүрээнд судалж, манай улсад хэрэгжүүлэх боломжтой зохистой арга хэлбэрийг тодорхойлох зорилгоор хийгдсэн юм.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь дэлхий дахины хэмжээнд өргөн тархсан, хүний эрхийг ноцтой зөрчиж буй үйлдэл бөгөөд хохирогчдын дийлэнх нь хүүхэд, эмэгтэйчүүд байна. ХХГХ-ийн хохирогчдод нөхөн олговор олгох, гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх асуудал үр төдийлөн дүнтэй биш байгаа нь бидний анхаарлын төвд байх ёстой чухал асуудал юм.

Энэхүү тайланг уншсанаар та бүхэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох талаар олон улсын сайн туршлагаудтай танилцах төдийгүй манай улсад хэрхэн хэрэгжүүлэх боломжтой талаарх санал, зөвлөмжүүдийг авах болно. Судалгааны багийн гишүүд энэхүү тайланг боловсруулах явцдаа төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагууд, хохирогчидтой ажиллаж буй мэргэжилтнүүдээр хэлэлцүүлэн, тэдний туршлага, зөвлөгөөг авч, үнэтэй мэдээллүүдийг нэгтгэж чадсан билээ.

Судалгааны дүгнэлт, зөвлөмжүүд нь манай улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх тусламж, дэмжлэгийг сайжруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэлтэй байна. Энэхүү судалгаа нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчдын эрхийг хамгаалахад чиглэсэн бодлого боловсруулагчид, судлаачид, мэргэжилтнүүдэд үнэтэй эх сурвалж тул судалгааны санал, зөвлөмжүүдийг анхааралтай судлан, өөрийн эх орондоо хэрэгжүүлэх арга хэмжээг авна гэдэгт итгэж байна.

Эцэст нь, энэхүү судалгааг хийж гүйцэтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан бүх эрдэмтэн судлаачид, хамтран ажилласан байгууллагуудад талархал илэрхийлье. Та бүхний хүчин чармайлт, мэдлэг туршлага нь энэхүү чухал судалгааг амжилттай болгоход үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан билээ.

Энэхүү чухал судалгааг хийж гүйцэтгэсэн та бүхэнд дахин талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

**Г. ГАНБАЯСАХ**  
ХТЭТ-ийн ТЭРГҮҮН

## ГАРЧИГ

---

ТАЛАРХАЛ	3
ТОВЧИЛСОН ҮГ	5
УДИРТГАЛ	6
НЭГ. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ҮНДСЭН АСУУДАЛ	10
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ	22
ГУРАВ. ГАДААД УЛСЫН САЙН ТУРШЛАГА	28
3.1. Америкийн Нэгдсэн Улс	29
3.2. Франц Улс	55
3.3. Нидерланд Улс	67
3.4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	85
3.5. Япон Улс	99
3.6. Тайвань Улс	113
3.7. Бүгд Найрамдах Молдова Улс	127
3.8. Румын Улс	136
3.9. Тайланд Улс	146
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	161
ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ	168
ЭХ СУРВАЛЖ	170
ХАВСРАЛТ	178

## ТОВЧИЛСОН ҮГ

---

<b>АНУ</b>	Америкийн Нэгдсэн Улс
<b>ХБНГУ</b>	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
<b>НҮБ</b>	Нэгдсэн үндэстний байгууллага
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>ЭХХШТХ</b>	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
<b>ИХШХШТХ</b>	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
<b>ОУХБ</b>	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
<b>ЭБША</b>	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа
<b>ЭХХША</b>	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
<b>ИХХША</b>	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
<b>ХЗДХЯ</b>	Хууль зүй, дотоод хэргийн яам
<b>ХЗҮХ</b>	Хууль зүйн үндэсний хүрээлэн
<b>ХТЭТ</b>	Хүйсийн тэгш эрх төв
<b>МКХ</b>	Монголын Криминологичдын холбооны
<b>ННФ</b>	Нээлттэй нийгэм форум
<b>UNODC</b>	НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар

## УДИРТГАЛ

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2 дугаар зүйлийн 2.27 дахь заалт “Хүн бүр эдийн болон сэтгэл зүйн хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй”, 8 дугаар зүйлд “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй” гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадгаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй” гэж хохирогчийн эрхийг баталгаажуулж, Арван есдүгээр зүйлд “төр хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах” хэмээн төрийн хариуцлагын механизмыг хуульчлан тогтоосон.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд хохирогч нь хохирлын нөхөн төлбөрийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй хэмээн заасан боловч 2023 оны Хүн худалдаалах асуудлын төлөв байдлын тухай тайланд Эрүүгийн хууль болон Иргэний хууль хоорондын зөрчилтэй зохицуулалт дээрх заалтыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжгүй болгож байна гэжээ.<sup>1</sup> Мөн Монголын хүний эрхийн ТББ-уудын форумгаас НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд 2019 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг /UPR/-ийн тайланг хүргүүлжээ.<sup>2</sup> Тус тайланд хохирогчид нөхөн олговор олгох асуудлаар Монгол Улсад хэрэгжиж буй хуулиудад үнэлгээ хийж, цоорхой болон давхардлыг илрүүлж, хохирогчид учирсан нөхөн төлбөр олгож байх нөхцөлийг эрүүгийн болон иргэний хууль тогтоомжид оновчтой зааж, тусгах, хэрэгжүүлэх шаардлагатайг онцолсон байна.

Иймд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нөхөн төлбөр авах асуудлаар уг судалгааны ажлыг хийхээр зорьсон ба ингэхдээ олон улсын хүний эрхийн гэрээ конвенц, НҮБ-ын тунхаглал, зарчим, удирдамжид суурилан, гадаадын орны сайн туршлагуудыг харьцуулан судалсны үр дүнд Монгол Улсад хэрэгжүүлэх зохистой арга хэлбэрийг тодорхойлох, санал зөвлөмж боловсруулах юм.

<sup>1</sup> Монгол Улсын хүн худалдаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан (2023), <https://mn.usembassy.gov/mn/2023-trafficking-in-persons-report-mn/>

<sup>2</sup> Монголын хүний эрхийн ТББ-уудын форум 2019 оны 10 дугаар сарын 3-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг /UPR/-ийн гурав дахь мөчлөгт хүргүүлсэн тайлан <https://www.uprmonqolia.mn/?cmd=Content&menuid=53&/%D0%93%D1%83%D1%80%D0%B0%D0%B2-%D0%B4%D0%B0%D1%85%D1%8C-%D0%BC%D3%A9%D1%87%D0%BB%D3%A9%D0%B3-2019>.

## **Судалгааны зорилго, зорилт**

Судалгааг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох талаар эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, Монгол Улсад тохирох загварыг санал болгохоор гүйцэтгэсэн бөгөөд энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох олон улсын эрх зүйн зохицуулалтыг судалж, Монгол Улсын хүлээсэн үүргийг тодорхойлох;
- Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хохирол нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдал, олон улсын гэрээ, конвенцын уялдаа холбоог тогтоох;
- Нэгдүгээрт, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын чиглэлээр туршлагажсан, эрх зүйн орчин тодорхой, хохирогчид олгох нөхөн төлбөрийн систем нь тогтворжсон, хоёрдугаарт, энэ төрлийн механизмыг харьцангуй шинээр бий болгон ажиллаж байгаа ч туршлага болохуйц, гуравдугаарт, манай улстай эрх зүйн систем ойролцоо гэсэн 3 түвшинд хамаарах гадаад орны эрх зүйн зохицуулалт, туршлагыг харьцуулан судлах;
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох олон улсын стандарт, гадаад орны сайн туршлагад үндэслэн, Монгол Улсад эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх санал зөвлөмжийг боловсруулж, тохирох загварыг санал болгох.

## **Судалгааны ажлын үндэслэл, ач холбогдол**

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд хохирогч нь эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй гэсэн заалттай хэдий ч төрөөс нөхөн олговор олгуулж буй механизм, арга хэлбэр хангалтгүй, Эрүүгийн болон Иргэний хуульд өөр хоорондоо нийцэхгүй зэрэг байдал нь энэхүү хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлэх боломжийг хааж байна.<sup>3</sup> НҮБ-ын санал зөвлөмж болон бусад судалгааны тайланд Монгол Улс олон улсын гэрээ, Үндсэн хууль, бусад хуулиар хүлээсэн хохирогчийн эрхийг хамгаалах үүргийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох тогтолцоог боловсронгуй болгох, тохирох арга хэлбэрийг бүрдүүлэх талаар шаардлагатайг дурджээ.

АНУ-ын Төрийн департаментаас гаргасан Монгол Улсын хүн худалдаалах асуудлын төлөв байдлын тайланг үндэслэвэл, Монгол

<sup>3</sup> Монгол Улсын хүн худалдаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан (2023), <https://mn.usembassy.gov/mn/2023-trafficking-in-persons-report-mn/>

Улсын Засгийн газар хүн худалдаалах гэмт хэргийг таслан зогсооход тавигдах суурь шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байгаа хэдий ч энэ чиглэлээр ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа тул Монгол Улс II дугаар шатлалд хэвээр үлдсэн.<sup>4</sup> Гэсэн хэдий ч, Засгийн газар хэд хэдэн гол чиглэлээр суурь шаардлагыг хангаагүй, сүүлийн есөн жилийн турш гэхэд л холбогдох эрх бүхий байгууллага эрэгтэй хохирогчийг албан ёсоор олж тогтоогоогүй зэрэг асуудлууд тулгамдсаар байна.

Иймд цаашид Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох талаарх эрх зүйн орчныг олон улсын баримт бичигт суурилан тодорхойлохын зэрэгцээ гадаад улсуудын хууль тогтоомж, практик, сайн туршлагыг харьцуулан судалж улмаар манай улсад тохирох зохицуулалт, хэм хэмжээ, практик, арга хэлбэрийг бий болгох санал зөвлөмж гаргах нь нэн ач холбогдолтой гэж үзлээ.

### **Судалгааны арга зүй**

Дээрх судалгааны ажлаар хууль зүйн шинжлэх ухааны үндсэн аргууд болох норматив аргаар хэм хэмжээнүүдийг логик зарчмын үүднээс авч үзэж, тухайн асуудлыг илүү оновчтой авч үзэх үүднээс харьцуулалтын арга, нийгмийн асуудлыг тодорхой болгох үүднээс анализ, синтезийн арга, мөн тухайн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн зохицуулалт тэдгээрийн ойлголтыг системтэйгээр судлах үүднээс системчлэх аргыг хэрэглэсэн болно.

### **Судалгааны хүрээ**

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох талаарх Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн зохицуулалт, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, Нэмэлт Протокол, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцыг хэрэгжүүлэх хууль зүйн зааварчилгаа, Хүн худалдаалахтай тэмцэх аргачлал зэрэг олон улсын баримт бичиг болон 9 улсын эрх зүйн зохицуулалт, сайн туршлагыг сонгон авч, харьцуулан судаллаа.

### **Судлагдсан байдлын тойм**

Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх асуудал нь хүний эрхийг хангах, судлаачдын анхаарлыг татсан нэн чухал сэдэв болохын хувьд энэ чиглэлээрх судалгаа Монгол Улсад цөөнгүй байна. Тухайлбал, Азийн сангийн захиалгаар ХТЭТ ТББ-ын судалгааны баг гүйцэтгэсэн Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал, 2021, Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий

<sup>4</sup> Монгол Улсын хүн худалдаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан (2023). <https://mn.usembassy.gov/mn/2023-trafficking-in-persons-report-mn/>



болон тэсвэртэй байдлын суурь судалгаа, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ судалгаа, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хамгаалах талаарх олон улсын туршлага судалгаа, Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь төслийн суурь судалгааны тайлан, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ судалгаа зэрэг дурдаж болох юм.

Нөгөөтээгүүр, гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох, хохирол нөхөн төлөх талаар ХЗҮХ-ээс “Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлын нөхөн төлүүлэлт”, Хохирлын сангийн тухай гадаад орнуудын харьцуулсан судалгаа, ННФ, МКХ хамтран Монгол Улсад гэмт хэргийн хохирлыг үнэлж, тогтоож, нөхөн төлүүлж буй нөхцөл байдал, Тодорхой төрлийн гэмт хэргийн хохирол, хор уршгийн нөхөн төлүүлэлт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад учирсан хохирлын нөхөн төлүүлэлт шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ зэрэг судалгаа байна.

Эдгээр судалгаанууд нь нийт гэмт хэргийн тухайд хохирогчийн эрхийг хамгаалах, хохирогчид үзүүлж буй тусламж үйлчилгээ, хохирлыг барагдуулж буй байдлыг судалж, цаашид хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг боловсронгуй болгох чиглэлээр хийгджээ. Харин хүн худалдаалах гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр нарийвчлан судалж буй гэдгээрээ бидний энэхүү судалгаа нь шинэлэг байна.

# 1

## ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ҮНДСЭН АСУУДАЛ

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох талаарх олон улсын туршлагыг судлах хүрээнд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба шийтгэх тухай протокол (цаашид “Палермогийн Протокол” гэх), Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцыг хэрэгжүүлэх хууль зүйн зааварчилгаа (цаашид “Хууль зүйн зааварчилгаа” гэх), НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар (UNODC)-ын баталсан “Хүн худалдаалахтай тэмцэх аргачлал” (цаашид “Хүн худалдаалдахтай тэмцэх аргачлал” гэх) зэргийг нэн тэргүүнд авч үзлээ.

Мөн бүс нутгийн олон улсын баримт бичиг болох 2005 оны 5 дугаар сард Европын зөвлөл баталсан Хүн худалдаалах ажиллагааны эсрэг Европын Холбооны конвенц нь Палермогийн протоколын тодорхойлолтыг үндэслэн, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх арга барил хүний эрхийг иж бүрнээр нь нэвтрүүлсний зэрэгцээ ялангуяа хохирогчийг хамгаалах болон тусламжийн чиглэлээр нэлээдгүй шинэлэг зүйлийг заасан. Тус конвенцын 15 дугаар зүйлд нөхөн төлбөрийн талаар заахдаа гишүүн улс бүрийн эрх бүхий байгууллага хохирогчтой анх харилцаа тогтоосон цагаас холбогдох шүүх, захиргааны ажиллагаанд хохирогчийг ойлгох хэлээр нь мэдээллээр хангаж, тэднийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэвтрэх боломжийг эдлүүлнэ гэж, мөн үндэсний хууль тогтоомжид хохирогч үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах болон гэмт этгээдээс хохирогч нөхөн төлбөр авах эрхийг хэрэгжүүлэх тухай зааж өгөхийг заасан.<sup>5</sup> Түүнчлэн гишүүн бүр дотоодын хууль тогтоомжоор хохирогчдод нөхөн төлбөр олгох баталгаа хангасан хууль тогтоох болон бусад арга хэмжээг авна гэж заасан байдаг.

Тухайлбал, хохирогчийн хохирлыг барагдуулах сан байгуулж 23 дугаар зүйлд зааснаар хохирогчид нийгмийн туслалцаа үзүүлэх, нийгэмд эргэн нэгтгэхэд чиглэсэн арга хэмжээ, хөтөлбөрийг санхүүжүүлж болох юм.

Бүс нутгийн шинжтэй дараагийн олон улсын эрх зүйн зохицуулалт болох Хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай Европын конвенц (Европ 1983 оны 116 дугаар гэрээний цуврал)-

<sup>5</sup> Council of Europe Convention on Action against Trafficking in Human Beings, Warsaw, 16.V.2005 <https://rm.coe.int/168008371d>

ын 2 дугаар зүйлд хохирогч нөхөн олговрыг бусад эх үүсвэрээс бүрэн авах боломжгүй тохиолдолд төр нөхөн олгоно гээд (а) Хүчирхийллийн гэмт хэргийн улмаас бие махбодын хүнд гэмтэл, эрүүл мэнд нь шууд хохирсон хүмүүс, (б) Ийм гэмт хэргийн улмаас нас барсан хохирогчийн асрамжид байсан хүмүүс хамаарна гэжээ. Түүнчлэн дээрх тохиолдолд гэм буруутай этгээдийг яллагдагчаар татсан эсвэл шийтгэсэн байхаас үл хамааран нөхөн төлбөр олгох тухай заасан юм.<sup>6</sup> Тус конвенцын 3 дугаар зүйлд нөхөн төлбөрийг нутаг дэвсгэрт нь гэмт хэрэг үйлдсэн улс (а) энэхүү конвенцод нэгдсэн улсын иргэдэд; (б) нутаг дэвсгэрт нь гэмт хэрэг үйлдэгдсэн тухайн мужид байнга оршин суугч, Европын Зөвлөлийн бүх гишүүн улсын иргэдэд төлнө гэж заажээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох талаар олон улсад мөрдөж буй баримт бичгүүдийн дундаас “Хүн худалдаалахтай тэмцэх аргачлал” нь дэлгэрэнгүй, нарийвчилсан зөвлөмж юм. Энэ аргачлал нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хохирол нөхөн төлөх зохих процедурыг бий болгохыг шаарддаг. Ингэхдээ Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенц болон Палермогийн Протоколын заалтуудын дагуу зөвлөмжилсэн. Энэхүү хэрэгсэл нь мөн түүнийг олгохтой холбоотой олон улсын болон бүс нутгийн заалтуудтай холбоотой зарчим болон нөхөн төлбөрийн зорилго, эх сурвалжийг хэлэлцэнэ. Эцэст нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тэдэнд зориулсан нөхөн төлбөрийн механизмыг бэхжүүлж, хөгжүүлсэн дотоодын тогтолцооны зарим ирээдүйтэй жишээг онцолсон.

Тус аргачлалд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох зорилгыг дараах байдлаар тодорхойлжээ.

Нөхөн төлбөр олгох нь нэгдүгээрт, хүн худалдаалах үйлдлийг гэмт хэрэг гэж нийгэмд хүлээн зөвшөөрөх, хоёрдугаарт, хохирогчид учирсан гэмтэл, шаналлыг хүлээн зөвшөөрч, үүнээс үүдсэн эмгэгийг даван туулах эхний алхам болох, гуравдугаарт, хохирогч амьдралаа дахин эхлүүлэхэд санхүүгийн тусламж үзүүлэх, дөрөвдүгээрт, гэмт этгээдийг залхаан цээрлүүлэх, урьдчилан сэргийлэх зорилготой гэжээ.<sup>7</sup> Эндээс үзвэл хохирлын нөхөн төлбөр нь хүний эрхийг хангах, хохирлыг нөхөн сэргээх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг олон зорилгыг агуулдаг байна.

Европын Холбооны улсуудад хүнд гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох асуудлыг нэн чухал гэж үзэж, 1977 онд Европын зөвлөлөөс санаатай гэмт хэргийн улмаас бие махбодод хүнд гэмтэл учруулсан бол

<sup>6</sup> European Convention on the Compensation of Victims of Violent Crimes, Strasbourg, 24.XI.1983, 2 дугаар зүйл. <https://rm.coe.int/1680079751>

<sup>7</sup> Toolkit to Combat Trafficking in Persons, 2006, <https://www.unodc.org/documents/human-trafficking/HT-toolkit-en.pdf>

нөхөн төлбөр төлүүлэх тогтоолын төслийг боловсруулсан. Гэмт этгээд хохирогчдод нөхөн төлбөр төлөх боломжгүй тохиолдолд хохирлыг барагдуулах боломжтой сан байгуулах асуудлыг авч үзэхийг гишүүн орнуудад уриалсан. Эдгээр хохиролд өнгөрснийг нөхөн сэргээхээс гадна ирээдүйд олох орлогоо алдагдсаныг оруулна гэжээ. (Европын Зөвлөл, 1977)

Палермогийн протоколын 6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Оролцогч улс бүр дотоодын хууль зүйн тогтолцооны хүрээнд хүн худалдаалах хэргийн хохирогчдод учирсан хохиролдоо нөхөн төлбөр авах боломж олгож байх арга хэмжээг харгалзсан нөхцөлийг хангана”<sup>8</sup> гэжээ. Энэ нь үндэсний хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр авах боломж байхгүй тохиолдолд зохистой схемийг бий болгохын тулд тохирох эрх зүйн зохицуулалтыг хуульчлахыг тухайн улсаас шаардаж буй заалт юм.

Гэсэн хэдий ч нөхөн төлбөр авах эрхийн хэрэгжилтийг дүгнэсэн сүүлийн үеийн тайланд Европын орнууд болон АНУ-ын аль алинд нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр авах боломж олон талаараа хязгаарлагдмал байна. Өөрөөр хэлбэл, олон улсын эрх зүйн зохицуулалт хангалттай байгаа ч нөхөн төлбөр авах эрхийг хамгаалах талаар гадаад орнуудын эрх зүйн орчин харилцан адилгүй байхын зэрэгцээ хэрэгжилт хангалтгүй байсаар байна.<sup>9</sup> Тухайлбал, АНУ-ын Техас улсын Хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас 2023 онд хүн худалдаалах гэмт хэргийн 70 хохирогч нөхөн олговор олгох хүсэлтийг ирүүлснээс 12-т нь нөхөн олговор олгожээ.<sup>10</sup> Тайланд Улсад 2021 онд 182 гэмт хэрэг бүртгэгдэж 352 хохирогч тогтоогдсоноос 19-т нөхөн төлбөр олгожээ.<sup>11</sup>

Олон улсын эрх зүйн зохицуулалтыг судалж, үндсэн асуудлыг тодорхойлох зорилгоор нөхөн төлбөр, түүний төрөл, хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа, арга зам, эд хөрөнгийг хурааж нөхөн олговор зарцуулах, хохирогчид нөхөн олговор авах эрхийн талаар мэдээлэл хүргэх болон хохирогч нөхөн олговор авахад тулгамдаж буй асуудал бэрхшээлийн талаар судаллаа.

## 1.1. Нөхөн төлбөр, түүний төрөл, эх үүсвэр

Нөхөн төлбөр гэсэн ойлголт нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл онооход харгалзан үзэх нөхцөл, гэмт хэргийн

<sup>8</sup> Хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба шийтгэх тухай протокол, 2000. <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/protocol-prevent-suppress-and-punish-trafficking-persons>

<sup>9</sup> Jeltsje Cusveller, Compensation for Victims of Human trafficking: Inconsistencies, Impediments and Improvements, Master thesis of criminology, 2015.

<sup>10</sup> Crime Victim Services 2023 Annual Report. <https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/annual-reports/23106-CVS-Annual-Report-2023-4.pdf>

<sup>11</sup> Royal Thai Government's Country Report on Anti-Human Trafficking Efforts, pp.10, 11, 56.

<https://aseanactpartnershiphub.com/wp-content/uploads/2022/02/Thailands-Country-Report-on-Anti-Human-Trafficking-Efforts-2021.pdf>

хоширогчид бие махбодын болон сэтгэл санааны хохирол учруулсныхаа төлөө төлөх төлбөрийг ойлгоно.<sup>12</sup>

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийг материаллаг ба материаллаг бус буюу эдийн ба эдийн бус гэж ангилдаг. Эд хөрөнгийн буюу материаллаг хохиролд эмчилгээ, эрүүл мэндийн үзлэг, тээвэрлэлт, эд хөрөнгөд учруулсан хохирол болон олох байсан орлого зэрэг орно. Харин эдийн бус хохиролд бие махбодын болон сэтгэл санааны зовуурь шаналал, айдас, хөдөлмөрийн чадвар алдагдуулсан хүнд гэмтэл, ирээдүйд учрах мөнгөн бус хохирол зэрэг багтана.<sup>13</sup>

Хохирлын нэхэмжлэлд дараах үндсэн нөхөн төлбөрийн хэлбэрүүд багтаж болдог. Үүнд:

- Бие махбодын болон сэтгэл зүйн хүчирхийллийн зовуурь, шаналал;
- Эмчилгээний зардал;
- Төлөгдөөгүй болон дутуу төлөгдсөн цалин хөлс;
- Ажилд зуучлах, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад хууль бусаар төлсөн "төлбөр" эсвэл хууль бусаар хил нэвтрүүлсэн болон тээвэрлэсэн нөхөн төлбөр;
- Гэмт үйлдэлд оногдуулах "торгууль"
- Түрээс, амьжиргаа, унаа, татвар эсвэл нийгмийн даатгалын "төлбөр" зэрэг.<sup>14</sup>

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 60/147 дугаартай Үндсэн зарчим болон Удирдамжийн 20 дугаар зүйлд Олон Улсын хүний эрхийн хуулийг бүдүүлгээр зөрчсөн зөрчлийн хүнд хөнгөн, нөхцөл байдалд тохирсон, эдийн засгийн хувьд үнэлж болох аливаа хохирлыг нөхөн төлүүлэх ёстой<sup>15</sup> гэжээ. Түүнчлэн тус Удирдамжид нөхөн төлбөрийн төрлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

1. Бие махбодын эсвэл сэтгэл санааны хохирол,
2. ажил, боловсрол, нийгмийн байдлын хувьд алдагдсан боломж,
3. материаллаг хохирол, олсон болон олох ёстой байсан цалин хөлсний хохирол,
4. ёс суртахууны хохирол,
5. хууль зүйн болон шинжээчид шаардагдсан хөлс, эмийн ба

<sup>12</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (Албан хаагчдыг чадавхжуулах сургалтын гарын авлага), 2022.

<sup>13</sup> <https://rm.coe.int/victims-of-human-trafficking-right-to-legal-aid-and-compensation/1680765504>

<sup>14</sup> Toolkit to Combat Trafficking in Persons, 2006, <https://www.unodc.org/documents/human-trafficking/HT-toolkit-en.pdf>, Бүлэг 8, 437 дахь тал.

<sup>15</sup> Үндсэн зарчим ба удирдамж, 20 дугаар зүйл. [Basic Principles and Guidelines on the Right to a Remedy and Reparation for Victims of Gross Violations of International Human Rights Law and Serious Violations of International Humanitarian Law | OHCHR](#)

эмчилгээний, сэтгэл зүйн болон нийгмийн үйлчилгээний хохирол<sup>16</sup> гэжээ.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцыг хэрэгжүүлэх Хууль зүйн зааварчилгааны 233 дугаар зүйлд Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хэсгээс улсын төсвийн хөрөнгөөр буюу шүүхээр шийдвэрлэх нөхөн төлбөрийн хэлбэр нь дараах төлбөрийг багтаахыг зөвлөж байна гэжээ. Үүнд:

- (а) Хохирогчийн шаардагдах эмнэлгийн, бие махбод, сэтгэлзүйн болон сэтгэцийн эмчилгээний зардал;
- (б) Хохирогчийн шаардсан биеийн болон хөдөлмөрийн эмчилгээ, нөхөн сэргээх зардал;
- (в) цалин хөлстэй холбоотой үндэсний хууль тогтоомж, дүрэм журмын дагуу алдсан орлого, цалин;
- (г) Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирогчид учирсан хууль зүйн хураамж болон бусад зардал, процесст оролцохтой холбоотой зардал;
- (д) хохирогчийн эсрэг үйлдсэн гэмт хэргийн улмаас учирсан ёс суртахуун, бие махбод, сэтгэл санаанд учирсан зовлон, шаналал буюу эдийн бус хохирлын төлбөр.

Дээрхээс үзэхэд олон улсын туршлагад хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэлбэр материаллаг ба материаллаг бус гэсэн үндсэн 2 төрөлтэй байх бөгөөд үүнд бие махбодод учирсан хохирол, эмнэлгийн ба эмчилгээний зардал, олсон болон олох байсан цалин хөлс, түрээс, амьжиргаа, тээвэр, хууль зүйн үйлчилгээ зэрэгт зарцуулсан төлбөр, сэтгэл санааны болон нэр хүндэд учирсан эдийн бус хохирол зэрэг хамаарч байна. Түүнчлэн гэмт этгээд хохирогчийн байрны түрээс, хоол унд, хувцас хэрэглэлд зориулж өгсөн бага хэмжээний мөнгийг их хэмжээний өр зээл болгох, түүнийгээ цалингаас нь хэд нугалж төлүүлэх, барьцаалах, хохирогчид нөхөн төлбөр төлөхгүй байх зэрэг асуудал тулгамдсаар байна.

## 1.2. Хохирол нөхөн төлүүлэх арга зам, ажиллагаа

Палермогийн протоколын 6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан дотоодын хууль зүйн тогтолцооны хүрээнд хүн худалдаалах хэргийн хохирогчдод учирсан хохирлын нөхөн төлбөр авах боломж олгох арга хэмжээг хэрэгжүүлэх талаар **Хууль зүйн зааварчилгаа**-ны 232 дахь хэсэгт<sup>17</sup> “Нөхөн олговор авах боломжийг санал болгож буй зохих

<sup>16</sup> Мөн тэнд. 20 дугаар зүйл.

<sup>17</sup> Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцыг хэрэгжүүлэх хууль зүйн зааварчилгаа, 2020.

[https://www.unodc.org/documents/treaties/Review\\_Mechanism/Review\\_Mechanism\\_2020/Website/Legislative\\_Guide\\_on\\_TIP/TIP\\_LegislativeGuide\\_Final.pdf](https://www.unodc.org/documents/treaties/Review_Mechanism/Review_Mechanism_2020/Website/Legislative_Guide_on_TIP/TIP_LegislativeGuide_Final.pdf)

схемүүд хараахан гараагүй байгаа тохиолдолд хууль тогтоомж шаардлагатай талаар тусгасан тул оролцогч улсууд дараах зохицуулалтыг хийх юм.

Үүнд:

- (а) Гэмт этгээдийг ялласан тохиолдолд эрүүгийн шүүх хохирогчид нөхөн төлбөр олгохыг зөвшөөрөх;
- (б) Хохирогч хуульд зааснаар эсхүл гэм хорын эрх зүйн дагуу гэмт этгээд, бусад этгээдийн эсрэг иргэний шүүхэд нэхэмжлэл гаргах боломжийг бүрдүүлэх;
- (в) Хохирогч гэмт хэргийн улмаас учирсан гэмтэл, хохиролд нөхөн төлбөр нэхэмжлэх боломжтой төрийн тусгай сан эсвэл схемийг бий болгох.

Үүнтэй холбогдуулан “Хүн худалдаалахтай тэмцэх аргачлал”-д эрх зүйн зохицуулалт харилцан адилгүй орнуудад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хохирлоо нөхөн төлүүлэх 3 арга зам байгааг тодорхойлжээ. Эдгээр нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (хөдөлмөрийн хуулийн дагуу хохирлоо нэхэмжлэх энд хамаарна) болон захиргааны тогтолцоогоор (Засгийн газрын сан) хохирол нөхөн төлүүлэх явдал юм.

Хохирлыг нөхөн төлүүлэхдээ 1/ гэмт хэрэг үйлдсэн этгээдээс болон 2/төрөөс гаргуулах боломжтой нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, эрүүгийн ба иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирлыг гэмт этгээдээс төлүүлдэг бол төрөөс хохирлын сангаар дамжуулан төлж байна.<sup>18</sup> Эх газрын эрх зүйн тогтолцоотой дийлэнх улсад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлдэг практиктай бол, Англи-Америкийн эрх зүйн тогтолцоотой улсад хохирол төлүүлэх нь нэмэгдэл ялын шинжтэй хэрэгжих нь түгээмэл байна.<sup>19</sup>

#### 1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хохирол нөхөн төлүүлэх

Ихэнх улс оронд хохирогч гэм буруутай үйлдэл болон гэрээний эрхээ хэрэгжүүлээгүйгээс болж учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр иргэний нэхэмжлэл гаргаж болдог. Түүнчлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь аливаа хэлбэрийн гэрээ, хэлцэл байгаа эсэхээс үл хамааран хөдөлмөрийн хуульд заасан эрх эдэлж байна. ИХХША нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод ЭХХША-аас илүү нээлттэй байдаг. ИХХША-ны явцад цагдаагийн байгууллага оролцдоггүй хэдий ч

<sup>18</sup> Toolkit to Combat Trafficking in Persons, 2006. <https://www.unodc.org/documents/human-trafficking/HT-toolkit-en.pdf>

<sup>19</sup> OSCE, National Referral Mechanisms: Joining Efforts to Protect the Rights of Trafficked Persons, A Practical Handbook, p.84.

иргэний шүүх гэмт этгээдийг олж тогтоосон байхыг шаардах ба гэмт этгээд нь тухайн улсын харьяалалтай байх, цаашлаад, төлбөрийн чадвартай байх асуудлыг чухалчилдаг. Хохирлыг үнэлэхдээ иргэний хуулийн заалтад тулгуурлан, материаллаг ба материаллаг бус хохирлыг тооцдог.

## 2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хохирол нөхөн төлүүлэх

Зарим улсад нөхөн төлбөр шаардах иргэний нэхэмжлэлийг ЭХХША-тай нэгтгэн шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл, шүүх хуралдаанаар гэмт этгээдийг шийтгээд зогсохгүй хохирогчийн хохирлыг барагдуулдаг. Энэ нь хохирогчдод үзүүлэх аливаа дарамтыг бууруулдаг. Зарим улсад нөхөн төлбөр төлөх нь гэмт этгээдэд оногдуулах ялын нэг хэсэг болох нь ч бий. Иргэний хэргийг эрүүгийн хэрэгтэй хамтатгаж шийдвэрлэж байгаа нь хоёр процессыг нэг болгон нэгтгэх давуу талтайн зэрэгцээ прокурор хохирогчид учирсан хохирлыг нотлох хүрээнд нотлох баримт цуглуулах, танилцуулах үүрэг хүлээдгээрээ онцлогтой. Эрүүгийн шүүх гэмт этгээдээс нөхөн төлбөр гаргуулах тухай шийдвэрийг ял оногдуулах тогтоолтой хамтад нь гаргана. Гэмт этгээдээс гаргуулах нөхөн төлбөрийн хэмжээг иргэний хууль тогтоомжид зааснаар эсвэл өөр үндэслэлээр тогтоож болдог. Нэхэмжлэл гаргахад эрх бүхий байгууллагаас хохирогчийг тогтоосон байхын зэрэгцээ ЭХХША-гаар гэмт этгээдийн гэм буруутайг тогтоосон байхыг шаардана. Гэвч гэмт хэрэгтэн тодорхойгүй эсвэл харьяаллаас зугтсан эсвэл гэмт хэрэг үйлдсэнийг нотлох баримт хангалтгүй, хохирогч хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах хүсэлгүй байх зэрэг шалтгааны улмаас энэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх нь харьцангуй хүндрэлтэй байдаг.

## 3. Төрийн тусгай сангаас хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа

Төрөөс хүн худалдаалах гэмт хэргийн хохирлыг нөхөн төлөх тогтолцооны олон улсын эрх зүйн үндэслэлийн нэг нь “Гэмт хэргийн хохирогчийн шүүхэд хандах эрх болон эрх мэдлээ хэтрүүлэхтэй холбогдох үндсэн зарчмын тунхаглал”-ын 13 дугаар зүйлд “Хохирогчид нөхөн төлбөр олгох үндэсний санг байгуулах, бэхжүүлэх, өргөжүүлэхийг дэмжих ёстой. Шаардлагатай бол хохирогчийн харьяат улсын хувьд хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэх боломжгүй тохиолдолд тус зорилгоор бусад сан байгуулж болно.”<sup>20</sup> гэжээ.

Зарим улсад хүчирхийллийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс төлөх механизмыг бий болгожээ. Улсаас санхүүждэг эсвэл

<sup>20</sup> Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power | OHCHR  
<https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/declaration-basic-principles-justice-victims-crime-and-abuse>



төрөөс татаас авдаг нөхөн төлбөрийн схемүүд нь хохирогчдод нөхөн төлбөрийг баталгаатай олгох давуу талтай бөгөөд тодорхой гэмт этгээдийг олж тогтоох шаардлагагүй байдгаараа онцлогтой.

Дээрх санд хүсэлт гаргахад, хохирогчийн зүгээс мөрдөн байцаалтын ажиллагаанд туслахад бэлэн байгаа тухайгаа илэрхийлэхээс гадна хэргийн талаарх цагдаагийн бүртгэл байхад хангалттай. Төрийн схем ч харьцангуй энгийн, хүнд сурталгүй, ИХХША-аас хурдан байдаг.<sup>21</sup> Нөхөн олговрын схемийг хэд хэдэн эх үүсвэрээс санхүүжүүлж болно. Үүнд, торгууль, гэмт этгээдээс хураасан эд хөрөнгө, татварын орлого, улсын санхүүжилтийн бусад хэрэгсэл, хувь хүмүүс, байгууллагуудаас өгсөн хандив гэх мэт.

Хүн худалдаалахтай тэмцэх аргачлалд зааснаар төрийн сан хохирогчдод үр дүнтэй туслахын тулд:

- "Хууль бус" гэсэн үндэслэлээр хасаж болохгүй (Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид тухайн улсад хууль ёсны статустай байх нь ховор байдаг)
- Үйл явц нь энгийн бөгөөд үр дүнтэй байх ёстой (ихэнх хохирогчийг эх оронд нь нэн даруй буцаадаг)
- Хохирогчдыг шүүхийн журмаар “дахин яллах”-аас дээд зэргийн боломжит хэмжээнд хамгаалах ёстой.

### **1.3. Хохирлыг нөхөн төлүүлэхээр эд хөрөнгө хураах**

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын 14 дүгээр зүйлд хураагдсан гэмт хэргийн орлого буюу эд хөрөнгийг захиран зарцуулах явцад оролцогч улсуудын нөхөн төлбөрийн асуудлаар олон улсын хэмжээнд хамтран ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Түүнчлэн тус конвенцын 16 дугаар зүйлд оролцогч улсууд гэмт хэргийн улмаас хураагдсан орлогыг хохирогчид нөхөн төлбөр олгохын тулд эд хөрөнгө буцаан олгох асуудлын талаар гаргасан оролцогч улсын хүсэлтийг нэн тэргүүнд анхаарч үзэх талаар заасан. Тус конвенцын 25 дугаар зүйлд оролцогч улсууд конвенцод хамрагдсан гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр авах боломжийг олгохын тулд зохих журам тогтоохыг шаарддаг. Ийм боломж эдлэх эрхийнх нь талаар хохирогчдод мэдэгдэх ёстой байдаг.<sup>22</sup>

Хүн худалдаалахтай тэмцэх аргачлалын 8.7 дугаар зүйлд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь гэмт этгээдийн учруулсан бие махбодын, сэтгэл санааны хохирол болон хөдөлмөрийн хөлсийг нөхөн төлүүлэх эрхтэй гэж заасан. Тус аргачлалд тусгаснаар, хохирогчид

<sup>21</sup> Toolkit to Combat Trafficking in Persons, 2006. <https://www.unodc.org/documents/human-trafficking/HT-toolkit-en.pdf>

<sup>22</sup> Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, 2000 он. <https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html>

мэдээлэл өгөх, гэмт этгээдийн хөрөнгийг хураах асуудал нь нөхөн төлбөр авахад нэн чухалд тооцогддог. Гэмт этгээд хөрөнгөө нуун дарагдуулдаг, эсвэл гадаад руу шилжүүлдэг нь хохирогчдод нөхөн олговор авахад саад болдог. Энэхүү саад бэрхшээлийг даван туулахын тулд улс орнууд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын хохирлыг барагдуулах зорилгоор гэмт этгээдийн эд хөрөнгө, мөнгийг хураах ёстой гэжээ. Иймд аливаа улс хилийн чанад руу шилжүүлсэн гэмт этгээдийн эд хөрөнгөд нэвтрэх эрхийг хангах хууль сахиулах байгууллагуудын олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх ёстой.<sup>23</sup>

Хүн худалдаалахтай тэмцэх аргачлалд зааснаар иргэний болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хөрөнгийн хөдөлгөөнийг мөшгөж, хөрөнгийг битүүмжлэх, царцаах, хураан авсан тохиолдолд нөхөн төлбөр төлүүлэх ажиллагааны хэрэгжилт сайжирдаг гэжээ.<sup>24</sup>

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу оролцогч улс бүр энэхүү конвенцод хамаарах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох болон хохирлыг арилгах талаар зохих журам батална. Конвенцын 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заахдаа оролцогч улсуудаас дотоодын хууль тогтоомжийн дагуу гэмт хэргийн улмаас хураагдсан орлого, эд хөрөнгийг буцаан олгох асуудлыг нэн тэргүүнд анхаарч үзэхийг шаардсан.<sup>25</sup>

#### 1.4. Хохирогчид мэдээлэл өгөх

Палермогийн протоколын 6 дугаар зүйлийн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах болон туслах гэсэн 2 дахь хэсэгт, оролцогч улс бүр шүүхийн буюу захиргааны журмын талаарх мэдээллийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод өгөх<sup>26</sup> ёстой гэж заасан.

Хууль зүйн зааварчилгааны 236 дугаар зүйлд зааснаар Палермогийн протоколын 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчдод мэдээлэл өгөх, тусламж үзүүлнэ. Өөрөөр хэлбэл, хохирогчид нөхөн төлбөр авах эрхийнх талаар бүрэн тайлбарлаж, тэдний ойлгодог хэлээр нэхэмжлэл гаргах талаар мэдээлэл өгөх ёстой. Түүнчлэн тус протоколын 8 дугаар

<sup>23</sup> Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх зааварчилгааны 4.6 дугаар зүйл болон 5.7 дугаар зүйлийг үзнэ үү.

<sup>24</sup> Мөн тэнд, хөрөнгө хураах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл 4.6 дугаар зүйл болон 5.7 дугаар зүйлийг үзэх боломжтой.

<sup>25</sup> 14 дүгээр зүйлийн 2. Энэхүү конвенцын 13 дугаар зүйлийн дагуу оролцогч улс нөгөө улсаас гаргасан хүсэлтээр үйл ажиллагаа явуулах тохиолдолд оролцогч улсын дотоодын хуулиар зөвшөөрсөн бөгөөд хэрэв хүсэлт хүлээн авсан бол хүсэлт гаргагч оролцогч улсад албадан хураасан гэмт хэргийн орлого буюу эд хөрөнгийг буцаах болон тэдгээрийн хууль ёсны эзэмшигчид тийм гэмт хэргийн орлого буюу эд хөрөнгийг буцаах, эсхүл гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох тухай хүсэлтийг нэн тэргүүнд авч үзнэ гэжээ.

<sup>26</sup> Палермогийн протоколын 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

зүйлийн 2 дахь хэсэгт хүн худалдаалах хэргийн хохирогч нь тус улсын байнгын оршин суугчийн статустай этгээд байсан бол эх орон руу нь буцаахдаа тухайн этгээдийн аюулгүй байдлыг хангах асуудлыг харгалзан, аль болохоор сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлнэ гэжээ.

Хүн худалдаалахтай тэмцэх аргачлалын 8.7 дугаар зүйлийн “Мэдээлэл” гэсэн хэсэгт хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр авах эрх болон шаардлагатай процедурын арга хэмжээ авах талаар мэдээллийг өгөөгүйгээс болж нөхөн төлбөр авах боломжоо алдаж байдаг. Тиймээс хууль хяналтын байгууллагын зохих албан тушаалтнууд эсвэл хуульчид хохирогчид мэдээлэл өгөх нь хохирлоо нөхөн төлүүлэх чухал урьдчилсан нөхцөл юм<sup>27</sup> гэсэн байна.

Хууль зүйн зааварчилгааны 235 дүгээр зүйлд оролцогч улсуудад хохирогчийн цагаачлалын статусыг баталгаажуулахыг зөвлөсөн. Хохирогч эх орондоо буцсан, эсхүл хохирогч харьяалалгүй байх нь нөхөн төлбөр төлөхөд саад болох ёсгүй. Протоколын 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагын дагуу хохирогчийг эх оронд нь буцаах ажиллагааг явуулахдаа оршин суух статусыг харгалзан үзэх ёстойг заасан байдаг.

Эдгээр нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хохирлоо нөхөн төлүүлэх ажиллагааг амжилттай явуулахад хуульч, хууль сахиулагчдын мэдээлэх үүрэг маш чухал болохыг онцолсон заалтууд юм.

## **1.5. Хохирол нөхөн төлүүлэхэд тулгамдаж буй асуудал**

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нөхөн төлбөр авах нь улс орнуудад хэрэгжилт муу байгааг дээр дурдсан. Хэдийгээр олон улсын эрх зүйн зохицуулалт, үндэсний хууль тогтоомжид гэмт хэргийн хохирогч эрүүгийн, иргэний журмаар хохирлоо нөхөн төлүүлэх, улсын сангаас мөнгөн тусламж авах эрхтэйгээр хуульчилсан ч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч дараах шалтгааны улмаас нөхөн төлбөр авах нь бага байна гэж үзжээ. Үүнд:

- Хохирогчдыг тогтоохгүй байх

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад хохирогчоор тогтоогоогүй нь нөхөн төлбөр шаардах боломжгүй болгож байна. Энэ нь бусад хэд хэдэн асуудалтай холбоотой. Барууны ихэнх орнууд хүн худалдаалах гэмт хэргийг гэмт хэрэгт тооцож, түүний бүх төрлүүдийг хүлээн зөвшөөрч байгаа ч хөдөлмөрийн мөлжлөгийг хүн худалдаалах гэмт хэрэг гэж хараахан хүлээн зөвшөөрөхгүй улсууд дэлхий дээр байсаар байна. Евростатын мэдээлэл

<sup>27</sup> Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Хэрэгсэл 8.4 болон Хэрэгсэл 8.15-ыг үзнэ үү.

(2015)-д зааснаар Европын холбооны гишүүн 15 улс тайлан өгснөөс хөдөлмөрийн мөлжлөгтэй холбоотой нийт 7 эрүүгийн хэрэг үүсгэжээ.<sup>28</sup> UNODC (2014) тайланд дэлхий даяар Палермогийн протоколын дагуу эрх нь бүрэн хамгаалагдаагүй хоёр тэрбум гаруй хүн байна гэжээ. Гэсэн хэдий ч илрээгүй хохирогчдын тоог албан ёсоор тодорхойлох нь төвөгтэй байдаг. Учир нь хууль сахиулах байгууллагуудын хүрээнд хүн худалдаалах гэмт хэргийг нарийвчлан мөрдөн шалгах, ялангуяа эрэгтэй хохирогчид болон бэлгийн бус мөлжлөгт өртсөн хохирогчдыг тогтоох ажиллагаа учир дутагдалтай байгаа юм.<sup>29</sup>

- Хохирогчийг буруутгаж харьцах

Хууль сахиулах байгууллага болон шүүгчдийн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх буруутгах хандлага нь нөхөн төлбөр авах эрхээ эдлэхэд сөргөөр нөлөөлдөг. Хохирогч нь тус улсад хууль бус статустай тул гэмт хэрэгтэн гэж үзэх эсвэл тэдний үйлдлийг ёс зүйгүй гэж үзэх зэрэг сөрөг хандлага байна. Жишээлбэл, биеэ үнэлэхийг гэмт хэрэгт тооцдог улс орнуудад хохирогчийг гэм буруутайд тооцож хорих тохиолдол бий.. Нэмж дурдахад хохирогчийг хохирогч болсон гэж буруутгах, сөрөг хандлагатай байх нь ялангуяа биеэ үнэлэгчдийн хувьд нийтлэг байдаг бөгөөд энэ нь нөхөн олговрын хэмжээнд нөлөөлдөг байна.<sup>30</sup>

- Хууль зүйн туслалцааны хангалтгүй байдал

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүмүүсийг тогтоож чадсан ч тэдэнд хэрхэн нөхөн олговор авах эрхээ эдлэх талаар хууль зүйн туслалцаа үзүүлэх, мэдээлэх өгөх явдал хангалтгүй байна. Евростатын мэдээлэл (2015)-д 2010-2012 оны хооронд хууль зүйн туслалцаа үзүүлсэн 1211 тохиолдол бүртгэгдсэн байна. Энэ нь бүртгэгдсэн нийт хохирогчдын тоотой харьцуулахад маш бага хэвээр байна. Хохирогч нөхөн төлбөр нэхэмжлэхэд саад болж зүйл нь ихэнх хохирогчдод энэ ажиллагааг явуулж буй дүрэм журам нь тодорхойгүй, айдас төрүүлдэг, төвөгтэй байгаатай холбоотой. Цаашилбал, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид ихэвчлэн санхүүгийн нөхцөл муутай байдаг тул тэдэнд үзүүлэх хууль зүйн туслалцаа нь үнэ төлбөргүй байх ёстойг харуулж байна.

<sup>28</sup> Jeltsje Cusveller, Compensation for Victims of Human trafficking: Inconsistencies, Impediments and Improvements, Master thesis of criminology, 2015, p.18.

[https://documentation.lastradainternational.org/lsidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwZXh0bgNhZW0CMTAAR0ZyO1mlYmXGZKtdF-tbKep9w-GVHifK0Rhael-dxFGkQpe852-Y9\\_j1Y\\_aem\\_ARdTQ22DLsbVtKZ\\_OiF0YRaVeZobMwerUblDeqhPZgBKXBmXJAeqWWcXkIFvVHX1h497ELab7dlITLly20HqIV0](https://documentation.lastradainternational.org/lsidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwZXh0bgNhZW0CMTAAR0ZyO1mlYmXGZKtdF-tbKep9w-GVHifK0Rhael-dxFGkQpe852-Y9_j1Y_aem_ARdTQ22DLsbVtKZ_OiF0YRaVeZobMwerUblDeqhPZgBKXBmXJAeqWWcXkIFvVHX1h497ELab7dlITLly20HqIV0)

<sup>29</sup>

Мөн тэнд.

<sup>30</sup>Toolkit to Combat Trafficking in Persons, 2006. <https://www.unodc.org/documents/human-trafficking/HT-toolkit-en.pdf>

- Хохирогч өөрийгөө хохирогч гэж үзэхгүй байх

Хууль зүйн туслалцаа авах боломжтой байсан ч хохирогч нөхөн олговор нэхэмжлэхгүй байх шийдвэр гаргах нь цөөнгүй. Зарим хохирогч, тэр дундаа хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хохирогчид өөртөө "хохирогч" эсвэл "хүний худалдаалах гэмт хохирогч" гэсэн шошго зүүхийг хүсдэггүй. Хохирогчдын зарим нь гэмт этгээдээс айсандаа нөхөн төлбөр нэхдэггүй, учир нь өөрийнх болон гэр бүлийнх эсрэг дарамт, заналхийлэл үзүүлэх вий гэсэн айдастай байдаг. Цаашлаад, нөхөн төлбөр нэхэмжлэх үйл явц удаан үргэлжлэх тул хохирогч мөлжлөгт өртсөн дурсамжийг сэдрээхээс айхын зэрэгцээ түүнийг мартахыг эрмэлздэг байна.

# 2

## МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгохтой холбоотой эрх зүйн орчныг Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, ЭХХШТХ, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Иргэний хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ИХХШТХ, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж бүрдүүлж байна. Дээрх хууль тогтоомжийн холбогдох заалтуудад хохирол, хор уршиг, хохирогчийн эрх зүйн байдал, хохирлыг тогтоох, үнэлэх, нотлох, хохирол нөхөн төлүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээхтэй холбоотой зохицуулалтыг заасан.

Монгол Улсад Хүн худалдаалахтай тэмцэх тухай тусгайлсан хуулийг 2012 онд баталсан ба тус хуулиар тодорхойлохдоо "хүн худалдаалах" гэж хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг хэлнэ<sup>31</sup> гэжээ.

Мөн Эрүүгийн хуулийн 13.1 дугаар зүйлд "Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэжээ.

Харин Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд зааснаар "хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл

<sup>31</sup> Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012, 3.1.1 дэх хэсэг.

шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг хэлнэ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3.1.1, 3.1.2 болон 12 дугаар зүйлд хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээг тусгайлан заахдаа 1.эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ, 2.сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ, 3.ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах, 4.хууль зүйн туслалцаа, 5.гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах гэжээ. Улмаар тус хуулийн 15 дугаар зүйлд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хохирол нөхөн төлүүлэх талаар заахдаа:

- Хохирогч нь эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэхийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй.
- Хохирогчийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө.
- Хохирогчийн сэтгэл санааны хохирлын хэмжээг түүний нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хохирогчид учирсан гэм хорын хэр хэмжээг харгалзан шүүх тогтооно гэжээ.

Эндээс үзвэл хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид учирсан эдийн ба эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн үндэслэлийг Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар тусгайлан бүрдүүлсэн ч бусад хууль тогтоомж, тухайлбал ЭХХШтХ, ИХХШтХ-д гэмт хэргийн хохирогчийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг ерөнхий байдлаар зохицуулжээ. Гэвч Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэхдээ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг бус Эрүүгийн хууль, Иргэний хууль, ЭХХШтХ болон ИХХШтХ-г баримталдаг нь тусгайлан хуулиар тогтоосон эрх зүйн зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх боломжийг хангахгүй байх талтай.

Иймд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хохирол төлүүлэх Монгол Улсын нөхцөл байдлыг нэгдүгээр бүлэгт авч үзсэн үндсэн асуудлын хүрээнд судалж, дүн шинжилгээ хийх нь зүйтэй байна.

## **1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирол төлүүлэх:**

ЭХХШтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 заалтад хохирогчийг тодорхойлсон. Харин тус хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.9 дэх хэсэгт зааснаар хохирогч нь “гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах”, 1.2 дахь хэсэгт

“1.2.хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг гаргаж өгч хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах” эрхтэй гэж заажээ. Тус хуулийн 8.5 дугаар зүйлд иргэний нэхэмжлэгчийг тодорхойлохдоо “1.Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа хүн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ.” гэжээ.

Улмаар гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ.<sup>32</sup> ЭХХШтХ-т зааснаар мөрдөгч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргаж иргэний нэхэмжлэгчээр тогтооно.<sup>33</sup>

Дээрхээс үзвэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь ЭХХША-ны явцад өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах, хамтад нь шийдвэрлүүлэх эрх зүйн зохицуулалттай байна. Цаашлаад иргэний нэхэмжлэл гаргах, түүнд холбогдох нотлох баримтыг өгөх нь хохирогчоос бүрэн хамааралтай байна.

## **2. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хохирол нөхөн төлүүлэх:**

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч ИХШХШтХ-ийн 3 дугаар зүйлд зааснаар шүүхэд мэдүүлэх эрх эдэлнэ. Тус хуулиар Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсэн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй гэж заасан.<sup>34</sup> Иргэний хуулийн 497 дугаар зүйлд зааснаар гэм хор учруулснаас хариуцлага хүлээх үндэслэлийг заасан. Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй. Түүнчлэн Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.3 дахь хэсгийн дагуу гэмт хэргийн улмаас сэтгэцэд учруулсан гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгах үүргийг гэм хор учруулсан этгээд хүлээнэ. Гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хохирол, түүний хэр хэмжээг Шүүх шинжилгээний тухай хууль, холбогдох журмын дагуу тогтооно. Гэвч ЭХХШтХ-т зааснаар гэмт хэргийн улмаас учирсан хохиролтой

<sup>32</sup> ЭХХШтХ, 2017, 8.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

<sup>33</sup> ЭХХШтХ, 2017, 8.5 дугаар зүйлийн 5,6 дахь хэсэг.

<sup>34</sup> Иргэний хууль, 2002, 3.1 дүгээр зүйл.



холбогдолтой нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхийг хориглоно гэсэн байна.<sup>35</sup>

Түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуулийн 142.2 дахь хэсэгт “Насанд хүрээгүй хүний оюун ухаан, биеийн хөгжил, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөх, хууль тогтоомжоор хориглосон хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжлөгийн хэлбэрээр ашиглах, цалин хөлсийг шударга бусаар тооцож олгох, хүүхдийн нэрээр хууль бус үйл ажиллагаа явуулах зэрэг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийг хүүхдээр эрхлүүлэхийг хориглоно.” гэж зааснаас өөрөөр хөдөлмөрийн мөлжлөгтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу 165 дугаар зүйлийг үндэслэж хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйлийн дагуу хохирлоо нөхөн төлүүлэх боломжтой. Тухайлбал, Зөрчлийн тухай хуульд зааснаар ажил олгогч нь ажилтныг хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллуулж байгаа тохиолдолд ажилтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага үндсэн цалин, хөлс олгосон эсхүл ажилтны цалин хөлсийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацаанд нь олгоогүй, эсхүл саатуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Гэвч Зөрчлийн тухай хууль нь гагцхүү хөдөлмөрийн харилцаа буюу хөдөлмөрийн гэрээ эсхүл түүнтэй төсөөтэй гэрээний харилцаа үүссэн үед хэрэглэгдэх шинжтэй байгаагаас гадна энэ талаар практик байхгүй.

Эндээс үзвэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч тус гэмт хэргийг эрүүгийн шүүхээр эцэслэн шийдвэрлэж, гэмт этгээдийн гэм бурууг тогтоосны дараа иргэний шүүхэд хохирлоо нөхөн төлүүлэхээр гэмт этгээдийн эсрэг нэхэмжлэл гаргах боломжтой байна. Өөрөөр хэлбэл, Иргэний хуульд заасны дагуу нэхэмжлэл гаргах, ялангуяа сэтгэцэд учирсан хохиролд нөхөн төлбөрөө гаргуулах боломж нь ЭХХША-тай нягт уялдаатай байна. Иргэний хуулийн 230 дугаар зүйлд “Сэтгэцэд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгах бөгөөд бусад эдийн бус гэм хорыг гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөн хэлбэрээр арилгана” гэж заасан. Өөрөөр хэлбэл, “гагцхүү гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хохирол”-ыг шаардах боломжтой байна. Иймд “гэмт хэрэг” үйлдсэн гэдгийг эрүүгийн шүүхээр эцэслэн шийдвэрлээгүй тохиолдолд иргэний журмаар хохирогч эдийн бус хохирлоо нэхэмжлэх боломж хязгаарлагдмал байна. Эрүүгийн шүүх цагаатгах тогтоол

<sup>35</sup> ЭХХШТХ, 2017, 8.5 дугаар зүйлийн 5,6 дахь хэсэг.

гаргасан тохиолдолд сэтгэцэд учирсан хохирлыг шаардах боломжгүй боловч бусдын хууль бус үйлдлийн улмаас учирсан эдийн хохирлыг ИХ-ийн 497 дахь хэсгийн дагуу барагдуулах боломж бий.

Цаашлаад хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэрийг хууль тогтоомжид тухайлан заагаагүйгээс хөдөлмөрийн мөлжлөгийн зорилго бүхий хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч авах ёстой байсан цалин хөлсөө шаардах нөхцөл төдийлөн бүрдээгүй байна.

### **3. Хохирол нөхөн төлүүлэх төрийн сан, түүний эрх зүйн зохицуулалт:**

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 хэсэгт “Гэмт хэргийн хохирогчид Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн төлбөр олгоно.” гэж заасан. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйл буюу Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан гэсэн зүйлд 10.1.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, энэ хуулийн 10.3-т заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгох зориулалттай байна гэжээ.<sup>36</sup> Тус сангийн хөрөнгө нь хуульд зааснаар шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө болон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр энэ хуулийн 10.3 хэсэгт заасан гэмт хэрэгт гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөрөөс бүрдэнэ.<sup>37</sup>

Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгийг Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл /Хүнийг алах/, 11.1 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 11.4 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйл /Бэлгийн мөлжлөг/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/ ...-д заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дараах хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна гээд

1. Эмчилгээний зардал;
2. Оршуулгын зардал;
3. Хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого<sup>38</sup> гэжээ.

<sup>36</sup> Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2020, 10.1 дүгээр зүйл.

<sup>37</sup> Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2020, 10.2.1, 10.2.2 дугаар зүйл.

<sup>38</sup> Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2020, 10.3 дугаар зүйл

Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдох ба тусгайлсан журамтай<sup>39</sup> байна. Тус журмын 4 дэх хэсэгт нөхөн төлбөр олгуулах хүсэлт гаргах талаар заахдаа нөхөн төлбөр хүсэх өргөдлийг хохирогч буюу түүний хууль ёсны төлөөлөгч нь аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш гаргана.<sup>40</sup> Өргөдөл гаргахдаа хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шийтгэх тогтоол болон гүйцэтгэх хуудасны хуулбар, өргөдөл гаргагчийн иргэний баримт бичгийн хуулбар, дансны талаар тодорхойлолт, хохирлыг гэм буруутай этгээд буюу түүний хууль ёсны төлөөлөгчөөс барагдуулаагүй, эсхүл дутуу барагдуулсныг нотлох баримтыг хавсаргана.<sup>41</sup>

Дээрхээс дүгнэвэл, сангаас олгох нөхөн төлбөрийн төрөл хязгаарлагдмал байгаагаас гадна гагцхүү эрүүгийн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон, шүүхийн шийдвэрт нөхөн төлбөрийн төрөл, хэмжээг тусгасан тохиолдолд л олгохоор байна. Олон улсын туршлагын үүднээс авч үзвэл, төрийн сангаас олгох нөхөн төлбөрийн төрөл, хэмжээг өргөн хүрээнд тодорхойлж, хохирогч амьдралаа дахин эхлүүлэх санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх, шүүхийн журмаар хохирогч “дахин хохирох”-оос сэргийлэх зорилгод чиглэсэн байх ёстой. Гэтэл Монгол Улсын гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тусгай сангийн зохицуулалт нь хэт явцуу хүрээнд тодорхойлогдсон тул хохирогчийн эрхийг бүрэн хамгаалах механизм гэж үзэхэд хүндрэлтэй байна.

---

<sup>39</sup> Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмыг Засгийн газар батална гэсэн заалтын дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугар сарын 16-ны өдрийн 220 дугаар тогтоолоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10.5-д заасныг үндэслэн “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам”-ыг шинэчлэн баталсан.

<sup>40</sup> “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам”, 2020, 4.1 дүгээр зүйл.

<sup>41</sup> “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам”, 2020, 4.2 дугаар зүйл.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хохирол нөхөн төлүүлэх талаар гадаад орны туршлагаас судлахдаа захиалагчийн санаачилгаар 3 түвшний улсыг сонгон авч судаллаа.

- i) Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын чиглэлээр сайн ажилладаг, эрхзүйн орчин тодорхой, хохирогчид олгох нөхөн олговрын систем нь тогтвортой хэрэгждэг 3 улс (АНУ, Франц, Нидерланд);
- ii) Хүн худалдаалах, гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор өгөх чиглэлээр нэлээдгүй туршлага хуримтлуулж байгаа 3 улс (ХБНГУ, Тайвань, Япон);
- iii) Манай улстай эрх зүйн систем ойролцоо бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо төдийлөн өндөр хөгжөөгүй 3 улс (Молдав, Румын, Тайланд)-ыг сонгосон.

Харьцуулсан судалгааг хийхдээ хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгож буй эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийг нарийвчлан судаллаа. Тухайлбал,

1. Хохирогчид нөхөн олговор олгох эрх зүйн зохицуулалтын салбар буюу эрүү, иргэн, хөдөлмөрийн хуулийн журмаар нөхөн олговор олгох ажиллагааны онцлог,
2. Нөхөн төлбөрийн буюу хохирлын хэлбэр: эдийн ба эдийн бус хохирол (ёс суртахууны хохирол), хохирлын хэр хэмжээ, түүнийг тогтоох, үнэлэх аргачлал,
3. Насанд хүрээгүй хохирогчид тусгайлсан эрх зүйн зохицуулалттай эсэх,
4. Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллээр хангагдах эрх буюу мэдээлэл өгөх талаар үүрэгжүүлсэн эрх зүйн зохицуулалт,
5. Гэмт хэрэгтнээр хохирол төлүүлэх зорилгоор эд хөрөнгийг нь хураах,
6. Төрөөс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох төрийн тусгай сан буюу захиргааны журмаар хохирол нөхөн төлүүлэх,
7. Хохирогчид нөхөн төлбөр олгож буй шат дараалал, хариуцах байгууллага буюу институтийн тогтолцоо,
8. Нөхөн төлбөр авах эрх үүсэх шалгуур, бүрдүүлэх материал, зарцуулах хугацаа, олгох нөхөн төлбөрийн төрөл,
9. Тохиолдол, шийдвэрлэсэн байдал буюу сайн туршлага зэрэг эрх

зүйн зохицуулалт, процессын асуудлуудыг нарийвчлан судалж, улс бүрийн онцлогт дүгнэлт өгөхийг хичээсэн болно.


### 3.1. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ 2023 онд 1 дүгээр түвшний (Tier1) статусаа хадгалсан нь АНУ-ын засгийн газар Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль (TVPA)-ийн наад захын стандартыг хангахын тулд хүчин чармайлт гаргасныг харуулж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн иргэний нэхэмжлэлтэй хэргийн дийлэнх хувийг гадаадын нэхэмжлэгч нар эзэлдэг. Нийт 29 тохиолдолд нэхэмжлэгчийн гарал үүслийн улс тодорхойгүй байх ба бусад нэхэмжлэгчийн харьяаллыг доорх хүснэгтэд жагсаав.

БҮГД НАЙРАМДАХ БАНГЛАДЕШ АРД УЛС	2	БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛС	1	МЕКСИКИЙН НЭГДСЭН УЛС	42	ТӨВ АФРИКИЙН БҮГД НАЙРАМДАХ УЛС	2
БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ УЛС	1	БҮГД НАЙРАМДАХ ГВАТЕМАЛ УЛС	10	БҮГД НАЙРАМДАХ МОЛДОВА УЛС	1	БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН СОЦИАЛИСТ ШРИ ЛАНКА УЛС	2
БҮГД НАЙРАМДАХ БОЛИВИ УЛС	2	БҮГД НАЙРАМДАХ ГВИНЕЙ УЛС	1	МАРОККОГИЙН ХААНТ УЛС	2	БҮГД НАЙРАМДАХ СУДАН УЛС	1
ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ БРАЗИЛ УЛС	3	БҮГД НАЙРАМДАХ ХАЙТИ УЛС	3	ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН БАЛБА УЛС	4	ШВЕЙЦАРЫН ХОЛБООНЫ УЛС	1
БУРКИНА ФАСО УЛС	2	БҮГД НАЙРАМДАХ ХОНДУРАС УЛС	3	ШИНЭ ЗЕЛАНД УЛС	1	АРАБЫН БҮГД НАЙРАМДАХ СИРИ УЛС	1
КАМБОЖИЙН ХААНТ УЛС	2	УНГАР УЛС	1	БҮГД НАЙРАМДАХ НИКАРАГУА УЛС	2	БҮГД НАЙРАМДАХ НЭГДСЭН ТАНЗАНИ УЛС	2
БҮГД НАЙРАМДАХ КАМЕРУН УЛС	4	БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС	29	ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ НИГЕРИ УЛС	2	ТАЙЛАНДЫН ХААНТ УЛС	3
БҮГД НАЙРАМДАХ ЧИЛИ УЛС	3	БҮГД НАЙРАМДАХ ИНДОНЕЗ УЛС	10	ИСЛАМЫН БҮГД НАЙРАМДАХ ПАКИСТАН УЛС	1	БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС	1
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС	4	ЯМАЙКА УЛС	2	БҮГД НАЙРАМДАХ ПАНАМ УЛС	1	БҮГД НАЙРАМДАХ УГАНДА УЛС	1
БҮГД НАЙРАМДАХ КОНГО УЛС	1	БҮГД НАЙРАМДАХ КЕНИ УЛС	2	БҮГД НАЙРАМДАХ ПАРАГВАЙ УЛС	1	УКРАИН УЛС	1
БҮГД НАЙРАМДАХ ХОРВАТ УЛС	1	БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС	3	БҮГД НАЙРАМДАХ ПЕРУ УЛС	9	АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС	48
ДОМИНИКАНЫ БҮГД НАЙРАМДАХ УЛС	1	БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН ЛАОС АРД УЛС	1	БҮГД НАЙРАМДАХ ФИЛИППИН УЛС	45	БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛС	2
БҮГД НАЙРАМДАХ ЭКВАДОР УЛС	2	БҮГД НАЙРАМДАХ ЛИБЕРИ УЛС	1	РУМЫН УЛС	1	БҮГД НАЙРАМДАХ ЗАМБИ УЛС	1
БҮГД НАЙРАМДАХ ЭЛЬ САЛЬВАДОР УЛС	1	БҮГД НАЙРАМДАХ МАЛАВИ УЛС	1	ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС	1	БҮГД НАЙРАМДАХ ЗИМБАБВЕ УЛС	1
ЭРИТРЕЙ УЛС	1	МАЛАЙЗ УЛС	1	БҮГД НАЙРАМДАХ СЛОВАК УЛС	1	Тодорхойгүй	29
ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН ЭТИОП УЛС	5	БҮГД НАЙРАМДАХ МАЛИ УЛС	1	БҮГД НАЙРАМДАХ СЕРБИ УЛС	1		

АНУ дахь хүн худалдаалах гэмт хэргийн гаралт нь 2019 оны байдлаар дараах үзүүлэлттэй байна. Нийт хэргийн гуравны хоёр орчимд хариуцагч нь ажил олгогч хуулийн этгээд байсан.



АНУ-ын 50 муж улсад хүн худалдаалах гэмт хэргийг хүнд гэмт хэрэгт хамааруулсан (2003 онд Вашингтоноос эхэлсэн).

АНУ-ын код (US.Code)-ийн 1584 дүгээр зүйлд Албадан боолчлох зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийг, 1589 дүгээр зүйлд Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийг, 1590 дүгээр зүйлд Насанд хүрсэн хүнийг худалдаалах, боолчлох, албадан эрхшээлдээ байлгах, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг, 1591 дүгээр зүйлд Хүүхдийг бэлгийн зорилгоор эсхүл хүчээр, залилан мэхэлж, албадлага хэрэглэж худалдах гэмт хэргийг тус тус хуульчилсан байна.

Тухайлбал, 1584 дүгээр зүйлд зааснаар хүнийг санаатайгаар албадан боолчлолд байлгасан эсхүл хүнийг худалдсан бол албадан боолчлох зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг гэж үзэж торгох, хорин жилээс илүүгүй хугацаагаар хорих эсхүл аль алинаар шийтгэнэ. Гэмт хэрэг үйлдэхдээ хүний амь нас хохироосон, эсхүл хүн хулгайлах, хүн хулгайлахыг завдсан, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, бэлгийн хүчирхийлэл үйлдэхийг завдсан, амь насыг нь хөнөөхийг завдсан үйлдлээр үйлдсэн бол шүүгдэгчийг торгох, бүх насаар хорих ялаар эсхүл аль алинаар шийтгэнэ. Мөн 1589 дүгээр зүйлд хүний хөдөлмөр, үйлчилгээг дор дурдсан аргуудын аль нэгийг буюу хослуулан ашиглаж, мэдсээр байж олж авсан бол албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг гэж үзнэ.

Үүнд:

- 1) хүч хэрэглэх, хүчээр заналхийлэх, эрх чөлөөг нь хязгаарлах, эрх чөлөөг нь хязгаарлахаар заналхийлэх замаар;
- 2) хүний бие махбодод ноцтой хохирол учруулах, эсхүл ноцтой хохирол учруулахаар заналхийлэх замаар;
- 3) хууль, шүүхийн үйл явцыг урвуулан ашиглах, заналхийлэх замаар; эсхүл
- 4) хэрэв шаардсан ажил, үйлчилгээг хийгээгүй бол тухайн хүн эсхүл өөр хүн ноцтой хохирол амсах эсхүл бие махбодыг нь хязгаарлах шийтгэл оногдуулна гэж ойлгуулах зорилготой аливаа схем, төлөвлөгөө, загвараар.

1590 дүгээр зүйлд зааснаар хүнийг мөлжих зорилгоор аливаа хүнийг элсүүлсэн, байршуулсан, тээвэрлэсэн эсхүл ямар нэгэн аргаар олж авсан бол хүнийг худалдаалах, боолчлох, албадан эрхшээлдээ байлгах, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэг гэж үзэж, торгох эсхүл 20 жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсхүл аль алианаар шийтгэнэ. Энэ зүйлийг зөрчсөний улмаас хүн нас барсан эсхүл тухайн үйлдлийг хийхдээ хүн хулгайлсан, хулгайлахыг завдсан, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, бэлгийн хүчирхийлэл үйлдэхийг завдсан, амь насыг нь хөнөөхийг завдсан гэмт хэрэгт холбогдсон бол торгох эсхүл бүх насаар нь хорих эсхүл аль алианаар шийтгэнэ гэж, 1591 дүгээр зүйлд Хүүхдийг бэлгийн зорилгоор эсхүл хүчээр, залилан мэхэлж, албадлага хэрэглэж худалдах гэмт хэргийг зохицуулсан бөгөөд 25 жилээс ихгүй хорих ял эсхүл торгох ял ногдуулахаар тусгасан байна.

Дээрх АНУ-ын кодоос гадна муж бүр Үндсэн хууль, Эрүүгийн хууль, хууль сахиулах байгууллага бүхий өөр өөрийн эрх зүйн тогтолцоотой учраас муж бүр хүн худалдаалах гэмт хэргийг харилцан адилгүй зохицуулжээ. Тухайлбал, АНУ-ын Калифорни мужийн 2005 онд батлагдсан Эрүүгийн хууль (Penal code)-ийн 8 дугаар хэсгийн 8 дугаар бүлгийн 236 дугаар зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг “албадан хөдөлмөрлүүлэх зорилгоор бусдын хувийн эрх чөлөөг хассан, зөрчсөн этгээдийг хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, улсын хорих ангид 5, 8, 12 жил хорих, таван зуун мянган доллароос (500,000 доллар) илүүгүй торгох ял шийтгэнэ” гэж зохицуулжээ.

Дээр дурдсанаас гадна хүн худалдаалах гэмт хэргийн талаар бусад эрх зүйн зохицуулалтууд үйлчилдэг. АНУ-ын Дотоод аюулгүй байдлын яам (DHS) нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд гаргасан жагсаалтаас дурдвал:

1. 2000 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль
2. 1984 оны Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тухай хууль

3. 2015 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын төлөөх шударга ёсны тухай хууль
4. 1982 оны Хохирогч ба гэрчийг хамгаалах тухай хууль, Pub. L. дугаар 97-291, 96 Стат. 1248 (1982)
5. 1984 оны Гэмт хэргийн хохирогчдын тухай хууль, Pub. L. № 98-473, 98 Стат. 2170 (1984)
6. Эрүүгийн шүүхийн тогтолцоонд гэмт хэргийн хохирогч, гэрчтэй харьцах холбооны удирдамж, 18 U.S.C. § 1512 (1984)
7. 1990 оны Хүүхдийн хүчирхийллийн хохирогчдын тухай хууль, Pub. L. No 101-647 (1990)
8. 1990 оны Хохирогчийн эрх ба нөхөн төлбөрийг олгох тухай хууль, 34 U.S. § 20141 (2006)
9. 2004 оны Гэмт хэргийн хохирогчдын эрхийн тухай хууль, 18 U.S.C. § 3771 (2006 & III дугаар 2009)
10. АНУ-ын Хууль зүйн яам, Ерөнхий прокурорын хохирогч болон гэрчүүдэд туслах заавар (2023)
11. U.S.C. § 1232, Хүүхэд худалдаалахтай тэмцэх хүчин чармайлтыг нэмэгдүүлэх<sup>42</sup> зэрэг.

Дотоод аюулгүй байдлын яам нь хүн худалдаалах гэмт хэргээс гадна залилан, хар тамхины наймаа, хүн хууль бусаар хил нэвтрүүлэх, мөнгө угаах, визний залилан, хүүхдийн бэлгийн хүчирхийлэл, муж хоорондын биеэ үнэлэлт, хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах зэрэг гэмт хэрэгт эрүүгийн мөрдөн байцаалт явуулдаг.

Монгол Улсын хувьд хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой нарийвчилсан нэг хууль буюу 2012 онд батлагдсан “Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль” хүчин төгөлдөр үйлчилж байна. Харин АНУ-ын хувьд холбогдолтой эрх зүйн акт олон төрлөөр байдаг нь сайн жишиг болж байна. Иймд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалахтай холбоотой нарийвчилсан хууль журмыг батлах замаар эрх зүйн орчныг сайжруулах боломж байна.

## **1. Хохирогчид нөхөн олговор олгох эрх зүйн зохицуулалтын салбар буюу эрүү, иргэн, хөдөлмөрийн хуулийн журмаар нөхөн олговор олгох ажиллагааны онцлог, зохицуулалт**

Хүн худалдаалах гэмт хэргийг үйлдсэн, үйлдэхийг дэмжсэн, ашиг тусыг нь хүртсэн этгээдийн эсрэг дараах тохиолдолд иргэний нэхэмжлэл гаргаж болно.

1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон;

<sup>42</sup> Human Trafficking Laws & Regulations, <https://www.dhs.gov/human-trafficking-laws-regulations>.



2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон насанд хүрээгүй хүүхдийн эцэг эх;
3. Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас гэр бүлийн гишүүнээ алдсан хүн.

Конгресс 2003 онд Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах тухай хуулийг<sup>43</sup> баталсан бөгөөд энэ нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг "элсүүлэх, нуух, тээвэрлэх, тухайн нөхцөл байдлаар хангах, олж авах, дэмжих, ятгах" зэргээр хүн худалдаалах үйл ажиллагаанд оролцсон бүх хүмүүсийн эсрэг холбооны шүүхэд иргэний нэхэмжлэл гаргах боломжийг олгодог. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах талаар олон төрлийн хууль, эрх зүйн актууд АНУ-ын хэмжээнд үйлчилдэг. Тэдгээрээс 2003 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль (TVPA) нь гол эх сурвалж юм.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх төвийн нийтэлсэн тайланд дурдсанаар, сүүлийн 15 жилийн хугацаанд холбооны шүүхэд иргэний нэхэмжлэлээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирлыг нэхэмжилсэн хэргийн тоо тогтмол өссөн байна. 2017 оныг 2004 онтой харьцуулахад 6 дахин ихэссэн<sup>44</sup>.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрх, хохирогчид нөхөн олговор олгох талаар дараах хууль, эрх зүйн актууд АНУ-ын хэмжээнд үйлчилдэг.

### **Ану-ын код журам (US.code)**

- 77 дугаар бүлэг. Хүнийг хүн худалдаах, боолчлох, худалдах
- 78 дугаар бүлэг. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах

### **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль (TVPA)**

- 2000 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах тухай хууль, Pub. L. No 106-386 (2000 оны 10 дугаар сарын 28)
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай 2003 оны шинэчилсэн хууль, Pub. L. No 108-193 (2003 оны 12 дугаар сарын 19)

<sup>43</sup> Trafficking Victims Protection Reauthorization Act, 2003, <https://www.congress.gov/bill/108th-congress/house-bill/2620>.

<sup>44</sup> Human Trafficking Civil Cases & Personal Injury Lawsuits, [https://www.enjuris.com/blog/resources/human-trafficking-civil-lawsuits/?fbclid=IwAR3mFZV32GPd6xNAqin9BetSLykKQvqiX2ZQ8rzEPGzHF-ETQKGzniZi7JM\\_aem\\_AeFMgL5gnWzsHlqtggqVPpWKW6Y\\_7vGNI3WY4ehXW9RkdSIthADl-IRVF1aB1ZPDXDhAGikJPvA6i6hsoH6fs76L](https://www.enjuris.com/blog/resources/human-trafficking-civil-lawsuits/?fbclid=IwAR3mFZV32GPd6xNAqin9BetSLykKQvqiX2ZQ8rzEPGzHF-ETQKGzniZi7JM_aem_AeFMgL5gnWzsHlqtggqVPpWKW6Y_7vGNI3WY4ehXW9RkdSIthADl-IRVF1aB1ZPDXDhAGikJPvA6i6hsoH6fs76L).

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай 2005 оны шинэчилсэн хууль, Pub. L. No 109-164 (2006 оны 1 дүгээр сарын 10)
- Уильям Вилберфорс Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль 2008, Pub. L. No 110-457 (2008 оны 12 дугаар сарын 23)
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар шинэчилсэн хууль 2013, Pub. L. No 113-4, гарчиг хii (2013 оны 3 дугаар сарын 7)
- 2017 оны Хүн худалдаалах гэмт хэргийн тухай хуулийг хүчингүй болгох, Pub. L. No 115-392 (2018 оны 12 дугаар сарын 21)
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль 2017, Pub. L. No 115-393 (2018 оны 12 дугаар сарын 21)
- Фредерик Дугласс Хүн худалдаалах гэмт хэргээс хохирогчийг урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай хууль 2018, Pub. L. No 115-425 (2019 оны 1 дүгээр сарын 8)
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль 2017, Pub. L. No 115-427 (2019 оны 1 дүгээр сарын 9)

### **Хохирогчийн эрхийн хамгаалалттай холбоотой хууль**

- 1982 оны Хохирогч ба гэрчийг хамгаалах тухай хууль, Pub. L. дугаар 97-291, 96 Стат. 1248 (1982)
- 1984 оны Гэмт хэргийн хохирогчдын тухай хууль, Pub. L. № 98-473, 98 Стат. 2170 (1984)
- Эрүүгийн шүүхийн тогтолцоонд гэмт хэргийн хохирогч, гэрчтэй харьцах холбооны удирдамж, 18 U.S.C. § 1512 (1984)
- 1990 оны Хүүхдийн хүчирхийллийн хохирогчдын тухай хууль, Pub. L. No 101-647 (1990)
- 1990 оны Хохирогчийн эрх ба нөхөн төлбөрийг олгох тухай хууль, 34 U.S. § 20141 (2006)
- 2004 оны Гэмт хэргийн хохирогчдын эрхийн тухай хууль, 18 U.S.C. § 3771 (2006 & III дугаар 2009)
- АНУ-ын Хууль зүйн яам, Ерөнхий прокурорын хохирогч болон гэрчүүдэд туслах заавар (2023)

Мөн АНУ-ын мужуудад нөхөн төлбөрийг олгох тусгайлсан хуулиуд үйлчилдэг байна. Гэвч холбооны улсын хувьд нөхөн төлбөр олгох харилцааг нарийвчлан зохицуулсан нийтлэг хэм хэмжээ байхгүй байна.

АНУ-ын хувьд хүн худалдаалах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах, бууруулахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх талаар тусгайлсан олон төрлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг нь хохирогчийн эрхийг хамгаалдаг сайн жишиг болж байна.

АНУ-ын хууль тогтоогчид хүн худалдаалах гэмт хэргийн

хохилогчдыг шүүх эрх мэдлийн хүрээнд хамгаалах хэд хэдэн эрүүгийн хамгаалалт, иргэний эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан. Хууль тогтоогчид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод санхүүгийн хувьд дэмжлэг үзүүлэх дараах механизмуудыг бий болгосон.

### 1.1. Иргэний журмаар хохирол төлүүлэх ажиллагаа

Иргэний эрх зүйн хамгаалалтыг ашиглаж болно. Өөрөөр хэлбэл, хохирогчид учирсан хохирлыг иргэний журмаар нөхөн сэргээх боломжийг олгодог. Мужийн хуулиудад гэмт хэрэгтний эсрэг гаргаж болох иргэний нэхэмжлэлийн талаар заасан байдаг.

### 1.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хохирол нөхөн төлүүлэх

ЭХХША-ны явцад нөхөн төлбөр гаргуулах боломжтой. Эрүүгийн процессын явцад хүн худалдаалах гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдээс хохирогчид учирсан хохирлыг төлөхийг шаардаж болно

### 1.3. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хохирол нөхөн төлүүлэх

Тус улсын Хөдөлмөрийн шударга стандартын тухай хуулийн дагуу цалин хөлсөө тооцож, эрүү, иргэний шүүхээр нэхэмжилж болно.

Холбооны Засгийн газраас санхүүжүүлэх олон хөтөлбөрийн дагуу хохирогч олон төрлийн үйлчилгээнд хамрагдах боломжтой. Тухайлбал, орон байраар хангуулах, эмнэлгийн үйлчилгээ авах, зөвлөгөө, үйлчилгээ авах гэх мэт.

Монгол Улсын зохицуулалтыг авч үзвэл Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шүүхээс хохирлыг нөхөн төлүүлж болохоос гадна шүүхийн шийдвэр гарсны дараа иргэний журмаар тусад нь нөхөн төлүүлэх боломжийг олгосон. Мөн түүнчлэн Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн дагуу хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг авч болохоор хуульчилсан. АНУ-ын тухайд дээрх журмуудаар хохирлыг нөхөн төлүүлэх зохицуулалт байна<sup>45</sup>.

## **2. Нөхөн төлбөрийн буюу хохирлын хэлбэр: эдийн ба эдийн бус хохирол (ёс суртахууны хохирол), нөхөн төлбөрийн хэмжээ, түүнийг тогтоох, үнэлэх нь:**

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид эдийн засгийн болон

<sup>45</sup> Human Trafficking State Laws, <https://www.ncsl.org/civil-and-criminal-justice/human-trafficking-state-laws>

эдийн засгийн бус хохирлыг олгодог ба ихэнх тохиолдолд хохирлыг иргэний нэхэмжлэлээр авдаг байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь санхүүгийн нөхөн олговроос гадна хүн худалдаалах гэж буй хүмүүст саад хийх, бусад хохирогчдыг чадавхжуулах, мөрдөн шалгалтын явцад бусад хохирогч, гэмт хэрэг үйлдэгчдийг илрүүлэх зэрэг давуу талтай<sup>46</sup>.

### **Эдийн засгийн хохирол**

Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас учирсан санхүүгийн хохирлыг барагдуулах ёстой. Эдийн засгийн хохирол гэдэг нь нөгөө талын хайхрамжгүй байдлаас болж хэн нэгэнд учирсан шууд санхүүгийн хохирол юм. Эдийн засгийн хохирол нь мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх бөгөөд эдийн засагч эсвэл бусад ижил төстэй санхүүгийн мэргэжилтнүүд үнэлэн тогтооно. Эдийн хөрөнгийн алдагдлаас гадна олох ёстой байсан цалин хөлс үүнд хамаарна. Хөдөлмөрийн шударга стандартын тухай хууль (Fair Labor Standards Act)-д заасны дагуу олох ёстой цалин хөлсөө нэхэмжлэх боломжтой.<sup>47</sup>

Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас учирсан нийтлэг эдийн засгийн хохиролд дараах зүйлс орно.

- Цалин хөлс, орлого;
- Түрээс, амьжиргааны зардал, тээврийн зардал;
- Татвар эсвэл нийгмийн даатгалын "төлбөр";
- Ажилд зуучлах, ажилд зуучлах агентлагт төлсөн хууль бус төлбөр;
- Хууль бусаар хил нэвтрүүлэх буюу тээвэрлэсэн зардал;
- Эмнэлгийн зардал гэх мэт.

### **Эдийн засгийн бус хохирол**

Хүн худалдаалах гэмт хэрэг нь орчин үеийн боолчлолын нэг төрөл бөгөөд албадан хөдөлмөрлөлт өртөж буй хүмүүст онцгой хэмжээний өвдөлт, зовлон зүдгүүрийг авчирдаг гэж үздэг. Эдийн засгийн бус хохирол олгогдоход харгалзан үзэх хүчин зүйлсийг дурдвал:

- Нийгмийн харилцаанд хэвийн, бие даан оролцох чадвар;
- Сэтгэл зүйн гэмтэл;
- Амьдралын таашаал алдагдах зэрэг<sup>48</sup>

<sup>46</sup> Human Trafficking Civil Cases & Personal Injury Lawsuits, [https://www.enjuris.com/blog/resources/human-trafficking-civil-lawsuits/?fbclid=IwAR3mFZV32GPd6xNAqin9BetSLyKkQvqiX2ZQ8rzEPGzHF-ETQKGzniZi7JM\\_aem\\_AeFMgL5gnWzsHlqtggqVPpWKW6Y\\_7vGNI3WY4ehXW9RkdSItHADI-IRVF1aB1ZPDxDhAGikJPvA6i6hsoH6fs76L](https://www.enjuris.com/blog/resources/human-trafficking-civil-lawsuits/?fbclid=IwAR3mFZV32GPd6xNAqin9BetSLyKkQvqiX2ZQ8rzEPGzHF-ETQKGzniZi7JM_aem_AeFMgL5gnWzsHlqtggqVPpWKW6Y_7vGNI3WY4ehXW9RkdSItHADI-IRVF1aB1ZPDxDhAGikJPvA6i6hsoH6fs76L)

<sup>47</sup> Lee Ann Dunbar, Getting Restitution into the Hands of Trafficking Victims, 2024, <https://blog.dol.gov/2024/01/29/getting-restitution-into-the-hands-of-trafficking-victims>

<sup>48</sup> Damages in Florida Human Trafficking Lawsuits February 3, 2021 | Attorney, Matthew Dolman, <https://www.dolmanlaw.com/blog/human-trafficking-lawsuit-damages/>

Эдийн бус хохирлын зохих хэмжээний талаар тангарагтны шүүх өөр өөр дүгнэлт хийж болно. Илүү хийсвэр, субъектив шинж чанартай тул эдийн бус хохирол нь олон муж, улсад хохирлын нөхөн олговрын талаарх дээд хэмжээг гэмтлийн төрлөөс хамааран хуульчилсан байдаг. Ихэнх муж, улсад хүн гэмтсэн тохиолдолд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх хязгаар гэж байхгүй, харин эмнэлгийн буруутай үйлдлээс болж хүн хохирсон тохиолдолд эдийн бус хохирлын хэмжээ хязгаарыг тогтоон нөхөн төлбөрийг барагдуулдаг. Тухайлбал, эмнэлгийн буруутай үйл ажиллагааны улмаас хохирсон тохиолдолд олон мужууд 250,000-750,000 ам.доллар ба түүнээс дээш долларын хооронд хязгаар тогтоодог байна.

Иллинойс мужийн Дээд шүүх 1997 оны Best and Taylor Machine Works-ийн хэрэгт<sup>49</sup> эдийн бус хохирлыг 500,000 ам.доллаар тогтоосон байна. Энэ нь хохирогч хөдөлмөрийн чадвараа алдсан буюу хамгийн хүнд хохирол буюу насан туршдаа хөдөлмөрийн чадвараа алдахад олгох нөхөн төлбөрийн хэмжээ юм гэдгийг шүүхээс тогтоожээ.

### ***Шийтгэлийн нөхөн төлбөр /punitive damage/***

Бусад хохирлоос ялгаатай нь хохирогчид учирсан хохирлыг барагдуулахгүй, харин гэмт хэрэгтний үйлдэл нь харгис хэрцгий байсан тохиолдолд шүүгдэгчид энэ төрлийн нөхөн төлбөр төлөх үүргийг оногдуулдаг. Энэ нь шүүгдэгч болон бусад хүмүүсийг ирээдүйд ижил төстэй үйлдэл хийхээс урьдчилан сэргийлэх зорилготой юм<sup>50</sup>.

Флоридагийн Дээд шүүх 1994 онд WR Grace & Co v. Уотерс хэргийн тухайд гаргасан шийдвэртээ шүүгдэгчийн зан авир нь залилан мэхэлсэн, хорлонтой, санаатайгаар хүчирхийлсэн, дарамталсан эсвэл бусдын эрхийг үл тоомсорлож буйг илтгэх бүдүүлэг хайхрамжгүй үйлдэл хийсэн тохиолдолд шийтгэлийн хохирол ногдуулах боломжтой гэж үзсэн. Шүүх дээрх шийдвэрт нэг шүүгдэгчээс ижил зан үйлийн улмаас хохирлыг барагдуулах тухай хэд хэдэн нэхэмжлэлийг үндэслэлтэй гэж үзсэн<sup>51</sup>.

Монгол Улсын хувьд Хүн худалдаалах гэмт хэрэгт эдийн засгийн хохирол учирсан тохиолдолд түүнийг барагдуулдаг. Мөн сүүлийн үед эдийн бус хохирлыг барагдуулах эрх зүйн орчин үүсээд байна. АНУ-ын тухайд эдийн засгийн болон эдийн бус хохирлыг нарийвчлан тодорхойлж тооцох аргачлалыг өргөн хүрээнд авч үздэг болох нь тодорхойлогдож байна. Түүнчлэн шийтгэлийн хохирол (punitive damage)-ыг гэмт хэрэгтэнд оногдуулж хохирлыг барагдуулдаг нь тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн арга байна.

<sup>49</sup> Best v. Taylor Mach. Works, 689 NE 2d 1057 - Ill: Supreme Court 1997.

<sup>50</sup> Punitive Damages, <https://injury.ansaralaw.com/punitive-damages.html>

<sup>51</sup> Punitive Damages, <https://injury.ansaralaw.com/punitive-damages.html>

## **Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, үнэлэх тухайд**

### **1. Шийтгэлийн нөхөн төлбөр (punitive damage) 18 U.S.C. § 1595**

Шийтгэлийн нөхөн төлбөрийг шүүхийн жишгээр тогтоож байна.

Дитуллио э. В.Боем хэргийн тухайд 2008 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуульд шийтгэлийн нөхөн төлбөр шаардах үндэслэлийг тавьсан. Энэ хэрэгт есдүгээр тойргийн шүүхээс тус зохицуулалтыг ашигласан. Шүүгдэгчийг эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 2005 онд хүчирхийлэл үйлдэхийг завдсан хэрэгт буруутгаж, 135 сарын хорих ялаар шийтгэсэн. Шийтгэлийн нөхөн төлбөрийн хэмжээг хохирол нөхөн төлүүлсэн хэмжээтэй тэнцүү байхаар тогтоосон. Гэсэн хэдий ч зарим шүүх үүнээс хамаагүй илүү дүнгээр шийдвэр гаргасан. Рое э. Ховардын хэргийн хувьд тангарагтнууд “Хэрэв нэхэмжлэгч нь хариуцагчийн үйлдэл зүгээр ч нэг үндэслэлгүй бус хорлонтой, болгоомжгүй байсныг нотлох баримтаар нотолсон тул” шийтгэлийн нөхөн төлбөр олгохыг даалгасан. Тангарагтны шүүгчид нөхөн төлбөрийг хоёр дахин нэмэгдүүлэн нийт 3,000,000 долларыг шийтгэлийн нөхөн төлбөрт олгохоор шийдвэрлэсэн.

### **2. Хөдөлмөрийн шударга стандартын тухай хуулийн дагуу тооцох хохирол (FLSA)**

Шүүхүүд 18-аас доош насны хохирогчтой албадан хөдөлмөр, албадан боолчлолын хэргүүдийн хохирлыг тооцоходоо Хөдөлмөрийн шударга стандартын хуулийг тогтмол ашигладаг. §1595. Уг хуулийн дагуу 1 цагийн хөдөлмөрийн хөлс 7.95 ам доллар байх бөгөөд илүү цагаар ажилласан цагийг тооцоходоо 1-1.5 дахин нэмэгдүүлнэ.<sup>52</sup> Гэвч нэхэмжлэгч, хариуцагчийн хооронд хөдөлмөрийн харилцаа үүссэн тохиолдолд л дээрх хууль үйлчилнэ.

### **3. Сэтгэл санааны хохирол**

Сэтгэл санааны хохирлыг тооцоход өдрөөр тооцох (per diem method) арга болон нэмэгдүүлэх арга (multiplier method) зэрэг 2 үндсэн аргыг ашиглах нь бий. Эхний арга нь тодорхой дүнгээр сэтгэл санааны шаналалд автсан өдөр бүрээр тооцдог. Тухайлбал, Калифорни мужид хуульч нар хохирогчийн өдөрт олгох сэтгэл санааны хохирлын хэмжээг 100-200 ам доллароор үнэлдэг байна.<sup>53</sup> Хоёр дахь аргын хувьд эдийн

<sup>52</sup> Wages and the Fair Labor Standards Act, [https://www.dol.gov/agencies/whd/flsa#:~:text=The%20Fair%20Labor%20Standards%20Act%20\(FLSA\)%20establishes%20minimum%20wage%2C.%2C%20State%2C%20and%20local%20governments](https://www.dol.gov/agencies/whd/flsa#:~:text=The%20Fair%20Labor%20Standards%20Act%20(FLSA)%20establishes%20minimum%20wage%2C.%2C%20State%2C%20and%20local%20governments)

<sup>53</sup> The Ryan Law Group, How To Calculate Pain And Suffering In California, <https://theyanlawgroup.com/how-to-calculate-pain-and-suffering-in-california/>

хохирлыг 1.5-5 дахин нэмэгдүүлж олгох арга юм.<sup>54</sup>

Шүүхүүд сэтгэл санааны хохирлыг тооцохын тулд сэтгэл санааны зовиурын үргэлжлэх хугацаа, хэр хэмжээ болон "ижил төрлийн хэргийн нөхөн төлбөрийн дүн"-г харгалзан үздэг. Муж улсуудын хувьд нийгмийн харилцаанд хэвийн оролцож чадахгүй болсон өдрийн тоогоор 171-800 долларын хооронд нөхөн төлбөр тооцож олгох тогтолцоо байна. Зарим шүүхүүд нэг удаагийн төлбөрийг олгуулахаар шийдвэрлэх нь бий<sup>55</sup>. Жишээлбэл, Иллинойс мужийн Дээд шүүх 1997 оны Best and Taylor Machine Works-ийн хэрэгт эдийн бус хохирлыг 500,000 ам.доллараар тогтоосон байна.

Гэмт хэргийн хохирогчид төрөөс санхүүгийн туслалцаа үзүүлэх сангийн үйл ажиллагаа тус улсад сайн хөгжсөн. Муж улс гэмт хэргийн хохирогч нөхөн олговор олгох сантай байх бөгөөд түүнээс олгох дээд хэмжээ, аргачлал нь харилцан адилгүй. Тухайлбал Калифорния муж 70000 ам доллар хүртэлх нөхөн олговрыг олгодог.<sup>56</sup>

АНУ-ын муж улс бүр гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох улсын сан, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилладаг. Тухайлбал, Техас мужийн хувьд Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тухай хуулийн дагуу Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөр (Crime Victims' Compensation Program)<sup>57</sup> 1997 оноос хойш хэрэгжсэн бөгөөд тус муж улсад үйлдэгдсэн эсхүл тус муж улсын иргэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон бөгөөд гэмт хэргийн улмаас бие махбод, сэтгэцийн эрүүл мэндэд хохирол учирсан бол гэмт хэрэг үйлдэгдсэнээс 3 жилийн дотор дээр дурдсан муж улсын хөтөлбөрөөс нөхөн олговор авахаар хүсэлт гаргаж болно. Тус хөтөлбөрийн дагуу хэд хэдэн гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор, санхүүгийн туслалцаа үзүүлдэг бөгөөд түүний нэг нь хүн худалдаалах гэмт хэрэг юм. 2023 онд тус сангаас хүн худалдаалах гэмт хэргийн 70<sup>58</sup> хохирогч нөхөн олговор олгох хүсэлтийг ирүүлснээс 12 хохирогчид нийт 21,269.09 ам.долларын нөхөн олговор олгожээ.<sup>59</sup> Хөтөлбөрийн дагуу дараах нөхөн олговрыг хохирогчид эсхүл түүнийг гэр бүлийн гишүүнд олгоно. Үүнд:<sup>60</sup>

<sup>54</sup> Perenich, Caulfield, Avril & Noyes Personal Injury Lawyers, The Two Calculation Methods for Pain and Suffering Damages, <https://usalaw.com/personal-injury-resources/how-are-pain-and-suffering-damages-calculated/>

<sup>55</sup> Alexandra F. Levy, Federal Human Trafficking Civil Litigation: 15 Years of the Private Right of Action, The Human Trafficking Legal Center (December 2018), <https://www.htlegalcenter.org/wp-content/uploads/Federal-Human-Trafficking-Civil-Litigation-1.pdf>

<sup>56</sup> California Victim Compensation Board, Recovery From Human Trafficking, <https://victims.ca.gov/for-victims/victims-of-human-trafficking/>

<sup>57</sup> Attorney General of Texas, Eligibility for Crime Victims' Compensation Program, <https://www.texasattorneygeneral.gov/crime-victims/crime-victims-compensation-program/eligibility-crime-victims-compensation-program>

<sup>58</sup> Crime Victim Services 2023 Annual Report, <https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/annual-reports/23106-CVS-Annual-Report-2023-4.pdf>

<sup>59</sup> Crime Victim Services 2023 Annual Report, <https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/annual-reports/23106-CVS-Annual-Report-2023-4.pdf>

<sup>60</sup> Texas Crime Victims' Compensation Program Quick Reference Chart, 2016, [https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/CVC\\_QuickReferenceGuide.pdf](https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/CVC_QuickReferenceGuide.pdf)

- Оршуулгын зардал. Үүнд оршуулах ажиллагааны зардалд 6500 ам доллар хүртэл, унааны зардалд 6500 ам доллар хүртэл, оршуулгын улмаас ажилдаа явж чадаагүй 10 хүртэлх өдрийн цалин хөлсийг 1400 ам доллар хүртэл.
- Эмнэлгийн зардлыг учирсан хэмжээгээр.
- Сэтгэл зүйн зөвлөгөөний зардлыг 60 удаагийн уулзалт хүртэлх төлбөрөөр.
- Олох ёстой байсан цалин хөлс долоо хоногт 700 ам.доллараар тооцно.
- Тэжээгчээ алдсаны тэтгэмжийг долоо хоногт 700 ам доллар хүртэл.
- Асаргааны зардлыг долоо хоногт 100 ам.доллар, нийт 52 долоо хоног хүртэл.
- Гэмт хэргийн газрыг цэвэрлэх зардлыг 2000 доллар хүртэл.
- Нотлох баримтаар хураагдсан эд юмсын үнэ 1000 доллар хүртэл.
- Түрээс, нүүлгэн шилжүүлэлтийн зардал. Гагцхүү бэлгийн хүчирхийлэл эсхүл хууль бусаар мөрдөх гэмт хэргийн тохиолдолд нүүлгэн шилжүүлэлтэд 2000 хүртэл, түрээсийн төлбөрт 3 сарын нийтдээ 1800 доллар хүртэл.
- Өмгөөлөгчийн хөлс. Үүнд энэхүү сангаас нөхөн төлбөр авахаар хүсэлт гаргах хүсэлт боловсруулах үйлчилгээ авсны төлбөрийг 300 ам доллар хүртэл.
- Тээврийн зардал. Үүнд эмчилгээ хийлгэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох гэх мэт шалтгааны улмаас үүссэн тээврийн зардлыг бодит хэмжээгээр.
- Хөдөлмөрийн чадвараа алдсаны улмаас шаардлагатай болсон орчны засварын үнэ. Тухайлбал орон гэрт хийсэн шаардлагатай засвар.
- Хөдөлмөрийн чадвараа алдсаны улмаас шаардлагатай болсон туслах хэрэгслийн үнэ. Тухайлбал тэргэнцрийн үнэ зэргийн үнийг 75000 доллар хүртэл.
- Хөдөлмөрийн чадвараа алдсаны улмаас үүссэн сургалт, зөвлөгөө, үйлчилгээний зардал (75000 доллар хүртэл)
- Хөдөлмөрийн чадвараа алдсаны улмаас алдсан олох ёстой байсан цалин хөлс. 7 хоногт 500 доллар, нийт 75000 доллар.
- Хөдөлмөрийн чадвараа алдсаны улмаас үүссэн байнгын эмчилгээ, үйлчилгээний зардал. Тухайлбал, гэрээр хийх эмчилгээний зардал, сувилагчийн зардлыг 75000 доллар хүртэл нөхөн олгоно.

Нөхөн олговрын хүсэлтийг<sup>61</sup> Улсын ерөнхий прокурорын газрын

<sup>61</sup> Texas Crime Victims' Compensation Program Application, <https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/Printed%20CVC%20Application.pdf>



Гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх хэлтэс хүлээн авна. Хүсэлт гаргаж буй зардал бүрд бүрдүүлэх материалыг нарийн тодорхой заасан байдаг.<sup>62</sup> Нөхөн олговор олгохоос татгалзсан шийдвэрт гомдол гаргах боломжтой.<sup>63</sup> Тус хөтөлбөрийн хүрээнд сэтгэцийн өвчин, шаналалд нөхөн олговор олгохгүй гэж заасан байна.<sup>64</sup>

### **3. Насанд хүрээгүй хохирогчид тусгайлсан эрх зүйн зохицуулалттай эсэх**

2018 онд АНУ-д хүн худалдаалах гэмт хэргийн талаас илүү хувь нь (51.6%) нь зөвхөн хүүхдүүдтэй холбоотой бэлгийн мөлжлөгийн хүн худалдаалах хэргүүд байжээ<sup>65</sup>. АНУ-ын код болон 2008 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуульд насанд хүрээгүй хохирогчидтой гэмт хэргийг хянах, хохирогчид дэмжлэг үзүүлэх хэд хэдэн заалтууд байдаг. Гэхдээ нөхөн төлбөр өгөх, хохирол барагдуулах тал дээр тухайлсан хууль байдаггүй.

2022 оны санхүүгийн жилд Хууль зүйн яамнаас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх тусламжийн хөтөлбөрийг АНУ даяар зохион байгуулж хүүхдийн албадан хөдөлмөр эрхлэлтийн хохирогчдыг дэмжих үйлчилгээнд 1.3 сая долларын, хүүхдийн бэлгийн гэмт хэргийн хохирогчийн асуудлыг шийдвэрлэхэд 6.3 сая долларын, хохирогч хүүхдүүдэд үзүүлэх үр дүнг сайжруулахад бараг 5.5 сая долларын<sup>66</sup> дэмжлэгийг үзүүлсэн байна.

Мөн өмгөөлөгчид хүүхдийн хөдөлмөр эрхэлдэг төрийн байгууллагуудаас хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн хохирогчдыг илүү сайн илрүүлж, дэмжихийг шаардахын тулд холбооны хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахын зэрэгцээ бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсвэл өртөх эрсдэл өндөр байгаа хүүхдүүдэд анхаарлаа хандуулахыг уриалж байна.<sup>67</sup>

### **4. Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллээр хангагдах эрх буюу мэдээлэл өгөх талаар үүрэгжүүлсэн эрх зүйн зохицуулалт**

АНУ-ын код журам (US.Code)-ийн 7105 дугаар зүйлийн b хэсгийн 2

<sup>62</sup> Texas Crime Victims' Compensation Program Quick Reference Chart, 2016.

[https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/CVC\\_QuickReferenceGuide.pdf](https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/CVC_QuickReferenceGuide.pdf)

<sup>63</sup> Appeals Process of the Crime Victims' Compensation Program (CVC).

[www.texasattorneygeneral.gov/crime-victims/crime-victims-compensation-program/appeals-process](http://www.texasattorneygeneral.gov/crime-victims/crime-victims-compensation-program/appeals-process)

<sup>64</sup> Texas Crime Victims' Compensation Program Application.

<https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/Printed%20CVC%20Application.pdf>

<sup>65</sup> U.S. Is a Top Destination for Child Sex Trafficking, and It's Happening in Your Community,

<https://www.heritage.org/crime-and-justice/commentary/us-top-destination-child-sex-trafficking-and-its-happening-your>

<sup>66</sup> Improving Outcomes for Child and Youth Victims of Human Trafficking program,

[https://ovc.ojp.gov/funding/opportunities/o-ovc-2022-171313?utm\\_medium=email&utm\\_source=govdelivery](https://ovc.ojp.gov/funding/opportunities/o-ovc-2022-171313?utm_medium=email&utm_source=govdelivery)

<sup>67</sup> 2023 Trafficking in Persons Report: United States, <https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/united-states>

дахь хэсэгт хохирогчийн мэдээлэл авах эрхийг “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид өөрсдийн эрх, орчуулгын үйлчилгээний талаарх мэдээлэл авах боломжтой. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид боломжийн хэрээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг, холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй эсвэл хүн худалдаалахтай тэмцэх хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг авах боломжийг олгох ёстой.”<sup>68</sup> гэж хуульчлан баталгаажуулж өгсөн байна.

## **5. Гэмт хэрэгтнээр хохирол төлүүлэх зорилгоор эд хөрөнгийг нь хураах эрх зүйн зохицуулалт**

Эд хөрөнгө хураах нь үндсэндээ иргэний <sup>69</sup> болон эрүүгийн журмаар<sup>70</sup> гэсэн хоёр хэлбэртэй байдаг. Иргэний журмаар эд хөрөнгийг хураах нь ялаас шалтгаалахгүй бөгөөд ихэнхдээ эрүүгийн хэрэг үүсгээгүй тохиолдолд ч биелүүлж болно. Нотлох баримтын стандарт нь доогуур байдаг. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотойгоор иргэний журмаар эд хөрөнгийг хураахыг тусгайлан заасан АНУ-ын 12 муж улс байдаг. Иргэний журмаар эд хөрөнгийг хураах тусгай журам нь муж бүрд харилцан адилгүй. Иргэний журмаар эд хөрөнгийг хураахын тулд прокуророос тогтоол гаргах, өмчлөгчид мэдэгдэх, хариуцагч хариу өгөх, шийдвэрийг сонсгох шаардлагатай.

Харин эрүүгийн журмаар эд хөрөнгө хураах нь зөвхөн ял шийтгэл хүлээсний дараа л авах боломжтой бөгөөд түүнийг ял оногдуулах болон эд хөрөнгө хураах асуудлыг тус бүрд нь шүүх хуралдааны үеэр нэхэмжилдэг ба хураах эд хөрөнгө нь эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсэг байсныг нотлох шаардлагатай. Прокурорууд гэмт хэрэгтний эд хөрөнгийг эрүүгийн журмаар хураан авах замаар олж авах боломжтой. Эрүүгийн журмаар эд хөрөнгийг хураах нь эрүүгийн гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө шүүхээр шийтгүүлсэн хүнд оногдуулах ялын нэг хэсэг юм.

Шүүхийн шийдвэр гарсны дараа хураан авах шийдвэр гаргахад эдгээр хөрөнгийг хаана хуваарилахыг хуулиар зааж өгдөг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэгэн адил эд хөрөнгө, борлуулалтаас олсон орлого нь хохирогчид нөхөн төлөх, улсын бүртгэлтэй хохирогчийн санд эсхүл мөрдөн байцаалт, яллах ажиллагаанд оролцдог төрийн байгууллагын үйл ажиллагаанд зарцуулагдаж болно.<sup>71</sup>

<sup>68</sup> 22 U.S. Code § 7105 - Protection and assistance for victims of trafficking, <https://www.law.cornell.edu/uscode/text/22/7105>

<sup>69</sup> 18 U.S. Code § 983 - General rules for civil forfeiture proceedings, <https://www.law.cornell.edu/uscode/text/18/983>

<sup>70</sup> 18 U.S. Code —Crimes and criminal procedure, [https://www.law.cornell.edu/rules/frcrmp/rule\\_32.2](https://www.law.cornell.edu/rules/frcrmp/rule_32.2)

<sup>71</sup> Hitting Them Where It Hurts: Strategies for Seizing Assets in Human Trafficking Cases By Charlene Whitman, JD, <https://aequitasresource.org/wp-content/uploads/2018/09/Hitting-Them-Where-it-Hurts-Strategies-for-Seizing-Assets-in-Human-Trafficking-Cases.pdf>

Эрүүгийн эд хөрөнгийг хураах нь тухайн нөхцөл байдал, харьяаллын хууль тогтоомжоос хамааран ял оногдуулах эсвэл хураах тухай тусдаа шүүх хурлын үеэр тогтоогддог. Эрүүгийн эд хөрөнгийг хураах хууль тогтоомжийн гол зорилго нь шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэнийх нь төлөө шийтгэх явдал юм. Эд хөрөнгийн хэмжээ нь шүүгдэгчийн гэм буруутайд тооцогдсон тодорхой гэмт хэрэгтэй холбоотой байх ёстой. Шүүхийн шийдвэр гарсны дараа хураан авах шийдвэр гаргахад эдгээр хөрөнгийг хаана хуваарилахыг хуулиар зааж өгдөг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэгэн адил эд хөрөнгө, борлуулалтаас олсон орлого нь хохирогчид нөхөн төлөх, улсын бүртгэлтэй хохирогчийн санд эсвэл мөрдөн байцаалт, яллах ажиллагаанд оролцдог төрийн байгууллагуудад зарцуулагдаж болно<sup>72</sup>.

АНУ-ын дараах 16 муж нь хүн худалдаалах гэмт хэргийн улмаас эд хөрөнгийг хураах талаар тусгайлсан хуультай. Эдгээр нь Алабама, Калифорни, Коннектикут, Колумбийн дүүрэг, Хавай, Иллинойс, Мэрилэнд, Массачусетс, Миссисипи, Нью Хэмпшир, Хойд Каролина, Пенсильвани, Род Айленд, Өмнөд Каролина, Гуам, Холбоо болно. Харин дараах 20 мужид хүн худалдаалах гэмт хэргийн улмаас эд хөрөнгийг хураах талаар ерөнхий зохицуулалт үйлчилдэг байна. Үүнд: Флорида, Жеоржиа, Индиана, Айова, Канзас, Луизиана, Мэн, Мичиган, Миннесота, Миссури, Невада, Нью Жерси, Нью Йорк, Охайо, Орегон, Теннесси, Техас, Юта, Вашингтон, Америкийн Самоа зэрэг юм.<sup>73</sup>

## **6. Төрөөс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох төрийн тусгай сан буюу захиргааны журмаар хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа**

Төрөөс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид санхүүгийн туслалцаа үзүүлэхдээ Засгийн газрын болон бусад яамнаас хэрэгжүүлдэг хөтөлбөрийн дагуу санхүүжилт олгодог.

Тус улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид санхүүгийн туслалцаа үзүүлэхэд олон төрлийн хөтөлбөр, сан зэрэгцэн ажилладгаас Засгийн газрын гэмт хэргийн хохирогчийн сан болон Хууль зүйн яамны хохирогчийн хамгаалах албаны санг онцолж байна.

### **1. Засгийн газрын Гэмт хэргийн хохирогчийн сан<sup>74</sup>**

АНУ-ын Холбооны хэмжээнд 1984 батлагдсан Гэмт хэргийн

<sup>72</sup> Hitting Them Where It Hurts: Strategies for Seizing Assets in Human Trafficking Cases By Charlene Whitman, JD, <https://aequitasresource.org/wp-content/uploads/2018/09/Hitting-Them-Where-it-Hurts-Strategies-for-Seizing-Assets-in-Human-Trafficking-Cases.pdf>

<sup>73</sup> AEquitas, Restitution and Asset Forfeiture: A Focus on Human Trafficking Current as of April 2014, <https://aequitasresource.org/wp-content/uploads/2018/09/Restitution-and-Asset-Forfeiture-A-Focus-on-Human-Trafficking.pdf>

<sup>74</sup> Human Trafficking Grants & Funding, <https://ovc.ojp.gov/program/human-trafficking/grants-funding#grants-funding>

хохилогчийн тухай хууль (Victims of Crime Act (VOCA) нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд уг хуульд 1988, 1993-1997, 1999-2002 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Уг хуулиар гэмт хэргийн хохирогчийн сан байгуулах, санг бүрдүүлэх, санхүүжүүлэх, хуваарилах, гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох зардал, нөхөн төлбөр олгох эрх зүйн үндэслэл, олгох журам, уг ажлыг зохион байгуулах зэрэг асуудлыг хуульчилсан байна. Энэхүү хуульд зааснаар Холбооны хэмжээнд АНУ-ын Хууль зүйн яамны Гэмт хэргийн хохирогчийн алба нь тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх, сангийн мөнгөн хөрөнгийг хуваарилах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг хариуцан ажилладаг ажээ.

1984 оны Гэмт хэргийн хохирогчийн тухай хуулиар (VOCA) Гэмт хэргийн хохирогчдын сан<sup>75</sup> (Сан) байгуулагдсан. Сан нь татварын мөнгөөр бус, холбооны хэргүүдийн торгох ял, шийтгэлээс санхүүждэг.<sup>76</sup> Конгресс жил бүрийн санхүүжилтийн дээд хязгаарыг тогтоодог.

Тус сангаас санхүүжүүлдэг хөтөлбөр, үйл ажиллагаанаас дурдвал:<sup>77</sup>

*1. Бүх төрлийн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх цогц үйлчилгээний хөтөлбөр:*

Энэхүү хөтөлбөр нь хүн худалдаалах гэмт хэргийн бүх хэлбэрийн хохирогчдод үзүүлэх туслах үйлчилгээний чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилготой юм.

*2. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагааг сайжруулах хөтөлбөр:*

Хууль сахиулах байгууллага болон хохирогчийн үйлчилгээний аль аль нь бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг олж тогтоох, тэднийг цогц үйлчилгээнд хамруулах зорилготой ба хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон талт ажлын хэсгийг хөгжүүлэх, сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор санхүүжилт хүсдэг.

*3. Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг насанд хүрээгүй хүүхэд, гэр бүлийн шүүхийн хариу арга хэмжээг сайжруулах:*

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн зорилготой хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод өсвөр насны хүүхэд, гэр бүлийн шүүхийн тогтолцооноос үзүүлэх үйлчилгээг сайжруулахад оршино.

<sup>75</sup> 18 U.S. Code § 3525 - Victims Compensation Fund, <https://www.law.cornell.edu/uscode/text/18/3525>

<sup>76</sup> Мөн тэнд.

<sup>77</sup> Office for Victims of Crime, Current Funding Opportunities, <https://ovc.ojp.gov/funding/current-funding-opportunities>

*4. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслах инновац хөтөлбөр:*

Энэхүү хөтөлбөр нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод зориулсан хөтөлбөр, үйлчилгээний хийдлийг арилгахын тулд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх болон хохирогчийн үйлчилгээний салбараас бий болсон шинэлэг санаануудыг судалж, хэрэгжүүлэхэд чиглэдэг.

*5. Бэлгийн мөлжлөгийн зорилготой хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчдын чиглэлээр боловсруулсан стратеги:*

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь бэлгийн мөлжлөгийн зорилготой хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчдыг гэмт хэрэгт хохирох явдлыг таслан зогсоох, хохирогч төвтэй, мэдээлэл, нотолгоонд суурилсан хариу арга хэмжээг дэмжих зорилгоор хохирогч үйлчилгээний хөтөлбөрийг хөгжүүлэх, өргөжүүлэх, бэхжүүлэхэд оршино.

*6. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод олгох орон сууцны тусламж:*

Хөтөлбөр нь хүн худалдаалах гэмт хэргийн бүх хэлбэрийн хохирогчдод шилжилтийн үеийн орон сууц, богино хугацааны орон сууцны тусламжийг үзүүлэхэд чиглэнэ.

*7. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх сургалт, техникийн туслалцааны хөтөлбөр:*

Энэхүү хөтөлбөр нь хүн худалдаалах гэмт хэргийн талаар сургалт, туслалцаа, үйлчилгээ үзүүлэх, туслах хэрэгсэл, нөөцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх салбарыг дэмжихэд чиглэсэн.

*8. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхэд, залуучуудад үзүүлэх үр дүнг сайжруулах хөтөлбөр*

*9. Гэмт хэргийн хохирогчдод хандах эрх зүйн боломжийг нэмэгдүүлэх хөтөлбөр*

*10. Хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчдод зориулсан нэгдсэн үйлчилгээ*

*11. Охидыг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх*

12. *Бэлгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон Америкийн хотын индианчууд болон Аляскийн уугуул иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх хөтөлбөр:*

13. *Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ хөтөлбөр зэрэг.*

Цаашлаад төрийн захиргааны төв байгууллага бүр хүн худалдаалах гэмт хэргийн тодорхой чиглэлийг хариуцаж ажиллах бөгөөд үүнд холбогдох үйл ажиллагааг санхүүжүүлэх зарчмаар ажиллана.<sup>78</sup> Тухайлбал, **Хууль зүйн яамны Хохирогчийг хамгаалах сан**<sup>79</sup>-гийн талаар авч үзвэл:

Хууль зүйн яам (DOJ) нь АНУ-ын хэмжээнд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод зориулсан хөтөлбөрүүдийг хөгжүүлэх, өргөжүүлэх, бэхжүүлэх зорилгоор буцалтгүй тусламжийн санхүүжилт олгодог. Уг хөтөлбөрүүд нь хохирогчийг хамгаалах цогц, мэргэшсэн үйлчилгээ, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хэсэг, сургалт, техникийн туслалцаа, судалгаа шинжилгээг санхүүжүүлдэг. Дараах бүтцээр дамжуулан тендер, хөтөлбөр зарлаж санхүүжүүлнэ.

1. Гэмт хэргийн хохирогчдод зориулсан алба (OVC)
2. Хууль зүйн туслалцааны товчоо (BJA)
3. Насанд хүрээгүй хүмүүсийн хууль эрх зүйн болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алба (OJJDP)
4. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх алба (OVW)
5. Хууль зүйн үндэсний хүрээлэн (NIJ)

Үүнээс гадна АНУ-ын дараах яамдууд нь хүн худалдаалах гэмт хэргийн талаар төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг дангаараа болон хамтран хэрэгжүүлдэг байна.

- АНУ-ын Эрүүл мэнд, хүний үйлчилгээний яам (HHS)
- АНУ-ын Хөдөө аж ахуйн яам (USDA)
- АНУ-ын Орон сууц, хот байгуулалтын яам (HUD)
- АНУ-ын Хууль зүйн яам (USDOJ)
- АНУ-ын Хөдөлмөрийн яам (DOL)
- АНУ-ын Нийгмийн Хамгаалалтын Захиргаа (SSA)
- АНУ-ын Боловсролын яам (ED)<sup>80</sup>

Монгол Улсын хувьд 2012 оны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн дагуу Засгийн газар, хууль зүйн асуудал эрхэлсэн

<sup>78</sup> Current Federal Funding Opportunities, <https://www.state.gov/humantrafficking-federal-funding/>

<sup>79</sup> U.S. Department of Justice, Current Funding Opportunities, [https://www.oip.gov/funding/explore/current-funding-opportunities?\\_gl=1\\*2vn4w8\\*\\_gcl\\_au\\*OTk2NDY4MDI3LjE3MTE3NzA4MTk.#4-0](https://www.oip.gov/funding/explore/current-funding-opportunities?_gl=1*2vn4w8*_gcl_au*OTk2NDY4MDI3LjE3MTE3NzA4MTk.#4-0)

<sup>80</sup> Services Available To Victims of Human Trafficking, A Resource Guide for Social Service Providers, <https://www.acf.hhs.gov/sites/default/files/documents/otip/traffickingservices.pdf>

Засгийн газрын гишүүн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн байгууллага зэрэг нь үүрэг хүлээж байгаа хэдий ч АНУ-тай адил хүн худалдаалах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх тал дээр хөтөлбөр, арга хэмжээ авч хэрэгжүүлэх чиг үүрэг тусгагдаагүй байна.

## **7. Хохирогчид нөхөн төлбөр олгож буй шат дараалал, хариуцах байгууллага буюу институтийн тогтолцоо**

2000 онд Конгрессоос баталсан Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуулийн (TVPA) дагуу хүн худалдаалах гэмт хэргийн хохирлыг заавал нөхөн төлүүлэх ёстой. АНУ-ын код журмын § 1593-д "шүүх энэ бүлэгт заасан аливаа гэмт хэргийн хохирогчийн хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн төлүүлэхээр шийдвэрлэнэ" гэж заасан байдаг. TVPA албадан хөдөлмөрийн хохирлыг тооцохдоо Шударга хөдөлмөрийн стандартын тухай хуулийн дагуу тооцно.

Хохирогчид нөхөн төлбөр олгоход хоёр үндсэн саад бэрхшээл тулгардаг: 1) шүүх нөхөн төлбөр олгох шийдвэр гаргахгүй байх; 2) шүүхийн шийдвэрлэсэн нөхөн төлбөрийг авахгүй байх.

- Шүүхүүд нөхөн төлбөр олгохгүй байх

Өмнө дурдсанчлан, АНУ-ын хуулийн 77 дугаар бүлгийн (TVPA) дагуу хүн худалдаалах гэмт хэргийг эрүүгийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогчид нөхөн төлбөр олгох асуудлыг шийдвэрлэх ёстой ч зарим тохиолдолд шийдвэрлэдэггүй гэжээ. 2020 онд холбооны шүүхүүд 77 дугаар бүлгийн дагуу хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн 101 этгээдэд эрүүгийн ял оногдуулсан боловч тэдгээрийн 51 шийдвэрт нь л хохирогчид олгох нөхөн төлбөрийг шийдвэрлэсэн байна.

- Хохирогчид шүүхийн шийдвэрлэсэн нөхөн төлбөрийг авахгүй байх

2016 оны санхүүгийн жилд хохирогчдод олгох ёстой нийт 9,166,689 доллароос ердөө 257,449 доллар буюу 3% хүрэхгүй хувийг цуглуулсан байна. Учир нь ихэнх тохиолдолд шүүгдэгч шүүхээс тогтоосон нөхөн төлбөрийг төлөх санхүүгийн чадваргүй байдаг. 2015 онд Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хураагдсан хөрөнгийг

нөхөн төлүүлэхэд зарцуулна гэж заасан.<sup>81</sup> Гэвч энэ заалтаар мөнгө цуглуулах асуудлыг бүрэн шийдэж чадаагүй. Цаашилбал, Санхүүгийн Шүүхийн албадын (FLU) боловсон хүчний нөөц хангалтгүй байгаа нь нөхөн төлбөрийг шүүгдэгчээс цуглуулах ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна гэж үзжээ<sup>82</sup>.

АНУ-ын хүн худалдаалах гэмт хэргийн хохирлыг нөхөн олгож буй шат дарааллыг Монгол Улстай харьцуулж авч үзвэл процессын хувьд ерөнхийдөө ижил буюу шүүхээс нөхөн төлбөрийг төлүүлэхээр зохицуулагджээ. Гэхдээ шүүхүүд нөхөн төлбөр тогтоохгүй байх, тогтоосон нөхөн төлбөрийг барагдуулахгүй байх нийтлэг зөрчил гарч байна.

Хохирогчид олгох нөхөн төлбөрийн асуудлыг хариуцагч байгууллагыг авч үзвэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох талаар ерөнхий журмыг авч үзвэл дараах байгууллагууд хариуцдаг байна.

- Прокурор
- Шүүгч
- Хууль тогтоогчид

Сангийн хувьд муж улс бүр харилцан адилгүй. Тухайлбал, Техас улсын Хохирогчид нөхөн төлбөр олгох санг Муж Улсын Ерөнхий прокурорын газрын Хохирогчийг хамгаалах хэлтэс хариуцдаг.

### ***Прокурорын байгууллага***

Хохирогчдын эрхийн тухай хуульд Хууль зүйн яамны ажилтнууд, тэр дундаа прокурорууд хохирогчдод “хохирсон хохирлыг нөхөн төлүүлэх эрх”-ийг нь эдлүүлэхийн тулд “хамгийн сайн хүчин чармайлт гаргах” ёстой гэж заасан байдаг. Иймээс прокурорууд хохирол барагдуулах хүсэлтийг шууд гаргах ёстой бөгөөд энэ нь нөхөн төлбөр олгох магадлалыг нэмэгдүүлдэг. 2018 оны тайланд прокуророос хохирол барагдуулах хүсэлт гаргаагүй хүн худалдаалах гэмт хэргүүд 7% байсан. Прокурорууд хохирлыг барагдуулах тухай албан ёсны хүсэлтээс гадна эд хөрөнгийг хураах хүсэлтийг өгөх ёстой. Прокурор хохирол барагдуулах хүсэлт гаргахдаа нөхөн төлбөрийн тооцооны зохих баримт бичгийг харуулах шаардлагатай. Прокурор хэрвээ маргаантай байгаа хэргийн хувьд нөхөн төлбөр хүссэн хэмжээгээ зөвтгөх ёстой. Өөрөөр хэлбэл, нөхөн төлбөрийн хэмжээ, тооцоолол, тэдгээрийн үндэслэлийг тодорхойлж, нотлох үүрэг хэрэгжүүлэх ёстой.

<sup>81</sup> National trafficking institute, The Current State of Restitution for Survivors of Human Trafficking, <https://traffickinginstitute.org/the-current-state-of-restitution-for-survivors-of-human-trafficking/>

<sup>82</sup> National trafficking institute, The Current State of Restitution for Survivors of Human Trafficking, <https://traffickinginstitute.org/the-current-state-of-restitution-for-survivors-of-human-trafficking/>



## **Шүүхийн байгууллага**

Прокурор хохирлыг барагдуулах хүсэлт гаргахгүй байсан ч шүүгчид захирамж гаргах ёстой. Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо шүүхийн үзэмжээр хандах ёстой. Нэмж дурдахад, шүүгчид нөхөн төлбөр олгох шийдвэрийг биелүүлэхийн тулд хөрөнгө хураах шийдвэрийг шууд гаргах ёстой.

## **Хууль тогтоогчид**

Хууль тогтоох арга хэмжээ нь прокурор, шүүгчдэд нөхөн төлбөр олгох саад бэрхшээлийг шийдвэрлэхэд тусална. Конгресс хууль зүйн яамны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх албыг (НТРУ) хангалттай санхүүжүүлж, хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн байцаалтын чиглэлээр прокуроруудыг АНУ-ын туслах хуульч нартай улс орон даяар холбож, хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн байцаалтад туслах ёстой. НТРУ-ийн оролцоотой тохиолдлуудад нөхөн олговор олгох нь өндөр хувьтай байсан. Хууль тогтоогчид мөн 2015 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийн 114(с)(1)(С) хэсгийн хөтөлбөр шиг хууль тогтоомжоор дамжуулан хохирлыг албадан барагдуулах талаар шүүгчдэд зориулсан холбооны сургалтын хөтөлбөрийг үргэлжлүүлэх замаар эхний ээлжид шүүхээс нөхөн төлбөр олгох асуудлыг шийдвэрлэх боломжтой<sup>83</sup>.

## **8. Нөхөн төлбөр авах эрх үүсэх шалгуур, бүрдүүлэх материал, зарцуулах хугацаа, олгох нөхөн төлбөрийн төрөл**

АНУ-ын хууль тогтоогчид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг шүүх эрх мэдлийн хүрээнд хэд хэдэн эрүүгийн хамгаалалт, иргэний эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан.

АНУ-ын хувьд муж улс бүрийн хувьд хүн худалдаалах гэмт хэрэгт нөхөн төлбөр олгож буй зохицуулалт нь өөр байдаг талаар өмнө нь авч үзсэн. Үүнийг дагаад нөхөн төлбөр авах ёстой хохирогч, түүний бүрдүүлэх баримт бичиг нь өөр байх боломжтой. Тухайлбал, АНУ-ын Флорида мужийн Миами-Дэ каунтид дараах журам үйлчилж байна.

### **Нөхөн төлбөр авах боломжтой хохирогч:**

- Флоридагийн статутын 960 дугаар бүлэгт тодорхойлсон хохирогч эсвэл хэрэгт холбогдсон хохирогч

<sup>83</sup> National trafficking institute, The Current State of Restitution for Survivors of Human Trafficking, <https://traffickinginstitute.org/the-current-state-of-restitution-for-survivors-of-human-trafficking/>

- Нас барсан хохирогчийн амьд үлдсэн эхнэр, нөхөр, эцэг эх, хүүхэд эсвэл ах дүү.
- Насанд хүрээгүй, эрхийн чадамжгүй хүн, нас барсан хохирогчийн насанд хүрээгүй хүүхэд, асран хамгаалагч.
- Гэмт хэргийн улмаас гэмт хэргийн улмаас сэтгэл санааны болон сэтгэцийн гэмтэл авсан насанд хүрээгүй хүн, эсвэл хүүхдийн хүчирхийлэлд өртөж, сэтгэцийн гэмтэл авсан насанд хүрээгүй хүн.
- Оршуулгын зардлыг төлөх өөр эх үүсвэр байхгүй үед нас барсан хохирогчийн нэрийн өмнөөс хамаатан садан.
- Нас барсан хохирогч эсвэл бусад хохирогчдын дэмжлэгийг авч байсан бусад хүн.

### ***Нөхөн төлбөр авах шалгуур:***

- Гэмт хэргийн талаар 72 цагийн дотор хууль сахиулах байгууллагад мэдэгдэх ёстой;
- Гэмт хэргийн улмаас хохирогчид бие махбодын гэмтэл учирсан байх эсвэл амь насаа алдах ёстой. Зарим гэмт хэргийн улмаас сэтгэцийн болон сэтгэл зүйн гэмтэл авсан хохирогч байж болно;
- Гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол хоёр жилийн дотор хүсэлт гаргах ёстой;
- Хохирогч хууль сахиулах байгууллага, Улсын прокурорын газар, Улсын ерөнхий прокурорын газартай бүрэн хамтран ажиллах ёстой;
- Хохирогч гэмт хэрэг үйлдэх үедээ хууль бус үйл ажиллагаа явуулаагүй байх ёстой. (Гэвч энэ нь хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарахгүй)
- Хохирогч эсвэл өргөдөл гаргагч нь муж, хотын захиргааны байгууллагад хоригдож, цагдан хоригдоогүй байх;
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод нэн даруй гэр бүлийн хүчирхийллийн орчноос зугтах шаардлагатай байгаа хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх нэхэмжлэлийг Флорида муж дахь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төвөөр дамжуулан гаргаж, баталгаажуулсан байх ёстой. Хүсэлт, гэрчилгээг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор хэлтэс хүлээн авах ёстой;
- Аюулгүй байдлаа хангах үүднээс нүүлгэн шилжүүлэх шаардлагатай байгаа бэлгийн хүчирхийллийн хохирогчдын нүүлгэн шилжүүлэлтийн нэхэмжлэлийг Флорида муж дахь Хүчингийн гэмт хэргийн төвөөр дамжуулан гаргаж, баталгаажуулах ёстой. Өргөдөл, гэрчилгээг хүн худалдаалах гэмт хэргийн гэмт хэрэг үйлдэгчээс хамгийн сүүлд илрүүлсэн

аюул заналхийлэл хууль сахиулах байгууллагад мэдэгдсэнээс хойш 45 хоногийн дотор тус хэлтэст хүлээн авах ёстой.

### ***Нөхөн төлбөр авахад бүрдүүлэх баримт бичиг:***

- Хохирол нөхөн төлүүлэх анкетыг бөглөж, гарын үсэг зурсан хүсэлт;
- Нөхөн төлөх хохирол болон гэмт хэргийг нотлох баримтжуулсан хууль сахиулах гэмт хэргийн тайлан;
- Гэмт хэрэгтэнтэй холбоотой нотлох баримт, тухайлбал, эмчилгээ, үйлчилгээ авсан бол түүний зардлын баримт;
- Даатгал, нөхөн төлбөр, шүүхийн шийдвэр, төлбөр тооцоо гэх мэт гуравдагч этгээдийн төлбөрийг нотлох баримт;
- Нүүлгэн шилжүүлэлтийн тэтгэмжийн хувьд гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамгаалах байр эсвэл хүчингийн гэмтлийн төвөөс гэрчилгээ авах (тэтгэмжийн сонголтоос хамаарна)<sup>84</sup>.

Монгол Улсын хувьд Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирол учирсан, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах этгээдэд тавигдах шалгуур, нөхөн төлбөр авах шалгуур, бүрдүүлэх баримт бичгийг нарийвчлан хуульчлаагүй байна. Иймд дээрх сайн жишгийг харгалзан үзэж зохицуулах нь зүйтэй.

АНУ-ын хувьд хүн худалдаалах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэхэд дунджаар 2-3 жил зарцуулдаг байна<sup>85</sup>. АНУ-ын код журам (US.Code), Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль (TVPA)-д нарийвчилсан хугацааны талаар зохицуулалт байхгүй ч дараах хүчин зүйлээс хамаарч хугацаа тодорхойлогддог байна.

***Нөхөн олговрын хөтөлбөрийн төрөл:*** Өөр өөр нөхөн олговрын хөтөлбөрүүдэд хугацаа өөр байж болно. Жишээлбэл, мужийн хохирогчдод нөхөн олговор олгох хөтөлбөрүүд холбооны хөтөлбөрүүдтэй харьцуулахад өөр өөр хугацаатай байж болно.

***Өргөдлийн бүрэн байдал:*** Нөхөн олговрын нэхэмжлэлийг боловсруулахад шаардагдах хугацаа нь өргөдлийн бүрэн бүтэн байдал, үнэн зөв эсэхээс ихээхэн хамаардаг. Шаардлагатай бүх бичиг баримт, мэдээллийг урьдчилан өгөх нь үйл явцыг хурдасгах болно.

***Хэргийн нарийн төвөгтэй байдал:*** Хүн худалдаалах гэмт хэргийн

<sup>84</sup> Miami-de state attorney, Crimes Compensation, Stop Human Trafficking, <https://miamisao.com/humantrafficking/crimes-compensation.html>

<sup>85</sup> The Federal Human Trafficking Report (FHTR) 2020 is authored by Lindsey Lane, Senior Legal Counsel, Angela Gray, Senior Project Attorney, Alicen Rodolph, Project Attorney, and Brittany Ferrigno, Legal and Development Research Manager, [https://traffickinginstitute.org/wp-content/uploads/2023/06/2022-Federal-Human-Trafficking-Report-WEB-Spreads\\_compressed.pdf](https://traffickinginstitute.org/wp-content/uploads/2023/06/2022-Federal-Human-Trafficking-Report-WEB-Spreads_compressed.pdf)

зарим хэргүүд бусдаасаа илүү төвөгтэй байж болох тул хохирогчийн нэхэмжлэлийг шалгах, шалгахад илүү их цаг хугацаа шаардагддаг. Хэд хэдэн гэмт хэрэгтэн, хил дамнасан гэмт хэрэг, их хэмжээний хохирол учруулсан хэргийг хянан шийдвэрлэхэд удаан хугацаа шаардагдана.

*Хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах:* Хохирогчид хохирлыг барагдуулах үйл явцын хүрээнд хууль сахиулах байгууллагын мөрдөн шалгах ажиллагааг хамтран ажиллахыг шаардаж болно. Эдгээр мөрдөн шалгах ажиллагааны үргэлжлэх хугацаа нь нийт цаг хугацааны хуваарьт нөлөөлж болно.

*Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа:* Нөхөн олговрын нэхэмжлэлийн талаар маргаж, эсэргүүцэж байгаа бол шүүх хуралдаан, давж заалдах зэрэг хуулийн процессыг хамарч болох бөгөөд энэ нь процессын үргэлжлэх хугацааг уртасгаж болно.

*Хөрөнгө ба нөөцийн олдоц:* Нөхөн олговрын зарим хөтөлбөрүүд нөөцийн хязгаарлалт эсвэл их хэмжээний ажлын ачааллаас шалтгаалж хоцрогдол, саатал гарч болзошгүй бөгөөд энэ нь нөхөн олговрын нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх хугацааг уртасгаж болзошгүй.

Монгол Улсын хувьд мөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр өгөх хугацааг нарийвчлан тусгаагүй. Түүнчлэн хугацааны хувьд дээрх нийтлэг нөхцөл байдлууд нөлөөлж болохыг харгалзан үзэх нь зүйтэй.

## **9. Тохиолдол, шийдвэрлэсэн байдал**

2022 оны Холбооны хүн худалдаалах гэмт хэргийн талаар тайланд нөхөн төлбөрийн талаар дараах шүүхийн шийдвэрийг онцолсон байна.

Америкийн Нэгдсэн Улс v. Виллиам Фостер, Флоридагийн өмнөд дүүрэг

2022 онд Флоридагийн Өмнөд дүүрэгт гарсан АНУ-ын эсрэг Уильям Фостер нартай холбоотой бэлгийн мөлжлөгийн зорилготой хүн худалдаалах гэмт хэрэгт холбоотойгоор хэд хэдэн хохирогчид хамгийн их хэмжээний нөхөн төлбөрийг олгосон. Фостер нь насанд хүрсэн хүнийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах, насанд хүрээгүй хүнийг худалдаалах, биеийг нь үнэлүүлэх, мөнгө угаах зорилгоор хүнийг тээвэрлэх зэрэг олон гэмт хэргийг хорь гаруй жил үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргийн схемийг хэрэгжүүлсэн хэрэгт буруутгагджээ.

Фостер нь Өмнөд Флорида муж дахь тайчих бүжгийн клубт эрэгтэй, эмэгтэй олон хохирогчдыг худалдаалж, долоо хоногийн зургаан өдөр найман цагийн ээлжээр арилжааны зорилгоор биеийг нь үнэлүүлсэн хэргээр ял сонсжээ. Фостер хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх зорилготой “Foster’s Care” нэртэй цахим хуудсаараа

дамжуулан хохирогчдыг элсүүлэхийг оролдсон. Мөн тэрээр хохирогчдын олсон мөнгийг эрт тэтгэвэрт гарахад нь хөрөнгө оруулалт хийнэ гэж хэлсэн ч үнэндээ тэр мөнгөө өөртөө хадгалдаг байсан. Фостер өөрийн хохирогчдыг хянахын тулд сэтгэл зүйн заль мэх, хүчирхийллийг ашигласан бөгөөд хохирогчдын ихэнхийг хоолны дэглэм барих, аюултай турах мэс засал хийлгэх, оношгүйгээр сэтгэлийн түгшүүр болон сэтгэцийн эсрэг эм уухыг шаарддаг байсан. Мөн тэрээр хохирогчидтой бэлгийн харьцаанд орж байсан ба зарим нь насанд хүрээгүй байсан бөгөөд хохирогчдыг Нью-Йорк, Нью Жерси, Мичиган, Невада зэрэг олон муж улс хооронд тээвэрлэж байжээ.

2022 оны есдүгээр сард Фостерт 60 жилийн хорих ял оноож, хохирогчдын хохирлыг барагдуулахад 14,157,200.00 доллар төлөхөөр оноожээ. Хамгийн чухал нь, прокурорууд Фостерын эсрэг хөрөнгийг хураах ажиллагааг эхлүүлж, бэлэн мөнгө, үл хөдлөх хөрөнгө зэргийг хураах хүсэлт гаргасан. Шүүхээс нийт 3.4 сая долларын хөрөнгийг хураах шийдвэр гаргасан. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хүн худалдаалах гэмт хэрэгтэн идэвхтэй хорих ял эдэлж, хоригдож байгаа төлбөрийн чадваргүй байх үед эд хөрөнгийг хураах нь хууль эрх зүйн үр дүнтэй арга хэрэгсэл юм. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын хохирлыг Шүүх 2015 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн төлөөх хуулийн дагуу (JVTA) Ерөнхий прокурор нь 18 U.S.C § 1594-ийн дагуу хураан авч барагдуулахыг даалгасан.<sup>86</sup>

## ДҮГНЭЛТ

АНУ-ын код журамд хүн худалдаалах гэмт хэргийн зорилго, хэлбэр бүрээр нь тусгайлан гэмт хэрэгт тооцсон. Тухайлбал, 1584 дүгээр зүйлд Албадан боолчлох зорилгоор худалдах гэмт хэргийг, 1589 дүгээр зүйлд Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийг, 1590 дүгээр зүйлд Насанд хүрсэн хүнийг худалдаалах, боолчлох, албадан эрхшээлдээ байлгах, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг, 1591 дүгээр зүйлд Хүүхдийг бэлгийн зорилгоор эсвэл хүчээр, залилан мэхэлж, албадлага хэрэглэж худалдах гэмт хэргийг тус тусад нь зохицуулсан байна. Ийнхүү тус тусад нь хуульчилснаас улбаалан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх цогц ажиллагаа нь олон чиглэлээр бүрдэж байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бие даасан хууль байхаас гадна Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах бие даасан хуультай.

АНУ-д гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг өргөн

<sup>86</sup> The Federal Human Trafficking Report (FHTR) 2022 is authored by Lindsey Lane, Senior Legal Counsel, Angela Gray, Senior Project Attorney, Alicen Rodolph, Project Attorney, and Brittany Ferrigno, Legal and Development Research Manager, [https://traffickinginstitute.org/wp-content/uploads/2023/06/2022-Federal-Human-Trafficking-Report-WEB-Spreads\\_compressed.pdf](https://traffickinginstitute.org/wp-content/uploads/2023/06/2022-Federal-Human-Trafficking-Report-WEB-Spreads_compressed.pdf)

хүрээнд авч үзэж байх ба цаашлаад үйлдлийн хэр хэмжээ, ноцтой байдлыг үндэслэж шийтгэлийн нөхөн төлбөр (punitive damage)-ийг гаргуулахаар шийдвэрлэх нь бий.

Холбооны улсаас нэг бус хэд хэдэн эх үүсвэрээр дамжуулан, тухайлбал Засгийн газар, Хууль зүйн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам зэрэг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчийн эрхийг хамгаалахад чиглэсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг. Өөрөөр хэлбэл, холбооны улсаас хохирогчид шууд нөхөн олговор олгохгүй. Харин муж улс бүрд энэ төрлийн сан хөгжжээ.

АНУ-ын хүн худалдаалах гэмт хэргийн хохирлыг нөхөн олгож буй шат дарааллыг Монгол Улстай харьцуулж авч үзвэл процессын хувьд ерөнхийдөө ижил буюу шүүхээс нөхөн төлбөрийг төлүүлэхээр зохицуулагджээ. Гэхдээ шүүхүүд нөхөн төлбөр тогтоохгүй байх, тогтоосон нөхөн төлбөрийг барагдуулахгүй байх нийтлэг зөрчил гарч байна. Цаашлаад ЭХХША-ны явцад прокурор хохирол барагдуулах хүсэлтийг гаргах, хохирлын хэмжээг тооцоолох, үндэслэлийг тогтоох, тайлбарлах, нотлох үүргийг хүлээж буй нь хохирогчийн нөхөн төлбөр авах эрхийг баталгаажуулахад чухал ач холбогдолтой байна.

Монгол Улсын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шүүх, прокурор, цагдаагийн байгууллага нь дээрхтэй адил тогтолцоо-институтийн хувьд нөхөн олговор олгох асуудлыг шийдвэрлэж байна. Гэхдээ зөвхөн хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарах нарийвчилсан процессыг АНУ-ын жишигт нийцүүлэн хуульчлах нь зүйтэй байна. Хохирол нөхөн төлүүлэх шийдвэрийн биелэлтийг хангах зорилгоор шүүхээс эд хөрөнгийг хураах шийдвэр гаргах нь үр дүнтэй байгаа хэдий ч зарим тохиолдолд энэ төрлийн албадлагын арга хэмжээг авахгүй байна.

Холбооны улсаас хохирогчид шууд нөхөн олговор олгохгүй бөгөөд хохирогчийн эрхийг хамгаалах төсөл төлбөрийг санхүүжүүлэх замаар үүрэг гүйцэтгэдэг. Муж улс бүр гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сантай байх нь элбэг бөгөөд сангаас олгох зардал, тэдгээрийн хэмжээ, бүрдүүлэх баримт зэргийг тогтоох нь нийтлэг байна.

Монгол Улсын хувьд Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирол учирсан, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах этгээдэд тавигдах шалгуур, нөхөн төлбөр авах шалгуур, бүрдүүлэх баримт бичгийг нарийвчлан хуульчлаагүй байна. АНУ-ын хувьд мужийн хэмжээнд үүнийг нарийвчлан зохицуулдаг нь сайн жишиг болж байна. Түүнчлэн манай улсад АНУ-тай адил хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр өгөх хугацааг нарийвчлан тусгаагүй. Гэхдээ АНУ-д дундаж хэрэг 2-3 жилийн хугацаанд шийдвэрлэгддэг байна. Түүнчлэн хугацааны хувьд дээрх нийтлэг нөхцөл байдлууд нөлөөлж болохыг харгалзан үзэх нь зүйтэй.

## АНУ-ын сайн туршлагууд

АНУ-ын тухайд хүн худалдаалах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх зохицуулалтын тухайд дараах сайн туршлага бүхий зохицуулалттай байна.

1. АНУ-ын кодын 1584 дүгээр зүйлд Албадан боолчлох зорилгоор худалдах гэмт хэргийг, 1589 дүгээр зүйлд Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийг, 1590 дүгээр зүйлд Насанд хүрсэн хүнийг худалдаалах, боолчлох, албадан эрхшээлдээ байлгах, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг, 1591 дүгээр зүйлд Хүүхдийг бэлгийн зорилгоор эсвэл хүчээр, залилан мэхэлж, албадлага хэрэглэж худалдах гэмт хэргийг тус тусад нь зохицуулж нарийвчилж авч үзсэн.
2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль (TVPA), Хохирогчийн эрхийн хамгаалалттай холбоотой тус тусдаа хуулиудыг боловсруулан батлуулсан ба эдгээр нь холбогдох харилцааг зохицуулж хохирогчийн хохирлоо барагдуулах, нөхөн төлбөр авах эрхийг хангаж байна.
3. Муж улс бүр улсын сангаас олгох нөхөн олговрын төрөл, тэдгээрийн тооцох аргачлалыг тогтоосон байна.
4. Холбооны улсаас нэг бус хэд хэдэн эх үүсвэрээр дамжуулан, тухайлбал Засгийн газар, Хууль зүйн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам зэрэг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчийн эрхийг хамгаалахад чиглэсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг байна. Харин муж улс бүрээс төсвөөс гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох боломжтой бөгөөд харилцан ялгаатай байна.

### 3.2. ФРАНЦ УЛС

Хүн худалдаалахын эсрэг Европын конвенцыг оролцуулан хүн худалдаалах гэмт хэрэг, албадан хөдөлмөрийн талаарх олон улсын үндсэн стандартуудад Франц улс нэгдэн оржээ. Түүнчлэн Франц улс нь онц гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай Европын конвенцын гишүүн улс юм. Эх газрын эрх зүйн тогтолцоотой Франц улс нь Дотоодын аюулгүй байдлын тухай хуулиар хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлсон бөгөөд Эрүүгийн хуулийн 225-4-1 дүгээр зүйлд<sup>87</sup> бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалахыг гэмт хэрэг гэж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ. Тус хуулиар хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээд нь 7 жилийн хорих ял, 150000 еврогоор торгох ял, бага насны хүүхэд, эмзэг бүлгийн буюу жирэмсэн,

<sup>87</sup> Франц улсын Эрүүгийн хууль, 225-4-1 дугаар зүйл.

[https://legislationline.org/sites/default/files/documents/df/France\\_Criminal%20Code%20updated%20on%2012-10-2005.pdf](https://legislationline.org/sites/default/files/documents/df/France_Criminal%20Code%20updated%20on%2012-10-2005.pdf)

хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай зэрэг хүмүүсийн эсрэг үйлдсэн бол 10 хүртэл жил хорих ял, 1.5 сая еврогоор торгох, цаашилбал насан туршид нь хорих, 4.5 сая еврогоор торгох ял оногдуулахаар заасан.<sup>88</sup>

Францын Засгийн газар хүн худалдаалах гэмт хэргийг устгах наад захын стандартыг бүрэн хангаж байна.<sup>89</sup> Түвшин 1 (tier-1)<sup>90</sup>-д багтсан улсын хувьд Засгийн газраас олон төрлийн албан тушаалтнуудад иж бүрэн сургалтыг явуулж, хууль сахиулах байгууллагууд олон улсын өргөн хүрээтэй мөрдөн байцаалт, хамтын ажиллагааг явуулан, илүү олон хохирогчдыг илрүүлж, тэдэнд туслалцаа үзүүлсэн байна. Гэсэн хэдий ч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх тусламжийн санхүүжилт хоёр дахь жилдээ буурч, ерөнхийдөө хангалтгүй буюу хохирогчдод нөхөн олговор олгох, нөхөн төлбөр олгох нь маш ховор хэвээр байв.<sup>91</sup> Хөдөлмөрийн байцаагч, цагдаа, прокурор, шүүгч зэрэг тэргүүн эгнээний бүх албан тушаалтнуудад хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, хохирогчийг илрүүлэхэд хохирогч төвтэй хандлагыг системтэйгээр сургах шаардлагатайг тус улсад зөвлөсөн байна.<sup>92</sup>

Хохирогч хохирол нөхөн төлүүлэх нь практикт асуудалтай байгаа нь дараах байдлаас харагдаж байна. Тухайлбал, Засгийн газар 2022, 2021 онд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох талаар мэдээлээгүй ч төрөөс санхүүждэг төрийн бус байгууллага хүн худалдаалах гэмт хэргийн нэг хохирогч нөхөн төлбөр авсан тухай мэдээлсэн.<sup>93</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн бэлгийн хохирогчид хууль ёсны ажил эрхлээгүйгээс учирсан хохирлоо нөхөн төлүүлэх, нөхөн төлбөр шаардахад хүндрэлтэй байдаг бол хууль зүйн статусгүй хохирогчид нөхөн төлбөр авах, хохирлыг барагдуулах боломжгүй байдаг тул хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа амжилттай хэрэгжихгүй байна. Түүнчлэн Засгийн газар хүн худалдаалах гэмт хэрэгтнүүдээс хураан авсан эд хөрөнгийг ашиглаж, хохирогчид эсвэл тусламж үйлчилгээ үзүүлдэг холбоодод өгөх боломжтой ч ийм ажиллагаа хангалтгүй явагдаж байна.<sup>94</sup>

Франц улс нь хохирогчийн эрхийг хүлээн зөвшөөрдөг урт удаан

<sup>88</sup> Франц улсын Эрүүгийн хууль, 225-4-2, 3,4 дүгээр зүйл.

<sup>89</sup> Франц улсын хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын тайлан (2023).

<https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/france/#:~:text=Trafficking%20victims%20could%20obtain%20compensation,victims%20would%20receive%20less%20compensation.>

<sup>90</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын үнэлгээ, ангилал.

<https://www.knowyourcountry.com/human-trafficking>

<sup>91</sup> Франц улсын хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын тайлан (2023).

<https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/france/#:~:text=Trafficking%20victims%20could%20obtain%20compensation,victims%20would%20receive%20less%20compensation.>

<sup>92</sup> Мөн тэнд.

<sup>93</sup> Мөн тэнд.

<sup>94</sup> Мөн тэнд.



хугацааны түүхтэй боловч, зөвхөн 1980-аад оноос энэ талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж эхэлжээ.<sup>95</sup> Нөхөн төлбөрийн олон тооны тогтолцоог бий болгох, хохирогчийн иргэний нэхэмжлэгчийн үүргийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн олон тооны институцийн, дэгийн болон хууль эрхийн арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

## **1. Хохирогчид нөхөн олговор олгох эрх зүйн зохицуулалтын салбар буюу эрүү, иргэн, хөдөлмөрийн хуулийн журмаар нөхөн олговор олгох ажиллагааны онцлог, зохицуулалт**

### **1.1. Иргэний журмаар хохирол төлүүлэх ажиллагаа**

Гэмт хэргийн хохирогч шүүх ажиллагаанд иргэн хүний хувьд оролцох эрхтэй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын талаарх иргэний нэхэмжлэлийг шүүн таслах хурал энэ гэмт үйлдлийн улмаас шууд хохирол хүлээсэн хүмүүс бүгд оролцоход нээлттэй байх тухай заажээ. Тухайн гэмт хэргийн улмаас махбодын гэмтэл, эд материалын хохирол учирсан гэдгийг нотолсон бол нэхэмжлэлийн дээд хэмжээг заагаагүй ч нэхэмжлэгчээр оролцож болно. (Эрүүгийн хуулийн 420-ийн /1/ дүгээр хэсэг) Яллагдагчид шүүхээс хорих ял оноохын хамтаар түүний учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэрийг мөн гаргана.

Хохирогчийн эрхийн талаар Засгийн газрын мэдээллийн хуудаст иргэний нэхэмжлэл гаргах хохирлын төрлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: а/Бие махбод, сэтгэл мэдрэлд учруулсан хохирол; б/Тав тухтай амьдрах боломжгүйгээс үүссэн хохирол: эрхэлдэг ажил, тогтсон хэв маягаараа амьдрах боломжгүй болсон өөрөөр хэлбэл сонирхдог спорт, хоббигоо үргэлжлүүлэх боломжгүй болох; в/хэмжих аргагүй- ёс суртахууны хохирол, ойр дотнын хүнээ алдах, нэр хүнд унах; г/өмч хөрөнгийг эвдэх, гэмтээх зэрэг эд материалын хохирол учруулах.

Хэдийгээр нэхэмжлэгч шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа ч хэргийн үнэн мөнийг олж тогтоох үүрэг хариуцлагыг прокурор/шүүгч хүлээдэг. Харин хохирогч өмгөөлөгч авч болох бөгөөд өмгөөлөгчийн болон уг хэрэг дээр ажилласан бусад шинжээчдийн хөлсийг нөхөн төлбөрийн салшгүй хэсэг болгон нэхэмжилж болно. Иргэний нэхэмжлэгчээр оролцож буй тал шүүгчид нэхэмжлэлээ гаргах, гэрчийн этгээдэд асуулт тавих, шүүх хуралдааны дэг журмын талаар гаргасан шийдвэр, шүүх хуралдааныг хийх цаг хугацааны талаар мэдээлэл авах, гаргасан нэхэмжлэлтэй зөрчилдөж буй баримтын талаар давж заалдах

<sup>95</sup> 1982 онд Хохирогчдын асуудлыг судлах хороог Проф.Миллиезийн удирлаган дор байгуулсан бөгөөд уг хорооны итгэлийн үндсэн дээр хохирогчдод үйлчилгээ үзүүлэх албадыг олноор байгуулж, тусламж үзүүлэх журмыг ихээхэн өөрчлөн шинэчилсэн байна.

зэрэг өргөн хүрээтэй эрх эдэлнэ.

## **1.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хохирол нөхөн төлүүлэх**

Эрүүгийн хуулийн 225/13/ дугаар зүйлд хөлсийг нь төлөөгүй үйлчилгээнд төлбөр авах эсвэл хөлсийг нь төлж буй үйлчилгээ нь тухайн үйлчлэгч эмзэг болон хараат байдалд байгаа нь яллагдагчид тодорхой байгаа бол ямар ажил үйлчилгээ авч байгаагаас үл хамааран гэмт этгээдэд 5 жилийн ял өгч, 150,000 еврогоор торгоно гэж заажээ.

Улсын яллагчийн зөвшөөрснөөр хохирогч мөрдөн байцаалтын явцад уг хэрэг дээр ажилласан цагдаагийн мөрдөн байцаагч эсвэл өөр бусад албан хаагчтай хамтран хохирлыг барагдуулах нэхэмжлэлээ гаргаж болно. Энэ нь үндсэндээ болсон явдал, учруулсан хохирлын тухай баримт нотолгооны талаар хийх мэдээлэл байдаг. Шүүхийн нарийн бичгийн дарга үүнийг хэргийн баримтад авна. Энэ мэдэгдлийг шүүх хурал эхлэхээс 24 цагийн өмнө факсаар эсвэл шүүх хүлээн авсан баримт бүхий баталгаат захидлаар мөн өгч болно. Хор хохирол учруулсныг нотлох баримтыг гарган өгөх шаардлагатай. Ингэсэн нөхцөлд хохирогч өөрийн биеэр шүүх хуралдаанд оролцохгүй байж болно. Түүнчлэн хохирогч өөрийн биеэр шүүх хуралдаанд оролцож хохирлоо төлүүлэх нэхэмжлэл гаргаж болно. Урьдчилсан мөрдөн байцаалтаас эхлэн шүүхийн шийдвэр гарах хүртэл нэхэмжлэл гаргаж болно. Яллагдагч хуулийн хариуцлага хүлээх гэм буруугүй нь дараагийн хоёр тохиолдлоос бусад нөхцөлд нотлогдсон бол иргэний нэхэмжлэлийн дагуу төлбөр олгохгүй. (Үүнд: Уг хэргийг өмнө нь тангарагтны шүүхээр шүүсэн бөгөөд сэжигтний гэм буруутай эсэхийг хуульчид тогтоогоогүй, эсвэл яллагдагчийн хийсэн үйлдлийг зөвтгөх /цагаатгах /үндэстэй бол).

Нэхэмжлэлд учруулсан хохирол, алдагдал тус бүрийг, эд материалын болон ёс суртахууны хохирлыг тоон дүнгээр илэрхийлсэн байх хэрэгтэй. Түүнчлэн баримтууд тухайлбал, эмнэлгийн магадалгаа, эмийн чөлөөний хуудас, алдагдсан орлого тоогоор, төлбөрийн нэхэмжлэлүүд, тэдгээрийн үнэлгээ зэргийг хавсаргана. Хэрвээ бие махбодын гэмтлийн тухай яригдаж байгаа бол шүүхийн шийдвэрээр эсвэл хохирогчийн өөрийн хүсэлтээр мэргэжилтний дүн шинжилгээ хийлгэнэ. Мэргэжилтний шинжилгээний дүгнэлт гарах хүртэл шүүхээс хохирогчид түр хугацааны төлбөр олгох шийдвэр гаргана.

Нөхөн төлбөр авах үндэстэй нь нотлогдвол яллагдагч төлбөр хийх чадавхтай эсэхийг үл харгалзан төлбөрийг бүрэн хийх шийдвэрийг шүүхээс гаргана. Яллагдагчийн хөрөнгийн чадавхыг мөрдөн байцаах ажиллагааны явцад байцаан шалгаагүй бол шүүгч энэ талаар тодорхой

мэдээлэлгүй байх бөгөөд төлбөрийг хэсэг хэсгээр хийх шийдвэр гаргах магадлал өндөр байх болно. Жишээлбэл, хорих ялыг хойшлуулах эсвэл түр зогсоох хүсэлтийг илүү нааштай хүлээн авч болох юм. Нэхэмжилсэн төлбөрийг төлж барагдуулах нь зуучлагчаар дамжуулан хэлэлцэн тохиролцох тохиолдолд чухал үүрэг гүйцэтгэнэ (тухайлбал Шүүх хандахын өмнө шүүхийн зуучлагчаар дамжуулан яллагдагч болон хохирогчийн хооронд төлбөр хийх талаар тохиролцоонд хүрсэн хэргүүдэд). Зуучаар дамжуулан төлбөр хийгдсэн хэргийг яллагч авч үзэхгүй байх байх магадлал өндөр юм.

Хэргийг шүүн тасалсны дараа шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх ердийн аргаар уг хэргийг шийдэх оролдлого амжилтад хүрээгүй бол хохирогч, яллагдагч хоёрын хуульчид энэ талаар тохиролцоонд хүрэх оролдлого хийх нь ерийн үзэгдэл байдаг. Хэрвээ гэмт этгээдэд оноосон ял нь хохирогчид нөхөн төлбөр олгох зүйл ангитай бол тэнсэн харгалзах алба эсвэл хорих газрын төлөөлөгч хохирогчтой уулзаж уг төлбөрийг хэрхэн хийж барагдуулах асуудлыг судалж үзнэ.

Хэрвээ яллагдагч шоронд хоригдож байгаа бол хорих газрын удирдлага түүнийг шоронд хоригдож байх хугацаанд хөрөнгийг нь зарцуулж байх дансыг нээх бөгөөд уг мөнгөний зохих хувийг хохирогчид олгож байх болно. Хохирогч нь яллагдагчийн цалин хөлс банкны данснаас мөнгөө суутган авахаар шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн тусламжийг авч болох ба мөн улсын яллагчийн тусламжаар өртэй этгээдийн банкны дансыг (FICOBA буюу Францад байгаа бүх банкны данснуудын талаарх мэдээллийн сан) олох түүнд нэвтрэх хүсэлт гаргаж болно.

1993, 1998 оны Хууль зүйн яамны илтгэлд учруулсан хохирлыг барагдуулах асуудал туйлын хангалтгүй байгааг тэмдэглэсэн бөгөөд 2000 онд эрдэмтэд энэ талаарх шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх асуудал Францад "томоохон асуудал" болж байна гэсэн дүгнэлтэд хүрчээ.

#### Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хохирол нөхөн төлүүлэх

Франц улсад хэдийгээр тогтмол ажил эрхэлдэггүй ч ажилчин хүн албан ёсоор ямар нэг хэмжээний хамгаалалттай байдаг. Хөдөлмөрийн хуулийн 141. 6 дугаар зүйлд ажил олгогч бичиг баримтгүй ажилчныг ажилд авсан бол үүний төлөө үүрэг хариуцлага хүлээх ёстой гэж заажээ. Ийм учраас бичиг баримтгүй ажилчныг хохирогч гэж үзэх бөгөөд ажил олгогчийн эсрэг өөрийн эрхийг зөрчсөн талаар хэрэг үүсгэн шүүхэд хандах боломжтой юм. Эдгээр хүмүүст бага хэмжээний цалин хөлс олгож, нийгмийн даатгалыг төлөхөөс зайлсхийх замаар ажил олгогч ашиг орлого олсон гэж үзээд ийм арга хэмжээ авдаг байна. Ажил олгогчтой хөдөлмөрийн харилцаанд орсон учраас тухайн ажилчин

өөрийн эрхийг мөн эдлэх ёстой. Баримт бичиггүй ажилчин нь боломжийн цалин хөлс авах ( цалин нь цалингийн баталгаат доод хэмжээнээс доогуур байж болохгүй); илүү цагийн ажлын хөлс авах; тухайн бизнесийн хамтын хэлэлцээрээр олгох ёстой төлбөр; жилийн цалинтай амралт; хэрвээ ажлаас гарвал зохих төлбөр авах (энэ төлбөр нь 1 сарын цалингаас бага байж болохгүй) эрхтэй.

Ажил олгогч болон түр ажиллагсдын хооронд хөдөлмөрийн харилцаа байсан гэдгийг хууль зүйн үүднээс батлахад бэрхшээл учирдаг. Хэдийгээр гэрч байлаа ч гэсэн боломж хязгаарлагдмал байдаг учраас үйлдвэрчний эвлэлийн зөвлөгөө өгдөг албадын ашигладаг. Тэдний тусламжийг авахад уг үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх эсэх нь онцын чухал ач холбогдолгүй.

ТББ-уудын илтгэлээс үзвэл Францын шүүх баримт бичиггүй ажилчдыг, ялангуяа гэр орноороо ажилладаг хүмүүсийг чөлөөт ажил эрхлэгчид (freelancers) гэж үзэх хандлага давамгайлах болжээ. Ийм учраас тэд хуулийн өмнө хариуцлага хүлээх ёстой, эдлэх эрх нь зөрчигдсөн хохирогчид гэж тэднийг үзэхгүй болжээ. Баримт бичиггүй цагаачдыг түр хугацаагаар хөлслөн ажиллуулсны төлөө тэд нарыг хохирогч гэж үзэх зарчмыг хэрэглэхээс бага багаар татгалзах болжээ. Ингэснээр дутуу өгсөн цалин хөлсийг нэхэмжлэн авах хуулийн хамгаалалтыг авахад улам бэрхшээлтэй болж байгаа юм. ОУХБ-ын судлаачид Францын шүүгчидтэй дээрх эрхийн асуудлаар ярилцахад хэдийгээр хөдөлмөрийг нь шулан мөлжсөний нөхөн төлбөрийг нэхэмжлэх эрх цаасан дээр хэвээр байгаа боловч цагаачлалын албадаас шүүх хурлын явцад хохирогчдыг баривчлах, эсвэл саатуулах тохиолдол гарахгүй гэсэн баталгаа байхгүй гэж тэд үзэж байв.

## **2. Нөхөн төлбөрийн буюу хохирлын хэлбэр: эдийн ба эдийн бус хохирол (ёс суртахууны хохирол), нөхөн төлбөрийн хэмжээ, түүнийг тогтоох, үнэлэх нь**

Хохирогчийн эрхийн талаар Засгийн газрын мэдээллийн хуудаст иргэний нэхэмжлэл гаргах хохирлын төрлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- a) Бие махбод, сэтгэл мэдрэлд учруулсан хохирол;
- b) Тав тухтай амьдрах боломжгүйгээс үүссэн хохирол: эрхэлдэг ажил, тогтсон хэв маягаараа амьдрах боломжгүй болсон өөрөөр хэлбэл сонирхдог спорт, хоббигоо үргэлжлүүлэх боломжгүй болох;
- c) Хэмжих аргагүй- ёс суртахууны хохирол, ойр дотнын хүнээ алдах, нэр хүнд унах; г.м.
- d) Өмч хөрөнгийг эвдэх, гэмтээх зэрэг эд материалын хохирол учруулах.

### **3. Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллээр хангагдах эрх буюу мэдээлэл өгөх талаар үүрэгжүүлсэн эрх зүйн зохицуулалт**

ЭХХШТХ-ийн 53(1), 75 дугаар хэсгүүдэд цагдаагийн мөрдөн байцаах албаныхан болон шүүхийн цагдаа нь хохирогчдод эрхийнх нь талаар мэдээлэл өгөх ёстой гэж заажээ. Нэн ялангуяа хохирогч өөрт нь учирсан хохирол, гэмтлийн төлөө нөхөн төлбөр авах хэрэгтэйг онцгойлон заажээ.

### **4. Гэмт хэрэгтнээр хохирол төлүүлэх зорилгоор эд хөрөнгийг нь хураах эрх зүйн зохицуулалт**

Эрүүгийн хуулийн 225-ийн 25 дугаар заалтын дагуу хүний худалдаа энэ зорилгоор үйлдсэн гэмт хэрэгтэй холбоотой нэмэлт шийтгэл болгон яллагдагчийн хөрөнгийг хураан авах боломжтой. "Гэмт этгээдийн аль нэгэн болон бүх хөрөнгийг, хөдлөх болон үл хөдлөх түүнчлэн хамтран буюу дангаараа эзэмшигч хөрөнгийн төрлийг үл харгалзан хураан авна" гэж заажээ. Эрүүгийн хуулийн 225-ийн 25 дугаар заалтын дагуу хүний худалдаа энэ зорилгоор үйлдсэн гэмт хэрэгтэй холбоотой нэмэлт шийтгэл болгон яллагдагчийн хөрөнгийг хураан авах боломжтой. (Эрүүгийн хуулийн 5 дугаар бүлгийн 1бис, 2 заалтууд). Үүний дотор "гэмт этгээдийн аль нэгэн болон бүх хөрөнгийг, хөдлөх болон үл хөдлөх түүнчлэн хамтран буюу дангаараа эзэмшигч хөрөнгийн төрлийг үл харгалзан хураан авна" гэж заажээ.

### **5. Төрөөс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох төрийн тусгай сан буюу захиргааны журмаар хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа**

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох комисс (CIVI)-аар дамжуулан төрөөс хохирлын нөхөн төлбөр авах боломжтой. Гэмт хэрэг Францын нутаг дэвсгэр дээр үйлдэгдсэн тохиолдолд, дараах иргэдийн хувьд энэхүү төлбөрийн системийг хэрэглэнэ. (Францын эх газар, далайн чанад дахь муж, нутаг дэвсгэр )

- a) Францын харьяат;
- b) Европын холбооны гишүүн орнуудын харьяатууд;
- c) Олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдсэн улс орны харьяат, тухайн тогтолцоог хэрэглэх үед Францад хууль ёсоор амьдарч байсан гадаадын харьяат.

Хэрвээ гэмт хэрэг хилийн чанд үйлдэгдсэн бол зөвхөн Францын иргэншил бүхий хүн төлбөр авах хүсэлт гаргах эрхтэй.

Алан хядлага болон бусад төрлийн гэмт үйлдлийн хохирогчдод туслах баталгаат сан нь ЭХХША-нд нэхэмжлэгчээр оролцож болдог

бөгөөд энэ тохиолдолд хохирогч ганцаараа нэхэмжлэл гаргаснаас илүү үр дүнд хүрч болдог байна. Учир нь шүүх хувь хүнтэй харьцахаас илүүтэйгээр дээрх баталгаат сантай илүү үр нөлөөтэй хамтран ажиллаж чаддаг байна. Тухайн гэмт үйлдэл тохиолдсоноос хойш 3-н жилийн дотор эсвэл эрүүгийн гэмт хэргийг шүүн таслах ажиллагаа явагдаж эцсийн шийдвэрээ гаргаснаас хойш 1 жилийн дотор нөхөн төлбөр авах өргөдлөө гаргана. Хэрвээ комисс хугацааг сунгах үндэслэлтэй гэж үзвэл дээрх хугацааг сунгаж болно. Ямар ч төрлийн нөхөн төлбөр байсан дээрх журам бүгдэд нь хамаарна.

Алан хядлага болон бусад төрлийн гэмт үйлдлийн хохирогчдод төлбөр олгох баталгаат сан 2004 онд 16877 өргөдлийг хүлээн авч шийдвэрлэжээ. 2004 онд хийсэн нийт төлбөрийн хэмжээ 209,541,638 евро болсон бөгөөд гэмт хэрэгтнүүдээс тухайн жил 32 сая евро хураан авчээ. Энэ нь нийт төсвийнхөө 15 хувийг эргүүлэн олсон гэсэн үг юм. Гэхдээ энэ нь уг тогтолцоог хэрэгжүүлэхэд зарж буй нийт зардалд хамаарахгүй юм. Энэхүү тогтолцоо нь яллагдагч болон эрүүгийн шүүн таслах ажиллагаа явагдаагүй байх үед ч гэсэн нөхөн төлбөр авах нэхэмжлэл гаргах боломж олгодгоороо ихээхэн давуу талтай бөгөөд түүнийг хэрэглэх журам ч харьцангуй энгийн бөгөөд хялбар юм. Гэмт хэргийг хүн худалдаалах гэмт хэрэг мөн гэж нэгэнт тогтоосон нөхцөлд хуулийн зөвлөгөө өгдөг бөгөөд хохирогчид нөхөн төлбөрийг бүрэн бүтэн (ёс суртахууны болон эд материалын хохирлыг оролцуулан) олгодог байна. Энэ тогтолцоогоор яллагдагчийн учруулсан хохирлыг нэхэмжлэх үүргийг тогтолцоо өөртөө хүлээдэг бөгөөд ингэснээрээ гэмт этгээдийг хохирлыг төлөх үүрэг хариуцлагаас бултах замгүй болгодог ба түүнчлэн хохирогч өр төлбөрөө иргэний шүүхээр дамжуулан барагдуулах гэж хөөцөлдөх ачааллаас салдаг байна.

Уг сан нь нэхэмжлэгчид төлбөр олгохтой холбогдсон саналаа 2 сарын дотор өгнө. Хэрвээ нэхэмжлэгч уг саналыг хүлээн авбал баталгаат сан нь энэ тухай хэлэлцээрийг хохирогчдод нөхөн төлбөр олгох комиссын даргад илгээх бөгөөд түүний баталсны дараа төлбөрийг хийнэ. Хэрвээ нэхэмжлэгч баталгаат сангийн дэвшүүлсэн саналыг хүлээн авахаас татгалзах буюу түүнийг эсэргүүцэж байгаа бол ямар шалтгаанаар ингэснээ мэдэгдэх ёстой бөгөөд үүгээр асуудлыг маргаангүйгээр зохицуулах үе шат дуусаж түүнийг шийдвэрлэх үйл ажиллагаа төлбөр олгох комисс дээр үргэлжлэн явагдах болно. Энэ тохиолдолд комисс нь нэхэмжлэлийг Прокурорын алба болон баталгаат санд илгээх бөгөөд эдгээр байгууллагууд өөрсдийн саналаар шүүхийн хурал эхлэхээс өмнө 14 хоногоос дутуугүй хугацааны өмнө ирүүлэх ёстой. Хурал эхлэхээс өмнө наад зах нь 2 сарын өмнө нэхэмжлэгч болон баталгаат санд зарлан дуудах хуудас өгсөн байна. Хурлыг хаалттай явуулах ба нөхөн төлбөр олгох комисс нэхэмжлэлийг хүлээн авч төлөх

эсвэл татгалзах шийдвэрээ гаргана. Ингээд баталгаат сан болон нэхэмжлэгчид уг шийдвэрээ уламжилна. Баталгаат сан нь харилцан тохирсон төлбөрийг мэдэгдэл авснаас хойш 1 сарын дотор хийж дуусгана.

Нэхэмжлэгч болон баталгаат сан аль аль нь даван заалдах эрхтэй. Шүүхийн шийдвэрийг хүлээн авсны дараа 1 сарын дотор даван заалдах өргөдлийг хуульчаар дамжуулан гаргана. Төлбөр хийх хүсэлтийг нөхөн төлбөр хийх комиссын даргад гаргах бөгөөд тэрээр хүсэлтийг хүлээж авснаас хойш 1 сарын дотор хариугаа өгөх ёстой.

## **6. Хохирогчид нөхөн төлбөр олгож буй шат дараалал, хариуцах байгууллага буюу институтын тогтолцоо**

Нөхөн төлбөр авахын тулд хохирогч гэмт хэргийн талаар цагдаад мэдүүлсэн байх ёстой. Харин гэмт этгээдийг хэн болохыг тогтоосон эсвэл тэрээр шийтгэгдсэн байх албагүй. Эрүүгийн гэмт хэргийг шүүх ажиллагаа явж байгаа бол түүнийг заавал дуусгасан байх. Түүнчлэн яллагдагчийн эсрэг иргэний нэхэмжлэл заавал гаргасан байх шаардлагагүй.

Нэхэмжлэлийг нөхөн төлбөр олгох комисс хүлээн авсны дараа түүнийг шүүгч, мөрдөн байцаагч хянан шалгана. Шүүгч дараах эрх мэдлийг хэрэгжүүлнэ: гэмт хэргийн талаарх хэргийн холбогдох бүх материалыг эрүүгийн шүүн таслах хуралд оруулах, энэ ажиллагаа үргэлжилж байгаа нөхцөлд ч, тэдгээр материалыг ашиглуулахаар явуулах болон гэрчийг дуудаж байцаах, мөрдөн шалгах ажлыг өөрийн үзэмжээр үргэлжлүүлэн явуулах.

Ийнхүү цуглуулсан бүх баримт материалыг хохирогчид нөхөн төлбөр олгох комисс аллага болон бусад төрлийн гэмт үйлдлийн хохирогчдод туслах баталгаат санд явуулна. Уг сан нь нэхэмжлэгчид, төлбөр олгохтой холбогдсон саналаа 2 сарын дотор өгнө. Хэрвээ нэхэмжлэгч уг саналыг хүлээн авбал баталгаат сан нь энэ тухай хэлэлцээрийг хохирогчдод нөхөн төлбөр олгох комиссын даргад илгээх бөгөөд түүний баталсны дараа төлбөрийг хийнэ. Хэрвээ нэхэмжлэгч баталгаат сангийн дэвшүүлсэн саналыг хүлээн авахаас татгалзах буюу түүнийг эсэргүүцэж байгаа бол ямар шалтгаанаар ингэснээ мэдэгдэх ёстой бөгөөд үүгээр асуудлыг маргаангүйгээр зохицуулах үе шат дуусаж түүнийг шийдвэрлэх үйл ажиллагаа төлбөр олгох комисс дээр үргэлжлэн явагдах болно. Энэ тохиолдолд комисс нь нэхэмжлэлийг Прокурорын алба болон баталгаат санд илгээх бөгөөд эдгээр байгууллагууд өөрсдийн саналаар шүүхийн хурал эхлэхээс өмнө 14 хоногоос дутуугүй хугацааны өмнө ирүүлэх ёстой. Хурал эхлэхээс өмнө наад зах нь 2 сарын өмнө нэхэмжлэгч болон баталгаат санд зарлан дуудах хуудас

өгсөн байна. Хурлыг хаалттай явуулна. Нөхөн төлбөр олгох комисс нэхэмжлэлийг хүлээн авч төлөх эсвэл татгалзах шийдвэрээ гаргана. Ингээд баталгаат сан болон нэхэмжлэгчдэд уг шийдвэрээ уламжилна. Баталгаат сан нь харилцан тохирсон төлбөрийг мэдэгдэл авснаас хойш 1 сарын дотор хийж дуусгана.

## **7. Нөхөн төлбөр авах эрх үүсэх шалгуур, бүрдүүлэх материал, зарцуулах хугацаа, олгох нөхөн төлбөрийн төрөл**

Хохирогч тухайн хохирол нь гэмт хэргээс шууд үүдэлтэй гэдгийг тодорхой нотолж чадаагүй тохиолдолд нөхөн төлбөрийн хэмжээг бууруулах, эсвэл бүр олгохгүй ч байж болно.

Хэрвээ хохирогч өөрөө буруутай бол төлбөрийн хэмжээг бууруулах буюу бүр төлөхгүй байж болно. Жишээ нь хохирогч нөгөө этгээдийг үг хэлээр доромжилсон, зодоон нүдээн хийсэн биеэ туйлын зохимжгүй байдлаар авч явсан байж болно. Энэ заалт нь нас барсан хохирогчийн төрөл саданд ч мөн хамаарна. Хохирогчдод нөхөн төлбөр олгохдоо комисс нийгмийн халамж, хувийн даатгалаас авсан төлбөрийн хэмжээг суутгаж тооцно. Хохирогчид иргэний нэхэмжлэгчийнх нь хувьд эрүүгийн шүүн таслах хурлаас олгох болсон төлбөрийн хэмжээг ямар ч хэмжээгээр хасан бууруулж болох бөгөөд хэрвээ тэр төлбөрийг хохирогч авсан бол түүнийг буцаан төлөх шаардлага ч гарна.

Ноцтой гэмт хэргээс хохирогчдод нөхөн төлбөрийг бүрэн хэмжээгээр олгоно. Үүнд:

- a) Гэмт хэргийн уршгаар хүн амь насаа алдсан бол, байнга тахир дутуу болсон буюу хөдөлмөрийн чадамжаа 1 сар эсвэл түүнээс урт хугацаагаар алдсан бол;
- b) Хүчин, бэлгийн түрэмгийлэл, хүний худалдаа эсвэл 15 болон түүнээс бага насны хүний эсрэг хүчингийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд

Хариуцлагын тухай хуульд тодорхойлсноор "хүнд учруулсан хохирол нь шууд буюу шууд бусыг үл харгалзан бүх л төрлийн хохирлыг тооцон үзнэ" гэжээ. Хэрвээ хохирогч нь гэмт хэргийн хохирогчдод тусламж үзүүлэх баталгаат сангаас бүрэн хэмжээний төлбөр авах нөхцөлийг хуулийн дагуу бүрэн дүүрэн хангаж чадаагүй (өөрөөр хэлбэл тухайн хүний биед учруулсан гэмтэл нь 1 сар хүрэхгүй хугацаанд хөдөлмөрийн чадамжаа алдахад хүргэсэн эсвэл хохирогч зөвхөн эд хөрөнгийн хохирол амссан) тохиолдолд холбогдох шалгуур үзүүлэлтийг хангасан байдлыг харгалзан хязгаарлагдмал хэмжээний төлбөр авах эрхтэй. Энэ тохиолдолд төлбөрийн дээд хэмжээ 2008 онд олгосон 3984 еврогоор хязгаарлагджээ.



Хохирогчийн гаргасан өргөдлийн дагуу урьдчилсан төлбөрийг хийж болно. Өргөдөлд дараах мэдээллийг багтаасан байх хэрэгтэй:

- a) Тухайн гэмт үйлдэл гарсан газар орон, нөхцөл байдал, он сар (энэ талаар гаргасан гомдол эрүүгийн шүүн таслах ажиллагаатай холбогдсон баримт бичгийн хувь г.м.);
- b) Яллагдагчийг шүүсэн шүүхийн шийдвэр;
- c) Ямар гэмтэл авсан, ажлаа хийгээгүй байсан хугацаа (эмнэлгийн магадалгаа, өвчний түүх, шинжилгээ хийсэн тухай эмнэлгийн дүгнэлтүүд);
- d) Элдэв маргаан үүсээгүй өргөдөл гомдол гаргасан, шүүх ажиллагаа эхэлсэн, төлбөрийг хийж эхлээд тодорхой хэмжээний мөнгө төлсөн тохиолдолд (өдөр тутмын амьжиргаанд зориулан олгосон мөнгөний баримт, тэтгэвэр яллагдагч этгээдийн болон даатгалын компаниас төлсөн мөнгөний хэмжээ г.м.);
- e) Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох комиссын нэхэмжилсэн төлбөрийн хэмжээ.

Хэрвээ нэхэмжлэлийг шалган тогтоосон хөрөнгөнөөс (ЭХХШТХ-ийн 706-14 дүгээр зүйл ) төлбөр авахаар гаргаж байгаа бол нэхэмжлэгчийн орлогыг тодорхойлсон байх шаардлагатай бөгөөд (өмнөх оны ашиг орлогын татвараар баталгаажуулсан) түүнчлэн хохирогч ямар нэгэн даатгалд хамрагдаагүй, гэмт хэргийн улмаас эд материалын болон санаа сэтгэл, ёс суртахууны талаар хүнд байдалд орсныг нотлох баримт.

## **8. Тохиолдол, шийдвэрлэсэн байдал**

Нэгэн Франц гэр бүл 15 настай Того охиныг сургуульд явуулна, цагаачлалын статусыг нь зохицуулна гэж амлан Франц улсад авчирчээ. Тэр охиныг сургуульд явуулаагүй, хийсэн ажилд нь хөлс мөнгө төлөөгүй төдийгүй паспортыг нь хураан авсан. Хэсэг хугацааны дараа түүнийг өөр нэгэн гэр бүлд "зээлжээ" тэнд уг охин өглөө 7.30-аас оройн 22.30 хүртэл гэр орны ажил хийдэг байсан бөгөөд зөвхөн ням гаригийн мөргөлд явахыг нь зөвшөөрдөг байжээ. Охин хүүхдийн өрөөнд шалан дээр гудсан дээр унтаж, шөнө хүүхэд асардаг байжээ. Тэр охин тэндээс зугтаж өөр нэгэн газар цалин хөлс авч, гэр орны ажил хийж байсан боловч тухайн гэр бүл өмнөх айлын шахалт, цагаачлалын статусыг нь зохицуулна гэсэн амлалтын дагуу хуучин айлд нь буцаажээ. Гэвч тэр айл амлалтаа биелүүлсэнгүй хуучин байдал хэвээр үлджээ. Тэр охинд нэгэн удаа өөрийн паспортыг авах боломж гарсан бөгөөд хөрш айлдаа өөрийн нөхцөл байдлыг ярьж өгсөн бөгөөд тэр айл нь нэгэн ТББ- д энэ тухайн мэдээлжээ. Цагдаагийн газар дээрх гэр бүлийн эсрэг хуулийн арга хэмжээ авч уг охинд нөхөн төлбөр (15245 евро) олгожээ. Ажил эрхлэх

асуудал эрхэлсэн шүүхээс тэр охинд өнгөрсөн хугацаанд аваагүй цалин хөлсөнд нь 31238 евро төлүүлэх шийдвэр гаргасан байна.

## ДҮГНЭЛТ

Франц улс нь төрөөс болон яллагдагчаас нөхөн төлбөр авах нэхэмжлэл авах нэлээд зүгширсэн тогтолцоотой мөн энэ чиглэлээр багагүй сайн туршлага жишээ хуримтлуулсан орон юм. Хуулийг зөвлөгөө өгдгөөс гадна энэ чиглэлээр өргөн хүрээтэй үйл ажиллагаат явуулж туршлагажсан ТББ-тай.

Гэвч энэхүү тогтолцоог хүний худалдааны хохирогчдын хэрэгцээ шаардлагад тохируулан боловсруулаагүй хүн худалдсан хэргээр шүүн таслах явдал бараг гардаггүй ажээ. Энэ нь амьдрал дээр нөхөн төлбөр олж авах явдал хязгаарлагдмал гэдгийг харуулж байна. Түүнчлэн иргэний нэхэмжлэлээр гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд ихээхэн бэрхшээл учирдаг бөгөөд төлбөр хийх шийдвэр гарсан ч төлбөрийг барагдуулах тохиолдол ховор байдаг байна. Ийм учраас хүний худалдааны хохирогч хэрвээ хуулийн байгууллага, хуульчид төлбөрийг барагдуулах эрмэлзэлтэй, оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй бол хохирогч төлбөрөө олж авахын тулд багагүй саад бэрхшээлийг давах шаардлагатай болдог. Хэрвээ хохирогч нь францад оршин суудаггүй бол шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх асуудал нь бүр ч хүндрэлтэй байх болно. (тухайлбал оршин суух зөвшөөрлийн хугацаа дууссаны дараа)

Бичиг баримтгүй ажилчдыг хөдөлмөрийн хуулиар хамгаалж ирсэн уламжлалтай гэвч ТББ-ууд ажилчид нь энэ тогтолцоог цагаачлалын албадад мэдэгдэлгүйгээр ашиглаж болно гэдэгт нэг их итгэдэггүй байна. Төлөөгүй цалин хөлсийг олж авах өөр журам боломж байдаг бөгөөд үүнийг ТББ-ууд эрүүгийн таслан шийтгэх ажиллагаатай хослуулан идэвхтэй хэрэглэж иржээ.

### Франц улсын сайн туршлагууд

- Нөхөн төлбөр хийх төрийн сангийн тогтолцоогоор төр урьдчилсан буюу түр төлбөрийг хийдэг;
- Төрөөс санхүүжүүлдэг нөхөн төлбөрийн тогтолцоо нь яллагдагчийг иргэний шүүхээр мөрдөн байцаах боломж олгодог;
- Төрөөс санхүүжсэн тогтолцооноос бүрэн хэмжээний нөхөн төлбөр олгодог;
- Төрийн тогтолцоо нь ёс суртахууны хүчирхийллийг хүчирхийлэл гэж хүлээн зөвшөөрдөг;
- Иргэний нэхэмжлэлийг эрүүгийн шүүн таслах ажиллагааны үеэр, уг ажиллагаа эхлэхэд бус харин шүүхийн шийдвэр гаргах өдөр хүртэл хүлээж байгаад нэхэмжлэл гаргаж болдог;

- Хуулийн дагуу цагдаа нар хохирогчид түүний эрхийг ярьж таниулах үүрэгтэй;
- Ёс суртахууны талаар учруулсан хохиролд багагүй хэмжээний нөхөн хийх зарчмыг шүүх хүлээн зөвшөөрдөг;
- Яллагдагчийн барьцаанд тавьсан мөнгийг хохирогчийн төлбөрийг барагдуулахад ашиглаж болдог;
- Төрөл бүрийн хохирогчдод тусламж үзүүлэх ихээхэн идэвхтэй өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг тбб-уудтай, тбб –ууд нь төрийн агентлагуудтай түншийн харьцаатай ажиллаж буй жишээ бий;
- Эрүүгийн байцаан шийтгэх болон хөдөлмөр эрхлэлтийн хуулийг нэгэн зэрэг хэрэглэх хууль эрхийн үндсийг боловсруулж байна. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн шүүх эрүүгийн гэмт хэргийн шүүхээс бараг хоёр дахин илүү хэмжээний мөнгийг төлөх шийдвэр гаргасныг силиядиний хэргээс харж болно.

### 3.3. НИДЕРЛАНД УЛС

АНУ-ын Засгийн газрын үнэлгээгээр Нидерланд улс нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой тус улсын шаардлагыг бүрэн хангасан (Tier 1) орны нэг юм.<sup>96</sup> Нидерланд улс нь Европын Холбооны гишүүн улс тул дотоод хууль тогтоомж нь Европын холбооны хууль тогтоомжид нийцэх бөгөөд Европын холбооноос гаргасан дүрэм, журам зэрэг нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийн эрхийг хамгаалах, нөхөн төлбөр олгох зэрэг харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тус улсад, 2014 онд энэ төрлийн гэмт хэрэг 52 бүртгэгдэж нийт 55 хохирогч тогтоогдож, 86 нэхэмжлэл гаргаж, шүүхээс 67 нэхэмжлэлийг бүрэн эсхүл хэсэгчлэн хангасан байна.<sup>97</sup>

Европын холбооны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тухай 2011 оны 2011/36/EU тоот журмаар<sup>98</sup> энэ төрлийн гэмт хэргийн ойлголт, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх механизмыг зохицуулсан. Тус журмын 2 дугаар зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолтыг авч үзвэл, хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах,

<sup>96</sup> U.S. Department of State, 2023 Trafficking in Persons Report: Netherlands, <https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/netherlands/>

<sup>97</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.59 [https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSuc\\_N84AqZCI8I\\_S\\_6DOdC4MEkg4OVofA](https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSuc_N84AqZCI8I_S_6DOdC4MEkg4OVofA)

<sup>98</sup> Directive 2011/36/EU OF the European Parliament and of the Council of 5 April 2011 on preventing and combating trafficking in human beings and protecting its victims, and replacing Council Framework Decision 2002/629/JHA., <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:32011L0036>

хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээн авах үйлдлийг хэлнэ гэжээ.<sup>99</sup> Тус үйлдлийг хүүхдийн эсрэг (18 хүртэлх насны) үйлдсэн бол дээр заасан аргыг ашигласан байхыг шаардахгүй бөгөөд гэмт хэрэгт тооцно. Үүнээс үзэхэд, гэмт хэргийн ойлголт, тодорхойлолт, объектив үйлдлийн хувьд олон улсын эрх зүйн зохицуулалт болох НҮБ-ын Үндэстэн дамнасан Гэмт хэрэгтэй тэмцэх конвенцын нэмэлт протокол болох Хүнийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдах гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх, уг гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэгтнүүдийг шийтгэх протоколын зохицуулалттай ижил.

Европын холбооны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тухай 2011 оны 2011/36/EU тоот журмын 4 дүгээр зүйлд гэмт хэрэгтэнд оногдуулах ял шийтгэлийн доод хэмжээг тогтоосон. 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн этгээдэд ногдуулах ялын дээд хэмжээ нь хамгийн багадаа 5 жил, тус гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн, эсхүл зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн, эсхүл хохирогчийн амь насанд хохирол учруулсан эсхүл хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан нөхцөлд хамгийн багадаа 10 жил байхаар тусгахыг Гишүүн улс бүрд үүрэг болгосон. Мөн хуулийн этгээдэд ногдуулах эрүүгийн хариуцлага зайлшгүй байх талаар тусгаснаас гадна хуулийн этгээдэд ногдуулах ял шийтгэлийн төрлийг тусгасан байна.

Мөн Гишүүн улс бүр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг бие бялдар, сэтгэл зүй болон нийгэмд эзлэх байр суурийн хувьд нөхөн сэргээх арга хэмжээг авах үүрэг хүлээсэн. Тухайлбал, орон байраар хангах, хохирогчдод ойлгогдох хэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, эмнэлгийн, сэтгэл зүйн болон материаллаг туслалцаа үзүүлэх, хөдөлмөрлөх, боловсрол эзэмших боломжоор хангах гэх мэт. Цаашлаад Гишүүн улс бүр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр олгох боломж, тогтолцоог дотоодын хууль тогтоомждоо тусгах үүрэг хүлээсэн.

**Дотоодын хууль тогтоомжийг нарийвчлан авч үзвэл,** Нидерландын Эрүүгийн хуулийн 237f зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг заасан. Тус зүйлд гэмт хэргийн сэдэл, зорилго, объектив үйлдэл, арга, хэрэгслийг тодорхойлсон байдал нь Палермогийн протокол, Европын холбооны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан

<sup>99</sup> Article 2, Directive 2011/36/EU OF the European Parliament and of the Council of 5 April 2011 on preventing and combating trafficking in human beings and protecting its victims, and replacing Council Framework Decision 2002/629/JHA.

сэргийлэх, хохирогчийг хамгаалах тухай 2011 оны 2011/36/EU тоот журамтай адил. Гэсэн хэдий ч гэмт хэрэг үйлдэгдэнэ гэдгийг мэдсээр байж ийнхүү гэмт хэрэг үйлдэгдэх орчин нөхцөлийг үүсгэхээр хохирогчийг албадах, өдөөх, ятган үнэмшүүлэх үйлдэл нь мөн хүн худалдаалах гэмт хэрэгт тооцогдоно.<sup>100</sup> Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг бодитоор үйлдэгдээгүй боловч гэмт хэргийг үйлдэхээр хохирогчийг албадах, ятган үнэмшүүлэх замаар гэрээ, хэлцэл байгуулсан зэрэг үйлдэл үүнд хамаарна.<sup>101</sup> Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг 12 жил хүртэлх хорих ял эсхүл 5 дугаар түвшний торгуулийн ялаар шийтгэнэ.<sup>102</sup>

Гэмт хэргийг 2 буюу түүнээс дээш этгээд хамтарч үйлдсэн бол, гэмт хэргийг 18 нас хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол, гэмт хэргийг үйлдэхдээ хохирогчийг хүчирхийлсэн бол 15 жил хүртэлх хорих ял эсхүл 5 дугаар түвшний торгуулийн ялаар шийтгэнэ.<sup>103</sup>

Гэмт хэргийг үйлдэхдээ хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учруулж эсхүл амь насыг заналхийлсэн бол 18 хүртэлх ялаар эсхүл 5 дугаар түвшний торгуулийн ялаар, хохирогчийн амь насыг хохироосон бол 30 хүртэлх жил эсхүл 5 дугаар түвшний торгуулийн ялаар тус тус шийтгэхээр хуульд тусгажээ.<sup>104</sup>

Түүнчлэн Хууль зүйн туслалцааны тухай хуулийн дагуу хүнд эсхүл хүчиндэх гэмт хэргийн хохирогч хуульд заасан санхүүгийн байдлын шалгуурыг хангасан эсэхээс үл хамааран Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн сан (Criminal Injuries Compensation Fund)-гаас нөхөн төлбөр авах шалгуурыг хангасан бол үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах боломжтой байдаг. Хөдөлмөрийн мөлжлөг хийх зорилгоор үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч дээрх хуулийн дагуу хууль зүйн туслалцаа авахын тулд хуульд заасан санхүүгийн байдлыг хангасан байх ёстой. Зарим судлаачид бэлгийн мөлжлөгтэй адил хөдөлмөрийн мөлжлөгийн хохирогчдод ч мөн хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.<sup>105</sup>

Мөн хохирогчийн хүсэл зоригийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргээс бусад тохиолдолд хууль зүйн туслалцаа үнэгүй үзүүлдэггүй байна.<sup>106</sup>

<sup>100</sup> Translation of Article 237f of Dutch Penal Code, <https://eucpn.org/sites/default/files/document/files/NL.pdf>.

<sup>101</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.26 [https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZklN8o5ru9C-xQNLswSSSuc\\_N84AqZCl8l\\_S\\_6DOdC4MEkq4OVofA](https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZklN8o5ru9C-xQNLswSSSuc_N84AqZCl8l_S_6DOdC4MEkq4OVofA)

<sup>102</sup> Translation of Article 237f of Dutch Penal Code, <https://eucpn.org/sites/default/files/document/files/NL.pdf>.

<sup>103</sup> Мөн тэнд.

<sup>104</sup> Мөн тэнд.

<sup>105</sup> Marijn Heemskerck, Compensation for victims of human trafficking in the Netherlands, 2013,

<https://documentation.lastradainternational.org/lisidocs/3087-Compensation%20for%20Victims%20of%20Human%20Trafficking%20in%20The%20Netherlands.pdf> , p.10

<sup>106</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.26

[https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZklN8o5ru9C-xQNLswSSSuc\\_N84AqZCl8l\\_S\\_6DOdC4MEkq4OVofA](https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZklN8o5ru9C-xQNLswSSSuc_N84AqZCl8l_S_6DOdC4MEkq4OVofA)

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон гадаадын иргэнд Нидерланд улсад оршин суух эрхийг тодорхой хугацаанд олгож болох бөгөөд энэ нь тухайн иргэнд гэмт хэрэгтний эсрэг гомдол гаргах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, нөхөн төлбөр авах эрхийг хангахад чиглэсэн байна.<sup>107</sup> Прокурорын газар (the Public Prosecution Service)-аас гадаадын иргэн гэмт хэргийн хохирогч болсон бөгөөд цаашид Нидерланд улсад тодорхой хугацаанд оршин суух шаардлагатай талаар Цагаачлалын албанд (the Immigration and Naturalisation Service)-д мэдэгдсэн тохиолдолд орших суух зөвшөөрөл олгодог.

## **1. Хохирогчид нөхөн олговор олгох эрх зүйн зохицуулалтын салбар буюу эрүү, иргэн, хөдөлмөрийн хуулийн журмаар нөхөн олговор олгох ажиллагааны онцлог, зохицуулалт**

Тус улсад Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох талаар бие даасан хууль байхгүй. Тус гэмт хэргийн хохирогч иргэний болон эрүүгийн шүүхэд хандах замаар нөхөн төлбөрөө нэхэмжлэх боломжтой. Хөдөлмөрийн байцаагчид хандаж болох боловч одоогоор хөдөлмөрийн байцаагч хохирлыг барагдуулах боломжгүй, өөрөөр хэлбэл гагцхүү гэмт хэрэгтэнд торгууль ногдуулдаг.

### **1.1. Иргэний журмаар хохирол төлүүлэх ажиллагаа**

Хохирогчийн нэхэмжлэлийг эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлээгүй тохиолдолд хохирогч иргэний шүүхэд нэхэмжлэл гаргах бүрэн боломжтой. Гэсэн хэдий ч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хувьд иргэний шүүхэд нэхэмжлэл гаргах нь зардал, чирэгдэл ихтэй шийдэл байж болох талаар тэмдэглэжээ.<sup>108</sup>

### **1.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хохирол нөхөн төлүүлэх**

2013 оны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх заавар (the Human Trafficking Guidelines (2013)-т<sup>109</sup> хохирогч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний нэхэмжлэгчээр оролцох боломжтой бөгөөд хэрвээ хохирогч нөхөн төлбөр шаардах хүсэлтэй байгаа талаар илэрхийлсэн тохиолдолд прокурорын газраас хохирогчид ийнхүү нөхөн төлбөрөө амжилттай авахад шаардагдах туслалцааг

<sup>107</sup> Chapter B8/3 of the Aliens Act Implementation Guidelines 2000 (Vreemdelingen-circulaire 2000 or Vc 2000) See the introduction of B8/3 scheme at <https://repository.wodc.nl/bitstream/handle/20.500.12832/3285/3349-evaluatie-van-de-wijziging-van-de-B8-3-regeling-summary.pdf?sequence=6&isAllowed=y>

<sup>108</sup> FairWork, Compensation for victims of human trafficking in The Netherlands, 2013.

<https://documentation.lastradainternational.org/doc-center/3087/compensation-for-victims-of-human-trafficking-in-the-netherlands>

<sup>109</sup> Aanwijzing slachtofferrechten, <https://wetten.overheid.nl/BWBR0045831/2021-12-01>

боломжит хэлбэрээр үзүүлнэ гэж тусгажээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл (injured party claim) гаргаж болох бөгөөд энэхүү нэхэмжлэлийг эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлэж болно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 51f зүйлд энэ төрлийн нэхэмжлэлийг заасан.<sup>110</sup> Шүүх нэхэмжлэлийг хүлээн авах үндэслэлтэй эсэх талаар дүгнэлт гаргаж, эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд нөхөн төлбөрийн хэмжээг мөн шийдвэрлэдэг. Шүүхээс баримтлах нөхөн төлбөрийн жишиг үнийн тариф байхгүй.

2011 оныг хүртэл эрүүгийн шүүхээс эрүүгийн хэрэгтэй хамт иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэх эсэхийг шийдвэрлэхдээ, тухайн иргэний нэхэмжлэл нь эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдэхүйц энгийн шинж чанартай биш бол хүлээн авахаас татгалздаг байсан ба хүн худалдаалах гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг нэхэмжлэх ихэнх тохиолдол үүнд хамаарч байсан бол, 2011 оны нэмэлт, өөрчлөлтийн дараагаар тухайн нэхэмжлэл нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэт их хүндрэл (a disproportionate burden) үүсгэхээс бусад тохиолдолд татгалзахгүй байх зарчмыг баримтлах болсон.<sup>111</sup>

Цаашлаад иргэний нэхэмжлэгчээр оролцох болсон боловч шүүх хуралдаанд оролцох боломжгүй эсхүл оролцож чадаагүй тохиолдол практикт гардаг тул ийм тохиолдолд прокурор иргэний нэхэмжлэгчийн өмнөөс нөхөн төлбөр шаардаж болох талаар нарийвчлан тусгажээ. Хэдийгээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, холбогдох заавар, журамд дээр зааснаар хохирогчийн нөхөн төлбөр нэхэмжлэх эрхийг баталгаажуулсан байх боловч нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах талаар тусгай журам тогтоогоогүй. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэглэгдэнэ.

ЭХХША-ны явцад нөхөн төлбөр гаргуулах дараагийн нэг арга нь нөхөн төлбөрийн албадлагын арга хэмжээ (compensation measure) юм. Энэ нь торгуулийн ял биш боловч, прокурор хүсэлтээр эсхүл шүүгчийн санаачилгаар хохирогчид учирсан нөхөн төлбөрийг гаргуулахад чиглэсэн албадлагын арга хэмжээний төрөл бөгөөд хохирогчид нэмэлт зардал чирэгдэл үүсгэхгүй байх давуу талтай.<sup>112</sup> Нидерланд улсын Эрүүгийн хуулийн 36f зүйлд энэ төрлийн албадлагын арга хэмжээг

---

<sup>110</sup> Dutch Criminal Procedure Law, [https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/nld/1921/criminal\\_procedure\\_code\\_of\\_the\\_netherlands\\_html/Code\\_of\\_Criminal\\_Procedure\\_incorporating\\_amendments\\_up\\_to\\_October\\_2012.pdf](https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/nld/1921/criminal_procedure_code_of_the_netherlands_html/Code_of_Criminal_Procedure_incorporating_amendments_up_to_October_2012.pdf)

<sup>111</sup> Marijn Heemskerk, Compensation for victims of human trafficking in the Netherlands, 2013. [https://documentation.lastradainternational.org/lisdocs/3087-](https://documentation.lastradainternational.org/lisdocs/3087-Compensation%20for%20Victims%20of%20Human%20Trafficking%20in%20The%20Netherlands.pdf)

[Compensation%20for%20Victims%20of%20Human%20Trafficking%20in%20The%20Netherlands.pdf](https://documentation.lastradainternational.org/lisdocs/3087-Compensation%20for%20Victims%20of%20Human%20Trafficking%20in%20The%20Netherlands.pdf), p.11

<sup>112</sup> Marijn Heemskerk, Compensation for victims of human trafficking in the Netherlands, 2013.

[https://documentation.lastradainternational.org/lisdocs/3087-](https://documentation.lastradainternational.org/lisdocs/3087-Compensation%20for%20Victims%20of%20Human%20Trafficking%20in%20The%20Netherlands.pdf)

[Compensation%20for%20Victims%20of%20Human%20Trafficking%20in%20The%20Netherlands.pdf](https://documentation.lastradainternational.org/lisdocs/3087-Compensation%20for%20Victims%20of%20Human%20Trafficking%20in%20The%20Netherlands.pdf), p.9

зохицуулжээ.<sup>113</sup> Өөрөөр хэлбэл, энэ төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэх тохиолдолд хохирогчид учирсан нөхөн төлбөрийг цуглуулах нь хохирогчийн бус төрийн үүрэгт хамаарна. Гэвч шүүхээс нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг (injured party claim)-г хэрэгсэхгүй болгосон тохиолдолд энэ төрлийн албадлагын арга хэмжээг авахгүй бөгөөд хохирогч үндэслэлгүй хөрөнгөжих ёсгүй.

Албадлагын арга хэмжээг биелүүлээгүй тохиолдолд хорих ялаар солих боломжтой ч энэ нь гэмт хэрэгтний хохирол нөхөн төлөх үүргийг дуусгавар болгохгүй.

Нөхөн төлбөр төлөх албадлагын арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэхэд урьдчилан төлөх систем (advance payment system) чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Тухайлбал, нөхөн төлбөр төлөх албадлагын арга хэмжээ авсан шийдвэр хүчин төгөлдөр болсноор хойш гэмт хэрэг үйлдсэн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэл хариуцсан газар (the Central Judicial Collection Agency (CJIB)-т тохирсон хуваарийн дагуу нөхөн төлбөрийг төлөх үүрэгтэй бөгөөд тус газраас нөхөн төлбөрийг хүлээн авмагц хохирогчид шилжүүлэх ажлыг хариуцна. Нөхөн төлбөр төлөх албадлагын арга хэмжээ авсан шийдвэр хүчин төгөлдөр болсноор хойш 8 сарын дотор төлбөр бүрэн төлөгдөж дуусаагүй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэл хариуцсан газар (the Central Judicial Collection Agency (CJIB)-аас үлдэгдэл төлбөрийг хохирогчид шилжүүлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдээс үлдэгдэл төлбөрийг шаардах эрхийг шилжүүлж авч болно.<sup>114</sup> Энэхүү аргыг “advance payment system” буюу урьдчилан төлбөр төлөх тогтолцоо гэж нэрлэх бөгөөд 2011 оны 1 сараас энэ системийг нэвтрүүлсэн нь дэвшилтэт алхам болсон.

Нэхэмжлэлийг эрүүгийн болон иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэх аль ч тохиолдолд гэмт хэрэгтний үйлдэл болон хохирол хоёрын хооронд шалтгаант холбоо байхыг мөн учирсан хохирлыг нотлохыг шаардана.

### **1.3. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хохирол нөхөн төлүүлэх**

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (the Minimal Wage Act), Ажлын цаг (the Working Hours Act), and Хамтын гэрээ (Collective Labour Agreement) зэргийг зөрчсөн гэж үзэх тохиолдолд цалин хөлсөө нэхэмжлэх боломжтой. Харин Гадаадын иргэний хөдөлмөрийн тухай хууль (Foreign Nationals Employment Act)-ын 23 дугаар зүйлд зааснаар гадаадын иргэнийг 6 ба түүнээс дээш сарын хугацаанд хууль бусаар

<sup>113</sup> Criminal Code of Netherland, <https://antislaverylaw.ac.uk/wp-content/uploads/2019/08/Netherlands-Criminal-Code.pdf>

<sup>114</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.30 [https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSuc\\_N84AqZCI8I\\_S\\_6DOdC4MEkq4OVofA](https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSuc_N84AqZCI8I_S_6DOdC4MEkq4OVofA)



ажиллуулсан гэж үзэх тохиолдолд уг хугацаанд авах байсан цалин хөлсөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нэхэмжлэх боломжтой.<sup>115</sup>

Хөдөлмөрийн мөлжлөг хийх зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд энэ нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдохоос гадна Хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчсөн захиргааны зөрчлийн шинжийг бүрэн агуулдаг. Тус улсын NLA буюу Үндэсний хөдөлмөрийн байгууллагад харьяалагдах хөдөлмөрийн улсын байцаагч торгууль оногдуулж болох бөгөөд хариуцагч хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд захиргааны журмаар шүүхэд хандах боломжтой.<sup>116</sup> Хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчсөн захиргааны зөрчилд ногдуулсан торгуулийг хохирогчийн эрхийг хамгаалах, түүнд учирсан хохирлыг нөхөн төлөхөд зарцуулахыг зарим судлаачид зөвлөжээ.

## **2. Нөхөн төлбөрийн буюу хохирлын хэлбэр: эдийн ба эдийн бус хохирол (ёс суртахууны хохирол), нөхөн төлбөрийн хэмжээ, түүнийг тогтоох, үнэлэх нь**

Эдийн ба эдийн бус хохирлыг тооцож олгоно. Эдийн хохиролд алдагдал, олон ёстой байсан орлого хамаарна. Хуульд заасан тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд эдийн бус хохирлыг шаардах боломжтой.<sup>117</sup> Өмнө өгүүлснээр хохирогчид олгох нөхөн төлбөрийн талаар тусгай журам байхгүйгээс гадна Тусгай зохицуулалт байхгүй. Насанд хүрээгүй бол эцэг, эх нь энэ төрлийн нэхэмжлэл гаргах эрхтэй.

Эдийн хохирлыг нотлогдох хэмжээгээр олгох боломжтой. Эдийн хохиролд хохирогчоос гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй орох байсан орлогыг хохиролд тооцно. Иймд хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн тохиолдолд авах ёстой байсан цалин хөлс үүнд хамаарах бөгөөд цалин хөлсний доод хэмжээгээр нэхэмжилнэ. Харин Гадаадын иргэний хөдөлмөрийн тухай хууль (Foreign Nationals Employment Act)-ын 23 дугаар зүйлд зааснаар гадаадын иргэнийг 6 ба түүнээс дээш сарын хугацаанд хууль бусаар ажиллуулсан гэж үзэх тохиолдолд уг хугацаанд авах байсан цалин хөлсөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нэхэмжлэх боломжтой.<sup>118</sup> Эдийн бус хохирлыг тооцох нарийвчилсан аргачлал байхгүй.

<sup>115</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.31 [https://documentation.lastradainternational.org/lisdocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSuc\\_N84AqZCI8I\\_S\\_6DOdC4MEkq4OVofA](https://documentation.lastradainternational.org/lisdocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSuc_N84AqZCI8I_S_6DOdC4MEkq4OVofA)

<sup>116</sup> The Netherlands Labour Authority, Fining procedure, <https://www.nlLabourauthority.nl/topics/fining-procedure>

<sup>117</sup> Civil Code of Dutch, <http://www.dutchcivilaw.com/legislation/dcctitle6611bb.htm>

<sup>118</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.31 [https://documentation.lastradainternational.org/lisdocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSuc\\_N84AqZCI8I\\_S\\_6DOdC4MEkq4OVofA](https://documentation.lastradainternational.org/lisdocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSuc_N84AqZCI8I_S_6DOdC4MEkq4OVofA)

Гэмт хэрэгтнээс шаардах нөхөн төлбөрийн хэмжээнд хязгаарлалт байхгүй. Шүүх нотлох баримтыг үндэслэн нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг хэсэгчлэн эсхүл бүрэн хангах эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхтэй. ЭХХША-ны явцад хохирлын хэр хэмжээг тогтоолгохоор шинжээч томилох боломжтой.<sup>119</sup>

Эдийн ба эдийн бус хохирлоос гадна, Гаагийн шүүхээс хохирогчийн биеийг нь албадан үнэлүүлсэн тохиолдолд өдөрт 200 евро төлөхөөр тооцох жишиг тогтоосон.<sup>120</sup>

Эдийн ба эдийн бус хохиролд нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн бөгөөд шүүхийн шийдвэрт заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан хүү (statutory interest)-г шаардаж боломж бий.<sup>121</sup> Иргэний хуулийн 6:119 дүгээр зүйлд хугацаа хэтрүүлсний хохирол нэхэмжлэх урьдач нөхцөлийг мөнгөн хөрөнгийн үүргийн гүйцэтгэлийг хугацаа хэтрүүлснээс үүсэх хохирол нь үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй хугацаа дахь төлөгдөөгүй хэсэгт харгалзах хуульд заасан хүүгээс бүрдэнэ гэж заасан. Уг заалтын дагуу төлөгдөх ёстой байсан боловч хугацаа хэтрүүлсэн аливаа төлбөрийг хүүгийн хамт шаардах боломжтой.

Хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хохирогч Хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу авах ёстой байсан цалин хөлсөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож нэхэмжилнэ.

Улсын сангаас нөхөн олговор олгоход 6 шатлал бүхий жишиг тарифыг үндэслэдэг бөгөөд нөхөн олговор нь хохирогчийн бие физиологийн болон сэтгэцийн эрүүл мэндэд учирсан хохирол<sup>122</sup>, түүний улмаас үүссэн зардал, эмчилгээний зардал, олох ёстой байсан орлого зэргийг хамарна.<sup>123</sup> Сангаас олгох нөхөн олговрыг тооцох аргачлалын талаар төрийн тусгай сангийн талаарх хэсэгт нарийвчлан өгүүлнэ.

### **3. Насанд хүрээгүй хохирогчид тусгайлсан эрх зүйн зохицуулалттай эсэх**

Насанд хүрээгүй хохирогчийн эрхийг хамгаалах тусгайлан хууль журам байхгүй байна.

---

<sup>119</sup> Article 51i, Code of Criminal Procedure, [https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/nld/1921/criminal\\_procedure\\_code\\_of\\_the\\_netherlands\\_html/Code\\_of\\_Criminal\\_Procedure\\_incorporating\\_amendments\\_up\\_to\\_October\\_2012.pdf](https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/nld/1921/criminal_procedure_code_of_the_netherlands_html/Code_of_Criminal_Procedure_incorporating_amendments_up_to_October_2012.pdf)

<sup>120</sup> GRETA, Reply from the Netherlands to the Questionnaire for the evaluation of the implementation of the Council of Europe Convention on Action against Trafficking in Human Beings by the Parties, Third evaluation round, 2022. <https://rm.coe.int/reply-from-the-netherlands-to-the-questionnaire-for-the-evaluation-of-/1680a6615d>, p. 12

<sup>121</sup> Civil Code of Dutch, <http://www.dutchcivillaw.com/legislation/dcctitle6611bb.htm>

<sup>122</sup> List of injuries, [www.schadefonds.nl](http://www.schadefonds.nl).

<sup>123</sup> Application for Crime Victim Compensation, <https://www.schadefonds.nl/wp-content/uploads/2020/02/AANVRG-victim-ENG-19-v01-01-2020.pdf>

#### **4. Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллээр хангагдах эрх буюу мэдээлэл өгөх талаар үүрэгжүүлсэн эрх зүйн зохицуулалт**

Тус улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 51а дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу цагдаа, мөрдөгч, хэрэг бүртгэгч, прокурор зэрэг албан хаагч нь хохирогчийн хүсэлтээр нөхөн төлбөрийн нэхэмжлэл хэрхэн гаргах талаар мэдээлэл өгөх үүрэг хүлээдэг. Мөн хуулийн 51h зүйлийн дагуу мөрдөн байцаалтын шатанд хохирогч болон яллагдагч нарт нөхөн төлбөрийн талаар эвлэрэх боломжтой талаар мөн, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар мэдээлэл өгдөг.

#### **5. Гэмт хэрэгтнээр хохирол төлүүлэх зорилгоор эд хөрөнгийг нь хураах эрх зүйн зохицуулалт**

Тус улсын Эрүүгийн хуульд зааснаар хохирогчид учруулсан гэм хорыг арилгах, нөхөн төлөх зорилгоор гэмт хэрэгтний гэмт хэргийн улмаас олсон орлогыг хураах албадлагын арга хэмжээ авах боломжтой. Гэсэн хэдий ч энэхүү ажиллагаа нь гэмт хэрэгт гэм буруутай эсэхийг шийдвэрлэх шүүх ажиллагаатай зэрэгцэн хийгдэх ёстой гэж үздэг. Өөрөөр хэлбэл гэмт хэрэгтний гэмт хэргийн улмаас олсон ашиг, орлогыг тодорхойлох, гаргуулах, хураахтай холбогдуулан санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлдэг.

Гэмт хэрэгтэн эд хөрөнгөө бусад этгээд рүү шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор мөрдөн байцаалтын явагдаж байх үед эд хөрөнгийг хураах, битүүмжлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжтой. Ийнхүү санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэрэгтний эд хөрөнгийн хураан авах нь хохирогчийн нөхөн төлбөр авах эрхийн баталгааг хангаад зогсохгүй тус ажиллагааны явцад үйлдэгдсэн эсхүл цуглуулсан бичиг баримт, эд хөрөнгө хураан авах ажиллагааны тайлан зэрэг нь хохирогчид учирсан хохирлыг нотлоход чухал ач холбогдолтой байдаг.

2012 оны Эд хөрөнгийг хураах заавар (the Guidelines on Forfeiture)-т зааснаар хохирогч нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах хүсэлтэй байх тохиолдолд цагдаагийн байгууллагаас хохирогчтой зөвлөлдөж, хохирогчийн нэхэмжлэлийн дүн гэмт хэрэг олсон орлогоос их байх тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хөрөнгийг хураах шаардлага байгаа эсэх талаар дүгнэлт гаргана.

#### **6. Төрөөс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох төрийн тусгай сан буюу захиргааны журмаар хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа**

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн сан (Criminal Injuries Compensation Fund) гэх улсын тусгай сан байх бөгөөд энэхүү сангаас олон улсын гэрээ, конвенцод нөхөн төлбөр олгохоор тусгасан хэд хэдэн хүнд гэмт хэрэг (үүнд хүчиндэх, бэлгийн мөлжлөг зэрэг гэмт хэрэг хамаарна) -ийн хохирогч нөхөн төлбөр авах боломжтой.

Сангаас нөхөн олговор олгох нийтлэг үндэслэл нь гэмт хэрэг Нидерланд улсад үйлдэгдсэн байх шаардлагатай. Сангаас олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээ нь эдийн хохиролд 20000, эдийн бус хохиролд 15000, нийтдээ 35000 евро байдаг байна. Хохирогчид учруулсан хохирлын хэр хэмжээгээр нь үндсэн 6 дэд хязгаарт багтаан нөхөн төлбөр олгодог. Тухайлбал, хүч хэрэглэхээр заналхийлж эсхүл хүч хэрэглэн удаан хугацааны туршид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон бол 2 дугаар зэрэгт хамаарч, 2500 евро олгох бол хүчиндэх болон бэлгийн мөлжлөгийг хамтад нь үйлдсэн тохиолдолд 10000 евротой тэнцэх нөхөн төлбөр олгодог гэжээ. Бусад төрлийн мөлжлөгийг гагцхүү хүч хэрэглэн үйлдсэн байх тохиолдолд сангаас нөхөн төлбөр олгохоор зохицуулсан байна. Сангаас нөхөн төлбөр олгох үндсэн шаардлага нь хохирогч бусад эх үүсвэрээс нөхөн төлбөр аваагүй байх явдал юм. Гэсэн хэдий ч эрүүгийн хэрэг шийдвэрлэх явцад нөхөн төлбөрийн нэхэмжлэл (injured party claim) гаргасан нь сангаас нөхөн төлбөр авахаар хүсэлт гаргах эрхийг үгүйсгэхгүй. Хохирогч гэмт хэрэгтнээс нөхөн төлбөр авсан тохиолдолд санд буцаан төлөх нөхцөлөөр сангаас нөхөн төлбөрөө гаргуулан авч болдог байна. Сангаас нөхөн төлбөр авах хүсэлтийг 180 хоногт шийдвэрлэдэг нь нөхөн төлбөр авахаар шүүхэд хандахаас илүү хурдан хугацаанд нөхөн төлбөр авах боломжийг олгодог.<sup>124</sup>

Сангаас нөхөн төлбөр авахаар хүсэлт гаргасан хохирогчдын 90 орчим хувь нь нөхөн төлбөр авч чаддаг талаар тэмдэглэжээ.<sup>125</sup> Тус сангаас гэмт хэргийн улмаас учирсан хохиролд олгох нөхөн олговрыг хамгийн бага хэмжээгээр олгож байгааг анхаарч үзэх нь зүйтэй бөгөөд үүнээс дээд хэмжээний хохирол учирсан гэж үзсэн эрүү, иргэний шүүхэд хандах боломжтой юм. Учир нь төрийн тусгай сангаас олгох нөхөн төлбөр нь татвар төлөгчдийн төлсөн татвараас төлөгдөх тул хохирлыг бүрэн барагдуулахад чиглээгүй, гагцхүү хохирогчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, нийгмийн амьдралд эргэн хэвийн оролцох, ирээдүйн итгэл өгөхөд чиглэгдсэн.

Сангийн тухай хуульд зааснаар гэмт хэрэг үйлдэгдсэнээс 10 жилийн дотор Сангаас нөхөн олговор авахаар хүсэлт гаргах боломжтой.<sup>126</sup>

<sup>124</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.32 [https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSuc\\_N84AqZCI8I\\_S\\_6DOdC4MEkg4OVofA](https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSuc_N84AqZCI8I_S_6DOdC4MEkg4OVofA)

<sup>125</sup> GRETA (2018) Report Concerning the Implementation of the Council of Europe Convention on Action against Trafficking in Human Beings by the Netherlands, pp. 35-36.

<sup>126</sup> The Violent Crime Compensation Fund, <https://www.schadefonds.nl/schadefonds/>

Шүүхийн шийдвэр гарахаас өмнө хохирогч улсын санд хүсэлт гаргах замаар нөхөн олговор авч болно. Сангаас нөхөн олговор олгосны дараа шүүхийн шийдвэрээр шүүгдэгчээс нөхөн төлбөр гаргуулахаар шийдвэрлэсэн бол хохирогч энэ талаар Санд даруй мэдэгдэнэ. Хохирогч үндэслэлгүй хөрөнгөжих боломжгүй тул илүү нөхөн олговор сангаас авсан бол зөрүүг эргүүлэн өгнө.

Нөхөн төлбөр олгох шийдвэрийг Сангийн Зөвлөл шийдвэрлэх бол хүсэлт хүлээн авах, төлбөрийг шилжүүлэх чиг үүргийг Сангийн Агентлаг хариуцдаг.<sup>127</sup>

Сангийн хувьд, өмнө дурдсанаар гэмтлийн зэргээс хамаарч дараах 6 түвшинд багтаан нөхөн төлбөр олгоно.

- 1 түвшин. 1000 евро
- 2 түвшин. 2500 евро
- 3 түвшин. 5000 евро
- 4 түвшин. 10000 евро
- 5 түвшин. 20000 евро
- 6 түвшин. 35000 евро

Гэмтэл нь бие махбодын болон сэтгэцэд учирсан гэмтлээс бүрдэнэ.<sup>128</sup>

### ***Бие махбодын гэмтлийн зэргийг дурдвал***

- |          |  |
|----------|--|
| 0 түвшин | 6 долоо хоногт бүрэн эмчлэгдэх өвчин, гэмтэл. Эрүүл мэндэд үр дагавар үүсгэхгүй. Энэ түвшинд хамаарах гэмтэлд нөхөн олговор олгохгүй.  |
| 1 түвшин | 6 долоо хоногоос дээш хугацаанд эмчлэгдэх эсхүл түр зуур хөдөлмөрийн чадвараа алдсан эсхүл 24 цагаас дээш хугацаанд эмнэлгийн үйлчилгээ авах шаардлагатай.                     |
| 2 түвшин | Түр зуур хөдөлмөрийн чадвараа алдсан боловч 1 түвшинд хамаарах гэмтлээс үр дагавар ихтэй эсхүл хөдөлмөрийн чадвараа тодорхой хувиар алдсан эсхүл хагалгаанд орох шаардлагатай. |
| 3 түвшин | Хөдөлмөрийн чадвараа тодорхой хувиар алдсан бөгөөд энэ нь хохирогчийн өдөр тутмын мэргэжлийн, ажил хэргийн чадварт нөлөөлсөн эсхүл амь насанд                                  |

<sup>127</sup> The Violent Crime Compensation Fund, <https://www.schadefonds.nl/schadefonds/>

<sup>128</sup> Toelichting letsellijst, 2021. <https://www.schadefonds.nl/wp-content/uploads/2021/08/Letsellijst-20210801.pdf>

хүрэх аюулыг арилгах зорилгоор хагалгаа хийлгэх шаардлага үүссэн.

4 түвшин Хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдсан.

5 түвшин Хөдөлмөрийн чадвараа ноцтой түвшинд алдсан.

6 түвшин Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан.

Гэмтлийн зэргийг дээрх байдлаар тогтоосон бөгөөд зэрэг бүрд хамаарах өвчний шатлалыг эрхтэн бүрээр тухайлан тогтоосон. Жишээлбэл, гарын хувьд эрхий эсхүл долоовор хуруугаа алдсан тохиолдолд 3 түвшинд хамаарна.<sup>129</sup>

***Сэтгэцэд учирсан гэмтэл нь дараах зэрэгт ангилагдана. Үүнд:***

### ***1 түвшин***

1. Бэлгийн хүчирхийллийн шинжтэй үйлдэлд өртсөн. Жишээ нь бэлэг эрхтэнд нь хүрэх гэх мэт.
2. Хүч хэрэглэж эсхүл хүч хэрэглэхээр заналхийлсэн орон байрны хулгайн гэмт хэргийн хохирогч болсон.

### ***2 түвшин***

3. Бэлгийн хүчирхийллийн шинжтэй үйлдсэн өртсөн бөгөөд 1 түвшнээс илүү ноцтой шинжтэй. Жишээ нь насанд хүрсэн этгээд бага насны хүүхдэд дээр дурдсан үйлдлийг хийсэн.
4. Хүч хэрэглэх эсхүл хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар үйлдэгдээгүй хүн худалдаалах гэмт хэрэг
5. Бэлгийн мөлжлөгийн зорилгоор үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэрэг (Бэлгийн хавьталд ороогүй)
6. Хутга эсхүл галт зэвсэг ашиглан халдсан
7. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эсхүл 12 насны хүүхдийн хувьд гэр бүлийн хүчирхийллийн гэрч болсон
8. Хууль бусаар мөрдөх, заналхийлэх
9. Эд хөрөнгийг галдаж сүйтгэх (arson)

### ***3 түвшин***

10. Хүнд гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан эсхүл Зам тээврийн ослоор нас барсан хохирогчийн гэр бүлийн гишүүн

<sup>129</sup> Toelichting letsellijst, 2021. <https://www.schadefonds.nl/wp-content/uploads/2021/08/Letsellijst-20210801.pdf>

11. Хүнд гэмт хэргийн санаатай үйлдсэний улмаас нас барсан хохирогчийн гэр бүлийн гишүүн
12. Хүчирхийлэх гэмт хэрэг
13. Хүч хэрэглэх эсхүл хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэрэг
14. Бэлгийн мөлжлөгийн зорилгоор үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэрэг (Бэлгийн хавьталд ороогүй). Гэвч 2 дахь хэсэгт зааснаас ноцтой шинжтэй.
15. Хүсэл зоригийн эсрэг биеийг нь үнэлүүлсэн хүн худалдаалах гэмт хэрэг.
16. Хутга эсхүл галт зэвсэг ашиглан халдсан. Гэвч 2 дахь хэсэгт зааснаас ноцтой шинжтэй.
17. Гэр бүлийн хүчирхийлэлд удаан хугацаанд өртсөн
18. Удаан хугацаагаар ууль бусаар мөрдөх, заналхийлэх

#### **4 түвшин**

19. Хүнд гэмт хэргийн улмаас хоёр эсхүл түүнээс олон хохирогч нас барсан эсхүл Зам тээврийн ослоор нас барсан хоёр эсхүл түүнээс олон хохирогч нас барсан бөгөөд тэдгээрийн гэр бүлийн гишүүн
20. Хүнд гэмт хэргийн санаатай үйлдсэний улмаас гэр бүлийн хэд хэдэн гишүүн хүнд гэмтэл авсан
21. Удаан хугацаанд үргэлжилсэн ноцтой хүчирхийлэх гэмт хэрэг
22. Хүч хэрэглэх эсхүл хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар удаан хугацаанд үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэрэг
23. Бэлгийн мөлжлөгийн зорилгоор 1-ээс дээш жилийн хугацаанд үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэрэг (Бэлгийн хавьталд ороогүй).

#### **5 түвшин**

24. Ноцтой үр дагавар бүхий хүчирхийлэх гэмт хэрэг
25. Бэлгийн мөлжлөгийн зорилгоор 1-ээс дээш жилийн хугацаанд үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэрэг (Бэлгийн хавьталд ороогүй). Гэвч 4 дэх хэсэгт зааснаас ноцтой шинжтэй.
26. Эд эрхтэнг авсан хүн худалдаалах гэмт хэрэг

### **7. Хохирогчид нөхөн төлбөр олгож буй шат дараалал, хариуцах байгууллага буюу институтийн тогтолцоо**

Өмнө дурдсанаар, хохирогчийн нөхөн төлбөр шаардах эрхийн баталгааг хангахад Цагдаагийн байгууллага, Нидерландын хөдөлмөрийн байгууллага, Эзэн хааны хамгаалалтын алба, Хүн

худалдаалах гэмт хэргийн эсрэг зохицуулах төв (Coordination Center against Human Trafficking), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага (The Central Judicial Collection Agency (CJIB), Хохирогчийн хамгаалах төв зэрэг байгууллагууд тус бүрийн чиг үүргийг хэрэгжүүлж оролцоно.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг зохицуулах төв (Coordination Center against Human Trafficking)-өөс хариуцан ажиллуулдаг Хохирогчийн цэг (the Victims Desk буюу ("Slachtofferloket") -ээс 6 хэл дээр анхан шатны мэдээлэл, зөвлөгөө авах, эрх бүхий байгууллага, албан тушаалтантай шууд холбогдох зэрэг үйлчилгээг авна. Хохирогч, гэрч зэрэг нь Цагдаагийн байгууллага, Нидерландын хөдөлмөрийн байгууллага, Эзэн хааны хамгаалалтын алба (Royal Netherlands Marechaussee) эсхүл прокурорын газарт хандаж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гомдол гаргаж, хуульд заасан эрх, үүргийн талаар мэдээлэл авна. Үүнд нөхөн төлбөр нэхэмжлэх эрх хамаарна.

ЭХХША-ны хувьд хохирогч нэхэмжлэл гаргаж, иргэний нэхэмжлэгчийн эрх, үүргийг эдэлж шүүх хуралдаанд оролцож болно. Гэвч гэрчийн мэдүүлэг өгөх, шүүх хуралдаанд заавал орохыг шаарддаггүй.<sup>130</sup> Хохирогчийн хамгаалах төвөөс үнэ төлбөргүй хууль зүй туслалцаа үзүүлнэ.<sup>131</sup> 2013 оны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх заавар (the Human Trafficking Guidelines (2013)-т<sup>132</sup> зааснаар хохирогч нөхөн төлбөр шаардах хүсэлтэй байгаа талаар илэрхийлсэн тохиолдолд прокурорын газраас хохирогчид ийнхүү нөхөн төлбөрөө амжилттай авахад бүх шатанд туслалцаа үзүүлнэ.

Шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага (The Central Judicial Collection Agency (CJIB) - аас хариуцдаг.

Мөн Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн сан (Criminal Injuries Compensation Fund)—ийн Зөвлөлөөс нөхөн олговор олгох эсэх асуудлыг шийдвэрлэдэг.

Тогтолцооны хувьд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчийн эрхийг хамгаалах асуудлыг хүрээнд дараах хэдэн байгууллага голчлон үүрэг гүйцэтгэж байна.

Үүнд: The Repatriation and Departure Service (Dienst Terugkeer en Vertrek) буюу Нүүлгэн шилжүүлэлт хариуцсан албанаас харьяалалгүй

---

<sup>130</sup> GRETA, Reply from the Netherlands to the Questionnaire for the evaluation of the implementation of the Council of Europe Convention on Action against Trafficking in Human Beings by the Parties, Third evaluation round, 2022. <https://rm.coe.int/reply-from-the-netherlands-to-the-questionnaire-for-the-evaluation-of-/1680a6615d>

<sup>131</sup> GRETA, Reply from the Netherlands to the Questionnaire for the evaluation of the implementation of the Council of Europe Convention on Action against Trafficking in Human Beings by the Parties, Third evaluation round, 2022. <https://rm.coe.int/reply-from-the-netherlands-to-the-questionnaire-for-the-evaluation-of-/1680a6615d>

<sup>132</sup> Aanwijzing slachtofferrechten, <https://wetten.overheid.nl/BWBR0045831/2021-12-01>



иргэдэд хяналт тавих, шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй тохиолдолд цагдаад мэдэгдэнэ.

Цагдаагийн албанаас хохирогчийн аюулгүй байдлыг хангах, түүнийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд Хүн худалдаалах гэмт хэрэг, гадаадын иргэн, харьяат хариуцсан тусгай албатай (The Aliens Police, Identification and Human Trafficking Department (AVIM)).

Прокурорын газар (Public Prosecution Office) болон шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар нөхөн төлбөр нэхэмжлэхэд хохирогчийг мэдээллээр хангах, шийдвэр гаргах зэргээр ажиллана. Цаашлаад Хохирогчийн эрхийг хамгаалах төвөөс хууль зүйн туслалцаа үзүүлнэ. Мөн Прокурорын газар (the Public Prosecution Service)-аас гадаадын иргэн гэмт хэргийн хохирогч болсон бөгөөд цаашид Нидерланд улсад тодорхой хугацаанд оршин суух шаардлагатай талаар Цагаачлалын албанд (the Immigration and Naturalisation Service)-д мэдэгдсэн тохиолдолд орших суух зөвшөөрөл олгох бөгөөд хохирогчийг хилээр гаргах, шилжүүлэх процессыг тус албанаас хариуцна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах, урьдчилсан төлбөрийн системийн хүрээнд үлдэгдэл нөхөн төлбөрийг олгох зэрэг чиг үүргийг гүйцэтгэнэ.

Дээр дурдсанаас өөрөөр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, нөхөн төлбөр авах эрхийг баталгаатай эдлүүлэх хүрээнд прокурор голчлон үүрэг хүлээж оролцож байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллах хуульчдыг мэргэшүүлэхэд Хууль зүй дотоод хэргийн яам, Хохирогчийн эрхийг хамгаалах төв (“Slachtofferhulp Nederland”), Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах хуульчдын сүлжээ (Landelijk Advocaten Netwerk Zeden Slachtoffers or “LANZS”), Гэм хорын эрх зүйн хуульчдын холбоо (Vereniging van Letselschade Advocaten or “LSA “), Хууль зүйн туслалцааны зөвлөл (Raad voor rechtsbijstand), Нидерландын Хуульчдын холбоо (Nederlandse Orde van Advocaten or “NOvA”) нар хамтран ажилладаг.

## **8. Нөхөн төлбөр авах эрх үүсэх шалгуур, бүрдүүлэх материал, зарцуулах хугацаа, олгох нөхөн төлбөрийн төрөл**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл (injured party claim) гаргаж болох бөгөөд энэхүү нэхэмжлэлийг эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлэж болно.

ЭХХША явцад нөхөн төлбөр гаргуулах дараагийн нэг арга нь нөхөн төлбөрийн албадлагын арга хэмжээ (compensation measure) юм. Энэ нь торгуулийн ял биш боловч, прокурор хүсэлтээр эсхүл шүүгчийн санаачилгаар хохирогчид учирсан нөхөн төлбөрийг гаргуулахад чиглэсэн албадлагын арга хэмжээний төрөл бөгөөд хохирогчид нэмэлт зардал чирэгдэл үүсгэхгүй байх давуу талтай.<sup>133</sup> ЭХХША-ны хувьд иргэний нэхэмжлэл, түүнд холбогдох нотлох баримтыг бүрдүүлнэ. ЭХХША-аас гадна иргэний шүүхэд нэхэмжлэл гаргах замаар гэмт хэрэг үйлдсэн этгээдээс нөхөн төлбөр гаргуулж болно. Эрүү, иргэн, хөдөлмөрийн маргааны хувьд бие даасан процессын хуульд заасан хугацааг баримтална. Шүүх хуралдаан эхлэхээс өмнө нэхэмжлэл гаргана.<sup>134</sup>

Цаашлаад Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн сан (Criminal Injuries Compensation Fund) гэх улсын тусгай санд хүсэлт гаргах замаар хохирогч улсаас нөхөн олговор авах боломжтой. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн тухай хуульд зааснаар Сангийн зөвлөлөөс нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн шийдвэрлэнэ.<sup>135</sup> Хуульд зааснаар сангаас олгох дээд хэмжээг сайдын тушаалаар батална.<sup>136</sup> Сангаас нөхөн олговор авахад нөхөн олговор авах тухай хүсэлт, цагдаагийн байгууллагын тодорхойлолт, эмч, эмнэлгийн тодорхойлолт, магадалгаа, эмчилгээ хийлгэсэн тухай төлбөр төлсөн тухай баримт зэргийг бүрдүүлнэ.<sup>137</sup> Баримт бичгийг бүрдүүлэхэд Хохирогчид туслах төв туслалцаа үзүүлнэ. Эмч, эмнэлгийн тодорхойлолт, эмчилгээний төлбөр төлсөн баримт нь гэмтлийн зэргийг нотлоход хангалттай байх ёстой.<sup>138</sup> Сангийн хувьд хамгийн ихдээ 180 хоногийн дотор нөхөн олговрын хүсэлтийг шийдвэрлэнэ. Хүсэлтийг хангаагүй тохиолдолд 6 долоо хоногийн дотор хохирогч давж заалдах журмаар гомдол гаргаж болно. Ийнхүү хуралдаан болсны дараа 6 долоо хоногийн дотор Сангийн Зөвлөлөөс шийдвэр гарна. Сангаас дахин хүсэлтийг хангахгүй талаар шийдвэр гаргасан бол хохирогч анхан шатны шүүхэд хандах боломжтой.

## 9. Тохиолдол, шийдвэрлэсэн байдал

<sup>133</sup> Marijn Heemskerk, Compensation for victims of human trafficking in the Netherlands, 2013.

<https://documentation.lastradainternational.org/lisdocs/3087-Compensation%20for%20Victims%20of%20Human%20Trafficking%20in%20The%20Netherlands.pdf>, p.9

<sup>134</sup> Article 51e, Criminal Procedure Code,

[https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/nld/1921/criminal\\_procedure\\_code\\_of\\_the\\_netherlands\\_html/Code\\_of\\_Criminal\\_Procedure\\_incorporating\\_amendments\\_up\\_to\\_October\\_2012.pdf](https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/nld/1921/criminal_procedure_code_of_the_netherlands_html/Code_of_Criminal_Procedure_incorporating_amendments_up_to_October_2012.pdf)

<sup>135</sup> Aanwijzing slachtofferrechten, <https://wetten.overheid.nl/BWBR0002979/2016-07-01>

<sup>136</sup> Aanwijzing slachtofferrechten, <https://wetten.overheid.nl/BWBR0002979/2016-07-01>

<sup>137</sup> Marijn Heemskerk, Compensation for victims of human trafficking in the Netherlands, 2013.

[https://documentation.lastradainternational.org/lisdocs/3062-Policy%20paper%20compensation\\_Netherlands\\_28%20April%202014.pdf](https://documentation.lastradainternational.org/lisdocs/3062-Policy%20paper%20compensation_Netherlands_28%20April%202014.pdf), P.12

<sup>138</sup> Toelichting letsellijst, 2021. <https://www.schadefonds.nl/wp-content/uploads/2021/08/Letsellijst-20210801.pdf>

Мөлжлөгийн хэлбэр: Бэлгийн мөлжлөг

Факт: 2 хохирогчтой бөгөөд нэг шүүгдэгчид холбогдох хэргийг нэгтгэн шийдвэрлэсэн. Хохирогчид шүүгдэгчтэй хувийн харилцаатай байсан бөгөөд шүүгдэгч хохирогч нарт хүч хэрэглэж, заналхийлэх замаар Амстердам хот дахь шөнийн цэнгээний газар биеийг нь үнэлүүлдэг байсан. Эхний хохирогч 2009-2011 онд, хоёр дахь хохирогч 2012 оны 1 сараас 9 сар хүртэл бэлгийн мөлжлөгт өртсөн.

ЭХХША: Шүүгдэгчид эрүүгийн ял оноосон бөгөөд хохирогч тус бүрд эдийн бус хохиролд 2000 евро олгуулахаар шийдвэрлэсэн.<sup>139</sup>

## ДҮГНЭЛТ

Нидерланд улс нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч өөрт учирсан хохирлыг эрүү, иргэнийн шүүхээр болон хөдөлмөрийн хуулийн дагуу шийдвэрлүүлэх боломжтойгоос гаднын улсын сангаас нөхөн олговор авах бүрэн боломжтой байна. Ихэнх тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний нэхэмжлэлийг хамтад нь шийдвэрлэж байх бөгөөд энэ нь хохирогчид үүсэх санхүү, цаг хугацааны дарамтыг бууруулахад чиглэсэн.

Улсын сангаас олгох нөхөн олговрыг тооцох, үнэлэх аргачлал тодорхой бөгөөд эрүүгийн хэргийг эцэслэн шийдвэрлэхээс өмнө тус сангаас нөхөн олговор боломжтой байгаа нь хохирогчийн эрхийг хамгаалахад чухал ач холбогдолтой байна. Харин эрүү, иргэний шүүхээр хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэхдээ эдийн болон эдийн бус хохирлыг олгохоор шийдвэрлэдэг боловч эдийн бус хохиролд шүүхээс нөхөн төлбөр гаргуулахаар шийдвэрлэхдээ хэмжээг хэрхэн тооцож буй нь тодорхойгүй бөгөөд харилцан адилгүй байна.

Шүүхийн шатанд прокурорын үүрэг оролцоо ихээхэн байх бөгөөд цагдаагийн албан хаагч, прокурор нь хохирогчид нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах боломжтой талаар мэдээлэл үүргийг хүлээдэг нь энэ төрлийн нэхэмжлэл гаргах эрхээ хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд гэмт хэрэгтэн шүүхийн шийдвэрээр олгохоор үүрэг хүлээсэн нөхөн төлбөрийг олгоогүй тохиолдолд урьдчилсан байдлаар улсаас үлдэгдэл төлбөрийг өгч байгаа нь хохирогч, ялангуй гадаад улсын харьяалалтай хохирогч удаан хугацаанд санхүүгийн хүндрэл орохоос сэргийлж байна.

Өмнө өгүүлснээр Нидерланд улсын шүүхээс эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэр гаргадаг боловч эдийн бус

<sup>139</sup> ECLI:NL:RBGEL:2013:1486 <https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf>

хохирлыг хэрхэн тооцож, үнэлж буй талаар тодорхой аргачлалгүй байна. Гэвч хохирогчид мэдээлэх өгөх, нэхэмжлэл гаргах эрхийг танилцуулах, үүнд прокурор туслалцаа үзүүлэх, улсаас хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх, цаашлаад шийдвэр гүйцэтгэлийн шатанд улсаас төлөгдөөгүй үлдэгдэл төлбөрийг төлөх зэрэг олон арга хэрэгслийг ашиглаж хохирогчийн нөхөн төлбөр авах эрхийн баталгааг хангаж байна.

Түүнчлэн, Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн сан (Criminal Injuries Compensation Fund) гэх улсын тусгай сангийн хувьд хохирогчийн улсаас нөхөн олговор авах хүсэлтийг богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэдэг бөгөөд энэ нь тухайн сангаас хохирогчийн бие махбод болон сэтгэцэд учирсан хохирлыг үнэлэх, тооцох аргачлалын тодорхой байдалтай салшгүй холбоотой. Тухайлбал, хүн худалдаалах гэмт хэргийг ямар аргаар үйлдсэн байгаагаас хамааран нөхөн олговрын хэмжээ тодорхойлогдоно.

## Нидерланд улсын сайн туршлагууд

Нидерланд улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нөхөн төлбөр авах эрхийг баталгаатай эдлүүлэхээр дараах хэд хэдэн арга хэрэгслийг ашиглаж буй нь бусад улсаас онцлогтой, дэвшилттэй байна. Үүнд:

1. “Advance payment system” буюу урьдчилан төлбөр төлөх тогтолцоо - Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор хойш гэмт хэрэг үйлдсэн этгээд шүүхийн шийдвэрээр хохирогчид төлөх болсон нөхөн төлбөрийг тохирсон хугацаанд өгөөгүй бөгөөд 8 сар энэхүү төлбөрийн зөрчил нь үргэлжилсэн бол тус улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэл хариуцсан газар (the Central Judicial Collection Agency (CJIB)-т аас үлдэгдэл төлбөрийг хохирогчид олгодог.<sup>140</sup>
2. 2013 оны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх заавар (the Human Trafficking Guidelines (2013)-т<sup>141</sup> хохирогч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний нэхэмжлэгчээр оролцох хүсэлтэй байгаа талаар илэрхийлсэн тохиолдолд прокурорын газраас хохирогчид ийнхүү нөхөн төлбөрөө амжилттай авахад шаардагдах туслалцааг боломжит хэлбэрээр үзүүлэх үүрэгтэй гэж, хохирогч шүүх хуралдаанд оролцох боломжгүй эсхүл оролцож чадаагүй тохиолдолд прокурор иргэний

<sup>140</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.30 [https://documentation.lastradainternational.org/lisdocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSuc\\_N84AqZCI8I\\_S\\_6DOdC4MEkg4OVofA](https://documentation.lastradainternational.org/lisdocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSuc_N84AqZCI8I_S_6DOdC4MEkg4OVofA)

<sup>141</sup> Aanwijzing slachtofferrechten, <https://wetten.overheid.nl/BWBR0045831/2021-12-01>

нэхэмжлэгчийн өмнөөс нөхөн төлбөр шаардаж болох талаар нарийвчлан тусгажээ.

3. Цаашлаад эдийн ба эдийн бус хохиролд нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн бөгөөд шүүхийн шийдвэрт заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Иргэний хуулийн 6:199 дүгээр зүйлд заасан хуульд заасан хүү (statutory interest)-г шаардаж боломжтой.
4. Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх зэргээр хохирогчийн хүсэл зоригийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн бол тус улсын Хууль зүйн туслалцаа үзүүлэх төвөөс хохирогчийн санхүүгийн байдлыг үл харгалзан үнэ төлбөргүй хууль зүйн бүхий л төрлийн үйлчилгээг үзүүлнэ.
5. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн сан (Criminal Injuries Compensation Fund) гэх улсын тусгай сангийн хувьд хохирогчийн улсаас нөхөн олговор авах хүсэлтийг богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэдэг бөгөөд энэ нь тухайн сангаас хохирогчийн бие махбод болон сэтгэцэд учирсан хохирлыг үнэлэх, тооцох аргачлалын тодорхой байдалтай салшгүй холбоотой.

### 3.4. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ GERMAN УЛС

ХБНГУ-ын хууль тогтоомжид “хохирогч” буюу “victim” гэсэн нэр томъёог үгчлэн тодорхойлоогүй бөгөөд ихэвчлэн “co-plaintiff” or “injured party” гэх нэр томъёог хэрэглэсэн байна. Хохирогч гэдэг үгийг шууд утгаар нь ашигладаг хууль бол “Victim Compensation Act” буюу “Хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хууль” юм. Тус хуулиар хохирогчид төрөөс олгох нөхөн олговрыг зохицуулдаг бөгөөд гэмт хэргийг илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн хүнийг олж тогтоож чадаагүй тохиолдолд энэхүү хуулиар нөхөн олговор олгодог. Гэмт хэргийн улмаас шууд бус буюу дам байдлаар хохирсон хохирогчдод зориулсан тусгайлсан зохицуулалт байдаггүй.<sup>142</sup>

Хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хууль (opferentschadigungsgsesets (OEG)) нь 1976 онд батлагдсан. Тус хуулиар ХБНГУ-ын нутаг дэвсгэрт санаатай үйлдсэн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болж, улмаар эрүүл мэндээрээ хохирсон хүн нөхөн төлбөр авах хүсэлт гаргах эрхтэй байна. Тодорхой нөхцөлд гадаадын иргэн хохирлын нөхөн төлбөр авах эрхтэй. Хуулийн зорилго нь хүчирхийллийн улмаас учирсан эрүүл мэнд, эдийн засгийн хохирлыг нөхөн олгох юм. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч хүчирхийллийн гэмт хэргийн объект байсан бөгөөд эдгээр үйлдлийн үр дагаврыг амссан байх ёстой. Гэмт хэргийн хохирогч нас барсан тохиолдолд түүний гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн хуулийн дагуу нөхөн төлбөр авах

<sup>142</sup> Хохирлын үндэсний тогтолцоо гэмт хэргийн хохирол барагдуулах тогтолцооны харьцуулсан судалгаа, УБ, 2021, 29 дэх тал.

эрхтэй.<sup>143</sup>

Хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хуульд хүчирхийллийн үйлдлийг хүний эсрэг санаатайгаар, хууль бусаар хүчирхийлэл үйлдсэн халдлага гэж тодорхойлсон (санаатайгаар биед гэмтэл учруулах, хүчиндэх гэх мэт). Гэмт хэргийн хохирогч эрүүл мэндэд учирсан хохирол бүрээр нөхөн төлбөр шаардах эрхтэй. Эрүүл мэндтэй холбоотой асуудлууд нь бие махбодын болон сэтгэлзүйн эрүүл мэндэд үр дагавар үүсгэдэг бөгөөд тэдгээр нь түр зуурын болон байнгын байж болно.

Нөхөн олговрын хамрах хүрээг Холбооны Дэмжлэгийн тухай (Federal Support Act) хуулиар тодорхойлсон бөгөөд эмчилгээний зардал болон хохирогчийн тэтгэвэр, асрах тэтгэмж, яаралтай тусламж, амьжиргааны нэмэлт тэтгэмж, асрах тэтгэмж, яаралтай тусламж, амьжиргааны нэмэлт тэтгэмж, орон сууцны тэтгэмж гэх мэт нийгмийн халамжийн тэтгэмжийг хамарна. Нэмж дурдахад, тодорхой нөхцөлд хохирогч тохиолдол бүрд нэмэлт тэтгэмж авах эрхтэй байж болно. Эдгээрийг хувьд чиглэсэн тусламж үйлчилгээ, биет хандив, мөнгөн тэтгэмж хэлбэрээр олгоно.<sup>144</sup>

ХБНГУ-ын Засгийн газар хүн худалдаалах гэмт хэргийг устгах наад захын стандартыг бүрэн хангаж байна.<sup>145</sup> Түвшин 1 (tier-1)<sup>146</sup>-д Засгийн газраас санхүүжүүлдэг төрийн бус байгууллагуудын сүлжээтэй үндэсний хэмжээний хамтын ажиллагааны гэрээ байгуулж, хөдөлмөрийн мөлжлөгийн зорилго бүхий хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг хууль сахиулах ажиллагааг нэмэгдүүлсэн ч хохирогчдод нөхөн олговор олгох нь ховор, хамгаалах байр, хохирогчдод үзүүлэх тусламж, төрийн бус байгууллагын санхүүжилт хангалтгүй хэвээр байна.<sup>147</sup>

ХБНГУ-ын хүн худалдаалахтай тэмцэх хууль эрх зүйн орчны тухайд 2016 оны 10 дугаар сард Европын холбооны хүн худалдаалахтай тэмцэх удирдамжийг (2011/36/EU) хэрэгжүүлснээр томоохон өөрчлөлтүүд гарсан.<sup>148</sup> Удирдамжийн 17 дугаар зүйлд хохирогчдод нөхөн олговор олгох “гишүүн улсууд хүн худалдаалах гэмт хэргийг зориудаар үйлдсэн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох одоогийн схемд хамрагдах боломжийг хангана.” гэж заасан.

Хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хуулийн дагуу Герман улс хохирогчдын нөхөн төлбөрийн тогтолцоог бүрдүүлээд байна. 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн зөвхөн бие махбодын хүчирхийллийн хэрэгт бус сэтгэл зүйн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийн бүх

<sup>143</sup> Мөн тэнд,30 дахь тал.

<sup>144</sup> Мөн тэнд,30 дахь тал.

<sup>145</sup> ХБНГУ-ын Хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын төлөв байдлын тайлан (2023). <https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/germany/>

<sup>146</sup> Мөн тэнд.

<sup>147</sup> Мөн тэнд.

<https://www.kok-gegen-menschenhandel.de/en/human-trafficking/legal-framework-in-germany>

хэлбэрийг тодорхой тусгаж, хамруулдаг болсон. Цаашилбал, иргэншлээр нь ялгахаас бүрмөсөн татгалзсан. Өөрөөр хэлбэл, хүн худалдаалах гэмт хэргийн бүх хохирогчид ХБНГУ-ын иргэдтэй адил нөхөн олговор авах боломжтой болсон.

Хохирогчдод олгох нөхөн олговорт амбулаторийн гэмтлийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай авах, халамжийн тэтгэмж, асаргааны тэтгэмж зэрэг эмчилгээний мөнгөн тэтгэмж багтана.<sup>149</sup>

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын үр дагаврыг шүүх нэгэнт тогтоогоод байгаа тул хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид өөрсдөө иргэний хуулийн дагуу нэхэмжлэлд нэмэлт нотлох баримт бүрдүүлэх шаардлагагүй байдаг. Хохирлыг нөхөн төлүүлэх хүсэлтийг эрүүгийн шүүхэд гаргадаг. Гэхдээ шүүх заавал шийдвэр гаргах шаардлагагүй.

ХБНГУ-ын Холбооны Нийгмийн шүүх (Bundessozialgericht, файлын дугаар: 9 RVg 2/78) төр нь бүх иргэдээ хүчирхийлэл, гэмт хэргийн аливаа үйлдлээс хамгаалах үүрэгтэй гэж шийдвэрлэсэн. Хэрэв хамгаалахгүй бол хохирогчдод нөхөн төлбөрийг төлөхөөс өөр аргагүйд хүрдэг. Энэ төрлийн нөхөн төлбөрийг Германы Хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хуульд (OEG) заасан байдаг.

## **1. Хохирогчид нөхөн олговор олгох эрх зүйн зохицуулалтын салбар буюу эрүү, иргэн, хөдөлмөрийн хуулийн журмаар нөхөн олговор олгох ажиллагааны онцлог, зохицуулалт**

### **1.1. Эрүүгийн журмаар хохирол төлүүлэх ажиллагаа**

Хүн худалдаалах гэмт хэрэг нь эрүүгийн гэмт хэрэг тул хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирлоо барагдуулахаар нэхэмжлэл гаргах боломжтой.

2016 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг үйл ажиллагааг сайжруулах, Холбооны эрүүгийн хууль болон Нийгмийн хуулийн VIII дэвтэрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу Герман улс 2011/36EU удирдамжийн холбогдох зохицуулалтыг Эрүүгийн хуульд тусгаж, Эрүүгийн хууль дахь хүн худалдаалахтай тэмцэх тухай зохицуулалтыг үндсээр нь шинэчилж өргөжүүлсэн.<sup>150</sup>

<sup>149</sup> European Commission, Institutional, legal and policy framework to address Trafficking in Human Beings in Germany. [https://home-affairs.ec.europa.eu/policies/internal-security/organised-crime-and-human-trafficking/together-against-trafficking-human-beings/eu-countries/germany\\_en](https://home-affairs.ec.europa.eu/policies/internal-security/organised-crime-and-human-trafficking/together-against-trafficking-human-beings/eu-countries/germany_en)

<sup>150</sup> European Commission, Institutional, legal and policy framework to address Trafficking in Human Beings in Germany. [https://home-affairs.ec.europa.eu/policies/internal-security/organised-crime-and-human-trafficking/together-against-trafficking-human-beings/eu-countries/germany\\_en](https://home-affairs.ec.europa.eu/policies/internal-security/organised-crime-and-human-trafficking/together-against-trafficking-human-beings/eu-countries/germany_en).

Эрүүгийн процессын хуульд [Strafprozessordnung] эрүүгийн процесс ажиллагааны явцад мэдүүлэг өгөх хохирогчид хамаарах чухал заалтууд тусгагдсан. Хүн худалдаалах гэмт хэрэг нь "хувийн туслах прокурор" (Герман хэлээр Nebenkläger-status)-ийг зөвшөөрдөг гэмт хэрэг юм. Нэмж дурдахад, 403 ба бусад зүйлд заасан иргэний болон эрүүгийн нэгтгэсэн процесс [Adhäsionsverfahren] нь гэмт этгээдээс төлөөгүй хохирол нэхэмжлэх процесс юм. Германы Эрүүгийн процессын хуульд заасан энэ төрлийн процедур нь нэхэмжлэгчийн нэхэмжилсэн хохирлыг нөхөн төлүүлэх талаар шийдвэр гаргах боломжийг эрүүгийн шүүхэд олгодог. Онолын хувьд эдгээр нэхэмжлэлийг өөр журмаар хэрэгжүүлэх шаардлагатай боловч ийнхүү нэгтгэх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үр дүнтэй байдаг тул холбогдох шийдвэрийг нэгтгэсэн процедурын хүрээнд гаргах боломжтой.<sup>151</sup>

ХБНГУ-ын Эрүүгийн хууль дахь хүн худалдаалах, хөдөлмөрийн мөлжлөгтэй холбоотой заалтыг үндсэн таван төрөлд хуваадаг. Үүнд:<sup>152</sup> хүн худалдаалах, албадан биеэ үнэлэлт, албадан хөдөлмөрлүүлэх, хөдөлмөрийн мөлжлөг, эрх чөлөөг нь хасаж хөдөлмөрийн мөлжлөг хийлгүүлэх зэрэг хамаарна.

Эрүүгийн хуулийн [Strafgesetzbuch] 18 дугаар бүлэгт ("Хувийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг") хүн худалдаалах, хөдөлмөрийн мөлжлөгийг эрүүгийн гэмт хэрэг гэж тодорхойлсон. Хүний хувийн эрх чөлөөг хамгаалах зорилгоор дараах зөрчлийг хууль тогтоомжид заасан.

Хүн худалдаалах, 232-232б дугаар хэсэгт заасан гэмт бүлэглэл, арилжааны зорилгоор, албадан биеэ үнэлэлт, албадан хөдөлмөр эрхлэх, 233 дугаар хэсэгт заасан эрх чөлөөг нь хассан хөдөлмөрийг мөлжлөгийн зорилгоор бүлэглэн зохион байгуулсан хүн худалдаалах гэмт хэргийн талаар заасан.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 232 дугаар хэсэгт хүн худалдаалах гэмт хэргийн талаар дараах байдлаар заасан.<sup>153</sup>

- Эрүүгийн хуулийн 232а хэсэг: Хүчээр биеэ үнэлүүлэх;
- Эрүүгийн хуулийн 232б хэсэг: Албадан хөдөлмөрлүүлэх;
- Эрүүгийн хуулийн 233 хэсэг: Хөдөлмөрийн мөлжлөг;
- Эрүүгийн хуулийн 233а хэсэг: Эрх чөлөөг нь хассан мөлжлөг.

## **1.2. Иргэний журмаар хохирол төлүүлэх ажиллагаа**

Хохирогч Иргэний хууль (Bürgerliches Gesetzbuch (BGB))-ийн заалтын дагуу гэмт этгээдийн эсрэг шууд нэхэмжлэл гаргаж болно. Гэвч

<https://www.kok-gegen-menschenhandel.de/en/human-trafficking/legal-framework-in-germany>

<sup>152</sup> Criminal code of Germany, [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_stgb/englisch\\_stgb.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html)

<sup>153</sup> Criminal code of Germany, Section 232.

[https://www.gesetze-im-internet.de/englisch\\_stgb/englisch\\_stgb.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html)



Хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хуулийн дагуу нөхөн олговор авах тухай нэхэмжлэл гаргах боломжийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид төдийлөн өргөн ашигладаггүй. Энэ хуулийн дагуу нэхэмжлэл гаргасан ч нэхэмжлэлийг бүрэн хангаж шийдвэрлэдэггүй байна. Шүүхээр шийдвэрлэгдсэн цөөн хэдэн хэргийн дийлэнхэд нь ялтан, хохирогч нар хоорондоо зөвшилцөж, тохиролцоонд хүрсэн байна. Төлсөн төлбөр нь ихэвчлэн анх нэхэмжилж байсан нэхэмжлэлээс хамаагүй бага байдаг бөгөөд ихэнх тохиолдолд энэ нь хохирогчийг хохироох замаар гэмт этгээдийн олж авсан хөрөнгийн маш бага хэсэгтэй тэнцдэг.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 612 дугаар зүйлд заасны дагуу хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч бичгээр хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй ч зохих цалин авах эрхтэй. Германы Иргэний хуулийн 823 дугаар хэсгийн I-т зааны дагуу бусдын амь нас, бие, эрүүл мэнд, эрх чөлөө, эд хөрөнгө, бусад эрхийг хууль бусаар гэмтээж, санаатай эсвэл болгоомжгүй гэмтээсэн аливаа этгээд үүнээс учирсан хохирлыг нөгөө талдаа нөхөн төлөх үүрэгтэй гэж заасан. Гэсэн хэдий ч эдгээр эрхийг баталгаажуулах нь хэцүү байдаг. хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод хөдөлмөрийн харилцаа байгааг нотлоход ихэвчлэн бэрхшээлтэй байдаг. Нэмж дурдахад, олон тооны хохирогчийн оршин суугаа газар тодорхойгүй байгаа тул нэхэмжлэлийн хангахаас татгалздаг. Гэсэн хэдий ч оршин суух зөвшөөрөлгүй хүн байсан ч хөдөлмөрийн нэхэмжлэлийг биелүүлэх боломжтой гэдгийг мэдэх нь чухал юм.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид ихэвчлэн 823 BGB (Иргэний хууль)-ийн дагуу гэмт этгээдийн хууль бус үйлдлийн учирсан хохирлоо барагдуулахаар шаарддаг. Эрүүгийн процесс ажиллагаанд янз бүрийн хэлбэрээр нөхөн төлбөр авах боломжтой.

Хохирогч эд материалын хохирол амссан бол түүнийг Иргэний хуулийн 823 (1) хэсэг [Bürgerliches Gesetzbuch, BGB]-ийн дагуу гэмт хэрэгтэн бүрэн нөхөн төлөхөөр заасан. Хэрэв хүн худалдаалах гэмт хэрэг нь хууль бусаар хорих болон/эсвэл бие махбодод гэмтэл учруулахтай хамт үйлдэгдсэн бол эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээр мөн бие махбодын хохирлын нөхөн төлбөрийг нэхэмжилж болно (BGB-ийн 253 (2) хэсэг).

Тодруулбал, Германы Иргэний хуулийн 823 дугаар хэсэгт заасны дагуу иргэний нэхэмжлэл гаргаж болгохоор заасан ба Иргэний хуулийн “823 дугаар хэсгийн I-т зааны дагуу бусдын амь нас, бие, эрүүл мэнд, эрх чөлөө, эд хөрөнгө, бусад эрхийг хууль бусаар халдаж, санаатай эсвэл болгоомжгүй гэмтээсэн аливаа этгээд үүнээс учирсан хохирлыг нөгөө талдаа нөхөн төлөх үүрэгтэй. Заасан объектууд нь тусгай хамгаалалтад байдаг тул 823 дугаар хэсгийг хэрэгжүүлэхийн тулд хөдөлмөрийн гэрээ байгуулах шаардлагагүй.” гэж “823 дугаар хэсгийн II-

т заасан нөхөн төлбөрийг нэхэмжилж болно. 823 дугаар хэсгийн II-т заасан нь бусад хүмүүсийг хамгаалсан хуулийг зөрчсөн гэм буруутай хүнийг нөхөн төлбөр авахыг шаарддаг.” гэж “253 дугаар хэсгийн II-т заасны дагуу бие махбод, эрүүл мэнд, эрх чөлөө, бэлгийн хүчирхийллийн харьцаанд орсон аливаа гэмтэлд санхүүгийн нөхөн төлбөр нэхэмжилж болно.” гэж заасан.

### **Нэгтгэсэн процесс**

Иргэний хуулийн дагуу хохирлыг барагдуулах нэхэмжлэлийг ерөнхийд нь хохирол учруулсан этгээдийн эсрэг чиглүүлдэг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг болох "нэгтгэсэн процесс" (Adhäsionsverfahren) -ийг ашиглан нэхэмжлэл гаргаж болно.<sup>154</sup> 403 дугаар зүйлд заасны дагуу иргэний хэрэг үүсгэнэ. Нэгтгэсэн процесс нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод зарим давуу талыг өгдөг. Тухайлбал, гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэж, нөхөн төлбөрөө бүрэн хэмжээгээр нь авах боломжтой ба шүүх хуралдааныг л явуулахад л хангалттай байна. Нөхөн олговор олгох ёстой хохиролд бүх үндсэн материаллаг болон материаллаг бус (бие махбодын өвдөлт, сэтгэл зүйн шаналал) зүйлс орно.<sup>155</sup>

### **Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хохирол нөхөн төлүүлэх**

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид цалин хөлсөө төлөх тухай нэхэмжлэлээ Хөдөлмөрийн шүүхэд гаргаж болно. Улсаас нөхөн олговор авах тухай нэхэмжлэлийг тэтгэвэр, тэтгэмжийн алба (Versorgungsämter) хариуцдаг.

## **2. Нөхөн төлбөрийн буюу хохирлын хэлбэр: эдийн ба эдийн бус хохирол (ёс суртахууны хохирол), нөхөн төлбөрийн хэмжээ, түүнийг тогтоох, үнэлэх нь**

"Нөхөн төлбөр" гэдэг нь хохирлоос үүдэн гарах санхүүгийн нөхөн төлбөрийг хэлнэ. Санхүүгийн нөхөн төлбөр нь (Schadensersatz), бие махбодын өвдөлт, гэмтлийн хохирлын нөхөн төлбөр (Шмерценсгелд) эсвэл төлөөгүй цалингийн нөхөн төлбөр хэлбэрээр байж болно. хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид материаллаг болон эдийн бус их хэмжээний хохирол амсаж байгаа тул тэдэнд зөвхөн цалин хөлс төдийгүй зохих нөхөн олговор авах нэхэмжлэлээ үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тэдэнд зохих эрх зүйн зохицуулалтыг хангах нь

<sup>154</sup> German NGO network against Trafficking in Human beings, Legal Framework in Germany, Provisions regarding criminal proceedings.

<https://www.kok-gegen-menschenhandel.de/en/human-trafficking/legal-framework-in-germany>

<sup>155</sup> Мөн тэнд.

чухал юм. Хэдийгээр Герман улс нөхөн олговор олгох, төлөөгүй цалинг олгох хууль эрх зүйн үндсийг бүрдүүлсэн ч хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон хүмүүсийг бодит амьдрал дээр эрхээ хэрэгжүүлэхэд тодорхой шалтгаанууд саад болж болж байна.

Хохирогчид гэмт хэрэгтнүүдээс эд материалын болон эд материалын бус хохирлын аль алиных нь хувьд нөхөн төлбөр авах эрхтэй.<sup>156</sup>

Иргэний хуулийн 253 дугаар хэсэгт биет бус хохирлын тухай заасан.

- (1) Зөвхөн хуульд заасан тохиолдолд эд хөрөнгийн хохирол биш аливаа хохирлыг нөхөн төлүүлэхээр мөнгө шаардаж болно.
- (2) Бие махбод, эрүүл мэнд, эрх чөлөө, бэлгийн замаар өөрийгөө тодорхойлох эрхэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр бол эдийн засгийн хохирол биш аливаа хохирлыг мөнгөн хэлбэрээр шударгаар нөхөн төлбөр төлүүлэхийг шаардаж болно.<sup>157</sup>

Өмнө дурдсанаар, Иргэний болон эрүүгийн нэгдмэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад (Германы Эрүүгийн процесс хуулийн/*Strafprozessordnung*, StPO-ийн §§ 403 ба бусад зүйлд заасан *Adhäsionsverfahren*) эрүүгийн шүүх нэхэмжлэгчийн хүсэлтээр материаллаг бус болон материаллаг хохирлын гэмт хэргийн нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн талаар шийдвэр гаргаж болно.<sup>158</sup> Энэ процедурыг хэрэгжүүлэхэд нь эрүүгийн хэрэг үүсгэсэн, яллагдагчаар татсан, гэмт этгээдийг ялласан байх шаардлагатай. Энэхүү журмын давуу тал нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн иргэний нэхэмжлэлийг эрүүгийн процесс ажиллагааны явцад шалгаж, нотлох баримтуудыг гаргаж өгдөг. Жишээлбэл: тухайн хүний бие махбодод гэмтэл учруулсан гэдгийг харуулах.

Нөхөн олговрын хэмжээг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын нэхэмжилсэн хохирлын хэмжээгээр бус харин гэмт этгээдүүдийн хөрөнгө, хууль сахиулах байгууллагаас тодорхойлсон техникийн ур чадвар, тэдний тодорхойлсноор олгодог байна.<sup>159</sup> Шүүхээр шийдвэрлэгдсэн цөөхөн хэрэгт эмэгтэйчүүдэд 12,000-аас 30,000 еврогийн нөхөн олговор олгосон байна. Гэхдээ нөхөн олговрын ихэнх нь 1000-аас 4000 еврогийн хооронд олгож шийдвэрлэсэн байна.<sup>160</sup>

Хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хуулийн “За хэсэгт гадаад

<sup>156</sup> Justice at last European Action for Compensation for Victims of crime working paper, [https://www.kok-gegen-menschenhandel.de/fileadmin/user\\_upload/3239-Justice at Last Working Paper - Legal assessment Compensation practices - La Strada International 2018 - Liliana Sorrentino.pdf](https://www.kok-gegen-menschenhandel.de/fileadmin/user_upload/3239-Justice_at_Last_Working_Paper_-_Legal_assessment_Compensation_practices_-_La_Strada_International_2018_-_Liliana_Sorrentino.pdf)

<sup>157</sup> Civil Code of Germany, [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_bgb/englisch\\_bgb.html#p4209](https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/englisch_bgb.html#p4209)  
<https://www.kok-gegen-menschenhandel.de/en/human-trafficking/compensation>

<sup>159</sup> Petra Follmar, Heike Rabe, Human Trafficking in Germany: Strengthening Victim's Human Rights, p.68  
<https://documentation.lastradainternational.org/lsidocs/Human%20trafficking%20in%20Germany%20-%20Strengthening%20victims%20human%20rights.pdf>

<sup>160</sup> Мөн тэнд.

улсад хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд нөхөн төлбөр авах тухай зохицуулсан. “1 хэсгийн 1(1)-д заасны дагуу хүчирхийллийн гэмт хэргийн улмаас 1(1)-д заасны дагуу биедээ гэмтэл учруулсан 1(4) буюу (5) №1-д заасны дагуу Герман улсын иргэн эсвэл гадаадын иргэн эсвэл (2) гадаадад үйлдсэн нь өргөдөл гаргасны дагуу 2 дахь хэсэгт заасан эрүүл мэнд, эдийн засгийн хохирлын нөхөн төлбөр авах эрхтэй.” гэж заасан байна. <sup>161</sup> Гэмтсэн хүмүүс гэмтлийн зэргээс шалтгаалан шаардлагатай сэтгэлзүйн эмчилгээ, түүний дотор нөхөн сэргээх эмчилгээ хийлгэх эрхтэй ба дараах нөхөн төлбөрийг авахаар хуульчилсан байна.<sup>162</sup>

- 10-20 хүртэлх хэмжээний хохирол учирсан тохиолдолд 800 еврогийн нэг удаагийн төлбөр;
- 30-40 хүртэлх хэмжээний хохирол учирсан тохиолдолд 1600 еврогийн нэг удаагийн төлбөр;
- 50-60 хүртэлх хэмжээний хохирол учирсан тохиолдолд 5800 еврогийн нэг удаагийн төлбөр;
- 70-90 хүртэлх хэмжээний хохирол учирсан тохиолдолд 10,200 еврогийн нэг удаагийн төлбөр;
- 100-ийн хохирлын зэрэгтэй тохиолдолд 16,500 еврогийн нэг удаагийн төлбөр.

### **3. Насанд хүрээгүй хохирогчид тусгайлсан эрх зүйн зохицуулалттай эсэх**

Насанд хүрээгүй хохирогч гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх хоёр өөр арга байна. Эхний арга нь Хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хуульд заасны дагуу төрөөс гэмт хэргийн хохирогчид учирсан хохирлыг барагдуулах юм. Насанд хүрээгүй хохирогчид хууль ёсны төлөөлөгчөөрөө дамжуулан нэхэмжлэлээ гаргана гэсэн ерөнхий зарчим үйлчилж байна. Нөхөн олговор нэхэмжлэх хоёр дахь арга нь гэмт хэрэгтэнд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхлэхтэй зэрэгцэн буюу дараа нь Иргэний хуулийн 253, 823 дугаар зүйлд заасан хохирлыг нөхөн төлүүлэхээр иргэний хуулийн зарчмын дагуу нэхэмжлэл гаргах явдал юм.

### **4. Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллээр хангагдах эрх буюу мэдээлэл өгөх талаар үүрэгжүүлсэн эрх зүйн зохицуулалт**

Цагдаагийн байгууллагын үүрэг бол аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг шалгах явдал бөгөөд ингэснээр гэмт хэрэгтнүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой болно. Нэмж

<sup>161</sup> Crime Victims Compensation Act - OEG [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_oeg/englisch\\_oeg.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_oeg/englisch_oeg.html)

<sup>162</sup> Мөн тэнд.

дурдахад тэд гэмт хэрэгт өртсөн хүмүүст болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, хамгаалалтын арга хэмжээ, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны талаар мэдээлдэг.

## **5. Гэмт хэрэгтнээр хохирол төлүүлэх зорилгоор эд хөрөнгийг нь хураах эрх зүйн зохицуулалт**

Хөрөнгийг үр дүнтэй хураах ажиллагааг бэхжүүлэх, оновчтой болгохын тулд Герман улс 2017 онд Эрүүгийн хууль дахь хөрөнгө хураах тухай зохицуулалтыг иж бүрэн шинэчилсэн. Хохирогч өөрөө нөхөн төлбөр (жишээ нь, хүн худалдаалах, хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор биеийг нь үнэлүүлэх) нэхэмжилсэн байсан ч гэмт хэргийн үйлдлээс олсон орлогыг төр хураах боломжтой болсон. Хохирогчид хураагдсан хөрөнгөөс нөхөн төлбөрөө энгийн журмаар авна. Харин шийдвэр ажиллагааны шатанд нэхэмжлэлээ гаргах ёстой. Хэд хэдэн хохирогч холбогдсон тохиолдолд тэдэнд адилхан нөхөн төлбөр олгоно. Хохирогчдод нөхөн олговор олгох талаар ямар сонголт хийх талаар хуульд заасан байдаг.<sup>163</sup>

Эрүүгийн хуулийн 73b-д заасны дагуу шинэ зохицуулалт нь ашиг хонжоо олсон гуравдагч этгээдийн эсрэг арга хэмжээ авах боломжийг хөнгөвчлөх бөгөөд ингэснээр хамааралгүй талуудад хөрөнгө шилжүүлэх нь утгагүй болно. Энэ нь өв залгамжлалын хувьд ч хамаарна. Хэрэв шилжүүлэг нь өөрөө Германы хуулиар аль хэдийн шийтгэгдсэн бол мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэнэ. Хэрэв анх олж авсан хөрөнгө, ашиг орлого нь байхгүй бол § 73c StGB-д заасан нөхөн олговрын тухай заалтууд нь гэмт хэрэгтний үлдэгдэл эд хөрөнгийг төрөөс авах боломжийг олгодог. Энэ нь үндсэндээ хууль ёсны хөрөнгийн эсрэг улсын төлбөрийн нэхэмжлэлийг шаардаж болно гэсэн үг юм.

Эрүүгийн хуулийн 73b хэсэгт бусдын гэмт хэргийн улмаас олсон орлогыг хураах тухай заасан.<sup>164</sup>

73 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 73b (3) зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу эд зүйлийг хураан авах шийдвэр гаргаагүй, олж авсан зүйлийн шинж чанар, бусад шалтгааны улмаас тодорхой зүйлийг хураах боломжгүй бол шүүхээс олж авсан мөнгөн дүнтэй тэнцэх хэмжээний мөнгийг хураах шийдвэр гаргасан. Мөн шүүхээс тухайн зүйлийг анх олж авсан мөнгөн дүнгээс нь доогуур үнээр хураахаас гадна ийм захирамж гаргадаг.

<sup>163</sup> European Commission, Institutional, legal and policy framework to address Trafficking in Human Beings in Germany. [https://home-affairs.ec.europa.eu/policies/internal-security/organised-crime-and-human-trafficking/together-against-trafficking-human-beings/eu-countries/germany\\_en](https://home-affairs.ec.europa.eu/policies/internal-security/organised-crime-and-human-trafficking/together-against-trafficking-human-beings/eu-countries/germany_en).

<sup>164</sup> Criminal code of Germany, [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_stgb/englisch\\_stgb.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html)

## **6. Төрөөс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох төрийн тусгай сан буюу захиргааны журмаар хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа**

Нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд хүнд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тухай заасан байдаг бол Баруун Европын ихэнх орнуудад нөхөн олговрын тусгай сангаас нэг удаагийн тэтгэлэг олгодог. Хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хуульд заасан байна.<sup>165</sup>

## **7. Хохирогчид нөхөн төлбөр олгож буй шат дараалал, хариуцах байгууллага буюу институтийн тогтолцоо**

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хохирлыг барагдуулах талаар нэхэмжлэл гаргах хэд хэдэн арга байдаг.<sup>166</sup>

- Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрүүгийн шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.
- Иргэний нэхэмжлэл нь ЭХХША явуулж байгаа эсэхээс үл хамааран сонголт юм.
- Орон нутгийн шүүх (Amtsgericht) нь 5,000 евро хүртэлх хохирол учирсан тохиолдолд шүүх эрх мэдэлтэй байдаг.
- Арга хэмжээг бүс нутгийн шүүхэд (Landgericht) гаргах маргаантай дүн нь 5,000 еврогоос дээш байна.
- Хохирол нь хөдөлмөрийн харилцаатай холбоотой бол цалин хөлсний нөхөн төлбөр олгох нэхэмжлэлтэй холбогдуулан нэхэмжлэлийг мөн гаргаж болно.

Хөдөлмөрийн шүүх (arbeitsgericht).

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид цалин хөлсөө төлөх тухайн нэхэмжлэлээ Хөдөлмөрийн шүүхэд гаргаж болно. Улсаас нөхөн олговор авах тухай нэхэмжлэлийг тэтгэвэр, тэтгэмжийн алба (Versorgungsämter) хариуцдаг.

### **Хариуцах байгууллага**

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний зөвлөл нь хүн худалдаалах, хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хүмүүст мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг холбоо юм.<sup>167</sup> Мөн хохирогчид туслах

<sup>165</sup> Crime Victims Compensation Act - OEG [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_oeg/englisch\\_oeg.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_oeg/englisch_oeg.html)

<sup>166</sup> Petra Follmar, Heike Rabe, Human Trafficking in Germany: Strengthening Victim's Human Rights, p.66 <https://documentation.lastradainternational.org/lisdocs/Human%20trafficking%20in%20Germany%20-%20Strengthening%20victims%20human%20rights.pdf>

<sup>167</sup> What should you do if you are affected by trafficking in human beings? [https://www.hilfe-info.de/WebS/hilfeinfo/EN/Leaflets/29-merkblatt\\_menschenhandel.html](https://www.hilfe-info.de/WebS/hilfeinfo/EN/Leaflets/29-merkblatt_menschenhandel.html)

үндэсний хэмжээний байгууллага “WEISSER RING ” нь Герман дахь хохирогчдод үнэ төлбөргүй тусламж үзүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Weisser Ring ашгийн бус байгууллага нь гэмт хэргийн хохирогчдод олон төрлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг. Weisser Ring нь шүүхээс өмнөх шатны хохирлын тогтолцооны бас нэг онцлог нь хохирогчдыг нөхөн сэргээх, хохирлоо барагдуулахаар өргөдөл гаргахад нь туслах бөгөөд бусад хэлбэрийн санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.<sup>168</sup> Хохирогч гэмт хэргийн талаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж, он, сар, өдөр, байршил, гэмт хэргийн улмаас учирсан гэмтэл, хохирлын талаарх мэдээллийг заавал өгөх ёстой.

### *Тогтолцооны хувьд*

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус гол байгууллагуудаас бүрдсэн хүүхэд худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх албан ёсны Ажлын хэсэг байхгүй. Гэсэн хэдий ч хүн худалдаалах гэмт хэрэг, түүнтэй холбоотой асуудал хариуцсан хэд хэдэн Ажлын хэсэг байдаг. Муж, мужуудын эмэгтэй хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хэсэг ('Bund-Länder-Arbeitsgruppe Frauenhandel', BLAG) нь хүүхэд худалдаалах гэмт хэрэгтэй хэрхэн тэмцэх талаар үзэл баримтлал боловсруулах зэрэг олон асуудлыг авч үздэг. Хохирогчийн гэрч буюу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд нөхөн төлбөрийг хэрхэн шаардах тухай заавар. Үүнтэй төстэй Ажлын хэсгүүдийг хэд хэдэн мужид болон хотын захиргааны түвшинд байгуулсан.

Хүн худалдаалах гэмт хэргийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд 45 хот, нийт 16 мужид ажиллаж, хамгаалах байр, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж, хууль эрх зүйн туслалцаа, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, оршин суух зөвшөөрөл авахад туслалцаа үзүүлэх, цагдаа, шүүхийн байцаалт, шүүх хуралдаанд бэлтгэх, эх оронд нь буцаах, нүүлгэн шилжүүлгийн дэмжлэг зэрэг үйл ажиллагаа явуулдаг.<sup>169</sup>

## **8. Нөхөн төлбөр авах эрх үүсэх шалгуур, бүрдүүлэх материал, зарцуулах хугацаа, олгох нөхөн төлбөрийн төрөл**

Эрүүгийн процесс ажиллагааны явцад гэмт этгээдүүд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр болгон мөнгө санал болгож болох бөгөөд энэ нь ялыг тогтоохдоо ерөнхийдөө нааштай авч үздэг.<sup>170</sup> Өөр нэг хувилбар бол нөхөн олговрыг туршилтын нөхцөл

<sup>168</sup> Мөн тэнд.

<sup>169</sup> ХБНГУ-ын Хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын төлөв байдлын тайлан (2023). <https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/germany/>

<sup>170</sup> Petra Follmar, Heike Rabe, Human Trafficking in Germany: Strengthening Victim's Human Rights, p.67

болгох явдал юм. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорих ялаар шийтгэдэг гэж үзэх ба нөхөн төлбөрийг бодитоор хийсэн эсэхэд шийдвэр гүйцэтгэх эрх бүхий шүүх хяналт тавьдаг давуу талтай. Энэ нь хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон хүмүүсийг тодорхой нөхцөл байдалд өмгөөлөгчийн туслалцаатайгаар мөнгөө бодитоор төлж барагдуулах шаардлагаас чөлөөлдөг.

## **9. Тохиолдол, шийдвэрлэсэн байдал**

Гурван тусдаа хохирогчид учирсан материаллаг бус хохирлын нөхөн төлбөр болгон тус бүр 2000 еврогоор нөхөн төлбөр олгосон. Тэднийг хүч хэрэглэн биеийг нь үнэлүүлж байжээ. Нэг тохиолдолд 15,000 еврогийн материаллаг бус хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргасан бол 2,000 еврогийн нөхөн төлбөрийг гаргуулсан. Энэ хохирогчийг гурван өдрийн турш заналхийлж, зодож, хүчиндсэн байна.

Түүний мэдүүлгээр сэтгэл санааны хүнд гэмтэл авсан нь тогтоогдсон. Өөр нэг тохиолдолд эд материалын хохирол учирсан хоёр хохирогчид ижил хэмжээний нөхөн төлбөр олгож шийдвэрлэсэн байна. Эдгээр хохирогчдын аль аль нь гэмт этгээдтэй харилцаатай байсан бөгөөд тэд өөрсдөд нь түрэмгий, харгис хэрцгий хандаж, Амстердамын секс клубт албадан ажиллуулдаг байжээ. Эхний хохирогч нь 2009 оны 6 дугаар сараас 2011 оны 6 дугаар сар хүртэл, хоёр дахь нь 2012 оны 1 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд хүч хэрэглэн биеийг нь үнэлүүлсэн байна.

Хоёулаа 4000 еврогийн биет бус хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжилж, 2000 еврогийн нөхөн төлбөр авчээ. Эдгээр гурван хохирогчийн хохирлын шинж чанарыг харьцуулж болохуйц байсан ч тэд өөр хугацаанд хүчирхийлэлд (гурван өдөр; есөн сар; ба хоёр жил) өртсөн байна. Эдгээр гурван хэргийн материаллаг бус хохирлыг барагдуулахуйц хэмжээгээр нөхөн төлүүлэх ёстой гэж үзсэн.

## **ДҮГНЭЛТ**

ХБНГУ-ын хүн худалдаадах гэмт хэргийн хохирогч нь хохирлоо барагдуулахын тулд Иргэний хууль, Эрүүгийн Хууль, Хохирогчид хохирлыг барагдуулах тухай хууль болон нэгтгэсэнд процессын дагуу нэхэмжлэл гаргаж хохирлоо барагдуулж, нөхөн төлбөр авах боломжтой байна. Хохирогчдын хохирлын барагдуулах тухай хуулийн дагуу бусад хүний эсрэг санаатай хууль бусаар бие махбодод халдаж эсхүл хууль ёсны хамгаалалтаас болж эрүүл мэнд, эдийн засгийн, ноцтой хохирол

---

<https://documentation.lastradainternational.org/Isidocs/Human%20trafficking%20in%20Germany%20-%20Strengthening%20victims%20human%20rights.pdf>



амссан хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч нөхөн төлбөр авах эрхтэй.

Энэхүү нэхэмжлэл нь хохирол учруулсан этгээдийн эдийн засгийн чадавхаас огт хамааралгүй юм. Энэ бол Хохирогчдын хохирлын барагдуулах тухай хуулийн нэг том давуу тал юм. Хохирогчдын хохирлын барагдуулах тухай хуулийн нэхэмжлэлийн тусламжтайгаар хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдын эрүүл мэнд, эдийн засгийн байдлыг үр дүнтэй сайжруулах боломжтой.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд [Strafprozessordnung] эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад мэдүүлэг өгөх хохирогчид хэрэгжүүлэх чухал заалтуудыг багтаасан байдаг. Хүн худалдаалах гэмт хэрэг нь "хувийн туслах прокурор" (Герман хэлээр Nebenkläger-status) - ийг зөвшөөрдөг гэмт хэрэг юм. Нэмж дурдахад, 403 ба бусад зүйлд заасан иргэний болон эрүүгийн нэгтгэсэн процесс [Adhäsionsverfahren] гэгддэг гэмт этгээдээс төлөөгүй цалин, хохирлын нөхөн төлбөрийг нэхэмжлэх процессууд байдаг. Германы Эрүүгийн байцаан шийтгэх хуульд энэ төрлийн процедур нь нэхэмжлэгчийн нэхэмжилсэн гэмтэл, нөхөн төлбөрийг нөхөн төлүүлэх талаар эрүүгийн шүүхүүдэд дүгнэлт гаргах боломжийг олгодог. Онолын хувьд эдгээр нэхэмжлэлийг өөр журмаар хэрэгжүүлэх шаардлагатай боловч нэгтгэх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үр дүнтэй байдаг, тиймээс шийдвэрийг нэгтгэсэн процедурын хүрээнд гаргах боломжтой.

## **ХБНГУ-ын сайн туршлагууд**

- ХБНГУ-ын Холбооны Нийгмийн шүүх (Bundessozialgericht, файлын дугаар: 9 RVg 2/78) төр нь бүх иргэдээ хүчирхийлэл, гэмт хэргийн аливаа үйлдлээс хамгаалах үүрэгтэй гэж шийдвэрлэсэн. Хэрэв хамгаалахгүй бол хохирогчдод нөхөн төлбөрийг төлөхөөс өөр аргагүйд хүрдэг. Энэ төрлийн нөхөн төлбөрийг Германы Хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хуульд (OEG) заасан байдаг.
- Хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хууль (opferentschadigungsgsesets (OEG)) нь 1976 онд батлагдсан. Тус хуулиар ХБНГУ-ын нутаг дэвсгэрт санаатай үйлдсэн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болж, улмаар эрүүл мэндээрээ хохирсон хүн нөхөн төлбөр авах хүсэлт гаргах эрх эдэлдэг. Түүнчлэн хохирол шаардах эрх нь хүчирхийллийн гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол түүний гэр хамаарал бүхий хүмүүсийн хувьд мөн адил хамаарна.
- Хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хуулийн дагуу Герман улс хохирогчдын нөхөн төлбөрийн тогтолцоог бүрдүүлээд байна. 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн уг хуулийн үйлчлэл

нь зөвхөн бие махбодын хүчирхийллийн хэрэгт бус сэтгэл зүйн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийн бүх хэлбэрт хамаарах болсон. Цаашилбал, иргэншлээр нь ялгахаас бүрмөсөн татгалзсан. Ингэснээр хүн худалдаалах гэмт хэргийн бүх хохирогчид Герман улсын иргэдтэй адил нөхөн олговор авах боломжтой болсон.

- 2016 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг үйл ажиллагааг сайжруулах, Холбооны эрүүгийн хууль болон Нийгмийн хуулийн VIII дэвтэрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу Герман улс 2011/36EU удирдамжийн дагуу Эрүүгийн хууль дахь хүн худалдаалахтай тэмцэх тухай заалтуудыг үндсээр нь шинэчилж, өргөжүүлсэн.<sup>171</sup>
- Иргэний хуулийн дагуу хохирлыг барагдуулах нэхэмжлэлийг ерөнхийд нь хохирол учруулсан этгээдийн эсрэг чиглүүлдэг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг болох "нэгтгэсэн процесс" (Adhäsionsverfahren) -ийг ашиглан нэхэмжлэл гаргаж болно.<sup>172</sup> 403 дугаар зүйлд заасны дагуу иргэний хэрэг үүсгэнэ. Германы Эрүүгийн процесс хууль (StPO). Нэгтгэсэн процесс нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод зарим давуу талыг өгдөг. Тэд гэмт хэрэг үйлдэгчдийг хамгийн сайнаар шийтгэж, нөхөн төлбөрөө бүрэн хэмжээгээр нь авах боломжтой шүүх хуралдааныг л явуулахад л хангалттай. Нөхөн олговор олгох ёстой хохиролд бүх үндсэн материаллаг болон материаллаг бус (өвдөлт, зовлон) зүйлс орно.<sup>173</sup>
- Германы Эрүүгийн процесс хуульд [Strafprozessordnung] эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мэдүүлэг өгөх хохирогчид хэрэгжүүлэх чухал заалтуудыг багтаасан байдаг. Хүн худалдаалах гэмт хэрэг нь "хувийн туслах прокурор" (Герман хэлээр Nebenkläger-status) -ийг зөвшөөрдөг гэмт хэрэг юм.
- Нэмж дурдахад, 403 ба бусад зүйлд заасан иргэний болон эрүүгийн/эрүүгийн нэгтгэсэн процесс [Adhäsionsverfahren] тусгагдсан байх бөгөөд энэ нь гэмт этгээдээс төлөөгүй цалин, хохирлын нөхөн төлбөрийг нэхэмжлэх процесс юм. Германы Эрүүгийн процесс хуулийн энэ төрлийн процедур нь хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэх талаар шийдвэр гаргах эрхийг эрүүгийн шүүхэд олгодог. Онолын хувьд эдгээр нэхэмжлэлийг өөр журмаар хэрэгжүүлэх шаардлагатай боловч нэгтгэх нь хэрэг хянан

<sup>171</sup> European Commission, Institutional, legal and policy framework to address Trafficking in Human Beings in Germany. [https://home-affairs.ec.europa.eu/policies/internal-security/organised-crime-and-human-trafficking/together-against-trafficking-human-beings/eu-countries/germany\\_en](https://home-affairs.ec.europa.eu/policies/internal-security/organised-crime-and-human-trafficking/together-against-trafficking-human-beings/eu-countries/germany_en).

<sup>172</sup> German NGO network against Trafficking in Human beings, Legal Framework in Germany, Provisions regarding criminal proceedings.

<sup>173</sup> Мөн тэнд.

шийдвэрлэх ажиллагаанд үр дүнтэй байдаг тиймээс шийдвэрийг нэг журмын хүрээнд гаргах боломжтой.<sup>174</sup>

### 3.5. ЯПОН УЛС

Япон улсад хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг бие даасан хууль байдаггүй байна. Эрүүгийн хуульд насанд хүрэгчид болон хүүхдүүдийн "биеийг үнэлэх", хүүхдийн халамж, цагаачлал, бэлгийн хүчирхийлэл, хөдөлмөрийн мөлжлөгийн гэмт хэргийг тус тус заасан байдаг.<sup>175</sup>

1974 онд хэт даврагч бүлгүүдийн санамсаргүй бөмбөгдөлт болсонтой улбаалан уг гэмт хэрэгтэй эсрэг тэмцэж, Гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох тухай хуулийг 1980 оны 5 дугаар сарын 1-нд баталж, 1981 оны 1 дүгээр сараас гэмт хэргийн хохирогчдод тэтгэмж олгох тогтолцоог бий болгожээ.<sup>176</sup>

Хожим нь 1995 онд Токиогийн метроны галт тэргэнд сарин хийтэй халдлага үйлдэгдсэн. Хохирогчдод хүнд гэмтэл учирч, амь насаа алдаж, аймшигтай нөхцөл байдалд байгааг олон нийт мэдэж, хохирогчдод дэмжлэг үзүүлэх, түүний дотор нөхцөл байдлыг сайжруулах шаардлага улам бүр нэмэгдсэн байна.<sup>177</sup>

Гэмт хэргийн хохирогчийн тэтгэмж авах хамрах хүрээг тэлэх, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор тусламжийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авч, Гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох тухай хуулийг 2001 оны 7 дугаар сарын 1-нд шинэчлэн найруулсан.<sup>178</sup>

Япон улс 2005 оноос хойш Эрүүгийн хуульд урьд нь дотоодын хууль тогтоомжийн дагуу шийтгэл оногдуулахгүй байсан үйлдлүүдийг (Хүн худалдах, худалдах гэмт хэрэг гэх мэт) шинэчлэн найруулснаас хойш Хүн худалдаалах тухай протоколд заасан хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолтод хамаарах бүх үйлдлүүд эрүүгийн гэмт хэрэгт тооцогдох болсон.

Цаашилбал, 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Зохион байгуулалттай гэмт хэргийг шийтгэх, гэмт хэрэгт холбогдсон орлогод хяналт тавих тухай хуулийг хэсэгчлэн шинэчлэн найруулах тухай хууль (2017 оны 67 дугаар хууль) нь НҮБ-ын эсрэг конвенцыг байгуулахад

<https://www.kok-gegen-menschenhandel.de/en/human-trafficking/legal-framework-in-germany>

<sup>175</sup> Япон улсын Хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын тайлан (2023).

<https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/japan#:~:text=Japan%20did%20not%20have%20a,%2C%20immigration%2C%20and%20employment%20standards.>

<sup>176</sup> Act on the Support of Crime Victims by Payment of Crime Victims, etc.

[https://elaws.e-gov.go.jp/document?lawid=355AC0000000036\\_20210901\\_503AC0000000036&fbclid=IwAR3ffG8eF-TzXdQyY9igVnaILt9rlvYiYUL4WGynvCBsilOCb\\_9vtX-hlko](https://elaws.e-gov.go.jp/document?lawid=355AC0000000036_20210901_503AC0000000036&fbclid=IwAR3ffG8eF-TzXdQyY9igVnaILt9rlvYiYUL4WGynvCBsilOCb_9vtX-hlko)

<sup>177</sup> Benefit payment systems for crime victims, White paper on crime 2001 Part 2/Chap.6/Sec.3/2..

[https://hokusyo1.moj.go.jp/en/46/nfm/n\\_46\\_2\\_2\\_6\\_3\\_2.html](https://hokusyo1.moj.go.jp/en/46/nfm/n_46_2_2_6_3_2.html)

<sup>178</sup> Мөн тэнд.

зайлшгүй шаардлагатай хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг (цаашид “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц” гэх)-ийг 193 дугаар чуулганаар баталж, уг хууль 2017 оны 7 дугаар сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Улмаар тухайн өдөр Япон улс Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцод нэгдэн орсон. Зохион байгуулалттай гэмт хэрэг, түүнчлэн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх протокол, конвенцын нэмэлт протокол гэх мэт конвенц болон протоколд оролцогч улсаар нэгдсэн.

Засгийн газраас хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх 2022 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2022 оны 12 дугаар сард боловсруулсан. Засгийн газар хүн худалдаалах гэмт хэрэгтэй иж бүрэн, цогц байдлаар тэмцэж Засгийн газрын 2022 оны мөрийн хөтөлбөртэй уялдуулан арга хэмжээ авч байна.

Гэмт хэргийн хохирогч болон тэдний ар гэрийнхэнд учирсан хохирлыг барагдуулах нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээх нь иргэний хариуцлага юм. Гэсэн хэдий ч гэмт хэрэг үйлдэгчдийн олонх нь санхүүгийн эх үүсвэргүй байдаг тул гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгоход төрийн идэвхтэй оролцоо шаардлагатай байгааг дурдсан байна.

Гэмт хэргийн хохирогчийн тэтгэмжийн тогтолцооны дагуу гэмт хэргийн хохирогчийн тэтгэмжийг төрөөс гэмт хэргийн улмаас хүнд гэмтсэн, тахир дутуу болсон нас барсан, хүмүүсийн ар гэрийнхэнд олгодог. Гэмт этгээдүүд санхүүгийн хангалттай эх үүсвэргүйгээс үр дүнтэй тусламж авч чадахгүй байгаа хохирогчид болон тэдний ар гэрийнхэнд дэмжлэг үзүүлэх зорилгоор эдгээр системийг бий болгосон.

Тэтгэмжийг гурван төрөлд хуваан олгодог. Үүнд:

- "тэжээгчээ алдсаны тэтгэмж" тэжээгчээ алдсаны ар гэрийнхэнд олгох;
- "тахир дутуугийн тэтгэмж" хөгжлийн бэрхшээлтэй хохирогчдод олгох;
- "хүнд гэмтэл, өвчлөлийн тэтгэмж" хүнд гэмтэл авсан хохирогчдод олгох.

Тэжээгчээ алдсаны тэтгэмж болон тахир дутуугийн тэтгэмжийн хэмжээг хохирогчийн нас, цалин гэх мэтээр тооцдог.

- нэг хохирогчийн тэтгэмжийн дээд хэмжээ нь тэжээгчээ алдсаны тэтгэмжид 15.73 сая иен;
- тахир дутуугийн тэтгэмжид 18.492 сая иен байна;

- 14-өөс доошгүй хоног эмнэлэгт хэвтэх, 1 сараас доошгүй хугацаагаар эмчлүүлэх шаардлагатай гэмтэл авсан, өвчтэй хохирогчдод хүнд гэмтэл, өвчний тэтгэмж олгох бөгөөд тэтгэмжийг 3 сар хүртэл хугацаагаар олгоно. Энэ хэмжээ нь хохирогчийн эрүүл мэндийн даатгалд даатгуулсан эмчилгээний зардалтай тэнцүү байна.<sup>179</sup>

## **1. Хохирогчид нөхөн олговор олгох эрх зүйн зохицуулалтын салбар буюу эрүү, иргэн, хөдөлмөрийн хуулийн журмаар нөхөн олговор олгох ажиллагааны онцлог, зохицуулалт**

### **Иргэний журмаар хохирол төлүүлэх ажиллагаа**

Хохирогч, ар гэрийнхэн болон бусад хүмүүс хохирлоо барагдуулах талаар зөвшилцөлд хүрээгүй байгаа хүмүүс иргэний нэхэмжлэлийг хангахын тулд иргэний журмаар шүүхэд хандах ёстой.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үед хохирогч нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шүүхэд өгөхдөө ямар шийдвэр гаргаж байгаагаар тодорхой зааж, гэмт хэрэг үйлдсэн этгээд ямар гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн улмаас ямар хохирол учруулсан бэ гэдгийг нотлох ёстой. Цаашилбал, хэрэв гэмт хэрэгтэн нэхэмжлэлийг эсэргүүцэж байгаа бол та нэхэмжлэлээ нотлох баримтыг өгөх ёстой.

Иргэний хуулийн 711 дүгээр зүйлд бусдын амь насыг хохироосон этгээд хохирогчийн эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үүрэгтэй.<sup>180</sup>

Иргэний хуулийн 724 дүгээр зүйлд “гэм хорын улмаас учирсан хохирол, хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг дараах тохиолдолд арилгана.

- хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч хохирсон болон гэмт этгээдийн хэн болохыг мэдсэнээс хойш гурван жилийн дотор эрхээ хэрэгжүүлээгүй;
- эрүү үүсгэсэн үеэс хойш 20 жилийн дотор эрхээ хэрэгжүүлээгүй;

(Гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон, гэмтлийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийн үл мэдэгдэх заалт) хамаарна.” гэж тусгажээ.

Гэмт хэрэг гэж тухайн хүний хууль ёсны эрхэнд халдаж, улмаар түүнд хохирол учруулсан үйлдлийг. Иргэний хуулийн 709 дүгээр зүйл болон түүнээс хойших зүйлд заасан гэм буруутай үйлдэлтэй ижил

<sup>179</sup> Benefit payment systems for crime victims. White paper on crime 2001 Part 2/Chap.6/Sec.3/2. [https://hokusyo1.moj.go.jp/en/46/nfm/n\\_46\\_2\\_2\\_6\\_3\\_2.html](https://hokusyo1.moj.go.jp/en/46/nfm/n_46_2_2_6_3_2.html)

<sup>180</sup> Civil Code of Japan, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3494/en>

утгатай. Ийм учраас гэмт хэргийн хохирогч буюу гэмт хэргийн хохирогчийн ар гэрийнхэн нь эд хөрөнгийн хохирол болон/эсвэл сэтгэл зүйд учирсан хохирлоо нөхөн төлүүлэхийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй. Зөрчлийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргаж, хянан шийдвэрлэдэг. Эрүүгийн хэргээс ялгаатай нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь үйл явцын хувьд өөр өөр шинж чанартай байдаг.<sup>181</sup>

Гэмт хэргийн хохирогчид хохирлоо нөхөн төлүүлэхийг шаардахын тулд өмгөөлөгч авах шаардлагатай байсан ч өмгөөллийн төлбөр гэх мэт санхүүгийн ачааллыг даах чадваргүй бол эдгээр хүмүүс Иргэний эрх зүйн системийн дагуу туслалцаа авах боломжтой байна. Түүнчлэн, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үр дүнд (2008 оны 12 дугаар сард хүчин төгөлдөр болсон) хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцооны дагуу хохирлоо энгийн бөгөөд хурдан нөхөн төлүүлэхийг хүссэн ч гэмт хэргийн хохирогчид Иргэний эрх зүйн туслалцааны системийг ашиглан хүүгүй зээлийг ашиглаж болно. 2014 оны 4 дүгээр сараас хойш өмгөөлөгчийн төлбөрийг оруулсан. Мөн хохирогчийн өмгөөлөгчтэй уулзаж учирсан хохирлоо нөхөн төлүүлэх асуудлаар ярилцах гэж байгаа зөвлөх үйлчилгээний зардалд мөн иргэний эрх зүйн туслалцаа хамаарна.<sup>182</sup>

### **Эрүүгийн журмаар хохирол төлүүлэх ажиллагаа**

Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийн талаар 226 дугаар зүйлд заасан.<sup>183</sup>

Эрүүгийн хуулийн 226-2 дугаар зүйлийн 1 хэсэгт зааснаар бусдыг худалдаж авсан бол гурван сараас доошгүй, харин таван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэнэ.

(2) Насанд хүрээгүй хүүхдийг худалдаж авсан хүнийг гурваас доошгүй сар, харин долоон жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэнэ.

(3) Ашиг хонжоо олох, гэрлэх, амь нас, бие махбодод нь заналхийлэх зорилгоор бусдыг худалдаж авсан бол нэг жилээс доошгүй, харин арван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэнэ.

(4) Өмнөх догол мөр нь өөр хүнийг худалдсан хүнд хамаарна.

(5) Нэг улсаас нөгөө улс руу зөөвөрлөх зорилгоор өөр хүнийг худалдсан,

<sup>181</sup> Metropolitan Police Department, Victims of crime  
[https://www.keishicho.metro.tokyo.lg.jp/multilingual/english/safe\\_society/become\\_a\\_victim/you\\_victim.files/physical\\_crime\\_english.pdf](https://www.keishicho.metro.tokyo.lg.jp/multilingual/english/safe_society/become_a_victim/you_victim.files/physical_crime_english.pdf)

<sup>182</sup> Efforts to Recover the Victims' Damages and to Provide them with Economic Support,  
<https://www.npa.go.jp/hanzaihigai/whitepaper/english/2020/pdf/chapter1.pdf>

<sup>183</sup> Penal Code of Japan, [https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3581/en#ie\\_pt2ch35](https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3581/en#ie_pt2ch35)

худалдаж авсан бол хоёр жилээс доошгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.

## **2. Нөхөн төлбөрийн буюу хохирлын хэлбэр: эдийн ба эдийн бус хохирол (ёс суртахууны хохирол), нөхөн төлбөрийн хэмжээ, түүнийг тогтоох, үнэлэх нь**

Хохирогч, ар гэрийнхэн болон бусад хүмүүс хохирлоо барагдуулах талаар зөвшилцөлд хүрээгүй байгаа хүмүүс иргэний нэхэмжлэлийг хангахын тулд иргэний журмаар шүүхэд хандах ёстой.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үед хохирогч нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шүүхэд өгөхдөө ямар шийдвэр гаргаж байгаагаа тодорхой зааж, гэмт хэрэг үйлдсэн этгээд ямар гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн улмаас ямар хохирол учруулсан бэ гэдгийг нотлох ёстой. Цаашилбал, хэрэв гэмт хэрэгтэн нэхэмжлэлийг эсэргүүцэж байгаа бол та нэхэмжлэлээ нотлох баримтыг өгөх ёстой.

Иргэний хуулийн 711 дүгээр зүйлд бусдын амь насыг хохироосон этгээд хохирогчийн эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үүрэгтэй.<sup>184</sup>

Иргэний хуулийн 724 дүгээр зүйлд “гэм хорын улмаас учирсан хохирол, хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг дараах тохиолдолд арилгана.

- i. хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч хохирсон болон гэмт этгээдийн хэн болохыг мэдсэнээс хойш гурван жилийн дотор эрхээ хэрэгжүүлээгүй.
- ii. эрүү үүсгэсэн үеэс хойш 20 жилийн дотор эрхээ хэрэгжүүлээгүй.

(Гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон, гэмтлийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийн үл мэдэгдэх заалт) хамаарна.” гэж тусгажээ.

## **3. Насанд хүрээгүй хохирогчид тусгайлсан эрх зүйн зохицуулалттай эсэх**

Өнчин хүүхэдтэй, гэмт хэргийн хохирогч болсон залуу хүмүүс тэжээгчээ алдсаны тэтгэмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Гэмт хэргийн хохирогч болсон эцэг, эх, өнчин хүүхдүүдийн бодит нөхцөл байдлыг харахад тэд ерөнхийдөө өөрийгөө тэжээх чадваргүй, сэтгэл зүй, эдийн засгийн хувьд ихээхэн хохирол амссан нь ажиглагдаж байна. Тэдний хохирлыг барагдуулж туслахын тулд илүү өгөөмөр дэмжлэг

<sup>184</sup> Civil Code of Japan, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3494/en>.

үзүүлэх шаардлагатай гэж үздэг.

Хохирогч болон ар гэрийнхэн нь хүсэлтийн дагуу насанд хүрээгүй хохирогч өөрийн мэдрэмж, санал бодлоо илэрхийлж болно.<sup>185</sup>

- а. Шүүхийн шүүгчид;
- б. Шүүхээс гадуур шүүгчид;
- с. Гэр бүлийн мөрдөн байцаагчид.

#### **4. Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллээр хангагдах эрх буюу мэдээлэл өгөх талаар үүрэгжүүлсэн эрх зүйн зохицуулалт**

Цагдаа нар хамгаалах арга хэмжээний талаар мэдээлэл түгээж, хохирогчдод хууль эрх зүйн журмын талаар, тэр дундаа Япон улсад оршин суух тусгай зөвшөөрөл авах журамтай холбоотой бүрэн тайлбарыг өгдөг. Мөн цагдаа нар мөрдөн байцаалтын хэтийн төлөвийн талаар аль болох их мэдээлэл өгч, хохирогчдын нөхцөл байдлыг бүрэн харгалзан үзэж хариу өгөхийг хичээдэг.

Цагдаагийн ерөнхий газар нь гэмт хэргийн хохирогчдод тэтгэмж олгох тогтолцоог хянах үүрэгтэй администраторуудын уулзалтыг зохион байгуулж, дэмжлэгийн төлбөрийг түр хугацаагаар батлах, шийдвэрийг түргэсгэх зэрэг захиргааны сайжруулалттай холбоотой асуудлаар мужийн цагдаагийн газарт заавар зөвлөмж өгдөг.<sup>186</sup>

Цагдаагийн ерөнхий газар гэмт хэргийн хохирогчдод тэтгэмж олгох тогтолцооны талаарх мэдээллийг, тэр дундаа тусламжийн төлбөрийг түр батлах тухай мэдээллийг мэдээллийн товхимол, зурагт хуудас, цахим хуудсуудаар дамжуулан бүрэн түгээхийн зэрэгцээ гэмт хэргийн хохирогч, ар гэрийгээ алдсан хүмүүст тэтгэмжийн тогтолцоонд хамрагдах боломжтой хүмүүст нарийн зааварчилгааг санал болгож байна. Гэмт хэргийн хохирогчдод тэдний хууль ёсны эрх, журамд хамаарах асуудлаар.

#### **5. Гэмт хэрэгтнээр хохирол төлүүлэх зорилгоор эд хөрөнгийг нь хураах эрх зүйн зохицуулалт**

Гэмт хэрэг үйлдэгч(үүд)-ээс хураасан гэмт хэргийн орлого, эд хөрөнгийг мөнгөжүүлж, нөхөн олговрын сан болгон хадгалдаг бөгөөд тэдгээрээс тухайн гэмт хэргийн хохирогчдод тэтгэмж олгох боломжтой. Энэхүү системийг “Гэмт хэргийн хохирогчийн эд хөрөнгийг нөхөн төлүүлэх үндсэн дээр олгох үе шат” гэж нэрлэдэг.<sup>187</sup>

<sup>185</sup> Public Prosecutors Office, For victims of crime, <https://www.moj.go.jp/content/001348855.pdf>.

<sup>186</sup> Efforts to Recover the Victims' Damages and to Provide them with Economic Support. <https://www.npa.go.jp/hanzaihigai/whitepaper/english/2020/pdf/chapter1.pdf>

<sup>187</sup> Public Prosecutors Office, For victims of crime, <https://www.moj.go.jp/content/001348855.pdf>.



## **6. Төрөөс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох төрийн тусгай сан буюу захиргааны журмаар хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа**

Хохирогчийг дэмжих үндэсний сүлжээ буюу нийтийн ашиг сонирхлын нэгдсэн холбооноос олгодог яаралтай тусламжийн санхүүжилтийг эмнэлгийн зардлыг төлөхөд яаралтай санхүүгийн дэмжлэг шаардлагатай тохиолдолд, мөн тухайн байгууллагатай холбоотой тусламжийн байгууллагаас дэмжлэг авсан тохиолдолд нөхөн төлбөр олгодог. Уг систем нь зарчмын хувьд дээд тал нь 50,000 иен, онцгой нөхцөлд 200,000 иен хүртэл нөхөн төлбөр олгодог. Энэхүү дэмжлэгийн мөнгийг гэмт хэргийн хохирогчдод зориулсан нөхөн төлбөрт зарцуулдаг. Гэмт хэргийн хохирогч болсон даруйдаа эмнэлгийн зардлыг төлөхөд хүндрэлтэй байгаа тохиолдолд гэмт хэргийн хохирогчийг дэмжихэд уг мөнгийг ашиглаж байна.

## **7. Хохирогчид нөхөн төлбөр олгож буй шат дараалал, хариуцах байгууллага буюу институтийн тогтолцоо**

Нөхөн олговрын дээд хэмжээ нь хохирогч бүрийн бодит хохирлоос хамааран харилцан адилгүй байдаг. Хэрэв нөхөн төлбөр төлсөн дүн нь нийт хохирлын хэмжээнээс бага байвал нөхөн олговрын санг хохирогчдод хувь тэнцүүлэн (өөрөөр хэлбэл хохирогчийн хохирол тус бүрээр) хуваана. Түүгээр ч барахгүй нөхөн төлбөрийг хохирогчдод хуваахаас өмнө сангаас гаргана.<sup>188</sup>

2022 оны санхүүгийн жилд гэмт хэргийн улмаас ар гэрийнхэнд нь төлөх дундаж төлбөр 7,43 сая иен (ойролцоогоор 53,000 доллар) байсан нь зам тээврийн ослын үед гэр бүлийн гишүүд дунджаар 24 сая иен (171,000 доллар) авдаг автомашины хариуцлагын даатгалын стандартаас хамаагүй доогуур байна.<sup>189</sup>

Гэмт хэргийн хохирогчийн алба нь улсын төсвөөс санхүүждэг бөгөөд гэмт хэргийн улмаас өнчирсэн хүүхэд болон гэмт хэргийн хохирогч нарт дэмжлэг үзүүлэх туслах сангаар дамжуулан тэтгэлэг олгоно. Гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл учирсан бөгөөд хууль ёсоор Япон улсад амьдарч байгаа гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүлийн гишүүд гэмт хэрэг гарах үед Япон улсад хууль бусаар оршин сууж байсан гадаад иргэн нөхөн төлбөр авах өргөдөл гаргаж болно. Гомдлыг хүлээн авсан байгууллага нь ойролцоогоор 5 сарын дараа шийдвэр гаргах бөгөөд үүнээс 2 долоо хоногийн дараа өргөдөл гаргагчид зохих

<sup>188</sup> Мөн тэнд

<sup>189</sup> Mainichi Japan, Japan's crime victim relief system fails to meet reality, June 14, 2023 <https://mainichi.jp/english/articles/20230614/p2a/00m/0op/007000c>

хэмжээний төлбөрийг олгоно;

- Хохирогчийн гэр бүлд 10,179,000 иен (\$92,628.9) болон үндэслэл бүхий шийдвэрээр тогтоосон нөхөн олговорт 12,730,000 иен олгоно.(\$115,843);
- Хохирогч нас барахын өмнө гарсан эмчилгээний зардлын нөхөн төлбөрийн 10, 90,000 (\$98,189) 2001 оны 7 дугаар сарын 1-ний (\$143,143) олгоно;
- Хөдөлмөрийн чадваргүй болсны нөхөн төлбөрт 12,730,000 иен (\$115,843) (2001 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчид 18,492,000 иен (\$168,277.2)) олгоно.

Хөтөлбөрийн дагуу эмчилгээний зардал, цалин хөлс, гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүлд олгох нөхөн олговрыг бүхэлд нь олгодог.<sup>190</sup>

Нөхөн төлбөр авах эрхтэй бол өргөдлийн маягтыг бусад шаардлагатай бичиг баримтын хамт өөрийн оршин суугаа газрын харьяалалтай цагдаагийн газар эсвэл Цагдаагийн төв байгууллагаар дамжуулан Олон нийтийн аюулгүй байдлын хороонд ирүүлнэ. Гэсэн хэдий ч нөхөн төлбөр авах тухай нэхэмжлэлд тодорхой хугацааны хязгаарлалт байдаг.

Хэрэв санаатай гэмт хэргийн улмаас гэр бүлийн гишүүнээ алдсан, хүнд өвчтэй, гэмтэл авсан, хөдөлмөрийн чадвараа алдсаныг мэдсэн өдрөөс хойш хоёр жилийн дараа, эсхүл долоон жил өнгөрсний дараа өргөдөл гаргах боломжгүй. Гэр бүлийн гишүүнээ алдсан, хүнд өвчин туссан, гэмтэл авсан, үүний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс хойш нэг жил дотор нэхэмжлэл гаргана. Гэмт хэргийн хохирогч болсны дараа хойш зургаан сарын дотор аливаа нэхэмжлэлийг гаргах ёстой.

Гэмт этгээдийн эд хөрөнгөтэй холбоотой гэмт үйлдлээр (хохирогчийн орлого) олж авсан эд хөрөнгийг хураах (хураах, түүнтэй адилтгах үнийн дүнг хураах замаар) эрүүгийн шүүхээр хураан авах (гадаадын шүүхээр хураагдсан эрүүгийн орлогыг Япон руу шилжүүлэх)

Эрүүгийн шүүхээр хөрөнгөтэй холбоотой гэмт хэргийн хохирогч гэж хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүсээс гадна эд хөрөнгөтэй холбоотой хэд хэдэн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр нэхэмжилж болно. Үүнээс гадна ийм хохирогчдын өв залгамжлагчид нөхөн төлбөр авах боломжтой. Нөгөөтээгүүр, гэмт хэрэг үйлдэгч, гэмт хэрэгтнүүдийн хамсаатан, гэмт хэрэгтнүүдээс хууль бусаар орлого олж авсан хүмүүс хохирлоо

<sup>190</sup> Хохирлын үндэсний тогтолцоо гэмт хэргийн хохирол барагдуулах тогтолцооны харьцуулсан судалгаа, УБ., 2021.

барагдуулах боломжгүй.<sup>191</sup>

Улсын прокурор нөхөн төлбөр олгох үе шатыг эхлүүлдэг.

- Нөхөн төлүүлэх гэмт хэрэг, нэхэмжлэл гаргах хугацааг тогтоож, албан ёсны хэвлэлээр нийтэд мэдээлнэ.
- Хохирогчид нэхэмжлэлийн маягтыг нэхэмжлэлийн шаардлагын дагуу прокурорт гаргаж өгөх, Хохирол, түүнтэй адилтгах мөнгөн дүн, иргэний үнэмлэхийн хуулбар зэрэг шаардлагатай баримт бичгийн хамт ирүүлнэ. Үүнд:гэрэл зураг бүхий баримт бичиг (жишээ нь, жолооны үнэмлэх)

Улсын яллагч нэхэмжлэл бүрийг шалгаж шийдвэр гаргадаг. Улсын яллагч шийдвэрийнхээ баталгаажуулсан хуулбарыг илгээнэ. Нэхэмжлэгч нарт ("saitei-sho").

### ***Хариуцах байгууллага***

Цагдаагийн ерөнхий газраас 2016 оны 11 дүгээр сард мөрдөгдөж буй Хилийн чанадад гэмт хэрэгт хэлмэгдэгсдэд эмгэнэлийн мөнгөн тэтгэмж олгох тухай хуулийг үндэслэн хилийн чанадад гэмт хэрэгт хэлмэгдэгсдэд эмгэнэлийн тэтгэмж олгох тухай бодлогыг танилцуулсан.

Бодлогод дараах хэмжээний мөнгөн нөхөн олговор олгохоор тусгасан.

- Япон улсын иргэншилтэй нас барсан (Япон улсаас гадуур байнга оршин суугчдыг оролцуулалгүйгээр цаашид мөн адил хамаарна) нэн тэргүүний гэр бүлд (Япон улсад оршин суух газаргүй, Япон улсын харьяат бус хүмүүсийг оруулаагүй) хохирогч бүрд 2 сая иен.
- Хүний амь нас, бие махбодын эрүүл мэндэд хохирол учруулах зорилгоор Япон улсаас гадуур үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас амь насаа алдсан. Дээр дурдсан гэмт хэргийн улмаас 1 дүгээр зэргийн тахир дутуу болохтой дүйцэхүйц тахир дутуу болсон гадаадад гэмт хэргийн хохирогч болсон хүмүүст нэг сая иений мөнгөн тэтгэмж олгоно.<sup>192</sup>

Хүн худалдаалах гэмт хэрэг нь хохирогчдын хүний эрхийг зөрчсөн ноцтой гэмт хэрэг юм. Япон улсад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний үндсэн дээр хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах чиглэлээр холбогдох бүх байгууллагууд ажиллаж байна. Прокурорын байгууллага ийм төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимтэй явуулдаг.

<sup>191</sup> Public Prosecutors Office, For victims of crime, <https://www.moj.go.jp/content/001348855.pdf>.

<sup>192</sup> Efforts to Recover the Victims' Damages and to Provide them with Economic Support <https://www.npa.go.jp/hanzaihiqai/whitepaper/english/2020/pdf/chapter1.pdf>

Цагаачлалын албаны газраас Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын алба байгуулж, тус газрын дэргэдэх хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэл цуглуулж, холбогдох байгууллага, олон нийтээс хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэл цуглуулдаг.

Хохирогч гэмт хэргийн талаар цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ. Өргөдөл гаргагч 2 жилийн дотор өргөдөл гаргасан байх ба гомдлыг Цагдаагийн байгууллагад гаргасан байх Цагдаагийн байгууллага нь гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг тогтоосон байна. Өргөдлийг хүлээн авсан байгууллага нь ойролцоогоор 5 сараа дараа шийдвэр гаргах бөгөөд үүнээс 2 долоо хоногийн дараа өргөдөл гаргагчид зохих хэмжээний төлбөрийг олгоно.

## **8. Нөхөн төлбөр авах эрх үүсэх шалгуур, бүрдүүлэх материал, зарцуулах хугацаа, олгох нөхөн төлбөрийн төрөл**

Хохирогчид нэхэмжлэлийн маягтыг нэхэмжлэлийн шаардлагын дагуу прокурорт гаргаж өгөх, хохирол, түүнтэй адилтгах мөнгөн дүн, иргэний үнэмлэхийн хуулбар зэрэг шаардлагатай баримт бичгийн хамт ирүүлнэ.

Гэмт хэргийн хохирогчийн тэтгэмжийн тогтолцоонд хүнд өвчний тэтгэмж авахын тулд зөвхөн гэмт хэргийн улмаас учирсан гэмтэл, өвчтэй байхаас гадна эмчилгээний хугацаа дор хаяж нэг сар, гурваас доошгүй хоног байх ёстой.

Эмнэлэгт хэвтэх, төлбөр төлөхгүй байх шалтгаан байхгүй, бууруулах шалтгаан байгаа эсэх, төрийн бусад тэтгэмж байгаа эсэх, хохирлын нөхөн төлбөр байгаа гэх мэт төлбөрийн шаардлагыг баталгаажуулах шаардлагатай.

Аймгийн олон нийтийн аюулгүй байдлын комиссууд шүүх хуралдааны хугацааг богиносгохоор хүчин чармайлт гаргаж байгаа боловч хүнд гэмтлийн өвчний тэтгэмжийг (1,402 тохиолдол) 2011 оны 2016 оны санхүүгийн жил хүртэл барагдуулах өргөдөл гаргахаас эхлээд шүүх хүртэлх хугацаа (1,402 тохиолдол) ойролцоогоор 6,4 сар, дундаж нь ойролцоогоор 4,6 сар байна.

## **9. Тохиолдол, шийдвэрлэсэн байдал**

Хохирогчийн тэтгэмжийн тогтолцоо нь хохирогчдод учирсан хохирлыг барагдуулах зорилготой биш харин нэг удаагийн нөхөн төлбөр олгож хохирогчийн эдийн засгийн хүндрэлийг арилгах зорилготой юм. Тус хууль 2000 онд хэрэгжиж эхэлснээр гэмт хэргийн хохирогч болсон 2770 ар гэрийнхэнд тэжээгчээ алдсаны тэтгэмж 86 хохирогчдод тахир

дутуугийн тэтгэмж олгосон. 2001 онд хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр харьцангуй хөнгөн хөгжлийн бэрхшээлтэй хохирогчдод тэтгэмж олгох эрхийг өргөжүүлсэн.<sup>193</sup>

Гэрчүүдэд учруулсан хохирлыг барагдуулах асуудлыг эрүүгийн хууль эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэсэгчлэн нэмэлт оруулснаар гэмт хэргийн гэрч, түүний төрөл төрөгсөд шүүх, шүүгч, мөрдөн байцаах байгууллагад мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөр шүүхэд ирсний улмаас бусдын гарт амиа алдсан, бие махбодод гэмтэл учирсан бол, эсхүл тэдгээрийн төрөл төрөгсөд үүргээ гүйцэтгэж байх үедээ хохирол амссан тохиолдолд эмчилгээ, гэмтэл, тахир дутуу болох, нас барсан, оршуулах гэх мэтийн тэтгэмжийг төрөөс олгоно. 1996 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй хуулийн хэсэгчилсэн нэмэлт, өөрчлөлтөөр осол гэмтлийн улмаас шаардлагатай тусламж үйлчилгээ авч байгаа хохирогчдод үзүүлэх сувилахуйн тэтгэмжийн шинэ тогтолцоог бий болгож, осол гэмтэл/өвчний тэтгэмж эсвэл тахир дутуугийн тэтгэмжид хамруулахаар тусгасан.

Хуульд заасан тэтгэмжийн аль нэгийг нь авахыг хүссэн хүмүүс Хууль зүйн сайдад өргөдөл гаргаж, уг тэтгэмжийн асуудлыг шийдвэрлэдэг. Өнөөдрийн байдлаар энэ хуулийн дагуу /ХЗДХЯ-ны Эрүүгийн хэрэг эрхлэх газар/ 5 тохиолдолд тэтгэмж олгосон байна.<sup>194</sup>

Гэмт хэргийн хохирогчдод олгосон тэтгэмжийн хэмжээ 2018, 2019 оны санхүүгийн жилүүдэд тус тус 724,000,000 иен, 1,029,000,000 иен байв. Цаашилбал, шийдвэрийн дундаж хугацаа (өргөдөл гаргаснаас хойш шийдвэр гартал шаардагдах хугацаа) болон голч шийдвэрийн хугацаа 6.6 сар (өмнөх оноос 0.2 сараар илүү), 4.1 сар (өмнөх оноос 0.1 сар богино), тус тус 2018 оны санхүүгийн жилд, 2019 оны санхүүгийн жилд 7.8 сар (өмнөх оноос 1.2 сараар урт), 5.3 сар (өмнөх оноос 1.2 сараар илүү) тус тус тооцсон байна. Цагдаагийн ерөнхий газар нь захиргааны сайжруулалттай холбоотой асуудлаар мужийн цагдаагийн газарт заавар зөвлөмжийг үргэлжлүүлэн өгөхөөр төлөвлөж байна, тухайлбал шийдвэрээ түргэсгэх, гэмт хэргийн хохирогчдод тэтгэмж олгох тогтолцооны талаарх бүрэн мэдээллийг түгээх зэрэг болно.

## **Бусад онцлог зохицуулалт**

Гэмт хэргийн хохирогчийн тэтгэмжийн тогтолцоо болон бусад төрлийн бус тэтгэмжийн тогтолцоог эрүүл мэндийн тэтгэмжийн тухай:

Гэмт хэргийн хохирогчийн тэтгэмжийн тогтолцооны хүрээнд хүнд

<sup>193</sup> New Trends in Victim Support Scheme in Japan, Victims and Criminal Justice: Asian Perspective, pp.107-180, 2003, Tatsuya Ota, NCJ-202214.

<https://www.ojp.gov/ncjrs/virtual-library/abstracts/new-trends-victim-support-scheme-japan-victims-and-criminal-justice>

<sup>194</sup> Benefit payment systems for crime victims, White paper on crime 2001 Part 2/Chap.6/Sec.3/2.

[https://hokusyo1.moi.go.jp/en/46/nfm/n\\_46\\_2\\_2\\_6\\_3\\_2.html](https://hokusyo1.moi.go.jp/en/46/nfm/n_46_2_2_6_3_2.html)

гэмтлийн тэтгэмжийн тухайд олон төрлийн гэмтэл, өвчнийг хамруулж болох бөгөөд гэмтэл, өвчний шалтгаан нь гэмт хэргийн шинжтэй үйлдлээс үүдэлтэй болохыг нотлох, шалтгаан байгаа эсэхийг баталгаажуулна. Тэтгэмжийг төлөөгүй, бууруулсан, хохирлыг нөхөн төлүүлэх гэх мэт. Бусад системд тохируулга хийх шаардлагатай бөгөөд энэ нь төсвийн санхүүжилттэй эмнэлгийн тусламж үйлчилгээний систем гэх мэт бусад тэтгэмжийн тогтолцоонд захирагддаг тул өргөдлийг шалгах шаардлагатай. Үүний үр дүнд нөхөн төлбөр олгох хүртэл цаг хугацаа шаардагддаг тул эмнэлгийн байгууллага эмнэлгийн зардлын төлбөрийг нөхөн төлбөр олгох хүртэл хойшлуулах шийдвэр гаргавал эмнэлгийн байгууллага нэлээдгүй хугацаа хүлээх шаардлагатай болж, эцэст нь хариу өгөхгүй байх болно. Нөхөн төлбөр эсвэл төлбөрийг бууруулах нь тогтоогдсон тохиолдолд өвчтөн эмчилгээний зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

Нөгөөтээгүүр, эмнэлгийн тусламж үйлчилгээнд биет бусаар тэтгэмж олгохыг зөвшөөрдөг тогтолцоонд гэмтэл, өвчний шалтгаанаас үл хамааран гэрчилгээ олгох шаардлагыг хялбархан баталгаажуулдаг бөгөөд өргөдөл нь бусад төсвөөс санхүүждэг эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцооноос илүү ач холбогдолтой байдаг. Гэрчилгээ олгох нь гэмт хэргийн хохирогчийн тэтгэмжийн системээс илүү хялбар бөгөөд хурдан байдаг. Түүнчлэн ажилчдын ослын нөхөн олговрын даатгалын тогтолцооны дагуу эрүүл мэндийн байгууллагууд системд хамрагдаагүй гэж гэрчилгээ авсан тохиолдолд нөхөн төлбөрийг нөхөн төлүүлэх дарамтыг хариуцдаг боловч эрүүл мэндийн даатгалын тогтолцооноос ялгаатай нь ажил олгогчийн нөхөн төлбөрийг хариуцдаг.

Хохирогчид гэмт хэргийн нөхөн төлбөр авахын тулд иргэний нэхэмжлэл гаргаж болох боловч өмнөх жилүүдийн нэгэн адил засгийн газар ийм зүйл хийсэн эсэх талаар мэдээлээгүй. Гэтэл 2017 онд долоон хохирогчийн иргэний нэхэмжлэлийн дагуу шүүхээс цалин хөлсийг төлөөгүй хохирлыг хэсэгчлэн барагдуулах; Шүүгч хохирогчдын нэмэлт хохирол барагдуулах хүсэлтийг хүлээн аваагүй байна.

## **Арга зам**

Гэмт хэргийн хохирогчийн тэтгэмжийн тогтолцооны арга хэмжээ А: Бэлэн бус тэтгэмжийг нэвтрүүлэх:

Хүнд өвчний тэтгэмж авахын тулд гэмтэл, өвчин нь гэмт хэргийн улмаас үүссэн байхаас гадна нэг сар ба түүнээс дээш хугацаагаар эмчлүүлэх, гурав ба түүнээс дээш хоног эмнэлэгт хэвтсэн байх шаардлагатай. Шаардлагууд, төлбөр төлөхгүй байх шалтгаан байгаа эсэх, бууруулах шалтгаан байгаа эсэх, бусад олон нийтийн ашиг орлого байгаа эсэх, хохирлын нөхөн төлбөр байгаа эсэх гэх мэтийг тодорхойлох

шаардлагатай. Цаашилбал, хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд Цагдаагийн ерөнхий газрын мэдээлснээр, хүнд өвчний тэтгэмж авч буй хүмүүсийн тоо хүнд гэмтсэн хүмүүсийн 10 гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд 2016 онд хүнд өвчний тэтгэмж олгосон тохиолдлуудаас ердөө 10 тохиолдол бүртгэгдсэн байна. Хүнд өвчний тэтгэмжийг төлөөгүй, эсвэл төлөөгүй. Нийт тохиолдлын 39 орчим хувь нь төлбөрийн хэмжээг бууруулахаар шийдвэрлэсэн гэж үзвэл зөвхөн гэмт хэргийн улмаас гэмтсэн, өвчилсөн буюу эмчилгээ нь нэгээс дээш хугацаатай байх магадлалтай гэсэн дүгнэлтэд үндэслэн төлбөрийн шийдвэр гаргахад хүндрэлтэй байна.

Гэмт хэргийн хохирогчийн дараа нэн даруй мөнгөн тэтгэмж олгохоор болсон бол гэмт хэргийн хохирогчийн хохирлыг эмнэлгийн байгууллагад гаргуулахыг хориглож, төлбөрийг шийдвэрлэж дуустал хохирогчид төлбөрөө авах байсан.

Гэмт хэргийн хохирогчийн тэтгэмжийн систем нь нөхөн төлбөрийн шаардлагатай бүх баримтыг тогтоох боломжгүй байсан ч тодорхой болохуйц баримтын хүрээнд хэсэгчлэн түр тэтгэмж олгох боломжийг олгодог тогтолцоотой.

## **ДҮГНЭЛТ**

Тус улс гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх хохирогчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна. Япон улсад хүн худалдаадах гэмт хэргийн хохирогч нь хохирлоо барагдуулахын тулд Иргэний хууль, Эрүүгийн Хууль, Хохирогчид хохирлыг барагдуулах тухай хуулийн дагуу нэхэмжлэл гаргаж хохирлоо барагдуулж, нөхөн төлбөр авах боломжтой байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь хүний эрхийг ноцтойгоор зөрчиж байгаа бөгөөд хүн худалдаалах нь хохирогчдод сэтгэл зүйн болон бие махбодын ноцтой хохиролд өртүүлж, хохирлыг нөхөн сэргээхэд маш хэцүү байдаг тул хүмүүнлэгийн үүднээс шуурхай, зохих хариу арга хэмжээ авах шаардлагатай. Түүнчлэн хүн худалдаалах гэмт хэрэг нь ихэвчлэн хил дамнан гардаг хүнд гэмт хэрэг бөгөөд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх нь олон улсын хамтын нийгэмлэгийн яаралтай шийдвэрлэх нийтлэг асуудал юм.

Нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй зэрэгцэн хүн худалдаалах гэмт хэргийн арга барил улам боловсронгуй болж, хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдалд өөрчлөлт орох төлөвтэй байна. Ийм нөхцөлд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний эерэг үр дүнд хүрэхийн тулд хүн

худалдаалах гэмт хэргийн сүүлийн үеийн нөхцөл байдлын талаар мэдээлэл авах, олон төрлийн бодлогын арга хэмжээний ахиц дэвшлийг баталгаажуулах нь нэн чухал юм.

Япон улс 2005 оноос хойш Эрүүгийн хуульд урьд нь дотоодын хууль тогтоомжийн дагуу шийтгэл оногдуулахгүй байсан үйлдлүүдийг (Хүн худалдах, худалдах гэмт хэрэг гэх мэт) шинэчлэн найруулснаас хойш Хүн худалдаалах тухай протоколд заасан хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолтод хамаарах бүх үйлдлүүд эрүүгийн гэмт хэрэгт тооцогдох болсон.

Цаашилбал, 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Зохион байгуулалттай гэмт хэргийг шийтгэх, гэмт хэрэгт холбогдсон орлогод хяналт тавих тухай хуулийг хэсэгчлэн шинэчлэн найруулах тухай хууль (2017 оны 67 дугаар хууль) нь НҮБ-ын эсрэг конвенцыг байгуулахад зайлшгүй шаардлагатай хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг (цаашид “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц” гэх)-ийг 193 дугаар чуулганаар баталж, уг хууль 2017 оны 7 дугаар сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Улмаар тухайн өдөр Япон улс Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцод нэгдэн орсон. Зохион байгуулалттай гэмт хэрэг, түүнчлэн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх протокол, конвенцын нэмэлт протокол гэх мэт, улмаар Конвенц болон протоколд оролцогч улсаар нэгдсэн.

## Япон улсын сайн туршлага

- Гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл бөгөөд хууль ёсоор Япон улсад амьдарч байгаа гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүлийн гишүүд гадаад улсын иргэн нь гэмт хэрэг гарах үед Японд хууль ёсоор байсан иргэн нөхөн төлбөр авах эрхтэй. Хөтөлбөрийн дагуу эмчилгээний зардал, цалин хөлс, гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүлд олгох нөхөн олговрыг бүхэлд нь олгодог байна. Нөхөн олговрыг нь учирсан хохирол, хор уршгийн нөхцөл байдлаас хамаараан мөнгөн хэлбэрээр олгодог.
- Гэмт хэргийн хохирогчийн тэтгэмж авах хамрах хүрээг тэлэх, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор тусламжийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авч, Гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох тухай хуулийг 2001 оны 7 дугаар сарын 1-нд шинэчлэн найруулсан.<sup>195</sup>
- Гэмт хэргийн хохирогчийн алба нь улсын төсвөөс санхүүждэг бөгөөд гэмт хэргийн улмаас өнчирсэн хүүхэд болон гэмт хэргийн

<sup>195</sup> Мөн тэнд.



хохи­рогч нарт дэмжлэг үзүүлэх туслах сангаар дамжуулан тэтгэмж олгож байна.

- Иргэний хуулийн 711 дүгээр зүйлд бусдын амь насыг хохироосон этгээд хохирогчийн эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үүрэгтэй.<sup>196</sup>
- Цагдаагийн ерөнхий газраас 2016 оны 11 дүгээр сард мөрдөгдөж буй Хилийн чанадад гэмт хэрэгт хэлмэгдэгсдэд эмгэнэлийн мөнгөн тэтгэмж олгох тухай хуулийг үндэслэн хилийн чанадад гэмт хэрэгт хэлмэгдэгсдэд эмгэнэлийн тэтгэмж олгох тухай бодлогыг танилцуулж мөнгөн нөхөн олговор олгох эрх зүйн үндсийн тавьсан.
- Хуулийн дагуу цагдаа нар хохирогчид түүний эрхийг ярьж таниулах үүрэгтэй.

### 3.6. ТАЙВАНЬ УЛС

Тайвань нь албадан хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртөж буй улс байсаар ирсэн бөгөөд 2006 онд хүн худалдаалахтай тэмцэх бодлого боловсруулж эхэлсэн. Тайвань 2006 оны 11 дүгээр сард үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрөө баталж, төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг дэмжиж, Прокурорын газарт давж заалдах шатны шүүхэд мэргэжлийн хяналтын нэгж байгуулж, хохирогчдыг илрүүлэх арга хэмжээг боловсруулж, хохирогчдыг хамгаалах байр барьж, хохирогчдод нөхөн олговор олгох болон тэдний ар гэрийнхэнд хандах ажлыг зохион байгуулсан.<sup>197</sup>

АНУ-ын Төрийн департамент Тайвань 2010 оноос хойш түвшин 1 (tier 1)-д оруулсан бөгөөд энэ нь Тайвань хүн худалдаалахтай тэмцэхэд ихээхэн хүчин чармайлт гаргасныг илтгэж байгаа юм.<sup>198</sup>

Хөдөлмөрийн цагаачлалын бодлогыг дахин нягталж, хүн худалдаалах гэмт хэргийг бүрэн мөрдөн шалгах, хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх цогц хуулийг баталсан.<sup>199</sup> Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчийн эрхийг хамгаалах зорилгоор Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 2009 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр баталсан.<sup>200</sup>

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн “37 дугаар зүйлд Хууль зүйн яам нь хүн худалдаалах гэмт хэргийн гэмт

<sup>196</sup> Civil Code <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3494/en>

<sup>197</sup> Trafficking in human beings learning from Asian and European experiences. [https://www.kas.de/documents/252038/253252/7\\_dokument\\_dok\\_pdf\\_40567\\_2.pdf/c7cc3be7-a796-e7fd-df83-8c787bc98b40?version=1.0&t=1539660130033](https://www.kas.de/documents/252038/253252/7_dokument_dok_pdf_40567_2.pdf/c7cc3be7-a796-e7fd-df83-8c787bc98b40?version=1.0&t=1539660130033)

<sup>198</sup> 2023 Trafficking in Persons Report: Taiwan.

<https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/taiwan/>

<sup>199</sup> Мөн тэнд.

<sup>200</sup> Human trafficking Prevention act, <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080177>

хэрэгт холбогдон хураагдсан орлого, түүний цуглуулсан мөнгийг хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр болгон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох эрх бүхий төв байгууллагад шилжүүлнэ.

Нөхөн төлбөрийн төрөл, нэхэмжлэлийн шалгуур, төлбөрийн хэмжээ болон заавал дагаж мөрдөх бусад зохицуулалтыг холбогдох эрх бүхий төв байгууллагатай зөвшилцөн эрх бүхий төв байгууллага боловсруулна.”<sup>201</sup> гэж, 38 дугаар зүйл “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, түүний гэр бүлийн гишүүн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зэрэгцээ гэмт этгээдээс нөхөн төлбөр гаргуулах тухай иргэний хэрэг, иргэний нэмэлт нэхэмжлэл гаргасан бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд түр баривчлах, түр таслан сэргийлэх арга хэмжээ авах хүсэлт гаргаж болно. Уг өргөдөл нь түр зуурын хавсралт эсвэл түр захирамжийг орлуулах мэдүүлэг болгон таних мэдэгдлийг гаргаж болох бөгөөд баталгаа гаргах шаардлагагүй.”<sup>202</sup> гэж тус тус заасан байна.

## **1. Хохирогчид нөхөн олговор олгох эрх зүйн зохицуулалтын салбар буюу эрүү, иргэн, хөдөлмөрийн хуулийн журмаар нөхөн олговор олгох ажиллагааны онцлог, зохицуулалт**

### **Иргэний журмаар хохирол төлүүлэх ажиллагаа**

Иргэний хуулийн 195 дугаар зүйлд зааснаар бэлгийн эрх чөлөөнд зүй бусаар халдаж хохирол учруулсан бол хохирогч нь хохирлыг нь нөхөн төлүүлэхээр зохих төлбөрийг нэхэмжилж болно.

Тодруулбал, “Иргэний хуулийн 195 дугаар зүйлд<sup>203</sup> хэрэв хүн бусдын бие, эрүүл мэнд, нэр төр, эрх чөлөө, алдар нэр, хувийн нууц, бэлгийн эрх чөлөө, мөн бусдын хувийн шинж чанарыг ноцтойгоор хохироосон бол хохирсон этгээд уг гэмтэл нь гэмт хэрэг биш байсан ч зохих мөнгөн нөхөн төлбөрийг шаардаж болно. Хэрэв нэр хүнд нь халдсан бол хохирогч нэр төрөө сэргээх талаар зохих арга хэмжээ авахыг шаардаж болно. Тухайн хохирлын мөнгөөр үнэлж болохооргүй хэдий ч мөнгөн хэлбэрээр зохих нөхөн төлбөрийг нэхэмжилж болно. Нөхөн олговор олгохыг гэрээгээр амласан буюу эхлүүлээгүйгээс бусад тохиолдолд өмнөх хэсгийн нэхэмжлэлийг шилжүүлэх буюу өв залгамжлалд шилжүүлэхийг хориглоно. Эцэг, эх, хүү, охин, эхнэр/нөхөртэйгөө харьцах харьцааны үндсэн дээр бусдын статусыг зүй бусаар хохироосон тохиолдолд өмнөх хоёр хэсэгт заасан зохицуулалтыг хэрэглэнэ.” гэж заасан.

<sup>201</sup> Мөн тэнд.

<sup>202</sup> Мөн тэнд.

<sup>203</sup> Civil Code <https://law.moi.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=B0000001>.

Нөхөн олговрын хэмжээг тухайн хэргийн оролцогчдын эдийн засгийн нөхцөл байдал, хохирогчийн бие махбодод учирсан гэмтлийн зэрэг болон бусад холбогдох хүчин зүйлсийг харгалзан шүүгч тогтоодог.

Иргэний журмаар хохирол төлүүлэх нэхэмжлэлийн бүрэлдэхүүн хэсгүүд нь:

1. Хууль бус үйлдэл;
2. Нэхэмжлэгчийн учирсан хохирол;
3. Учир шалтгаан;
4. Сэтгэлзүйн байдал (санаатай эсвэл хайхрамжгүй байдал).

Процедурын хувьд иргэний нэхэмжлэлийг бие даан эсвэл эрүүгийн нэхэмжлэлд хавсаргаж болно.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, түүний гэр бүлийн гишүүн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зэрэгцээ гэмт этгээдээс нөхөн төлбөр гаргуулах тухай иргэний хэрэг, иргэний нэмэлт нэхэмжлэл гаргасан бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд түр баривчлах, түр таслан сэргийлэх арга хэмжээ авах хүсэлт гаргаж болно.<sup>204</sup>

Хохирогчдод шүүхээс гадуурх төлбөр тооцоо хийх замаар нөхөн төлбөр авах эсвэл гэмт этгээдийн эсрэг иргэний нэхэмжлэл гаргахыг зөвшөөрсөн боловч холбогдох бүх нотлох баримтыг өөрсдөө гаргаж өгөхийг шаарддаг.

## **2. Нөхөн төлбөрийн буюу хохирлын хэлбэр: эдийн ба эдийн бус хохирол (ёс суртахууны хохирол), нөхөн төлбөрийн хэмжээ, түүнийг тогтоох, үнэлэх нь**

2009 оны 6 дугаар сарын 1-нд Тайвань Дотоод хэргийн яамнаас “Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хураагдсан эд хөрөнгийг шилжүүлэх болон хохирогчид нөхөн олговор олгох тухай журам”-ыг баталсан.<sup>205</sup>

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 253 дугаар зүйлийн 2т Хохирогчид эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээр заасан байдаг. Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хураагдсан эд хөрөнгийг шилжүүлэх болон хохирогчид нөхөн олговор олгох тухай журмын 3 дугаар зүйлд хохирогчийн нөхөн төлбөр ба нөхөн төлбөр авагчдын төрлүүд нь дараах байдалтай байна гэж заасан.

Үүнд:

1. Тэжээгчээ алдсаны тэтгэмжийн нөхөн төлбөр: Энэхүү нөхөн

<sup>204</sup> Human trafficking prevention act, Article 37. <https://law.moj.gov.tw/Eng/LawClass/LawAll.aspx?pcode=D0080177>

<sup>205</sup> Regulations governing the Transfer of Seized Proceeds of Human Trafficking Crime and Compensation of Victims <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080183>.

төлбөрийг хүн худалдаалах гэмт хэргийн улмаас нас барсан хохирогчдын асрамжид үлдсэн хүмүүст олгоно;

3. Хүнд гэмтлийн нөхөн төлбөр: Энэхүү нөхөн төлбөрийг хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хүнд гэмтсэн хохирогчдод олгоно;
4. Эдийн засгийн бус хохирлын нөхөн төлбөр: Энэхүү нөхөн олговор нь хүн худалдаалах гэмт хэргийн улмаас сэтгэл зүйн гэмтэл авсан хохирогчдод олгоно.

2023 оны 12 дугаар сарын 28-нд Тайвань Дотоод хэргийн яамнаас “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх нөхөн төлбөр олгох журам”-ыг баталснаар “Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хураагдсан эд хөрөнгийг шилжүүлэх болон хохирогчид нөхөн олговор олгох тухай журам” хүчингүй болсон.<sup>206</sup>

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх нөхөн төлбөр олгох журмын 3 дугаар зүйлд хохирогчийн нөхөн төлбөрийн төрлийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. Эмгэнэл илэрхийлэх;
2. Ажилгүйдлийн тэтгэмж;
3. Дахин орох онгоцны тийз, байрны зардал;
4. Хохирогчийн эх орон (бүс) доторх тээврийн зардал.

Тайвань нөхөн олговрын дээд хэмжээ нь дараах байдалтай байна: Эрүүл мэндийн: NT\$400,000.00; Оршуулга: NT\$300,000.00; Нас барсан: 1,000,000.00 NT\$, хөгжлийн бэрхшээлтэй: 1,000,000.00 NT\$.

Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хураагдсан эд хөрөнгийг шилжүүлэх нөхөн олговор олгох тухай журам<sup>207</sup>

Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хураагдсан эд хөрөнгийг шилжүүлэх нөхөн олговор олгох тухай журмын 7 дугаар зүйл:

Хохирогчийн нөхөн олговрын дээд хэмжээг дараах байдлаар тогтоохоор заасан.

1. Хохирогч нас барсны улмаас оршуулгын зардлын нөхөн олговрын дээд хэмжээ 300,000 NT доллароос хэтрэхгүй байна.
2. Нас барсан хохирогчийн хууль ёсны дэмжлэг үзүүлэх үүргээ биелүүлэх чадваргүйн нөхөн төлбөрийн дээд хэмжээ 1,000,000 NT доллароос хэтрэхгүй байна.
3. Хохирогчийн ноцтой гэмтлийн улмаас гарсан эмчилгээний

<sup>206</sup> Regulation governing Subsidy for Victims of Human trafficking  
<https://law.moi.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080183>.

<sup>207</sup> Regulations governing the Transfer of Seized Proceeds of Human Trafficking Crime and Compensation of Victims  
<https://law.moi.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080183>.

зардлын нөхөн төлбөрийн дээд хэмжээ 400,000 NT доллароос хэтрэхгүй байна.

5. Хүнд гэмтсэн хохирогчийн хөдөлмөрийн чадвараа алдсан, эсхүл амьдралын хараат байдал нэмэгдсэний нөхөн төлбөрийн дээд хэмжээ 1,000,000 NT доллароос хэтрэхгүй байна.
6. Эд хөрөнгийн бус хохирлын нөхөн төлбөрийн дээд хэмжээ нь 400,000 NT доллароос хэтрэхгүй байна.

Хохирогчид нөхөн төлбөрийг эхний ээлжид холбогдох гэмт хэрэгт битүүмжлэгдсэн эд хөрөнгийг худалдсан бэлэн мөнгө, орлогоор олгох. Нөхөн олговрын сан нь нөхөн олговор олгох өргөдлийг зөвшөөрсөн хугацааны дагуу хэрэв байгаа бол түүний дутагдлыг нөхнө.

#### Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх нөхөн төлбөр олгох журам<sup>208</sup>

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх нөхөн төлбөр олгох журмын 4 дүгээр зүйлд “3 дугаар зүйлд заасан эмгэнэлийн төлбөрийг зохих төлбөрийн хэмжээтэй хамт авах шалгуур нь дараах байдалтай байна.

1. Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирогч бие махбод, сэтгэл зүйн гэмтэл авсан.
2. Нэг хүнд ногдох NT \$3000.
- 3 дугаар зүйлд заасан эмгэнэл олгох өргөдлийг хохирогч гэж тогтоогдсон өдрөөс хойш зургаан сарын дотор бөглөсөн анкет, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болохыг тогтоох мэдэгдлийн хамт гаргана.” гэж заажээ.

Хохирогчид нөхөн төлбөрийг эхний ээлжид холбогдох гэмт хэрэгт битүүмжлэгдсэн эд хөрөнгийг худалдсан бэлэн мөнгө, орлогоор олгоно. Нөхөн олговор олгох өргөдлийг хүлээн авсан хугацааны дагуу нөхөн олговрын сангаас нөхөн олговрыг олгоно.

#### Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хууль

Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 57 дугаар зүйлд<sup>209</sup> гэмт хэргийн төрлөөс шалтгаалан хохирогчдод төлөх нөхөн төлбөрийн хэмжээ дараах байдалтай байхаар заасан. Үүнд:

1. Амьд үлдсэн хүмүүсийн нөхөн олговор: NT\$ 1,800,000.

<sup>208</sup> Regulation governing Subsidy for Victims of Human trafficking.  
<https://law.moi.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080183>

<sup>209</sup> Crime Victims Rights Protection Act.  
<https://law.moi.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=I0050005>

2. Хүнд гэмтлийн нөхөн төлбөр: 800,000-1,600,000 NT\$.
3. Бэлгийн хүчирхийллийн нөхөн төлбөр: 100,000 NT\$-аас 400,000 NT\$.
4. Гадаадад нөхөн олговор: NT\$ 200,000.

Төсөв, нягтлан бодох бүртгэл, статистикийн ерөнхий газраас гаргасан хэрэглээний үнийн индексийн хуримтлагдсан өсөлтийн хувь 5 хувьд хүрсэн тохиолдолд эрх бүхий байгууллага нь өмнөх дэд зүйлд заасан хэмжээг тогтоолгох, зохицуулалт хийхээр Гүйцэтгэх юаньд тайлагнана.

Түүнчлэн Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 69 дүгээр зүйлд<sup>210</sup> түр зуурын нөхөн төлбөр нь 400,000 NT доллароос хэтрэхгүй байх ёстой. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн бол урьд авсан нөхөн төлбөрийн хэмжээг хасаж төлнө. Урьдчилсан нөхөн олговор нь нөхөн төлбөрийн нийт дүнгээс хэтэрсэн буюу нөхөн төлбөр олгох хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд хяналтын комисс хүлээн авагчид зөрүү буюу бүхэлд нь буцаан олгохыг даалгана гэж заасан.

### **3. Насанд хүрээгүй хохирогчид тусгайлсан эрх зүйн зохицуулалттай эсэх**

Харин Тайваний Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 58 дугаар зүйлд<sup>211</sup> асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй насанд хүрээгүй этгээд гэмт хэргийн хохирогч болсон эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь гэмт хэрэгтэн байх тохиолдолд тусгай чиг үүрэг бүхий байгууллага эсхүл төрөөс хүүхдийг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжтой байхаас гадна асран хамгаалагч эсхүл харгалзан дэмжигчгүй хүүхдэд олгох нөхөн төлбөрийг хохирогч хүүхдийг насанд хүрэх хүртэлх хугацаанд тусгайлан итгэмжлэн хадгалж, хуваарьтайгаар эсхүл хэсэгчлэн олгох чиг үүргийн тусгай байгууллагад хүлээлгэж болохоор зохицуулжээ.

Түүнчлэн Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 55 дугаар зүйлд<sup>212</sup> гэмт хэргийн хохирогч буюу нас барсан хохирогчийн гэр бүлийн гишүүд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр авах хүсэлт гаргах боломжгүй бол тэдний өмнөөс төлөөлөгч томилж өргөдөл гаргаж болно. Гэмт хэргийн хохирогч буюу нас барсан хохирогчийн гэр бүлийн гишүүд төлөөлөгч томилох боломжгүй, гэмт хэргийн хохирогч нь насанд хүрээгүй, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоогдсон этгээд бол түүний хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь

---

<sup>210</sup> Мөн тэнд.

<sup>211</sup> Мөн тэнд.

<sup>212</sup> Мөн тэнд.

гэмт хэрэг үйлдэгч бол гэмт хэргийн хохирогчийн ар гэрийнхэн, эсхүл тухайн хаягийн харьяалалд харьяалагдах хотын захиргаа, дүүрэг (хот)-ын засаг захиргаа, хамгаалалтын байгууллага тэдгээрийн нэрийн өмнөөс өргөдөл гаргаж болно гэж заасан.

Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 63 дугаар зүйлд<sup>213</sup> “гэмт хэргийн хохирогчийн хохирлыг барагдуулахыг шаардах эрх нь тухайн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг мэдсэнээс хойш тав (5) жилийн дотор нэхэмжлэгч хэрэгжээгүй бол уг эрхээ хасна. Гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш арав (10) жил өнгөрсөн бол мөн адил журмыг мөрдөнө. Харин гэмт хэрэг үйлдэх үед насанд хүрээгүй байсан хэн ч насанд хүрсэн хойноо таван жилийн дотор нэхэмжлэл гаргаж болно. Гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл учруулсан бол түүнийг мэдсэн цагаасаа хойш тав (5) жилийн дотор эдлэхгүй бол шаардах эрх нь хасагдана.” гэж заажээ.

#### **4. Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллээр хангагдах эрх буюу мэдээлэл өгөх талаар үүрэгжүүлсэн эрх зүйн зохицуулалт**

Гэмт хэргийн хохирогчийн хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлд “энэ хуулиар эрх нь хамгаалагдсан хүмүүст шаардлагатай тусламжийг байгууллага, гадаад дахь нэгжүүд үзүүлж, тэдний эрхийг идэвхтэй мэдээлнэ. Цагдаа, прокурорын байгууллагын бие бүрэлдэхүүн ажил үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа энэ хуульд заасан эрх бүхий этгээдийг мэдсэн тохиолдолд гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, нөхөн төлбөр олгох тухай хуулийн дагуу өргөдөл гаргах эрхээ мэдэгдэнэ.” гэж заажээ.

#### **5. Гэмт хэрэгтнээр хохирол төлүүлэх зорилгоор эд хөрөнгийг нь хураах эрх зүйн зохицуулалт**

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 455-12-т хөрөнгө хураах тусгай ажиллагааны талаар заасан. Өмчийг нь хурааж болох гуравдагч этгээд хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад аман мэтгэлцэхээс өмнө хураах ажиллагаанд оролцох хүсэлтээ шүүхэд гаргаж болно.<sup>214</sup>

Өмнөх догол мөрөнд дурдсанчлан өргөдөлд дараах зүйлийг бичгээр тусгана.

1. Хэргийн хураангуй, хариуцагчийн овог нэр, хүйс, төрсөн он, сар, өдөр, иргэний үнэмлэхийн дугаар, эсхүл шүүгдэгчийг танихад хангалттай бусад холбогдох өд.

<sup>213</sup> Мөн тэнд

<sup>214</sup> Code of Criminal Procedure <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0010001>.

2. Хураах ажиллагаанд оролцох үндэслэл.
3. Хураах ажиллагаанд оролцох хүсэлтэй байгаагаа илэрхийлж.

Хураагдаж болох эд хөрөнгийг хураах ажиллагаанд гуравдагч этгээд оролцох хүсэлт гаргаагүй бол шүүх зайлшгүй шаардлагатай гэж үзвэл уг гуравдагч этгээдийг хураах ажиллагаанд оролцохыг албан тушаалын дагуу шийдвэрлэнэ. Харин ийм гуравдагч этгээд эд хөрөнгөө хураахад татгалзах зүйлгүй гэдгээ шүүх, прокурорт тодорхой илэрхийлсэн тохиолдолд дээрх заалт хамаарахгүй.

## **6. Төрөөс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох төрийн тусгай сан буюу захиргааны журмаар хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа**

Гэмт хэргийн хохирогчийн хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлд “эрх бүхий байгууллага гэмт хэргийн хохирогчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үйлчилгээг сурталчлах, бэхжүүлэх зорилгоор сан байгуулж болно.” гэж заажээ.

Эрх бүхий төв байгууллага нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч (үүнд “хохирогч” гэх)-д нөхөн төлбөр олгох зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох сан (үүнд “Нөхөх олговрын сан” гэх)-аас олгоно.<sup>215</sup>

## **7. Хохирогчид нөхөн төлбөр олгож буй шат дараалал, хариуцах байгууллага буюу институтийн тогтолцоо**

### **Нөхөн олговор олгож буй шат дараалал**

#### *Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хууль*

Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 62 дугаар зүйлд<sup>216</sup> “гэмт хэргийн хохирогчид энэ хуулийн дагуу нөхөн төлбөр олгохыг шаардаж байгаа аливаа этгээд холбогдох нотлох баримт бичгийн хавсаргасан хүсэлтээ тухайн гэмт хэрэг үйлдсэн харьяаллын дагуу хянан шалгах хороонд бичгээр гаргана. Харин гадаадад нөхөн төлбөр авах хүсэлт гаргасан хүмүүс гэмт хэргийн хохирогчийн ар гэрийн бүртгэлтэй газрын хяналтын хороонд хүсэлтээ гаргана.” гэж заажээ.

Түүнчлэн дараах нөхцөл байдлын аль нэгэнд нөхөн олговрын нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх эрх бүхий Хяналтын хороог төв засгийн газар байрладаг харьяаллын дагуу Дахин хянан хэлэлцэх хороо

<sup>215</sup> Regulation governing the transfer of seized proceeds of human trafficking crime and compensation of victims  
<https://law.moi.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080183>.

<sup>216</sup> Crime Victim Rights Protection Act.  
<https://law.moi.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=I0050005>



ТОМИЛНО.

1. Эрүүгийн хэрэг үйлдсэн газар нь тодорхойгүй.
2. Нөхөн олговрын нэхэмжлэлийг аль хороо хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага болох талаар маргаан үүссэн.
3. Нөхөн олговрын нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх эрх бүхий хороо байхгүй.

## **Хариуцах байгууллага**

Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 61 дүгээр зүйлд<sup>217</sup> хянах хороо болон дахин хянан шийдвэрлэх хорооны талаар заасан.

Дүүргийн прокурорын газар, түүний салбар нэгжүүд хохирлоо барагдуулах болон бусад холбогдох асуудлыг хянан шалгах, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий Гэмт хэргийн хохирогчийн нөхөн төлбөрийг хянан шалгах хороо /цаашид “Хянах хороо” гэх/ байгуулна.

Улсын Ерөнхий Прокурорын газар, түүний салбар нэгжүүд гэмт хэргийн хохирогчийн хохирлыг барагдуулах тухай нэхэмжлэлийг хянан шалгах хорооны хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих үүрэг бүхий Гэмт хэргийн хохирогчийн нөхөн төлбөрийг дахин хянан шалгах хороо (цаашид “Дахин хянан шийдвэрлэх хороо” гэх)-ийг зохион байгуулна.

Дахин хянан шалгах хороо болон хяналтын хороо нь Улсын Ерөнхий прокурорын газар, түүний салбар, дүүргийн прокурорын газар, түүний салбарын ахлах прокурор байх тус бүр нэг хуралдагчтай байна. Хууль зүй, анагаах ухаан, сэтгэл зүй, нийгмийн ажил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэшсэн прокурор болон бусад мэргэжилтнээс бүрдсэн 6-10 гишүүнээс гурван жилийн хугацаатай байна. Эрх бүхий байгууллагад тайлагнасны дараа Улсын ерөнхий прокурор, Хяналтын хороо, хянан хэлэлцэх хорооны ажилтнууд нь холбогдох прокурорын байгууллагын одоо ажиллаж байгаа ажилтнууд байна.

Хорооны гишүүд нь аль ч хүйсийн хувьд гуравны нэгээс багагүй, янз бүрийн мэргэжилтэй хүмүүсийн талаас нэгээс доошгүй байх ёстой; Хяналтын хорооны гишүүд Дахин хянан хэлэлцэх хорооны гишүүнээр нэгэн зэрэг ажиллах ёсгүй. Дахин хянан хэлэлцэх хороо, хянан шалгах хорооны хурал болоход хамгаалалтын байгууллага, салбарыг урьж, төлөөлөгчдөө хуралд оролцуулна.

Гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах нийгэмлэг нь гэмт хэргийн хохирогчид болон тэдний амьд үлдсэн хүмүүст тусламж үзүүлдэг. Тэдний үзүүлж буй үйлчилгээнд:

---

<sup>217</sup> Мөн тэнд.

1. Суурьшлын болон орон сууцны зохицуулалт;
2. Эмнэлгийн үйлчилгээ;
3. Хууль зүйн туслалцаа;
4. Нөхөн төлбөр авах өргөдөл;
5. Нийгмийн халамжийн үйлчилгээ;
6. Мөрдөн байцаалтын ажилд туслалцаа үзүүлэх;
7. Аюулгүй байдлын хамгаалалт;
8. Сэтгэл зүйн тусламж;
9. Амьдралыг нөхөн сэргээх;
10. Итгэмжлэлийн удирдлага;
11. Яаралтай тусламжийн санхүүжилт;
12. Баталгааны бичиг өгөх;
13. Айлчлал.

Тайвань Хууль зүйн яамны Тайвань Нөхөн сэргээлт, нийгмийн хамгааллын хэлтэс хүчирхийллийн болон хувийн гэмт хэргийн хохирогчдод санхүүгийн нөхөн олговор олгох зорилгоор гэмт хэргийн хохирогчийн нөхөн төлбөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

### **Тогтолцооны хувьд**

Хууль зүйн яам нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдээс хууль тогтоомжид заасны дагуу хураагдсан орлого, цуглуулсан мөнгөн дүнг нь нөхөн төлбөр болгон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох эрх бүхий төв байгууллагад шилжүүлнэ. Нөхөн төлбөрийн төрөл, нэхэмжлэлийн шалгуур, төлбөрийн хэмжээ болон заавал дагаж мөрдөх бусад зохицуулалтыг холбогдох эрх бүхий төв байгууллагатай зөвшилцөн эрх бүхий төв байгууллага боловсруулна. Ижил төстэй бусад журмын дагуу нөхөн төлбөр олгох нөхцөлийг хангасан хохирогчид хуулийн дахин нөхөн төлбөр авахгүй.<sup>218</sup>

### **8. Нөхөн төлбөр авах эрх үүсэх шалгуур, бүрдүүлэх материал, зарцуулах хугацаа, олгох нөхөн төлбөрийн төрөл**

Өргөдлийн маягтыг Тайвань дахь Мөрдөн байцаах товчоо, дүүргийн шүүх, Америкийн хүрээлэнгээс авах боломжтой. Нэхэмжлэгч нь гэмт хэрэг үйлдсэн харьяаллын дагуу Гэмт хэргийн хохирогчийн хохирлыг барагдуулах хороо, Мөрдөн шалгах товчоо, дүүргийн шүүхэд өргөдөл гаргах ёстой. Өргөдлийг 3 сарын дотор боловсруулдаг. Дүүргийн шүүхийн нөхөн төлбөр олгохоос татгалзсан шийдвэрийг давж заалдах гомдлыг Дээд шүүхэд гаргаж болно.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх нөхөн төлбөр

<sup>218</sup> Human trafficking prevention act, Article 37. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080177>

олгох журмын 12 дугаар зүйлд Дотоод хэргийн яам өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дотор нөхөн төлбөр олгох тухай шийдвэрийн талаар өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэнэ гэж заасан.<sup>219</sup>

Өмнөх хэсэгт дурдсан бичгээр гаргасан шийдвэр нь дараах мэдээллийг агуулна.

1. Өргөдөл гаргагчийн овог нэр, төрсөн он, сар, өдөр, иргэний үнэмлэхийн дугаар, паспорт эсвэл зочин (оршин суугчийн) зөвшөөрлийн дугаар, захидал харилцааны хаяг. Хэрэв төлөөлөгч байгаа бол төлөөлөгчийн нэр, төрсөн он, сар, өдөр, иргэний үнэмлэхийн дугаар, паспорт эсвэл зочин (оршин суугчийн) зөвшөөрлийн дугаар, захидал харилцааны хаяг.
2. Зөвшөөрөгдсөн өргөдлийн хувьд олгогдсон нөхөн төлбөрийн төрөл, хэмжээг дэлгэрэнгүй бичих.
3. Татгалзсан өргөдлийн хувьд шийдвэрийн үндэслэл.
4. Өргөдлийг зөвшөөрсөн, эс зөвшөөрсний үр дүнг шийдвэрлэх эрх бүхий байгууллага.
5. Лавлах дугаар, шийдвэрийн огноо.
6. Шийдвэрийг арилгах арга, хугацаа, шийдвэрийн эсэргүүцлийг шийдвэрлэх эрх бүхий байгууллага.

### **Зарцуулах хугацаа**

Нэхэмжлэлийг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш хоёр жилийн дотор гаргах ёстой. Өргөдлийн маягтыг Мөрдөн байцаах товчоо, дүүргийн шүүх, Тайвань дахь Америкийн хүрээлэнгээс авах боломжтой. Нэхэмжлэгч нь Гэмт хэргийн хохирогчийн хохирлыг барагдуулах хороо, Мөрдөн байцаах товчоо, гэмт хэрэг гарсан харьяа дүүргийн шүүхэд өргөдөл гаргах ёстой.

Өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш 3 сарын дотор хэргийн талаар бичгээр шийдвэр гаргана. Дүүргийн шүүхийн нөхөн төлбөр олгохоос татгалзсан шийдвэрийг давж заалдах гомдлыг Дээд шүүхэд гаргаж болно.

Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 64 дүгээр зүйлд<sup>220</sup> Хяналтын хорооны нөхөн төлбөр олгох өргөдлийн тухай шийдвэрийг гэмт хэргийн үйл баримт тодорхой бол өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш гурав (3) сарын дотор бичгээр гаргана эсхүл гэмт хэргийн бодит байдлыг зөвхөн шүүхийн байгууллагын мөрдөн байцаалтын явцад олж авсан мэдээлэлд үндэслэн тогтоох боломжтой бол мөрдөн байцаалт, хяналт шалгалт, түүнтэй холбоотой мөрдөн байцаалтын ажиллагаа

<sup>219</sup>Regulations governing Subsidy for Victims of Human Trafficking.  
<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080183>

<sup>220</sup> Crime Victims Right Protection Act.  
<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=I0050005>

дууссан өдрөөс эхэлнэ гэж заасан.

Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 65 дугаар зүйлд хяналтын хорооны шийдвэртэй санал нийлэхгүй байгаа өргөдөл гаргагч нь шийдвэрийг гардан авснаас хойш 30 хоногийн дотор дахин хянан хэлэлцэх хороонд давж заалдсан үндэслэлээ бичгээр гаргаж болно. Хяналтын хороо өмнөх зүйлд заасан хугацаанд шийдвэр гаргаж чадаагүй бол өргөдөл гаргагч хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор дахин хянан хэлэлцэх хороонд бичгээр өргөдөл гаргаж болно. Дахин хянан хэлэлцэх хороо давж заалдах гомдлын талаар шийдвэр гаргах, эсхүл хянан шалгах хороог тойрон шийдвэр гаргах үед өмнөх зүйлийн заалтыг өөрчлөн дагаж мөрдөнө гэж заасан.<sup>221</sup>

Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 66 дугаар зүйлд өргөдөл гаргагч нь Хяналтын хорооноос гаргасан дахин хянан хэлэлцэх шийдвэр, эсхүл Хяналтын хорооноос дахин хянан хэлэлцэх хороонд хүргүүлсэн шийдвэрийг эс зөвшөөрвөл, эсхүл 64 дүгээр зүйлд заасан хугацаанд шийдвэр гаргаагүй бол өргөдөл гаргагч нь 30-ны дотор шийдвэрийг хүлээн авснаас хойш буюу хугацаа дууссаны дараа захиргааны журмаар хэрэг үүсгэнэ гэж заажээ.

Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 68 дугаар зүйлд<sup>222</sup> нэхэмжлэгч нэн шаардлагатай байгаа бол нөхөн олговрын нэхэмжлэлийг шийдвэрлэхийн өмнө дахин хянан хэлэлцэх хороо болон хянан шалгах хорооны албан тушаалтан өргөдлийн дагуу түр нөхөн төлбөр төлөх шийдвэр гаргаж болно. Хяналтын хороо болон дахин хянан хэлэлцэх хороо нь өмнөх хэсэгт заасан нөхөн төлбөр олгох тухай өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш хоёр сарын дотор бичгээр шийдвэрлэнэ. Түр нөхөн олговор олгох тухай шийдвэрийн эсрэг давж заалдах гомдол гаргах, захиргааны хэрэг үүсгэх боломжгүй гэж заасан.

## **9. Тохиолдол, шийдвэрлэсэн байдал**

2022 онд амьд үлдсэн дөрвөн гадаадын иргэн хүн худалдаалах гэмт хэргийн хэргээр иргэний хэрэг үүсгэсэн. Дүүргийн шүүх эдгээр хэргүүдийн хоёрыг нь дүгнэж, хохирогчдод нийт 106,000 NT буюу 3,830 ам.доллар (2020 онд нийт 7,93 сая гаруй төгрөг буюу 286,210 ам. доллар нөхөн олговор олгохоор) нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн.

Хоёр хэрэг нь тайлант хугацааны эцэст хянан хэлэлцэгдэж байсан. 2021 онд хийсэн судалгаагаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид улсын төсвөөс санхүүжилт, хамгаалах үйлчилгээгээ сул, хууль зүйн

---

<sup>221</sup> Мөн тэнд.

<sup>222</sup> Мөн тэнд.

зөвлөгөө өгөх чанар, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа удаан үргэлжилсэн, нөхөн олговор авахад хүндрэлтэй байсан зэрэг гомдол их байсан талаар дурджээ.

## ДҮГНЭЛТ

Тайвань 2010 оноос хойш түвшин 1 (tier 1)-д оруулсан бөгөөд энэ нь Тайвань улсын хүн худалдаалахтай тэмцэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ахиц дэвшил гаргасныг илтгэж байгаа юм. Тайвань улс Азийн бусад орнуудад хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг үлгэр жишээ болохуйц сайн туршлагыг хууль болон журамд тусгаж чадсан байна.

Тайвань хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд цогц хуулийг хэрэгжүүлж байгаагаас гадна 2023 оны 12 дугаар сарын 28-нд Тайвань Дотоод хэргийн яамнаас “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх нөхөн төлбөр олгох журам”-ыг баталсан. Бусад улстай харьцуулахад тусгайлсан журамтай бөгөөд тус журмаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид тусламж үзүүлэх зорилгоор “нөхөн төлбөрийн сан” байгуулсан ба Прокурорын байгууллага нь хууль тогтоомжийн дагуу хураагдсан гэмт хэргээс олсон орлого, нөхөн төлүүлэх боломжтой мөнгийг нөхөн төлбөрийг тухайн санд нэн даруй төвлөрүүлэн ажилладаг.

Тайвань тус журмаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн төрөл, нөхөн төлбөр авах шалгуур, нөхөн төлбөрийн хэмжээ, бүрдүүлэх материал, нөхөн төлбөр өгөхөөс татгалзах болон бусад процессын талаар нарийвчлан зохицуулсан нь дэвшилттэй байна. 2021 онд Тайвань хүн худалдаалах гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хүн, компанийг төрийн худалдан авах ажиллагаанд оролцох, төрийн гэрээ байгуулах, туслан гүйцэтгэгчээр төрийн худалдан авах ажиллагаанд оролцохыг таван жилийн хугацаанд хориглох заалтуудыг 2021 онд Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд нэмж оруулсан.

2023 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Тайвань улсын хууль тогтоох дээд байгууллага Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх тухай хуульд (人口販運防制法) хүн худалдаалах, хүн худалдаалахыг завдсан хэрэгт ногдуулах шийтгэлийг чангатгах зорилготой нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Нэмэлт, өөрчлөлтийн гол заалтууд нь дараах байдалтай байна,

1. Бэлгийн мөлжлөг: 5 сая NT доллар хүртэл торгууль ногдуулна. Дээр дурдсан гэмт хэрэг үйлдэхийг завдсан тохиолдолд мөн шийтгэл ногдуулдаг.

2. Хөдөлмөрийн мөлжлөг: 3 сая NT доллар хүртэл торгууль ногдуулна. Хохирогч нь 18 нас хүрээгүй бол дээр дурдсан гэмт хэргийг үйлдсэн этгээдийг 7 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэж, мөн таван сая NT долларын торгууль ногдуулна.
3. Эрхтэн хураах: 10 сая доллар хүртэл торгууль ногдуулна.
4. Хүн худалдаалах: 3 сая NT доллар хүртэл торгууль ногдуулна.

## Тайвань улсын сайн туршлагууд

- Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 57 дугаар зүйлд гэмт хэргийн төрлөөс шалтгаалан хохирогчдод төлөх нөхөн төлбөрийн хэмжээг тодорхой заасан;
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх нөхөн төлбөр олгох тусгайлсан журамтай;
- 2023 оны 12 дугаар сарын 28-нд Тайвань Дотоод хэргийн яамнаас “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх нөхөн төлбөр олгох журам”-ыг баталснаар “Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хураагдсан эд хөрөнгийг шилжүүлэх болон хохирогчид нөхөн олговор олгох тухай журам” хүчингүй болсон.<sup>223</sup>
- Процедурын хувьд иргэний нэхэмжлэлийг бие даан эсвэл эрүүгийн нэхэмжлэлд хавсаргаж болно.
- Гэмт хэргийн хохирогчийн хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлд “эрх бүхий байгууллага гэмт хэргийн хохирогчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үйлчилгээг сурталчлах, бэхжүүлэх зорилгоор сан байгуулж болно.” гэж заажээ.
- Эрх бүхий төв байгууллага нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч (үүнд “хохирогч” гэх)-д нөхөн төлбөр олгох зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох сан (үүнд “Нөхөх олговрын сан” гэх)-аас олгоно.<sup>224</sup>
- нөхөн төлбөр хийх төрийн тогтолцоогоор төр урьдчилсан буюу түр төлбөрийг хийдэг;
- хуулийн дагуу цагдаа нар хохирогчид түүний эрхийг ярьж таниулах үүрэгтэй;
- Тайвань улс хүн хүн худалдаалах гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хүн, компанийг төрийн худалдан авах ажиллагаанд оролцох, төрийн гэрээ байгуулах, туслан гүйцэтгэгчээр төрийн худалдан авах ажиллагаанд оролцохыг таван жилийн хугацаанд хориглодог.

<sup>223</sup>Regulation Governing Subsidy for Victims of Human trafficking.  
<https://law.moi.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080183>

<sup>224</sup> Regulation Governing the transfer of seized proceeds of human trafficking crime and compensation of victims  
<https://law.moi.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080183>.

### 3.7. БҮГД НАЙРАМДАХ МОЛДОВА УЛС

Молдова улс нь хүний худалдаалах, албадан хөдөлмөрийн талаар олон улсын гол гол конвенцын мөн цагаач ажилчдын эрхийн талаар ОУХБ-ын 97 дугаар конвенцын гишүүн орон юм. Тус улс нь мөн хүний худалдааны эсрэг Европын конвенцод гарын үсэг зурсан. Хүний худалдаа үүнтэй холбоотой асуудлыг шүүн таслах прокурорын тусгай алба 2000 оноос эхлэн ажиллаж байна. 2002 оны эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 165, 206 –р зүйлүүдэд хүний худалдаалахыг гэмт хэрэг хэмээн тодорхойлсон бөгөөд дээд шүүхээс энэ гэмт хэргийн шинж чанар, онцлогийн талаар дэлгэрэнгүй тайлбар гаргажээ.<sup>225</sup>

Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай хууль баталсан ба энэ хуулиар үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг баталжээ. Түүнчлэн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх үндэсний хороо байгуулж, хүн худалдаалахтай холбогдсон асуудлаар төрийн байгууллага, яамдын хүлээх үүргийг тодорхойлсон байна. Уг баримт бичигт худалдагдсан хүмүүсийг хамгаалах, тусламж үзүүлэх талаар хэрэгжүүлэх олон тооны арга хэмжээг тодорхойлж тэдгээрийн нэлээд хэсгийг ТББ-ууд хариуцан хэрэгжүүлэхээр заасан юм.

2006 оны 12 сарын 8-нд засгийн газар хүний худалдааны хохирогчдыг хамгаалах тэдэнд тусламж үзүүлэх төвүүдийн ажиллагааны журмыг баталжээ. Энэ журмыг эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны санаачилгаар 2005 оны хүн худалдаалахын эсрэг хуулийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан байна. Уг журамд бүс нутгуудад тусламж хамгааллын төвүүдийг байгуулж ажиллуулах талаар мөн тэдгээрийн үзүүлэх үйлчилгээний талаар тодорхой заасан байна. Түүнчлэн засгийн газар орон нутгийн байгууллагууд эдгээр үйл ажиллагааг төрийн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ гэж заажээ.

2005 оны 9 дүгээр сарын 6-нд Молдова, АНУ-ын Засгийн газрууд хүний худалдааны эсрэг тэмцэх агентлаг хоорондын төвийг байгуулах тухай тохиролцон захидал солилцжээ. Хүний худалдаатай тэмцэх асуудлыг хариуцсан тусгай анги үүний өмнө дотоод явдлын яаманд харьяалагдаж байсныг шинээр байгуулагдсан энэ төвд нэгтгэжээ. Төв нь гэрчийн этгээдийг хамгаалах хөтөлбөр, шинжилгээ, сурталчилгааны хэсэгтэй юм. Гэрчийг хамгаалах ажиллагааны зорилго нь гэрчийг хамгаалах албадыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагааны явцад тэдгээрт хуулийн зөвлөгөө өгөхөд орших юм. Хүний худалдааны хохирогчдод тусламж үзүүлэх ажиллагааг идэвхтэй явуулж буй ТББ-уудтай, үүний дотор La Strada, эмэгтэйчүүдийг худалдахаас урьдчилан

<sup>225</sup> БНМУ-ын Дээд шүүхийн бага хурлын шийдвэр, Хүний худалдаа болон хүүхдийн худалдаатай холбоотой хуулийг хэрэглэх талаар, 2004 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн №37 тоот.

сэргийлэх хороо, олон улсын цагаачлалын байгууллагын орогнох байрууд багтана. Эдгээр байгууллагууд худалдагдсан хүмүүсийг шилжүүлэх механизмаар дамжуулан эдгээр хүмүүст туслах, сурталчлан таниулах болон судалгааны ажлыг хэрэгжүүлж байна.

## **1. Хохирогчид нөхөн олговор олгох эрх зүйн зохицуулалтын салбар буюу эрүү, иргэн, хөдөлмөрийн хуулийн журмаар нөхөн олговор олгох ажиллагааны онцлог, зохицуулалт**

Молдова улсын Үндсэн хуульд аль нэг иргэн түүний эрх, эрх чөлөө ашиг сонирхлын эсрэг өдүүлсэн үйлдлийг засан залруулах шийдвэрийг хууль шүүхийн эрх мэдэл бүхий байгууллагуудаас гаргуулах эрхтэй<sup>226</sup> гэж заажээ. Эрүүгийн хэргийн шүүх шийтгэгдсэн яллагдагч “хохирогчийн гэр бүлд санхүүгийн тусламж үзүүлэх”, учруулсан хохирлыг шүүхээс тогтоосон тодорхой хугацааны дотор төлж дуусгах шийдвэр гаргана.<sup>227</sup> Молдовын эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 219 дүгээрт заасан ёс суртахууны болон эд материалын хохирлыг төлүүлэхээр энэ нэхэмжлэлийг гаргана.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд “гэмт хэргийн хохирогч”, “иргэний нэхэмжлэгч”, “эрх нь зөрчигдсэн этгээд”, мөн “гэрчүүд” гэж ангилан үзжээ.<sup>228</sup> Шүүх ажиллагаанд оролцогчийн эрхийн хүрээ түүний статусаас хамааралтай. Хохирогч нь өөрийгөө эрх нь зөрчигдсэн тал, эсвэл иргэний нэхэмжлэгч гэж үзэхийг хүсэх эрхтэй.

“Хохирогч”-ийг гэмт хэргийн улмаас ёс суртахууны, бие махбодын, эд материалын хохирол хүлээсэн хуулийн этгээд болон хувь хүн хэмээн тодорхойлжээ. Гэмт хэргийн хохирогч мөн болохоо батлахын тулд хохирсон этгээд хуулийн байгууллагад нэхэмжлэл гаргаж албан ёсоор бүртгүүлсэн байх ёстой.<sup>229</sup> (хохирогчийн төрөл садныг хохирогч гэж хүлээн зөвшөөрсөн үндэсний хэмжээний тодорхойлолт байхгүй)

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирогч нь гэмт хэрэг үйлдэгчтэй холбоотой хэргийг шүүн таслах явцад өөрийгөө “иргэний нэхэмжлэгч тал” хэмээн хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.<sup>230</sup> Ингэснээр тухайн хохирогч гэмт хэргийн улмаас түүнд учирсан ёс суртахууны болон эд хөрөнгийн хохирлыг төлүүлэх эрхээ эдлэх

<sup>226</sup> Free Access to Justice, 20- 1 дүгээр зүйл.

<sup>227</sup> Молдовын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 90(6)(d)(e) заалтууд

<sup>228</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг доорх байдлаар 2003-2006 оны илтгэлд ангилан ялгажээ. Үүнд:

“ хохирогч” – худалдагдсан хүмүүсийн дотроос зөвхөн 22%-ийг нь хохирогч хэмээн үзжээ. Энэ нь худалдагдсан таван хүний нэг юм.

“эрх нь зөрчигдсэн” гэдэгт худалдагдсан хүмүүсийн 79%-ийг оролцуулдан үзжээ. Таван хүний нэгийг (10% ) энэ ангилалд хэд хэд дахин хамруулж үзжээ.

“иргэний нэхэмжлэгч тал” гэдэгт гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн гэж хууль хяналтын байгуулагад хандаж хэргийг нь авч үзсэн хүмүүсийг оруулжээ. Энэ нь нийт хохирогчдын 85% болж байна.

(харин энэ нь хохирогчийг нэгээс илүү ангилалд хамруулан давхардуулсан тоо байж болох талтай)

<sup>229</sup> Молдовын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58(1), (2).

<sup>230</sup> Молдовын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58(3), (6).



боломжоор хангагдана.<sup>231</sup> Иргэний нэхэмжлэгч талын хувиар хохирогч нь түүний зөвшөөрөлтэйгөөр шүүхийн байгууллагаас шүүн таслах ажиллагааны явцад эд мөрийн баримт болгон авсан зүйлийг буцаан авах мөн түүнчлэн гэмт хэрэг үйлдэгчийн түүнээс авсан өмч хөрөнгөө эргүүлэн авах хүсэлт гаргаж болно.<sup>232</sup> Хохирогчийг мөн "эрх нь зөрчигдсэн тал" гэж үзэж болох бөгөөд өөрөөр хэлбэл гэмт хэргийн улмаас ёс суртахуун, бие махбод, эд материалын хувьд хохирсон хүн гэж үзнэ. Эрүүгийн мөрдөн байцаах ажиллагаа явуулж буй байгууллага нь эрх нь зөрчигдсэн тал гэж үзэх шийдвэрийг тухайн хохирогчийн зөвшөөрөл, ингэж үзэх шалтгааныг тодорхойлсны дараа хуулийн дагуу гаргана.<sup>233</sup> Ингэснээр хохирогч тал нь зарим нэмэгдэл эрхтэй болохын хамтаар цагдаа, прокурор, шүүхэд мэдүүлэг өгөх үүргийг мөн хүлээнэ.

Хохирсон болон иргэний нэхэмжлэгч талууд нь уг хэргийг шүүн таслах ажиллагаанд албан ёсны оролцогчийн хувьд шүүхэд яллагдагчийн эсрэг мэдүүлэг өгөх, нотлох баримт сэлтийг хянан шалгуулахаар гаргах эрхийг эдэлнэ. Түүнчлэн мөрдөн байцаах ажиллагаа явуулж буй байгууллага, шүүхээс авсан аль нэг арга хэмжээг эсэргүүцэх эрхтэй. Тэд мөн учруулсан хохирлын тухай асуудлыг авч хэлэлцэх шүүх ажиллагаанд оролцож болно.<sup>234</sup> Хохирсон болон иргэний нэхэмжлэгч талын өв залгамжлагчид нас барагчийн нэгэн адил эрх эдэлнэ. Хохирогч болон иргэний нэхэмжлэгч гэрчийн этгээдийн статустай шүүн таслах ажиллагаанд оролцогсод нь энэ завсар гаргасан зардлаа төлүүлэх боломжтой байх ёстой.<sup>235</sup> Энэ төлбөрт өөр газар оронд суугаа гэрчээс мэдүүлэг авахтай холбогдон гарсан зардал, түүний аян замын болон утсан харилцаа дүрст холбоогоор харилцсаны зардал орно.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу хуулийн бүх шийдвэр нь иргэний нэхэмжлэлийн дагуу ямар арга хэмжээ авах тухай шийдвэрийг мөн агуулж байх ёстой. Хохирогч ЭБША-д шүүхэд янз бүрийн статустай оролцох боломж нь багагүй ээдрээтэй, амьдрал дээр хохирогч олон удаа мэдүүлэг өгөхөд хүргэж болох талтай юм. Гэхдээ ингэснээрээ хохирогчид хууль ёсны байр суурь, эрхүүдийг олгож, түүнийг шүүн таслах бүх ажиллагаанд биеэр болон өмгөөлөгчөөр дамжуулан оролцох боломжийг хангадаг.

Эрүүгийн хуулийн дагуу "иргэний шүүх мөн шүүхийн захирамж, шийдвэрүүд"–ийг хэрэгжүүлэх шаардлага гардаг.<sup>236</sup> Шүүхийн эцсийн шийдвэр гарсны дараа шүүхээс хохирогчийн нэхэмжлэлийн дагуу нөхөн

<sup>231</sup> Молдовын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 61 дүгээр зүйл.

<sup>232</sup> Молдовын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 61(1), (20)

<sup>233</sup> Молдовын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 59(1), (2).

<sup>234</sup> Молдовын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 62 дугаар зүйл.

<sup>235</sup> Эрүүгийн шүүн таслах ажиллагаанд хохирогчийн оролцооны талаар суурь шийдвэрийн 7 дугаар зүйл.

<sup>236</sup> Молдовын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 336 дугаар зүйл.

төлбөр олгох захирамжийг гаргадаг.<sup>237</sup> Нэхэмжлэл гаргагчийн хүсэлтээр, шүүхийн захирамжаар шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллагаа эхэлнэ. Харин "шүүхийн шийдвэрийг зохих ёсоор цаг алдалгүй" хэрэгжүүлэх хариуцлагыг Хууль зүйн яамны шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хүлээнэ.<sup>238</sup> Иргэний шүүхийн хуулийн заалтаар бол шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх зарим тохиолдолд уг шийдвэрийг нэн даруй хэрэгжүүлэх ёстой боловч хөрөнгө боломж байхгүй учраас төрөөс тэдгээрийг хэрэгжүүлэхийг татгалзсан тохиолдол гардаг. Эмэгтэйчүүдийг худалдахаас урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх (Эмэгтэйчүүдийг худалдахаас урьдчилан сэргийлэх төв) ТББ-ын мэдээлснээр учруулсан эд материалын хохирлыг нотлох баримтгүй учраас хүн худалдагчийн эсрэг шүүхэд гаргасан нэхэмжлэлийн олонх нь зөвхөн ёс суртахууны хохирлыг төлөх нэхэмжлэл байдаг байна. Түүгээр ч зогсохгүй хохирогчийг орон нутагт нь буцаах эмчлэн сувилах, бичиг баримтыг шинээр олгох, хуулийн холбогдолтой бусад асуудлыг зохицуулахтай холбогдон гарсан зардлыг тус байгууллага болон олон улсын цагаачлалын байгууллага гаргаж ирсэн байна. Ёс суртахууны хохирлыг төлүүлэхээр гаргасан нэхэмжлэл нь дунджаар 50000 лей байна.

## 1.2. Хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэх хэргүүд

Молдовын үндсэн хуулийн 44 дүгээр заалтаар албадан хөдөлмөр хийхийг хориглосон. Албадан хөдөлмөр хийлгэсэн тохиолдолд дээр дурдсан иргэний болоод эрүүгийн шүүхээр асуудлыг шийдвэрлүүлэхээс гадна хохирогч хөдөлмөрийн хуулийг мөн ашиглаж болно.

Хөдөлмөрийн хуулийн 7 дугаар зүйлд албадан хөдөлмөрийг хориглоод үүнийг аль нэг хүнийг айлган сүрдүүлэх, эсвэл түүний зөвшөөрөлгүй, тулгасан ажил хөдөлмөр хэмээн тодорхойлжээ. Албадан хөдөлмөрт 7 дугаар зүйлийн 4-т зааснаар дараах зүйлүүд орно:

- цалин хөлсийг тогтсон хугацаанд эс төлөх эсвэл хагсыг нь төлөх;
- ажил олгогч хамтын болон хүн тус бүрийн нийгэм хамгааллын тогтолцоог хэрэглэхгүй байх эсвэл тухайн ажил нь ажил эрхлэгчийн эрүүл мэнд амь насанд аюултай байх тохиолдолд.

Хөдөлмөрийн хуулийн 329 дүгээр зүйлд зааснаар ажил үүргээ гүйцэтгэж байхад нь эсвэл ажлаас хууль бусаар халсан тохиолдолд тухайн ажилчинд учирсан эд материалын болон ёс суртахууны хохирлыг ажил олгогч бүрэн дүүрэн барагдуулах хариуцлага хүлээнэ. Эрхийг нь зөрчсөнийг мэдсэн буюу мэдэх ёстой байснаас хойш 1 жилийн дотор хөдөлмөрчин хүн нэхэмжлэл гаргаж болно; эсвэл тухайн хөдөлмөр

<sup>237</sup> Молдовын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 338 дугаар зүйл.

<sup>238</sup> Молдовын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйл.

эрхлэгч холбогдох эрхийг эдэлж эхэлснээс хойш гурван жилийн дотор гаргаж болно.<sup>239</sup>

Хөдөлмөрийн хуулийн 7 дугаар зүйлд заасан албадан хөдөлмөрийг хийлгэсэн хэргийн талаарх нэхэмжлэлээ хөдөлмөрийн хуулийн 355 дугаар заалтын дагуу ажилчин шүүхэд гаргана. Энэ эрхийг тэрээр ажил олгогчтой албан ёсоор гарын үсэг зурсан хөдөлмөрийн гэрээгүй нөхцөлд ч эдэлнэ. Тухайн хүн аль нэг компанийн ажилчин байгаа тохиолдолд ийм гэрээ зайлшгүй шаардлагатай болно. Хөдөлмөрийн хуулийн 58 дугаар зүйлийн 3 хэсэгт хэрвээ бичгээр байгуулаагүй бол хөдөлмөрийн гэрээг тодорхойгүй хугацаатайгаар байгуулагдсан гэж бөгөөд ажил олгогч ажилчныг ажилд авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон гэж үздэг байна. Хэрвээ ажил эрхлэгч уг ажлыг хийж байгаа гэдгээ нотолж чадвал ажил олгогч бичгээр гэрээг байгуулах үүрэг хүлээдэг.

## **2. Нөхөн төлбөрийн буюу хохирлын хэлбэр: эдийн ба эдийн бус хохирол (ёс суртахууны хохирол), нөхөн төлбөрийн хэмжээ, түүнийг тогтоох, үнэлэх нь**

Тус улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар

- 1) Эрүүгийн хуулиар хориглосон үйлдлийн уршгаар эвдэрч гэмтсэн эд хөрөнгийг өмнөх байдлаар нь сэргээх эсвэл дүйцэх үнийг нь төлөх;
- 2) Эвдэрч гэмтсэн буюу алдагдсан эд хөрөнгийг өмнөх худалдааны брэнд, чанарын хэмжээнд хүртэл нь сэргээх буюу худалдан авах, түүнчлэн гэмтэж муудсан эд хөрөнгийг сэргээн засварлахад зарцуулсан хөрөнгийг нөхөн төлөх;
- 3) Эрүүгийн хуулиар хориглосон үйлдлийн улмаас алдагдсан орлого ашгийг нөхөн төлөх;
- 4) Ёс суртахуун зарим нөхцөлд мэргэжлийн нэр хүндэд нь учруулсан хохирлыг төлөх.

Эд материалын хохирол гэдэг нь эрүүгийн хуулиар хориглосон үйлдэлтэй холбогдон гарах бөгөөд үнийн дүнгээр дараах байдлаар илэрхийлэгдэнэ.

- 1) гэмтэж бэртсэн талд үзүүлсэн эмчилгээ, сувилгаа;
- 2) эрх нь зөрчигдсөн талыг оршуулсан зардал;
- 3) даатгал төлөх, хохирлыг барагдуулах болон тэтгэвэр тэтгэмж өгөх;
- 4) үл хөдөх хөрөнгийг шилжүүлэх гэрээ байгуулах.

Ёс суртахууны хохирлын хэмжээг мөнгөөр үнэлэхдээ шүүх нь хохирогчийн бие махбод, гоо сайханд учирсан хохирол, амьдрах итгэл,

<sup>239</sup> Хөдөлмөрийн хуулийн 355 дугаар зүйл.

хань ижилдээ итгэх итгэл алдагдсан гүжир гүтгэлгийн улмаас нэр хүндээ алдсан, садан төрлийн хүн нь амь насаа алдсаны улмаас санаа сэтгэлийн зовлон амссан зэргийг анхааралдаа авч үзнэ. Энэ нь хохирлыг өргөн хүрээтэй тодорхойлсон хэрэг бөгөөд үүнд цалин хөлсийг нь төлөөгүй, бие махбодын хувьд хохирсон зэрэг тохиолдол мөн хамрагдах бөгөөд ингэснээр нэхэмжлэл гаргах өргөн боломжийг хохирогчид олгож хэрвээ учирсан хохирлыг нотлох хангалттай баримттай бол шүүгчийн зүгээс нэхэмжлэлийг барагдуулах шийдвэр гаргах хууль эрхийн нөхцөлийг бүрдүүлж байна.

### **3. Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллээр хангагдах эрх буюу мэдээлэл өгөх талаар үүрэгжүүлсэн эрх зүйн зохицуулалт**

Молдовын эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар хохирогч нь түүний эрх ашиг сонирхолтой холбогдох асуудал, гарах шийдвэрийн талаар шүүн таслах хурал, шүүхийн байгууллагуудаас мэдээлэл хүсэх эрхтэй.<sup>240</sup>

### **4. Гэмт хэрэгтнээр хохирол төлүүлэх зорилгоор эд хөрөнгийг нь хураах эрх зүйн зохицуулалт**

Хохирогч нэхэмжлэл гаргасан эсэхийг үл харгалзан учруулсан эд материалын хохирлыг нөхөн төлүүлэх түүнчлэн хөрөнгийг хураах, эрхийг шүүх эдэлнэ. Шүүх нь иргэний нэхэмжлэлийг салган авч түүнийг эцэслэн шийдвэрлэхээр иргэний шүүхэд шилжүүлэх эрхтэй.

Молдова улсын Эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдэхдээ хэрэглэсэн хөрөнгийг эсвэл гэмт хэргээс олсон орлогыг төр өөртөө шилжүүлэн авахыг зөвшөөрдөг. Хэрвээ тэр өмч хөрөнгө нь байхгүй болсон бол төр түүнтэй дүйцэх хэмжээний хөрөнгийг хураан авч болно. Хэрэг үйлдэгч эрүүгийн хариуцлага хүлээж ял шийтгүүлээгүй ч гэсэн түүний хөрөнгийг хураан авч болно.<sup>241</sup>

Эдгээр эрх мэдлийг зөвхөн хүний худалдааны хохирогчдын төлбөрийг барагдуулахад ашиглаж ирээгүй байна.

Хүн худалдагчийн гэмт хэргийн замаар олсон өмч хөрөнгийг баривчлах буюу хураан авч бүрдүүлсэн санхүүгийн эх үүсвэрээс худалдагдсан хүмүүст нөхөн төлбөр олгох санг байгуулахаар үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгажээ. Энэ илтгэлийг бэлтгэх үед төлөвлөгөөний заалтыг хэрэгжүүлэх алхам хийгээгүй байв.

<sup>240</sup> Молдовын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58(3), 62 дугаар зүйл.

<sup>241</sup> Молдовын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 106(1), (4), мөн 203-210 зүйлүүдийг үзнэ үү.

## 5. Хохирогчид нөхөн төлбөр олгож буй шат дараалал, хариуцах байгууллага буюу институтийн тогтолцоо

Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд худалдагдсан хүмүүс шүүх ажиллагааны бүх үйл явцад хууль эрхийн тусламж авах явдлыг хангах заалтууд орсон. Түүнчлэн хүн худалдахын эсрэг хуульд "хуулийн тусламж үнэ төлбөргүй олгох" нь хүн худалдах явдалтай тэмцэх үндсэн зарчим байх болно гэж заажээ.<sup>242</sup>

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэрэгжүүлэх журамд хохирогч болон гэрчийн этгээдийг хамгаалах явдал нь тэдэнд үзүүлэх хууль эрхийн туслалцааны салшгүй хэсэг гэж үзжээ. Хохирогчид түүний хүсэлтийн дагуу эсвэл шүүхээс (өөрийн шийдвэрээр) хуулийн зөвлөгөө өгнө.<sup>243</sup>

Гадаадын харьяат эсвэл иргэн харьяалалгүй хохирогчид шүүх ажиллагааны бүх шатанд хууль эрхийн туслалцааг үнэ төлбөргүй авах эрхтэй. Ерөнхий прокурорын газар нь "хүний эрх үүний дотор хүний худалдааны хохирогчдын эрхийг хамгаалж буй байдалд хяналт тавина." Гэвч засгийн газар тусламж үзүүлэх хөрөнгө гаргадаггүй бөгөөд үнэн хэрэгтээ ийм үйлчилгээг ТББ-ууд олон улсын цагаачлалын байгууллага өөр бусад эх сурвалжаас санхүүжүүлсээр байна. "эргэн нийгэмшүүлэх" болон бусад төрлийн "хамгааллын болон тусламжийн" арга хэмжээнүүдээс "хууль эрхийн" туслалцааг онцгойлон дурджээ.<sup>244</sup> Хамгааллын төвүүд "хууль эрхийн яаралтай тусламж" үзүүлэх нөхцөлөөр хангагдсан байх ёстой бөгөөд харин ТББ-ууд нь хүний худалдааны хохирогчдын ашиг сонирхлыг эрүүгийн болон иргэний нэхэмжлэлийн явцад хамгаалж, туслах болно.<sup>245</sup>

Хүн худалдахаас урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх хууль нь үндсэндээ одоо үйлчилж буй нөхөн төлбөр авах эрхийг дахин давтахаас цааш нэг их хэтрээгүй байна. Хүний худалдааны хохирогч нь хуульд заасны дагуу түүнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй гэж заажээ.

Харин хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө<sup>246</sup> нь гэмт этгээд болон төрөөс нөхөн төлбөр авах боломжийг олгосон хуулийн заалтуудтай болох мөн төлбөр авах тухай хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлжээ. Төрөөс нөхөн төлбөр олгох боломжийг бүрдүүлэхдээ:

Хүн худалдагчдын гэмт хэргийн замаар олж авсан хөрөнгийг

<sup>242</sup> Хүн худалдахаас урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх тухай хууль, 4 е дүгээр зүйл.

<sup>243</sup> Молдовын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58(2), (4).

<sup>244</sup> Хүнийг худалдахаас урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх тухай хууль, 16, 20 (1) дугаар зүйл.

<sup>245</sup> Хүнийг худалдахаас урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх тухай хууль 17(1), 20(1), (7) дугаар зүйл.

<sup>246</sup> 2005 оны 8 дугаар сарын 25-нд Засгийн газрын 925 дугаар шийдвэрээр батлагдсан, Official Monitor сэтгүүлийн 2005 оны 9 дүгээр сарын 9-ы дугаарт хэвлэгдсэн.

баривчлах болон хураан авах замаар худалдагдсан хүмүүст төлбөр олгох санг сэлбэж байх болно гэж заажээ. Цаашилбал, хохирогчийн нөхөн төлбөр авах талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх... эрүүгийн шүүн таслах ажиллагааны бүхий л явцад хуульчаас хуулийн тусламж зөвлөгөө авах боломжийг олгох, түүнчлэн шүүн таслах ажиллагааны явцад хохирогчийн эдлэх эрх, төлбөр авахтай холбогдсон мэдээлэл материалаар хангаж байх зорилт дэвшүүлжээ.

Хэдийгээр энэ хариуцлагыг төрийн байгууллагууд хүлээж байгаа боловч төрийн байгууллагууд өөрийн үүрэг хариуцлагыг биелүүлэхгүй байгаа учраас ажлын ихэнхийг ТББ-ууд гүйцэтгэж байна.

## **6. Тохиолдол, шийдвэрлэсэн байдал**

АНУ-ын элчин сайдын яам, дээд шүүхээс хамтран хэрэгжүүлсэн төслийн тухай илтгэлд 2004 оноос 2005 оны 9 дүгээр сар хүртэл шийдвэрлэсэн хүний худалдаатай холбогдох 106 хэргийг задлан шинжилжээ. Нийт 84 хохирогчийн 45% (дунджаар 38) нь хохирлоо төлүүлэх нэхэмжлэл гаргасан бөгөөд үүнээс 11% (дунджаар 9 хүн)–д нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэжээ. Харамсалтай нь яагаад татгалзсаныг илтгэлд дурдаагүй бөгөөд зарим нэхэмжлэлийг иргэний шүүхэд шилжүүлсэн бололтой юм. Хохирогчид дунджаар 12618 лей (ойролцоогоор 756 евро) олгожээ. Энэ нь эд материалын эсвэл ёс суртахууны хохирлын төлбөрийн аль болох нь тодорхойгүй байна.<sup>247</sup>

### **ДҮГНЭЛТ**

Молдова улсад төрөөс хүний худалдаатай холбогдсон асуудлыг зохицуулах хохирогчдод дэмжлэг үзүүлэх хууль эрхийн болон бодлогын чанартай нэлээд арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Цаашид засгийн газар онц хэрцгий гэмт хэрэгтэй тэмцэх Европын конвенцыг батламжлах, түүнчлэн худалдагдсан хүмүүст ач тусаа өгөх төрөөс санхүүжүүлсэн, эсвэл татаас авдаг тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна.

Эрүүгийн хэргийг таслан шийтгэх шүүхээс хохирогчийн нэхэмжлэлийг үндэслэн олон төрлийн хохирлыг барагдуулах шийдвэр гаргаж болно. Мөн эд материалын хохирлыг барагдуулах шийдвэрийг шүүгч өөрийн санаачилгаар гаргаж болно. Бидний судалсан хэргүүд дотор энэ эрхийг хэрэгжүүлснийг нотлох баримт байхгүй боловч энэ нь нэн чухал эрх мэдэл бөгөөд өөр газар тэр болгон байдаггүй билээ. Шүүн таслах ажиллагаанд оролцож буй гэмт хэргийн хохирогчийн статусаас хамааран янз бүр байж болох олон тооны онцгой эрхийг ЭБШХ-нд цохон

<sup>247</sup> С.Сорсару, Н. Wiseman, Хүний худалдаа – 2004 – 2005 оны 9 дүгээр сард Молдовад шүүн тасалсан хэргүүдийг задлан шинжлэх нь” (2006 оны 6 сар хуудас 28).

дурджээ. Түүнээс гадна хохирогчид нь өмгөөлөгч үнэ төлбөргүй авах эрхтэй боловч амьдрал дээр төр энэ үүргийг биелүүлдэггүй байна. Ёс суртахууны хохирлыг барагдуулах талаар гаргасан олон тооны иргэний нэхэмжлэл амжилтад хүрсэн байна. Гэвч эдгээр нэхэмжлэлийг хэрхэн барагдуулсан, яаж амжилттай хэрэгжүүлсэн болон тэдгээрийн чанар чансааг цаашид нарийвчлан задлан шинжлэх хэрэгтэй бөгөөд чухам үүний үр дүнд нөхөн төлбөр олгоход учир ч буй саад бэрхшээлийг олж тогтоох болно. Хуульчид, прокурор, шүүгчдэд зориулсан сургалт явуулах, тэдэнд удирдамж заавар өгөх замаар хуулийн хэрэгжилтийн чанар чансаа туйлбартай байдал, нэхэмжлэлийг барагдуулах үзүүлэлтийг сайжруулж болно. хэдийгээр төлбөр авах шийдвэр гаргуулсан ч хохирогчид түүнийг авч чадаагүй тохиолдол олон байна. Гэмт этгээдийн хөрөнгийг хураан авах шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлэх арга замын талаар илүү анхаарах шаардлагатай байна.

Албадан хөдөлмөртэй холбоотой асуудлыг хөдөлмөрийн харилцааг зохицуулах шүүхээр тасалж хохирлыг барагдуулах шийдвэр гаргаж болгох эрх ч мөн байна. Энэ эрхийг эдэлснээр албан ёсоор бүртгүүлсэн хөдөлмөрийн гэрээгүй ч төлбөр авах нэхэмжлэл гаргах боломжтой болж байна.

Хүний худалдааны хохирогчдыг төлөөлдөг, тэдэнд дэмжлэг туслалцаа зөвлөгөө өгдөг, зарим тохиолдолд төрийн үүрэг хариуцлагыг өөртэй авч хэрэгжүүлдэг (тухайлбал гэрчийн замын зардлыг төлөх г.м ) идэвхтэй, туршлагатай ТББ-уудын томоохон хамтлаг ажиллаж байна.

## **Молдова улсын сайн туршлагууд**

- Хүн худалдахын эсрэг хууль нь одоо байгаа эрхүүдийг улам бэхжүүлж, хуулиудын хоорондын уялдаа холбоог сайжруулсан нь;
- Эрх зүйн тусламжийг үнэ төлбөргүй авах эрхийг хуулиар хүлээн зөвшөөрсөн нь;
- Эрүүгийн шүүн таслах ажиллагаанд оролцох эрх;
- Шүүгч өөрийн санаачилгаар зарим төрлийн нөхөн төлбөрийг эрүүгийн шүүхийн ажиллагааны журмаар олгож байгаа нь;
- Хүн худалдаалах гэмт хэрэгт ёс суртахууны хохирлыг төлүүлэх журмыг хүлээн зөвшөөрсөн нь;
- Хүний худалдааны хохирогчийг хамгаалах тусламж үзүүлэх үндэсний тогтолцооны ажиллагааг зохицуулах, санхүүжүүлэх алхмыг төрөөс хэрэгжүүлж байгаа нь;
- Хууль эрхийн туслалцаа үзүүлэх болон хохирогчдыг төлөөлөх тэдний эрхийг хамгаалж хохирогчдод тусламж үзүүлдэг идэвхтэй тбб-уудын хамтлаг байгаа болон энэ асуудлыг эрхэлсэн прокурорын тусгай баг ажилладаг нь давуу тал юм.

### 3.8. РУМЫН УЛС

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод шударга ёсны хүртээмж, үр дүнтэй арга хэмжээг үнэлж дүгнэсэн АНУ-ын Төрийн Департаментаас жил бүр гаргадаг “Хүн худалдаалах асуудлын төлөв байдлын тайлан”<sup>248</sup>-ийн шинэ тайланд Румын улс хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, бодлогын тогтолцоог үргэлжлүүлэн хөгжүүлсээр байгааг тэмдэглэжээ. 2020 онд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хүүхэд худалдаалах гэмт хэрэгт оногдуулах ялын доод хэмжээг нэмэгдүүлсэн бөгөөд эрх баригчид 2018-2022 он хүртэл хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний стратегийг шинэчлэн баталжээ.<sup>249</sup>

Хууль зүйн сайд Ерөнхий прокуророос хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг авах арга хэмжээг нэн тэргүүнд эрэмбэлэхийг хүссэнийг сайшаан хүлээж авахын зэрэгцээ олон тооны ялыг түдгэлзүүлж, гэм буруутайд тооцогдох хэлцэл эсвэл түүнтэй адилтгах гэрээг ашиглах нь гэмт хэрэгтнүүдийн ялыг хөнгөвчлөх боломжийг олгож байна.

Румын улс нь ХБНГУ, Итали, Испани, Их Британи зэрэг улсууд руу зорьсон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын гарал үүслийн орон хэвээр байна. Румын улсын эрх баригчдын тогтоосон хохирогчдын тоо жил ирэх тусам буурчээ. Илтгэлд хамрагдсан хугацаанд (2016-2019) нийт 2613 хохирогчийг илрүүлжээ. Дөрөв тутмын гурав нь эмэгтэйчүүд, тал нь хүүхэд байсан бөгөөд бэлгийн мөлжлөг нь хүн худалдаалах хамгийн түгээмэл зорилго хэвээр байна.

Румын улсын Засгийн газар хүн худалдаалахыг устгах наад захын стандартыг бүрэн хангаж чадахгүй байгаа ч үүний тулд ихээхэн хүчин чармайлт гаргаж байна. Засгийн газар өмнөх тайлант үетэй харьцуулахад нийтээр нэмэгдэж буй хүчин чармайлтыг харуулсан бөгөөд COVID-19 тахлын хүн худалдаалахтай тэмцэх чадавхад үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэж Румын улс 2-р шатлалдаа хэвээр үлджээ. Эдгээр хүчин чармайлтад улсын хэмжээнд санхүүгийн шинэ мөрдөн байцаагчийн орон тоо бий болгох, Зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризмыг мөрдөн шалгах газрын (DIICOT) хүрээнд хүн худалдаалахтай холбоотой гэмт хэрэг зэрэг санхүүгийн мөрдөн байцаах тусгай алба байгуулах зэрэг багтсан. Түүнчлэн гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдэд зориулсан хувийн сонсголын 42 танхимыг ашиглалтад оруулж, хүүхдэд ээлтэй асуулга авах арга зүйг нэг мөр болгох үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хохирогч хүүхэдтэй хэрхэн

<sup>248</sup> The Council of Europe's Group of Experts on Action against Trafficking in Human Beings (GRETA)

<sup>249</sup> Council of Europe, Romania urged to effectively prosecute human traffickers and ensure access to compensation for their victims, 2021.

<https://www.coe.int/en/web/portal/-/romania-urged-to-effectively-prosecute-human-traffickers-and-ensure-access-to-compensation-for-their-victims>



харьцах талаар цагдаагийн байгууллагад сургаж дадлагажуулжээ. Цаашилбал, Засгийн газраас Ерөнхий сайдын дэргэдэх Засгийн газар, иргэний нийгмийн гишүүдээс бүрдсэн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хороог байгуулж, хүн худалдаалахтай тэмцэх багцыг нэмэгдүүлж, төрийн хороонд иргэний нийгмийг хамруулах үүрэг өгсөн.<sup>250</sup>

АНУ-ын Төрийн Департаментаас жил бүр гаргадаг “Хүн худалдаалах асуудлын төлөв байдлын тайлан” хохирогчдод нөхөн төлбөр авах боломжийг хөнгөвчлөх, баталгаажуулах нэмэлт хүчин чармайлт гаргах. Үүнд:

- a) Шүүхэд нөхөн олговор олгох нэхэмжлэлийг дэмжих зорилгоор эрүүгийн мөрдөн байцаалтын шатанд хохирогчид учирсан хохирлын талаарх ялангуяа хохирогчийн мөлжлөгөөс үүссэн санхүүгийн ашиг зэрэг хохирогчийн учирсан хохирлыг багтаасан нотлох баримтыг цуглуулах;
- b) Эд хөрөнгийг битүүмжлэх, хураах тухай хууль тогтоомжийг бүрэн ашиглах, түүнчлэн олон улсын хамтын ажиллагааны дагуу хохирогчдод нөхөн олговор олгохдоо Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хураагдсан эд хөрөнгийг хохирогчдод аль болох хурдан буцааж өгөх явдлыг баталгаажуулах;
- c) Хуульч, прокурорт мөн шүүгчид зориулсан сургалтын хөтөлбөрт хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг хуульд буй бүх боломжийн дагуу ашиглах талаар тусгах;
- d) Нэн тэргүүнд хохирогчийг тогтоох замаар төрөөс хохирогчид нөхөн төлбөр авах боломжийг хөнгөвчлөх, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчдийн хураагдсан хөрөнгийг ашиглан нөхөн төлбөрийн санг санхүүжүүлэх, журам, шалгуурыг хялбарчлах (87-р зүйл).<sup>251</sup>

Румын улс нь Зохион байгуулалтай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын конвенц, Хүн худалдахын эсрэг протокол, ОУХБ-ын албадан хөдөлмөр болон хүний худалдааны эсрэг ба онц хэрцгий гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай Европын конвенцын гишүүн орон юм. Румын улс үндэсний хууль тогтоомжоо олон улсын гэрээгээр хүлээсэн үүргүүдтэй зохицуулах талаар онцгой хүчин чармайлт гаргаж<sup>252</sup> дараах хуулиуд батлагдсан. Үүнд: Хүн худалдахын эсрэг 678/2001 тоот хууль, Гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах зарим арга хэмжээний 211/2004 тоот хууль, Хүүхдийн эрхийг хөгжүүлэх хамгаалах тухай 272/2004 тоот хууль зэрэг болно. Түүнчлэн Гэр бүлийг хамгаалах үндэсний агентлаг,

<sup>250</sup> Report submitted by the authorities of Romania on measures taken to comply with Committee of the Parties Recommendation CP/Rec(2021)05 on the implementation of the Council of Europe Convention on Action against Trafficking in Human Beings, June 2023.

<https://rm.coe.int/report-submitted-by-the-authorities-of-romania-on-measures-taken-to-co/1680aba92d>

<sup>251</sup> Мөн тэнд.

<sup>252</sup> Европын сайд нарын 25-р бага хуралд Румын Хууль зүйн сайдын тавьсан илтгэл [www.coe.int/t/dgl/legalcooperation/minijst/](http://www.coe.int/t/dgl/legalcooperation/minijst/)

Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх болон хохирогчид тусламж үзүүлэх асуудалд хяналт тавих үндэсний агентлаг зэрэг 2 тусгай байгууллагыг байгуулжээ.

Хүний худалдаатай холбогдсон асуудлууд үүний дотор хууль эрхийн зөвлөгөө өгөх, тусламж үзүүлэх, хорогдох байр болон бусад үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн олон тооны ТББ-ууд ажиллаж байна. Эдгээр үйлчилгээг ихэвчлэн Засгийн газартай хамтран ажиллаж үзүүлдэг боловч дангаар үйлчилгээ үзүүлэх нь бий.

## **1. Хохирогчид нөхөн олговор олгох эрх зүйн зохицуулалтын салбар буюу эрүү, иргэн, хөдөлмөрийн хуулийн журмаар нөхөн олговор олгох ажиллагааны онцлог, зохицуулалт**

Румын улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хохирлыг нь нөхөн төлүүлэх арга замыг ЭХХША-д иргэний нэхэмжлэл гаргах, ИХХША-ы журмаар хохирол нэхэмжлэх, төрийн тусгай сангаас хохирол нөхөн төлүүлэх гэсэн 3 байдлаар шийдвэрлэж байна.

2005 оны 1-р сарын 1-нд хүчин төгөлдөр болсон Хохирогчийг хамгаалах тухай хууль нь хохирогчдод хууль эрхийн тусламж үзүүлэх, зөвлөгөө өгөх, учирсан эд материалын хохирлыг төрийн сангаас барагдуулах зэрэг олон төрлийн асуудлыг зохицуулжээ. Нөхөн төлбөр олгох тухай заалт нь зөвхөн "ноцтой гэмт хэргийн" хохирогчид үүний дотор онц хүнд гэмт хэрэг болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод хамаарах ажээ.<sup>253</sup> Хууль нь Румын улсын газар нутагт үйлдсэн гэмт хэрэгт, нэхэмжлэгч нь Румын улсын иргэн эсвэл хууль ёсоор оршин сууж буй гадаадын харьяат эсвэл Румын улс олон улсын Конвенцоор хүлээсэн үүрэг хариуцлагад хамаарч буй хэргүүдийг зохицуулах юм.

### **1.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хохирол нөхөн төлүүлэх**

Румын улсын ЭХХШТХ-ийн дагуу<sup>254</sup> иргэний нэхэмжлэлийг гэмт этгээд, түүний төрөл төрөгсөд/асран хамгаалагчид (хэрэв насанд хүрээгүй бол) эсвэл хамсаатны эсрэг гаргана. Нэхэмжлэх ажиллагааг эрүүгийн гэмт хэргийг авч хэлэлцэхтэй нэгэн зэрэг эхлүүлж нэхэмжлэлээ нэг шүүгчид гаргаж болох бөгөөд эсвэл бие даасан иргэний хэргийн журмаар шийдвэрлүүлж болно. Практикт эхний хувилбарыг түгээмэл хэрэглэдэг. Хэдий нэн ховор боловч эрүүгийн шүүн таслах ажиллагааны явцад амжилт олоогүй ч иргэний нэхэмжлэл нь амжилт олох тохиолдол

<sup>253</sup> Үүнийг хүн амь хөнөөхөөр завдах, бие махбодид хүнд гэмтэл учруулах, амь насанд болон бие махбодид санаатайгаар гэмтэл учруулах, хүчиндэх, насанд хүрээгүй хүмүүстэй бэлгийн харилцаанд орох, бага насны хүмүүсийг уруу татах болон тэдний эсрэг хүч хэрэглэх хэмээн тодорхойлжээ.

<sup>254</sup> Румыны ЭБШХ-ийн 998 – 1002 зүйлд хууль бус үйлдлийн учирсан хохирлыг хариуцах үүргийг тогтоожээ.

гардаг. Гэхдээ иргэний нэхэмжлэл нь эрүүгийн шүүн таслах явцад амжилт олоогүй бол эрүүгийн хэрэг үүсгэн түүнийг дахин шийдвэрлүүлэх нэхэмжлэл гаргах боломжгүй.

Иргэний нэхэмжлэлийг ихэнх тохиолдолд ЭХХША-ы явцад авч хэлэлцдэг бөгөөд хохирогч, яллагдагч хоёул оролцож мэдүүлэг өгдөг.<sup>255</sup> Хэрвээ нэхэмжлэлийг иргэний эрхийн шүүхээр авч үзэж байгаа бол нэхэмжлэгч оролцож мэдүүлэг өгөх шаардлага заавал гардаггүй онцлогтой.

Хохирогч эрүүгийн шүүхийн хуралд биеэр оролцож мэдүүлэг өгөх явдал нь хохирогчийн хувьд сэтгэл санааны шаналгаа болон бусад төрлийн эрсдэлтэй холбоотой байдаг бөгөөд энэ нь тэдгээрийг шүүх ажиллагаанд оролцож нэхэмжлэл гаргахад учирдаг гол саад бэрхшээл юм. Үүнээс гадна хэргийг шүүн таслах ажиллагаа удтал сунжирч хэдэн сараар төдийгүй жилээр ч үргэлжлэх тохиолдолд гардаг байна.

## **1.2. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хохирол нөхөн төлүүлэх**

Нэхэмжлэл гаргах хуулийн эрх нь Румынд оршин суудаг эсвэл нэхэмжлэгчийн иргэншлээс үл хамаарна. Төрийн төлбөрийн тогтолцооноос нөхөн төлбөр авах нэхэмжлэлийг тухайн гэмт хэргийг "ноцтой" гэж үзээгүй тохиолдолд ч гаргаж болно. Хэрэг хэр их ноцтой вэ гэдгээс төлбөрийн хэмжээ хамаарна. Гэм буруутай үйлдэл болон нөхөн төлүүлж байгаа төлбөрийн хооронд учир шалтгааны холбоо заавал байх ёстой. Гэмт этгээд болон нэхэмжлэгч хоёулаа оролцон шүүн таслах ажиллагааны явцад энэ учир шалтгааныг баримтаар нотлох ёстой.

Иргэний шүүхээс "ёс суртахуун"-ны хохирлыг оролцуулан төрийн нөхөн төлбөрийн тогтолцооноос олгодогтой адил ангиллын төлбөрийг төлөх шийдвэр гаргаж болно. Иргэний нэхэмжлэлийн дагуу шүүхийн шийдвэр гарсны дараа хохирогч гэмт этгээдээс уг төлбөрөө олж авах төвөгтэй асуудалтай тулгардаг. Хэрвээ төлбөрийг тэд сайн дурын үндсэн дээр хийхгүй бол иргэний шүүхийн шийдвэрийн журмын дагуу "шүүхийн шийдвэр биелүүлэгчид" хандаж болох бөгөөд энэ нь үнэ төлбөргүй ч ихээхэн чирэгдэлтэй асуудал байдаг. Ер нь хэзээ ч төлбөр хийхгүй байх магадлал маш их юм.

ЭХХШТХ-ийн 581 дүгээр зүйлд зааснаар эрүүгийн шүүхийн шийтгэх тогтоолд иргэний хохирлын талаар иргэний хуулийн дагуу албадан гүйцэтгэнэ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар (V дэвтэр, 622-р зүйл - 726-р зүйл) болон 188/2000 хуулиар шүүхийн

<sup>255</sup> 682/2002 тоот Гэрчийг хамгаалах тухай хууль

шийдвэр гүйцэтгэгч хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааг гүйцэтгэнэ. Румын улсын хууль тогтоомжийн дагуу Иргэний болон эрүүгийн хэргийн шинж чанараас үл хамааран хохирлыг барагдуулах нэхэмжлэл нь улсын тэмдэгийн хураамжаас чөлөөлөгдөнө.

### **1.3. Хөдөлмөрийн шүүхийн ажиллагаа**

Ямар төрлийн цалин хөлс вэ гэдгээс хамааран төлөөгүй болон дутуу төлсөн цалин хөлсийг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг Хөдөлмөрийн болон Иргэний хуулийн дагуу гаргаж болдог. Засгийн газраас жил бүр тогтоодог цалин хөлсний доод хэмжээтэй дүйцэх орлого хөдөлмөрийн хуулийн хүрээнд хамрагдах бөгөөд энэ хэмжээг хөдөлмөрийн зах зээлтэй жишин үнэлж болно. Орон нутгийн ТББ-уудын мэдээллээр Румынд хөдөлмөрийн мөлжлөгийн нөхцөл байдалд ажиллаж буй цагаач ажилчидтай холбоотой цөөн тооны хэрэг гарсан бөгөөд ийм учраас тэд Румын улсын хуулийн тогтолцооны дагуу нэхэмжлэл гаргах туршлага багатай байдаг.

## **2. Нөхөн төлбөрийн буюу хохирлын хэлбэр: эдийн ба эдийн бус хохирол (ёс суртахууны хохирол), нөхөн төлбөрийн хэмжээ, түүнийг тогтоох, үнэлэх нь**

Нөхөн төлбөр нь бие махбодын болон сэтгэл санааны хийгээд, хохирогчид учруулсан ёс суртахууны, нэр төрийн болон түүнд тохиолдсон стресс зэргийг багтаадаг. Ёс суртахууны хохирлын тухай ойлголтыг коммунизм сүйрсний дараа сэргээсэн боловч энэ төлбөрийг яаж тооцох асуудал Румын улсын хууль эрх, хуульчдын дотор ихээхэн маргаантай асуудал хэвээр байна. Үүний улмаас энэ талаар маргаантай, тууштай биш шийдвэр цөөнгүй гарч болох талтай юм. Энэ хохирлын хэмжээг хохирогчийн гаргасан нэхэмжлэл, учруулсан ёс суртахууны хохирол хэр ноцтой зэргийг харгалзан харгалзан шүүхээс тогтооно. Ямар шүүхээр асуудлыг авч хэлэлцэж байгаагаас үл хамааран хохирол учирсан гэдгийг нотлох баримтыг гаргана. (тухайлбал бие махбодын болон ёс суртахууны хохирлыг эмнэлгийн үзлэгээр нотолсон байна). Учирсан бүх хохирлыг нотлох бичиг баримтаар эсвэл гэрчийн мэдүүлэг мөн нэхэмжлэгч 250 лейгээс бага орлоготой гэдгийг нотлох баримтаар баталгаажуулсан байх ёстой.

Нөхөн олговрын төрөлд эмнэлгийн зардал болон бусад эмчилгээний зардал, материаллаг хохирол (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнээс хэтрэхгүй байх), олох байсан орлогыг хамааруулна.<sup>256</sup>

<sup>256</sup> Compensation for victims of Human trafficking in Romania, Ministry of Internal Affairs, 2017

Нөхөн төлбөр олгох шийдвэр гаргасан хэргийн тоо хязгаарлагдмал байгаа нь тухайн хууль зүйн тогтолцоо учирсан хохирлыг нь арилгаж чадна гэсэн хохирогчийн итгэлийг бууруулах нөлөө үзүүлж болох талтай.<sup>257</sup> ADPARE ТББ-ын нэг хэргийн талаар өгсөн мэдээллээр биеийг нь үнэлүүлж мөлжихөөр Турк улсад зарагдсан гурван эмэгтэй, нэг нь жирэмсэн болсон, эд материалын болон ёс суртахууны хохирлоо төлүүлэх нэхэмжлэлийг иргэний шүүхэд гаргажээ.

Ингээд хоёр хохирогч 5000 РОН (1480 евро) нөгөө нь 4000 РОН(1184 евро)-ы төлбөр авах шийдвэр гарчээ. Хүн худалдаалсан этгээдүүд 12 жил найман сараас 8 жил хоригдох ялаар шийтгүүлсэн байна. 2006 онд даван заалдах шүүхээс өмнөх шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ. Гэтэл энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэх асуудал бэрхшээлтэй тулгарсаар байгаа ажээ.

### **3. Насанд хүрээгүй хохирогчид тусгайлсан эрх зүйн зохицуулалттай эсэх**

Хуулиар хүүхдийн асуудал зохицуулагдаагүй байна. Учир нь хохирол гэдгийг зөвхөн тодорхой төрлийн эд материалын хохирлоор хязгаарлажээ. Хэрвээ нөхөн төлбөр олговол тэрхүү мөнгийг хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч захиран зарцуулах бөгөөд ихэнх тохиолдолд үүнд хүүхдийн хамгаалах эрх бүхий байгууллагуудын зүгээс тавих хяналт хамгаалалт байхгүй ажээ. Энэ нь уг мөнгийг хохирогч хүүхдийн ашиг тус тулд биш өөр замаар хялбархан ашиглах боломжтой гэсэн үг юм.

Хүний худалдааны хохирогч нь онц гэмт хэрэг, уг гэмт үйлдлийн талаар мэдэгдэх цаг хугацааны хязгаарт тавьсан шалгуурууд түүнчлэн хохирлын төрөл зүйлээс (тухайлбал ёс суртахууны хохирол гэж байхгүй учраас) болон энэ боломжийг ашиглах нөхцөл хязгаарлагдмал байна.

Гэмт этгээд илрээгүй байгаа тохиолдолд хохирогч гурван жилийн дотор нэхэмжлэл гаргаж болох бөгөөд хэрвээ тэрээр насанд хүрээгүй бол 18 нас хүрснээс хойш гурван жилийн дотор нэхэмжлэл гаргаж болно.

### **4. Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллээр хангагдах эрх буюу мэдээлэл өгөх талаар үүрэгжүүлсэн эрх зүйн зохицуулалт**

Хуульд зааснаар хохирогч хууль эрхийн туслалцаа, мэдээлэл авах эрхтэй. Гэвч эдгээр заалтуудыг хэрэгжүүлэхэд ТББ-уудад түшиглэх хандлага хүчтэй хэвээр байна. Худалдагдсан хүмүүсийг төлөөлөх тэдэнд хуулийн туслалцаа үзүүлэхтэй холбогдолтой хуулийн заалтуудыг

<sup>257</sup> 2008 оны 12-р сард Барселонд болсон Хүний эрхийн семинарт Румын улсын прокурорын хийсэн мэдээлэл.

тодорхой болгох улмаар бие даан ажилладаг хуульчдыг энэ чиглэлээр зохих хэмжээний сургалтад хамруулж мөн хохирогчдыг төлөөлөн ажилласныхаа төлөө сайн цалин хөлс авдаг болгох явдал чухал ач холбогдолтой.

Онолын хувьд хуулийн байгууллагууд (цагдаа, шүүх, мөрдөн байцаагч) хохирогчтой анх удаа харилцаа холбоо тогтоохдоо тэдний эрхийн талаар мэдээлэл өгөх үүрэгтэй. Хүн худалдахын эсрэг өмнөх хуулиудтай харьцуулахад илүү нарийн тодорхой заалт бүхий хохирогчийг хамгаалах тухай 211/2004 тоот хуулийг батлагдтал үүнийг амьдралд бүрэн хэрэгжүүлж ирсэнгүй. Гэсэн ч байдал өнөөг хүртэл хангалтгүй байгаа тул ТББ энэ үүргийг гүйцэтгэсэн хэвээр байна. Хэдийгээр ТББ сайн ажиллаж байгаа ч төр засагтай байгуулсан ямар нэгэн хамтын ажиллагааны хэлэлцээргүй санхүүжилт дутагдалтай нөхцөл байдалд энэ үүргийг гүйцэтгэсээр байна.<sup>258</sup>

## **5. Гэмт хэрэгтнээр хохирол төлүүлэх зорилгоор эд хөрөнгийг нь хураах эрх зүйн зохицуулалт**

Хүний худалдааны эсрэг хуулиар гэмт этгээдийг шүүн таслахдаа түүний эд хөрөнгийг хураах бүрэн эрхийг олгожээ. Үүнд ” гэмт хэрэг хийх замаар олсон мөнгө, үнэт зүйл болон бусад эд хөрөнгө” эсвэл ”эдгээр гэмт хэргийг үйлдэхдээ хэрэглэсэн зүйл”-ийг хураагдах хөрөнгөд багтаажээ, “худалдах хүмүүсийг тээвэрлэхэд ашигласан унаа машин, тэр хүмүүсийг байрлуулж байсан байр... гэмт хэрэгтний өмч бол”<sup>259</sup> тэдгээрийг мөн хураахыг заажээ. Харин эдгээр эд хөрөнгийг хэрхэн зарцуулах (тухайлбал үүнийг төрийн санд өгөх) эсвэл уг хөрөнгийг нэхэмжлэлийг төлж барагдуулах болон хэрэгт гэрчээр оролцогсад олгох төлбөрийн журмаар хэрэглэж болох эсэх тухай тодорхой заагаагүй байна.

## **6. Төрөөс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох төрийн тусгай сан буюу захиргааны журмаар хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бий болгож, түүгээр дамжуулан хуваарилагдсан мөнгөн хөрөнгийг зөвхөн гэмт хэргийн хохирогчдод онцгой байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн боловсрол олгох зорилгоор туслах, хамгаалахад ашиглаж байна. Франц Улс, Испанийн Вант Улс, АНУ зэрэг улс орнуудын дагаж мөрддөг загвартай төстэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бий болгосон ба энэ нь ЭБША-ны явцад

<sup>258</sup> Хохирогчийн хамгааллын талаарх судалгаа [www.antitrfic.ro](http://www.antitrfic.ro) сайтыг үзнэ үү.

<sup>259</sup> 679/2001 тоот хуулийн 19(1), (2) дахь хэсэг.

хураагдсан хөрөнгийг хохирогчдод нөхөн олговор олгоход зарцуулах, гэмт хэргийн хохирогчдод туслах, хамгаалах, хууль эрх зүйн боловсрол олгох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулагдана.<sup>260</sup>

Нөхөн төлбөрийг гэмт хэрэг үйлдэгч хэн болохыг тогтоосон эсэхээс үл шалтгаалан олгодог. Харин хуульд гэмт этгээд нь мэдэгдэж буй эсэхийг үл харгалзан өөр өөр шалгуурыг тогтоосон байна. Гэмт этгээд нь мэдэгдэж байгаа бол нэхэмжлэл гаргаснаас хойш уг хэргийг нэг жилийн дотор шийдэхийг заажээ. Хохирогч нь иргэний нэхэмжлэлээ эрүүгийн шүүн таслах ажиллагааны явцад гаргасан байх шаардлагатай (хэрвээ прокурор уг асуудлыг авч хэлэлцэхээс татгалзаагүй бол), гэмт хэрэг үйлдэгч нь санхүүгийн чадвартай ч олдохгүй байж болно, мөн хохирогч нь төлбөрөө даатгалын хэлбэрээр бүрэн аваагүй байх шаардлагатай. Гэмт хэрэг үйлдэгч нь мэдэгдэхгүй байгаа тохиолдолд хохирогч *гурван жилийн дотор* нэхэмжлэл гаргаж болох бөгөөд хэрвээ тэрээр насанд хүрээгүй бол 18 нас хүрснээс хойш гурван жилийн дотор нэхэмжлэл гаргаж болно.

## **7. Хохирогчид нөхөн төлбөр олгож буй шат дараалал, хариуцах байгууллага буюу институтийн тогтолцоо**

“Хохирогч” -ийг аль ч хуульд сайн тодорхойлж өгөөгүй учраас хохирогчид буруу нэр хаяг өгөх эсвэл түүнийг хүлээн зөвшөөрөхгүй байх улмаар нөхөн төлбөр зэрэг хамгаалалтын арга хэмжээнд хамрагдах хууль зүйн эрхгүй болгож байна.<sup>261</sup> Жишээлбэл шүүх ажиллагааны явцад шүүгч хохирогчийг “хохирогч тал” гэж нэрлэхийн оронд “гэрчийн этгээд” гэж буруу хаягласны улмаас хохирогчийн эдэлбэл зохих хуулийн эрхийг хязгаарлах хандлага ажиглагдаж байна.

Хүн худалдаалахын эсрэг хуульд тусгаж хохирогчийг хамгаалах 211/2004 тоот хуулиар баталгаажуулсан хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөөг гурван сар хүртэлх хугацаагаар (хүүхдэд 6 сар хүртэл) үнэ төлбөргүй өгөх тухай заалт бий. Энэ зөвлөгөөг хохирогчийг хамгаалах болон хэвийн байдалд нь эргүүлж оруулах тусгай байгууллагаас үзүүлнэ.

Хэдий худалдагдсан хүмүүст хуулийн туслалцаа үзүүлэх заалт, үүрэг байгаа боловч хууль нь бүрхэг бөгөөд ямар төрлийн тусламж үзүүлэх эрхтэй, эдгээр тусламж нь иргэний шүүх болон нэхэмжлэлд хамрах эсэх нь тодорхойгүй байна.<sup>262</sup> Практикт эрх зүйн туслалцаа

<sup>260</sup> Report submitted by the authorities of Romania on measures taken to comply with Committee of the Parties Recommendation CP/Rec(2021)05 on the implementation of the Council of Europe Convention on Action against Trafficking in Human Beings, June 2023.

<https://rm.coe.int/report-submitted-by-the-authorities-of-romania-on-measures-taken-to-co/1680aba92d>

<sup>261</sup> ЮНИСЕФ-ийн илтгэл хуудас, 42 дахь тал.

<sup>262</sup> ЮНИСЕФ-ийн илтгэл хуудас, 63 болон 95 дахь тал дахь зөвлөмжүүд.

үзүүлэх талаарх хүсэлтийн дагуу хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч зэрэг ноцтой гэмт хэргээс шууд хохирогчдод, хохирогч нь нас барсан тохиолдолд шууд бусаар хохирогчид, хохирогч 18 нас хүрээгүй эсвэл насанд хүрсэн хохирогч мөнгө хөрөнгөний бололцоогүй тохиолдолд үзүүлдэг байна. Түүнчлэн эрх зүйн туслалцаа үзүүлсэн ч гэсэн түүний төлөө хуульчдын авч буй цалин хөлс их биш учраас үзүүлэх тусламж нь мөн бага байж болох талтай. Чухам ийм хүчин зүйлүүдийг харгалзан ТББ-ууд өөрийн санхүүгийн боломжийг ашиглан энэ үүргийг гүйцэтгэсээр байна.

2000 оноос байгуулагдсан хүний худалдаанаас урьдчилан сэргийлэх болон хүний худалдааны хохирогчдод хяналт тавих үндэсний агентлаг гэдэг төрийн байгууллага хүний худалдааны хохирогчдод үзүүлэх тусламжид хяналт тавих, үүнийг сайжруулах боломжтой болжээ. Уг агентлагийг 2006 онд өөрчлөн зохион байгуулсан бөгөөд Хууль зүйн яамны мэдэгдсэнээр зөвлөгөө өгөх утастай 15 бүсийн төвөөс бүрэлдэж байна. Хохирогчдыг түр байрлуулж, тэдэнд туслалцаа дэмжлэг үзүүлэх зорилготой шилжүүлэх байруудыг бий болгожээ. Гэвч эдгээр арга хэмжээ нь илрүүлж тогтоосон хохирогчдын маш бага хувьд тусламж үзүүлсэн тоон мэдээ байна.

## **8. Нөхөн төлбөр авах эрх үүсэх шалгуур, бүрдүүлэх материал, зарцуулах хугацаа, олгох нөхөн төлбөрийн төрөл**

Хохирогчийг хамгаалах 211/2004 тоот хуулийн 5 дугаар бүлэгт гэмт хэргийн хохирогчийн хамгаалах зарим арга хэмжээг хуульчлахдаа тус улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч төрийн сангаас хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэйг заасан. Ингэхдээ хохирогч гэмт хэрэг үйлдэгдсэнээс 60 хоногийн дотор зохих байгууллагад гомдлоо гаргасан, ЭХХША-д иргэний нэхэмжлэл гаргасан эсхүл гэмт этгээд нь тодорхойгүй байгаа болон төлбөрийн чадваргүй, хохирогч даатгалаас нөхөн олговор аваагүй байх шаардлагатай. Санхүүгийн нөхөн олговор авах хүсэлт гаргахдаа оршин суугаа дүүргийн шүүхэд, эрүүгийн шүүхийн хохирол нэхэмжлэх эрхтэйг дурдсан шийдвэр гарснаас 1 жилийн дотор нэхэмжлэл гаргана.

Түүнчлэн тус хуулиар хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөөг гурван сар хүртэлх хугацаагаар (хүүхдэд 6 сар хүртэл) үнэ төлбөргүй өгөх тухай заалт бий. Энэ зөвлөгөөг хохирогчийг хамгаалах болон хэвийн байдалд нь эргүүлж оруулах (төрийн) албанаас үзүүлэх ёстойг хуульчилжээ.

## **ДҮГНЭЛТ**

Румын улс гэмт хэргийн хохирогчид нэн ялангуяа хүний худалдааны хохирогчдын байдлыг сайжруулах талаар нэлээд дорвитой алхам



хийжээ. Онц хэрцгий гэмт хэргийн хохирогчид болон хүний худалдааны эсрэг Европын конвенцыг баталсан нь үүнийг харуулж байна.

Нөхөн төлбөр олгох тогтолцоо хүний худалдааны хохирогчдод мэдэгдэхүйц ашиг тус өгөхийн тулд түүний заалтуудыг ёс суртахууны хохирлыг нэмэн оруулж засварлах шаардлагатай юм. Одоо байгаа хохирлын төрөлд хязгаар тогтоосон заалтууд түүнчлэн эрүүгийн шүүн таслах ажиллагаанд нэхэмжлэгчээр оролцох үүрэг зэрэг нь хохирогчийг нөхөн төлбөр олж авахын тулд хоёр чиглэлээр ажиллах шаардлагатай болгож байгаа юм. Энэ нь халширмаар төдийгүй цаг хугацаа их шаардах болно. Үүний оронд төрөөс нөхөн төлбөрийг нь бүгдийг нь төлдөг тогтолцоог бүрдүүлэх, түүнчлэн гэмт хэрэг үйлдэгчийн эсрэг иргэний хохирлыг барагдуулах эрхийг өөртөө өвлөн авах замыг сонгож болох юм. Мөн хохирогчид олгох төлбөрийг дахин шинээр бүлэглэн хувааж болох юм.

Хохирогч гэмт хэрэг үйлдэгчийг хэн болохыг тогтоож чадахгүй байгаа нөхцөлд тэд зөвхөн эд материалын хохирлыг төлүүлэх эрхтэй байна. Төлбөр авах эрхийн бусад шалгуурууд тухайлбал хүчирхийлэл, цаг хугацааны хязгаар зэрэг нь хүний худалдааны хохирогчид муу нөлөө үзүүлж болох талтай учраас эдгээрийг тодорхой хугацаанд туршиж дүгнэн цэгнэсний дараа хянаж үзэх шаардлагатай. Энэхүү үнэлгээ нь худалдагдсан хүмүүст үзүүлж буй тусламж, нэхэмжлэлийг хэр түргэн шийдэж байгаа зэрэгт тавих хяналт зэрэг асуудлыг мөн хамарсан байвал зохино.

Хохирогч эрүүгийн шүүх ажиллагааны үеэр бүх төрлийн хохирлыг төлүүлэх нэхэмжлэл гаргах, ингэхдээ хуль эрхийн тусламж авах боломжтой байна. Саявтар хохирогчид эрхийнх нь талаар мэдээлэл өгөх төрийн байгууллагуудын үүргийг нэмэгдүүлжээ. Гэвч амьдралд энэ мэдээллийг гол төлөв төрийн бус байгууллагууд өгсөөр байгаа байдал ажиглагдаж байгаа бөгөөд тэд мөн ёс суртахууны хохирлыг төлүүлэх талаар тодорхой амжилтад хүрсэн байна.

Хэдийгээр хэрхэн яаж тооцох нь тодорхой бус байгаа ч ёс суртахууны хохирлыг боломжийн хэмжээний мөнгөөр барагдуулах асуудлыг шүүхийн зүгээс авч үзэхэд бэлэн байгаа нь нааштай зүйл юм. Эд хөрөнгийг хураах, энэ талаарх шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлыг хууль эрхийн хүрээнд анхааралтай авч үзэх шаардлагатай. Хэдийгээр энэ эрх байгаа боловч хохирогчид нөхөн төлбөрөө авах баталгаа болж чадахгүй байна.

## **Румын улсын сайн туршлагууд**

- Үндэсний агентлагуудын хүний худалдааны талаар хүлээх үүрэг хариуцлага нь тодорхой;
- Хэдийгээр дөнгөж бүрэлдэн тогтоод байгаа ч төрөөс санхүүждэг төлбөрийн тогтолцоотой байгаа нь нааштай үзүүлэлт юм;
- Нөхөн төлбөр олгох, худалдагдсан хүмүүст тусламж үзүүлэх ажил эрхэлсэн төрийн агентлагуудыг байгуулсан;
- Төрийн төлбөрийн тогтолцоогоор дамжуулан урьдчилсан төлбөр олгох чадвартай нь;
- Хүний худалдааны хохирогчид ёс суртахууны хохирлыг төлөх зарчмыг шүүх хүлээн зөвшөөрсөн нь;
- Хууль эрхийн туслалцаа мэдээллийг үнэ төлбөргүй авах эрхийг хуулиар олгосон;
- Олон тооны төрөлжсөн тбб-уудаас бодит туслалцаа үзүүлж байгаа зэрэг болно.

### 3.9. ТАЙЛАНД УЛС

АНУ-ын Засгийн газрын үнэлгээгээр Тайланд улс нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой тус улсын шаардлагыг бүрэн хангаагүй боловч ихээхэн дэвшил гаргасан (Tier 2) орны нэг юм.  
263

Тайланд нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 онд баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”, түүний нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”, Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгээс баталсан “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх конвенц” зэрэгт нэгдэн орсноос гадна бүс нутгийн улсууд, тухайлбал Камбож, Мьянмар, Вьетнам зэрэг улстай 2 талт олон улсын гэрээ байгуулжээ.

Тайландын хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хууль эрх зүйн орчин нь дараах үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Нэгдүгээрт, 2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хууль<sup>264</sup>

Хоёрдугаарт, 2016 оны Хүн худалдаалах гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль юм.<sup>265</sup>

2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хууль нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гол эрх зүйн эх сурвалж юм. Тус хуулиар хүн худалдаалах гэмт хэрэг, түүнтэй

<sup>263</sup> U.S. Department of State, 2023 Trafficking in Persons Report: Thailand, <https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/thailand>

<sup>264</sup> The Prevention and Suppression of Human Trafficking Act BE 2551 (2008).

<sup>265</sup> The Human Trafficking Criminal Procedure Act BE 2559 (2016).

тэмцэх тогтолцоо, хохирогчид үзүүлэх хамгаалалт, тусламж, үйлчилгээ, нөхөн төлбөр олгох асуудалтай холбогдох харилцааг зохицуулсан.

Тус хуулийн 6 дугаар зүйлд зааснаар “хүн худалдаалах” гэдэгт нэгдүгээрт, хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг арилжаалах, худалдах, худалдан авах, тээвэрлэх, зөөвөрлөх, илгээх, саатуулах, хорих, нуух, хүлээн авах үйлдлийг, хоёрдугаарт хүүхдийг арилжаалах, худалдах, худалдан авах, тээвэрлэх, зөөвөрлөх, илгээх, саатуулах, хорих, нуух, хүлээн авах үйлдлийг хэлнэ гэжээ.<sup>266</sup>

Хүүхдийн эсрэг тухайн үйлдлийг үйлдсэн тохиолдолд өмнөх хэсэгт заасан арга, хэлбэр, зорилгыг шаардахгүй байхаар тусгайлсан хуульчилсан гэж үзэж болохоор байна.

Тус хуулийн 7 дугаар зүйлд гэмт хэргийн бусад оролцогчийн төрлийг тусгажээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэхэд тусалсан, өдөөн хатгасан гэх зэрэг үйлдэлд хүн худалдаалах гэмт хэрэгтэй адил эрүүгийн хариуцлага ногдуулахаар хуульчилжээ. Цаашлаад хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхэд бэлтгэсэн тохиолдолд ногдуулах эрүүгийн хариуцлагын доод хэмжээг уг гэмт хэргийг үйлдсэн этгээдэд ногдуулах эрүүгийн хариуцлагын 1/3-тэй тэнцүү байхаар, уг гэмт хэргийг үйлдэхээр завдсан бол 1/ 2-иас ихгүй заасан байна. Гэмт хэргээс үйлдэхээс сайн дураараа татгалзах тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй талаар заасан нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн зохицуулалттай ижил байна. Цаашлаад, нийтийн албан тушаалтан тус гэмт хэргийг үйлдэх тохиолдолд эрүүгийн хариуцлагыг 2 дахин нэмэгдүүлэх байдлаар эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхээр заасан нь онцлог байна.

Тус хуулийн 52 дугаар зүйлд эрүүгийн хариуцлагыг заасан байх бөгөөд энэ гэмт хэргийг үйлдсэн этгээдэд 4-10 жилийн хорих ял, эсхүл 80000-200000 Тайланд бат-тай тэнцэх торгох ял ногдуулна. Гэмт хэргийг 15 насанд хүрсэн боловч 18 насанд хүрээгүй этгээдийн эсрэг үйлдсэн бол 6-10 жил хорих ял, 120000-200000 Тайланд бат, 15 нас хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол 8-15 жилийн хорих ял, 160000-300000 Тайланд баттай тэнцэх торгох ял тус тус ногдуулахаар заасан байгаа нь онцлог байна.

Түүнчлэн хуулийн этгээдийн ашгийн төлөө үйлдсэн бол хуулийн

<sup>266</sup> Article 6, The Prevention and Suppression of Human Trafficking Act BE 2551 (2008), <https://www.mol.go.th/wp-content/uploads/sites/2/2021/02/ANTI-HUMAN-TRAFFICKING-ACT.pdf>

этгээдэд торгох ял, эрх бүхий этгээдэд хорих ял эсхүл торгох ял ногдуулахаар хуульчилжээ.<sup>267</sup>

2016 оны Хүн худалдаалах гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй хамааралтай ээдрээ бүхий эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд шүүхийн үйл ажиллагааны үр ашиг, үр өгөөжийг нэмэгдүүлэх, цаашлаад шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэх боломжийг олгоход чиглэсэн гэж үздэг.<sup>268</sup>

Цаашлаад Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль тогтоомж нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжийн нэг хэсэгт тооцогддог.<sup>269</sup> Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 14.9 дэх хэсэгт зааснаар хүн худалдаалах гэмт хэргээр дамжуулж мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй нөхцөлд Мөнгө угаахтай тэмцэх газар (AMLO) нь хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, сэжигтэн яллагдагчийн хөрөнгийг хураах бүрэн эрхтэй байхаар зохицуулжээ.

2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хуульд хохирогчдыг хамгаалах, дэмжих олон төрлийн арга хэмжээг заасан. Тухайлбал, хохирогчийн хувийн нууцыг хамгаалах, эрхийнхээ талаар мэдээлэл авах, нийгмийн харилцаанд урьдын адил оролцоход чиглэсэн тусламж авах эрх, гэмт хэрэгт яллахаас хамгаалах, хохирогчийн эрх зүйн байдал, гэрч, хохирогч гэрчийг хамгаалах харилцааг нийтлэг байдлаар зохицуулсан. Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдлын яам /The Ministry of Social Development and Human Security/-аас хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүргийг ерөнхийлөн хариуцдаг.

Эмчилгээ хийлгэх, нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдах, нөхөн төлбөр нэхэмжлэх эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн бол хохирогчид тус улсад оршин суух зөвшөөрлийг авахад нь эрх бүхий албан тушаалтнаас хуульд зааснаар хохирогчид тусламж үзүүлэхээр заасан байна.<sup>270</sup>

## **1. Хохирогчид нөхөн олговор олгох эрх зүйн зохицуулалтын салбар буюу эрүү, иргэн, хөдөлмөрийн хуулийн журмаар нөхөн олговор олгох ажиллагааны онцлог, зохицуулалт**

<sup>267</sup> Translation of Article 237f of Dutch Penal Code, <https://eucpn.org/sites/default/files/document/files/NL.pdf>.

<sup>268</sup> Human Rights and Development Foundation, Compensation for Victims of Trafficking in Persons, 2019 [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf), p. 13

<sup>269</sup> If there are reasonable grounds to believe that the offence of trafficking in persons involves money laundering, the enquiry officials must make an immediate report of their findings to the Anti-Money Laundering Office (AMLO): Office of the Prime Minister's Regulation on Coordination in the Implementation of the Anti-Money Laundering Act of 2009 and the Amendment of 2011, Gazette Vol 118, Дам эшлэв. [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf), p.13

<sup>270</sup> Article 37, The Prevention and Suppression of Human Trafficking Act BE 2551 (2008), <https://www.mol.go.th/wp-content/uploads/sites/2/2021/02/ANTI-HUMAN-TRAFFICKING-ACT.pdf>

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох талаар бие даасан хууль байхгүй. Гэвч 2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хуульд хохирогч нөхөн төлбөр нэхэмжлэх хүсэлтэй тохиолдолд төрийн байгууллага, мөрдөн байцаагч, прокурор, бусад албан тушаалтан ямар үүрэг хүлээх талаар зааснаас гадна 33 дугаар зүйлд зааснаар нөхөн төлбөр авах процессын талаарх нарийвчилсан журам, зааврыг Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдал хариуцсан сайд батлахаар заасан. 2013 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах заавар (Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking)<sup>271</sup>-т нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах шат дараалал, бүрдүүлэх материалыг заасан боловч нөхөн төлбөр үнэлэх тооцох талаар зохицуулалт байхгүй.

Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдал хариуцсан яам болон Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны агентлаг (JICA) нарын хамтарсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалахад Хамтарсан баг (MDT)-ийг чадавхжуулах” төслийн хүрээнд “Хамтарсан багийн үйл ажиллагааны заавар (MDT Operational Guideline)”<sup>272</sup> -ын эхний хэвлэлийг 2011 онд боловсруулж, түүнийг үйл ажиллагаандаа баримталж эхэлжээ.<sup>273</sup> Тус зааварт Хамтарсан багийн бүхий л үйл ажиллагаанд баримтлах хууль тогтоомжид заасан шаардлагыг ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлаар тусгаж өгсөн. Мөн тус зааварт хохирогч нөхөн төлбөр нэхэмжлэх процессын талаар дэлгэрэнгүй заасан байна. Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах шат дараалал, бүрдүүлэх баримт бичиг зэргийг холбогдох хэсэгт өгүүлнэ.

### **1.1. Иргэний журмаар хохирол төлүүлэх ажиллагаа**

Хохирогч нөхөн төлбөрөө эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эсхүл иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх замаар гэмт хэрэг үйлдсэн этгээдээс нэхэмжлэх боломжтой. 2005 оноос өмнө хохирогч хохирлоо гагцхүү иргэний шүүхэд хандаж нөхөн төлүүлэх боломжтой байсан бол 2005 онд Эрүүгийн хуульд орсон өөрчлөлтийн дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэл гаргах боломжтой болсон.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх замаар буюу Иргэний хууль тогтоомж дахь гэм хорын зохицуулалтад үндэслэн

<sup>271</sup> Bureau of Anti-Trafficking in Women and Children and Japan International Cooperation Agency, MDT Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking.

[https://www.iica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt\\_guideline\\_practical\\_version.pdf](https://www.iica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt_guideline_practical_version.pdf)

<sup>272</sup> Bureau of Anti-Trafficking in Women and Children and Japan International Cooperation Agency, MDT Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking.

[https://www.iica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt\\_guideline\\_practical\\_version.pdf](https://www.iica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt_guideline_practical_version.pdf)

<sup>273</sup> Bureau of Anti-Trafficking in Women and Children and Japan International Cooperation Agency, MDT Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking.

[https://www.iica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt\\_guideline\\_practical\\_version.pdf](https://www.iica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt_guideline_practical_version.pdf)

хохирол нэхэмжлэх боломжтой.

## **1.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хохирол нөхөн төлүүлэх**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нөхөн төлбөр шаардах үндэслэл нь нэгдүгээрт, 2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хууль<sup>274</sup>, 2016 оны Хүн худалдаалах гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль<sup>275</sup>, хоёрдугаарт Эрүүгийн хууль байх боломжтой. Хохирогч өөрт учирсан эдийн болон эдийн бус хохирлыг дээр заасан материаллаг хэм хэмжээг үндэслэн шаардаж болох боломжтойгоос гадна гэмт хэрэг үйлдэхдээ хохирогчийг эрүүдэн шүүсэн, хорьсон, эрүүл мэндэд нь хохирол учруулсан, хүнлэг бус хандсан тохиолдолд punitive damage<sup>276</sup> буюу шийтгэх нөхөн төлбөрийг<sup>277</sup> мөн шаардах боломжтой.<sup>278</sup>

Хохирогчийн нөхөн төлбөр авах асуудал нь хохирогчоор тогтоолгохтой салшгүй холбоотой гэж үзэх бөгөөд хохирогчийг тогтоох үр дүнтэй механизмыг сайжруулах зохицуулалт 2013 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах заавар (Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking)<sup>279</sup> болон 2016 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тогтоох ажиллагааны үр дүнтэй байдлыг дээшлүүлэх заавар (Guidelines to Enhance Efficiency of Human Trafficking Victim Identification)<sup>280</sup>-т тусгагдсан. Тус зааврын дагуу хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдээллийг авсан даруй холбогдох байгууллагууд Хамтарсан баг ('MDT')-ийг байгуулж, гэмт хэргийн ул мөрийг бэхжүүлэх чиглэлээр (initial fact finding) ажиллаж эхэлдэг. MDT-с аливаа этгээдийг хохирогч гэж үзсэн бол Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдлын яамнаас орон байраар хангаж, хуульд заасан туслалцааг үзүүлнэ.

2008 оны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хуулийн 35 дугаар зүйлд зааснаар хохирогч нөхөн төлбөр нэхэмжлэх хүсэлтэй байгаа бол прокурор түүний өмнөөс нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг нотлох үүрэгтэй байдлаар зохицуулсан байна. Цаашлаад ийнхүү нэхэмжлэл гаргаагүй тохиолдолд шүүх өөрийн санаачилгаар хохирол нөхөн төлүүлэхээр шийдвэрлэх эрхтэй

<sup>274</sup> The Prevention and Suppression of Human Trafficking Act BE 2551 (2008).

<sup>275</sup> The Human Trafficking Criminal Procedure Act BE 2559 (2016).

<sup>276</sup> Section 14 of the TIP Criminal Procedure Act.

<sup>277</sup> Article 14, Procedures for Human Trafficking Cases Act.

<sup>278</sup> <https://oia.coi.go.th/file/get/file/20190212acd9b5de108f0158aa87de8daf24f01b161433.PDF>

<sup>279</sup> [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf)

<sup>280</sup> Bureau of Anti-Trafficking in Women and Children and Japan International Cooperation Agency, MDT Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking.

<sup>280</sup> [https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt\\_guideline\\_practical\\_version.pdf](https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt_guideline_practical_version.pdf)

<sup>280</sup> Thailand's Country Report on Anti-Human Trafficking Response. 2016.

[https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/thailands\\_country\\_report\\_01.pdf](https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/thailands_country_report_01.pdf)

байдгаараа онцлогтой байгаа нь Монгол Улсын эрх орчноос ялгаатай байна.

Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар ийнхүү хохирогчид нөхөн төлбөр олгохоор шийдвэр гарсан тохиолдолд шийдвэрийн биелэлтийг хангуулахад туслах зорилгоор Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдлын яамнаас хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлдэг нь хохирогч бодитоор нөхөн төлбөрөө авахад чухал ач холбогдолтой байна.<sup>281</sup>

Өмнө дурдсан Хамтарсан баг ('MDT') хохирогч, прокурор зэрэг хэргийн оролцогчдын хамруулж уулзалт зохион байгуулж, прокурорын нэхэмжлэх үнийн дүнг хэлэлцэн тогтоодог. Гэвч хохирогч Эрүүгийн хуульд зааснаар дээрх дүнгээс илүү гарсан нөхөн төлбөрийн хэсгийг нэхэмжлэх эрхтэй бөгөөд ингэх тохиолдолд тухайн нөхөн төлбөрийн хэсэгт хамаарах нотлох, мэтгэлцэх чиг үүргийг хохирогч, түүний өмгөөлөгч хэрэгжүүлэх үүрэгтэй болно. Хэдийгээр хохирогчийн нөхөн төлбөр нэхэмжлэх эрхийн баталгааг хангах зорилгоор дээр дурдсанаар олон төрлийн дэмжлэг үзүүлэх боловч яллагдагчийг цагаатгасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд хохирогчийн нөхөн төлбөр шаардах эрхийг хэрэгжүүлэхэд томоохон хүндрэл учирдаг талаар судлаачид тэмдэглэжээ.

### **1.3. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хохирол нөхөн төлүүлэх**

Хохирогч мөн Хөдөлмөрийн тухай хууль /Labour Protection Act/-д зааснаар олгогдоогүй цалин хөлсөө шаардах боломжтой. Гэвч иргэний хэргийн хүрээнд төрийн туслалцаа төдийлөн байдаггүй тул улсын тэмдэгтийн хураамж төлөх, цаашлаад иргэний шүүхийн шийдвэрийн биелэлтийн хувь эрүүгийн шүүхийн биелэлтээс харьцангуй доогуур байдаг зэрэг олон хүндрэл нэхэмжлэгч хохирогчид учирдаг тул эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд энэ төрлийн нөхөн төлбөрийг хамтад нь шийдвэрлүүлэхийг зөвлөсөн байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу улсын байцаагч эсхүл хөдөлмөрийн шүүхэд хандан олгогдох ёстой цалин хөлсөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, хамгийн ихдээ 1 жилд ногдох цалин хөлсөө нэхэмжлэх боломжтой. Хүн худалдаалах гэмт хэргийн хувьд, холбогдох төрийн байгууллага хохирогчид нөхөн төлбөрийн хэмжээг тооцоход нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг хүлээдэг. Хөдөлмөрийн шүүхээр шийдвэрлэгдэх маргаан нь эрүүгийн хэргээс тусдаа шийдвэрлэгдэх боломжтой юм. Улсын байцаагч гомдол хүлээн

<sup>281</sup> Human Rights and Development Foundation, Compensation for Victims of Trafficking in Persons, 2019 [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf)

авснаар хохирогч, ажил олгогч, бусад этгээдтэй ярилцлага хийх зэргээр шалгах ажиллагааг эхлүүлдэг.

Улсын байцаагч үндэслэлтэй гэж үзвэл 30 хүртэлх хоногийн хугацаанд цалин хөлсийг олгох даалгаврыг ажил олгогчид өгнө. Гэвч хүн худалдаалах гэмт хэргийн үед гэмт хэрэг үйлдсэн этгээд ихэнх тохиолдолд хохирогчтой нүүр тулан уулзах, аливаа байдлаар нөлөөлөх зорилгоор улсын байцаагчийн шийдвэрт гомдол гаргаж, шүүхэд хандан эвлэрүүлэн зуучлах боломж эрэлхийлдэг талаар тэмдэглэжээ.<sup>282</sup>

## **2. Нөхөн төлбөрийн буюу хохирлын хэлбэр: эдийн ба эдийн бус хохирол (ёс суртахууны хохирол), нөхөн төлбөрийн хэмжээ, түүнийг тогтоох, үнэлэх нь**

Эдийн ба эдийн бус хохирлыг тооцож нэхэмжилж болно. Үүнд оршуулгын зардал, эмчилгээний зардал, олох ёстой байсан цалин хөлс, орлого, нэр хүндэд учирсан хохирол зэрэг хамаарна.<sup>283</sup> Гэмт хэрэгтнээс шаардах нөхөн төлбөрийн хэмжээнд хязгаарлалт байхгүй. Шүүх нотлох баримтыг үндэслэн нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг хэсэгчлэн эсхүл бүрэн хангах эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхтэй.

Хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хохирогч Хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу авах ёстой байсан цалин хөлсөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож нэхэмжилнэ.

Хохирлыг тооцох аргачлалын хувьд, эдийн хохиролд хохирогчоос гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй орох байсан орлогыг хохиролд тооцно. Иймд хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн тохиолдолд авах ёстой байсан цалин хөлс үүнд хамаарах бөгөөд өдрийн 300 Тайланд батаас илүүгүйгээр тооцож нэг жил хүртэлх хугацаанд ногдох цалин хөлсийг нэхэмжилж болно. Эдийн бус хохирлыг тооцох нарийвчилсан аргачлал байхгүй.

Дээр зааснаас гадна гэмт хэрэг үйлдэхдээ хохирогчийг эрүүдэн шүүсэн, хорьсон, хүнлэг бус хандаж гутаан доромжилсон бол punitive damage буюу шийтгэх нөхөн төлбөрийг хохирлоо нотлох шаардлагагүйгээр шаардах боломжтой. Хэмжээг хэрхэн тооцох талаар нарийн зохицуулалт байхгүй.<sup>284</sup>

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх улсын сан байх бөгөөд

<sup>282</sup> Human Rights and Development Foundation, Compensation for Victims of Trafficking in Persons, 2019 [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf), p. 25.

<sup>283</sup> Civil and Commercial Code of Thailand, <https://library.siam-legal.com/thai-law/civil-and-commercial-code-torts-section-438-448/>

<sup>284</sup> Procedures for Human trafficking cases act, <https://oia.coj.go.th/th/file/get/file/20190212acd9b5de108f0158aa87de8daf24f01b161433.PDF>



энэхүү гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг тус сангаас санхүүжүүлэхээс гадна хохирогчид санхүүгийн туслалцаа үзүүлдэг. Тус улсын сангаас 2017 онд 5.6 сая Тайланд бат, 2018 онд 6.4 сая Тайланд бат олгосон байна. 2022 онд тус сангаас 1657 хохирогчид, 142 мянга гаруй ам.доллартой тэнцэхүйц санхүүгийн туслалцаа үзүүлсэн байна. Сангаас олгох нөхөн олговрын төрөл, хэмжээг холбогдох хэсэгт нарийвчлан тусгав.

### **3. Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллээр хангагдах эрх буюу мэдээлэл өгөх талаар үүрэгжүүлсэн эрх зүйн зохицуулалт**

2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хууль<sup>285</sup>-ийн 34 дүгээр зүйлд зааснаар мөрдөн байцаагч, прокурор нь хохирогчид нөхөн төлбөр нэхэмжлэх боломжтой талаар мэдээлэл өгөх, хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх үүрэг хүлээнэ.

Цаашлаад Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдлын яамны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч туслалцаа үзүүлэх дүрэмд (Order on Assistance to Victims of Trafficking) -т зааснаар хамгаалах байрны ажилтан нь хохирогчийн эрх, тэр дундаа нөхөн төлбөр авах эрхийн талаар мэдээлэл өгөх үүрэг мөн хүлээдэг. Энэ нь мэдээлэл өгөх үүрэг хүлээсэн албан хаагчдын хүрээг тэлсэн шинжтэй байх бөгөөд Монгол Улсад энэ төрлийн нийгмийн халамж, үйлчилгээний албан хаагч, төрийн бус байгууллага мэдээлэл өгөх үүргийг хүлээж ажилласнаар хохирогчийн мэдээлэл авах эрх хангагдах чухал нөлөө үзүүлэхээр байна.

### **4. Гэмт хэрэгтнээр хохирол төлүүлэх зорилгоор эд хөрөнгийг нь хураах эрх зүйн зохицуулалт**

Эрүүгийн хуулийн 32, 33 дугаар зүйлд зааснаар шүүх хөрөнгө хураан авах албадлагын арга хэмжээг авах эрхтэй.<sup>286</sup>

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 14.9 дэх хэсэгт зааснаар хүн худалдаалах гэмт хэргээр дамжуулж мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй нөхцөлд Мөнгө угаахтай тэмцэх газар (AMLO) нь хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, сэжигтэн яллагдагчийн хөрөнгийг хураах бүрэн эрхтэй байхаар зохицуулжээ. Тухайлбал, 2021 онд Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх газраас хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой 12 хэргийн хүрээнд эд хөрөнгийг хураах арга хэмжээг авчээ.<sup>287</sup> Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хөрөнгийг хураах нь

<sup>285</sup> The Prevention and Suppression of Human Trafficking Act BE 2551 (2008).

<sup>286</sup> Seehanat Prayoonrat, An Overview of Asset Forfeiture System in Thailand, [https://www.unodc.org/roseap/uploads/archive/documents/2009/02/TOCAML0/Overview\\_of\\_Asset\\_Forfeiture\\_System\\_in\\_Thailand\\_3.pdf](https://www.unodc.org/roseap/uploads/archive/documents/2009/02/TOCAML0/Overview_of_Asset_Forfeiture_System_in_Thailand_3.pdf)

<sup>287</sup> Royal Thai Government's Country Report on Anti-Human Trafficking Efforts, 2021. <https://aseanactpartnershiphub.com/wp->

хоширогчийн нөхөн төлбөр авах эрхийн баталгааг хангахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

## **5. Төрөөс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох төрийн тусгай сан буюу захиргааны журмаар хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа**

Тус улсад хэд хэдэн төрлийн хохирогчид нөхөн олговор олгох тусгай сан бий. Үүнд:

### **1. 2008 оны хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хуульд заасан хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг сан (anti-tip fund)<sup>288</sup>**

Дурдсан хуулийн 42 дугаар зүйлийн дагуу үүсгэн байгуулагдсан Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг сангийн хөрөнгө нь Тайланд улс дахь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд зарцуулагдана. Тухайлбал, шүгэл үлээгч, мэдээлэгч зэрэгт олгох мөнгөн шагнал зэргийг тус сангаас олгодог.

Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг сангаас хохирогчийн эрхийг хамгаалах зорилгоор дараах төрлийн зардлыг тус сангаас төлнө. Үүнд: 289

1. Амьжиргааны зардал - Нэг хүнд нэг удаа 3000 Тайланд бат, нэг жилд нэг хүнд 3-аас илүүгүй олгож болно.
2. Эмнэлгийн зардал – Эмчилгээний бодит зардалд 30,000 Тайланд батаас ихгүй. Үүнд эмчилгээний үеийн унаа, хоол багтсан. Эм тарианд жилд 3-аас илүүгүй, нэг удаа 2,000 Тайланд батаас ихгүй. Эмнэлгийн зардал заасан хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд эмнэлгийн дүгнэлтийн дагуу шаардлагатай тохиолдолд нэмэлт олговор олгож болно
3. Бие физиологи болон сэтгэцийн эрүүл мэндийг нөхөн сэргээх эмчилгээний зардал - 20,000 Тайланд батаас ихгүй.
4. Олох ёстой байсан орлого – Өдрийн 300 Тайланд батаас илүүгүйгээр тооцож нэг жил хүртэлх хугацаанд ногдох.
5. Өргөн хэрэглээ - 3000 батаас хэтрэхгүй үнээр, жилд гурваас илүүгүй удаа.
6. Байрны зардал – Шаардлагатай хэмжээгээр.
7. Боловсрол, сургалтын төлбөр.

[content/uploads/2022/02/Thailands-Country-Report-on-Anti-Human-Trafficking-Efforts-2021.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2022/02/Thailands-Country-Report-on-Anti-Human-Trafficking-Efforts-2021.pdf)

<sup>288</sup> Human Rights and Development Foundation, Compensation for Victims of Trafficking in Persons, 2019 [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf).

<sup>289</sup> Human Rights and Development Foundation, Compensation for Victims of Trafficking in Persons, 2019 [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf).

8. Нөхөн олговор шаардах, шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, шүүх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зардал.
9. Эх оронд нь буцаах зардал
10. Хууль тогтоомжид олгохоор заасан бусад зардал.

**2. 2001 оны хохирогчид нөхөн олговор олгох, яллагдагчаар буцаан нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу нөхөн олговор олгох** (Compensation under the 2001 victim compensation and restitution for the accused person act)

Энэхүү санг гэмт хэргийн улмаас учирсан хохиролд нөхөн олговор олгох үндсэн сан гэж нэрлэж болно. 2022 онд тус сангаас 48,717 ам.долларын нөхөн төлбөр олгожээ.

Тус сангаас эмчилгээний зардал, олох ёстой байсан орлого болон нас барсны нөхөн олговор олгоно.

**Дээрх сангаас гадна Хууль ёсны сангийн тухай хуулийн дагуу олгох нөхөн олговор** (Compensation under the 2015 Justice Fund Act), **Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх сан** (The Anti-Money Laundering Fund established under the 1999 Anti-Money Laundering), **Гэрчийг хамгаалах тухай хуульд заасан дэмжлэг** (Support under the 2003 Witness Protection Act) зэргийг нэрлэж болно. Хэдийгээр дээр дурдсан төрийн сан, тусламжаас зохих нөхөн олговор, туслалцааг авах боломжтой боловч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид төдийлөн хүсэлт гаргадаггүй байна.

**6. Хохирогчид нөхөн төлбөр олгож буй шат дараалал, хариуцах байгууллага буюу институтийн тогтолцоо**

Хүн худалдаалах гэмт хэргийн ЭХХША-ны хувьд Хамтарсан баг (MDT) хохирогчоор тогтоож, прокурорын газарт очин гэрчийн урьдчилсан сонсголд (advanced witness-hearing) оролцож, прокуророос хохирогчид түүний эрхийг танилцуулж, хуульд заасан мэдээлэл өгнө. Үүний дараа, Нийгмийн хөгжил, халамжийн газар (Department of Social Development and Welfare) эсхүл Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдал хариуцсан орон нутгийн байгууллага (Provincial Office of Social Development and Human Security) хохирогч, прокурор, Хамтарсан багийг хамруулж уулзалт зохион байгуулж, нэхэмжлэлийн үнийн дүнг тогтооно. Уулзалтын товч, шийдвэрийг орон нутгийн Захирагчид мэдээлж, нэхэмжлэлтэй холбоотой нотлох баримт цуглуулах, гэрчийг дуудах, мэдүүлэг авах, шүүх хуралдаанд бэлдэх талаар хүсэлтийг прокурорт хүргүүлнэ. Прокурор өмнө дурдсан уулзалтаар тохирсон дүнгийн хэмжээнд нэхэмжлэгчийн төлөөлөн шүүх хуралдааны үеэр мэтгэлцэнэ.

мэдүүлэг авах, шүүх хуралдаанд бэлдэх талаар хүсэлтийг прокурорт хүргүүлнэ. Прокурор өмнө дурдсан уулзалтаар тохирсон дүнгийн хэмжээнд нэхэмжлэгчийн төлөөлөн шүүх хуралдааны үеэр мэтгэлцэнэ. Түүнээс хэтэрсэн хэмжээнд хохирогчийн өмгөөлөгч нотлох баримт цуглуулах, тайлбар өгөх, мэтгэлцэх зэрэг үүргийг гүйцэтгэнэ. Хамтарсан баг (MDT), (Department of Social Development and Welfare) эсхүл Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдал хариуцсан орон нутгийн байгууллага (Provincial Office of Social Development and Human Security), прокурор хохирогчийн нөхөн төлбөр авах эрхийг хангахад чухал үүрэг гүйцэтгэн оролцож байна.

Нидерландтай улстай харьцуулахад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын оролцоо муу бөгөөд шийдвэр гүйцэтгэлийн хувь хангалттай түвшинд биш байдаг байна.

Сангийн хувьд Эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх товчоо (BATWC) бичиг баримтыг хүлээн авч, Дэд зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүлнэ. Эрүүгийн хэргийг шүүхээс эцэслэн шийдвэрлэхээс өмнө хохирогчоор тогтоогдсон этгээд улсын сангаас санхүүгийн туслалцаа авах боломжтой.

Тогтолцооны хувьд авч үзвэл, 2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх зөвлөл (Anti-Human Trafficking Committee)<sup>290</sup> нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, шийдвэрийг батлах, мөн хуулийн 22 дугаар зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэргийн үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулах зөвлөл (Coordination and Supervision of Anti-Human Trafficking Operation Committee, abbreviated as “CSATO Committee”) нь хүн худалдаалах бодлого, шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах үндсэн чиг үүрэгтэй. Хамтарсан баг (MDT), (Department of Social Development and Welfare) эсхүл Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдал хариуцсан орон нутгийн байгууллага (Provincial Office of Social Development and Human Security), прокурор, цагдаагийн байгууллага, Мөнгө угаахтай тэмцэх газар, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллага, Хөдөлмөрийн улсын байцаагч, эрүү, иргэн, хөдөлмөрийн шүүх, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх сан, бусад

<sup>290</sup> 2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хуулийн 15 дугаар зүйл. Section 15. There shall be a Committee called an Anti-Human Trafficking Committee, abbreviated as “AHT Committee”, consisting of the Prime Minister as the Chairperson, the Deputy Prime Minister, who is the Chairperson of the CSATO Committee, as Vice Chairperson, the Minister of Defence, the Minister of Foreign Affairs, the Minister of Tourism and Sports, the Minister of Social Development and Human Security, the Minister of Interior, the Minister of Justice, the Minister of Labour, and four qualified persons appointed by the Prime Minister from experts who have had no less than seven years of outstanding and demonstrable professional experiences in the fields of prevention, suppression, rehabilitation and international cooperation on the issues of human trafficking, one from each field, provided that not less than one half shall be appointed from the private sector, as members, and the Permanent Secretary for Social Development and Human Security shall be the Secretary and the Director-General of the Department of Social Development and Welfare and the Director of the Office of Welfare Promotion, Protection and Empowerment of Vulnerable Groups shall be the Assistant Secretaries

улсын сан, Хууль зүйн туслалцаа үзүүлэх төв зэрэг байгууллагууд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчийг хамгаалахад тус тусын чиг үүргийг хэрэгжүүлэн оролцдог.

## **7. Нөхөн төлбөр авах эрх үүсэх шалгуур, бүрдүүлэх материал, зарцуулах хугацаа, олгох нөхөн төлбөрийн төрөл**

Сүүлийн жилүүдэд Тайланд улс хохирогчдод учирсан эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх боломжийг нэмэгдүүлэхийн тулд хууль, эрх зүйн орчныг сайжруулах хэд хэдэн чухал алхам хийсэн. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эсрэг өөрөө нэхэмжлэл гаргах эсхүл төрийн үйлчилгээгээр дамжуулан нэхэмжлэх гэсэн үндсэн хоёр арга замаар нөхөн төлбөр авах боломжтой.

Түүнчлэн улсын тусгай сангийн аль нэгт хүсэлт гаргах замаар улсаас нөхөн олговор авах боломж бий.

ЭХХША-ны хувьд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:<sup>291</sup>

1. Нөхөн төлбөр шаардах нэхэмжлэл, хүсэлт
2. Гэмт хэрэг үйлдсэн орчин, хүч хэрэглэсэн үйлдэл зэрэг гэмт хэргийн нөхцөл байдлыг илэрхийлэх зураг
3. Хохирогчийн аврах үеийн нөхцөл байдал
4. Эмнэлгийн магадалгаа эсхүл эрүүл мэндийн эсхүл сэтгэцэд учирсан гэмтлийн талаарх баримт
5. Эмчилгээний төлбөрийн баримт
6. Хамгаалах байранд шилжүүлэх үеийн гэмтлийн баримт
7. Хамгаалах байранд байх үеийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болон бусад албан тушаалтны үзүүлсэн зөвлөгөө, үйлчилгээний баримт.

Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг сангийн хувьд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд: <sup>292</sup>

1. Хүсэлт
2. Иргэний үнэмлэх, оршин суух бүртгэл
3. Бусад баримт (төлбөрийн баримт гэх мэт)

Бангкокт оршин суух хаягтай иргэд Эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх товчоо (BATWC)-д, өөр газар оршин суугаа иргэд тус нутаг дэвсгэрийн Нийгмийн хөгжил, хүний аюулгүй байдлын албанд (PSDHS) хүргүүлнэ.

<sup>291</sup> Bureau of Anti-Trafficking in Women and Children and Japan International Cooperation Agency, MDT Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking.

[https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt\\_guideline\\_practical\\_version.pdf](https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt_guideline_practical_version.pdf)

<sup>292</sup> Bureau of Anti-Trafficking in Women and Children and Japan International Cooperation Agency, MDT Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking.

[https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt\\_guideline\\_practical\\_version.pdf](https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt_guideline_practical_version.pdf)

Зарцуулах хугацааны хувьд, эрүү, иргэн, хөдөлмөрийн маргааны хувьд бие даасан процессын хуульд заасан хугацааг баримтална. ЭХХША-нд нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг прокурор гаргах талаар өмнө нь дурдсан бөгөөд прокурор яллах дүгнэлттэй хамт эсхүл шүүх хуралдааны явцад гаргах боломжтой.<sup>293</sup> Сангийн хувьд Эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх товчоо (BATWC) бичиг баримтыг хүлээн авч, Дэд зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрлэх хугацааг тодорхой заагаагүй.

Хөдөлмөрийн байцаагчид хандсан тохиолдолд гомдлыг 60 хоногийн дотор шалгаж шийдвэрлэнэ. Ийнхүү шийдвэр гаргаснаас 15 хоногийн дотор хариуцагч төлбөрийг төлөх үүрэгтэй.

## **8. Тохиолдол, шийдвэрлэсэн байдал**

Тайландад ажиллаж байсан Мьянмарын иргэдийн 7 настай хүүхдийг эцэг эхийнх нь өмнөх ажил олгогч хулгайлсан. Охин 2009-2013 оныг хүртэлх хугацаанд шүүгдэгчийн гэрт үнэ төлбөргүйгээр ажилласан бөгөөд шүүгдэгч охинд хүч хэрэглэж, түүний бие махбодод хохирол учруулж байсан. 2013 онд охиныг шүүгдэгчийн хохирогч авран охин эмнэлэгт эмчлүүлэн, охиныг хамгаалалтад авсан.

ЭХХША: Шүүгдэгчид эрүүгийн ял оноосон боловч ЭХХША-ны явцад хохирол төлүүлээгүй.

ИХХША: Охины ээж иргэний шүүхэд гэм хорын нэхэмжлэл гаргаж, шүүхээс охинд учирсан эдийн хохиролд буюу эмчилгээний зардалд нийт 4,603,233 бат гаргуулахаар шийдвэрлэсэн.

Улсын сан: 2001 оны Хохирогчид нөхөн олговор олгох, яллагдагчаар буцаан нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу улсаас 30000 ват нөхөн олговор олгосон.<sup>294</sup>

## **ДҮГНЭЛТ**

Тайланд улсын хувьд хэдийгээр хүн худалдаалах гэмт хэргийн гаралт өндөртэй боловч түүнтэй тэмцэх тогтолцоог харьцангуй сайн бүрдүүлжээ. Тухайлбал хохирогч эрүү, иргэн, хөдөлмөрийн шүүхээр дамжуулж хохирлоо нэхэмжлэх боломжтой бөгөөд хохирогчийн өмнөөс ЭХХША-ны явцад нэхэмжлэл гаргах үүргийг прокурорт хүлээлгэсэн онцлог талтай байна.

Хохирогчид нөхөн төлбөр амжилттай нэхэмжлэх гол үндэслэл нь

<sup>293</sup> Article 13, Procedures for Human Trafficking Cases Act, <https://oia.coj.go.th/th/file/get/file/20190212acd9b5de108f0158aa87de8daf24f01b161433.PDF>

<sup>294</sup> Human Rights and Development Foundation, Compensation for Victims of Trafficking in Persons, 2019 [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf).

нотолгоо гэж үзэж, хохирогчоор тогтоох, гэмт хэргийн ул мөрийг бэхжүүлэхэд тус улсын холбогдох яам, байгууллагаас анхаарлаа хандуулдаг.

Цаашлаад энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох улсын олон эх үүсвэр байх бөгөөд Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг сан гэх бие даасан сан байгаа нь дэвшилттэй байна.

Тус улсын хувьд хохирогч эдийн болон эдийн бус хохирлоо нэхэмжлэх боломжтой боловч эдийн бус хохирлыг гаргуулсан тохиолдолд цөөн байгааг анхаарах нь зүйтэй. Тайланд улсын шүүхээс мөн ялгаагүй эдийн ба эдийн бус хохирлыг гаргуулах боломжтой боловч эдийн бус хохирлыг гаргуулахаар шийдвэрлэсэн хэрэг тун ховор. Энэ нь энэ төрлийн хохирлыг хэрхэн үнэлэх аргачлал байхгүй байгаатай холбоотой байж болзошгүй байна.

Цаашлаад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх хүрээнд улсын болон орон нутгийн байгууллагуудын оролцоо, чиг үүрэг харьцангуй уялдаа сайтай байна.

Хэдийгээр эрүүгийн хэргийн шүүхээс эдийн бус хохиролд нөхөн төлбөр гаргуулахаар шийдвэрлэх нь олон боловч шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл төдийлөн хангалттай биш байна.

Улсын сангаас хэд хэдэн төрлийн зардлыг гаргах боломжтой бөгөөд тэдгээрийг тооцох аргачлал тодорхой боловч эдийн бус хохиролтой холбоотойгоор нөхөн олговор төдийлөн олгодоггүй.

## **Тайланд улсын сайн туршлагууд**

Тайланд улсын бусад улсаас онцлогтой бөгөөд эрх зүйн сайн туршлагыг дурдвал:

1. Тайландын хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хууль тогтоомж нь 2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хууль болон 2016 оны Хүн худалдаалах гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэх ажиллагаанд баримтлах бие даасан хуультай байгаа нь онцлог байна.
2. Гэмт хэрэгтэн гэмт хэрэг үйлдэхдээ хохирогчийг эрүүдэн шүүсэн, хорьсон, эрүүл мэндэд нь хохирол учруулсан, хүнлэг бус хандсан тохиолдолд punitive damage<sup>295</sup> буюу шийтгэх нөхөн төлбөр шаардаж болно.

<sup>295</sup> Section 14 of the TIP Criminal Procedure Act

3. Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар ийнхүү хохирогчид нөхөн төлбөр олгохоор шийдвэр гарсан тохиолдолд шийдвэрийн биелэлтийг хангуулахад туслах зорилгоор Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдлын яамнаас шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн явцад хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлдэг нь хохирогч бодитоор нөхөн төлбөрөө авахад чухал ач холбогдолтой байна.
4. Шүүх, цагдаагийн байгууллага, прокурорын албан хаагчдаас гадна Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдлын яамны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч туслалцаа үзүүлэх дүрэмд (Order on Assistance to Victims of Trafficking) -т зааснаар хамгаалах байрны ажилтан нь хохирогчийн эрх, тэр дундаа нөхөн төлбөр авах эрхийн талаар мэдээлэл өгөх үүрэг мөн хүлээдэг.
5. Мөнгө угаахтай тэмцэх газар (AMLO) нь хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, сэжигтэн яллагдагчийн хөрөнгийг хураах бүрэн эрхтэй байхаар зохицуулсан нь шүүхийн шийдвэр гараагүй байх үед гэмт хэрэг үйлдсэн хөрөнгийг хураах, царцаах ажиллагааг шуурхай хэрэгжүүлэх үндэс болж байна.
6. Тус улсад хэд хэдэн төрлийн хохирогчид нөхөн олговор олгох тусгай сан бий. Тухайлбал Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг сангаас санхүүгийн туслалцаа авах боломжтойгоос гадна 2001 оны Хохирогчид нөхөн олговор олгох, яллагдагчаар буцаан нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу нөхөн олговор улсаас авах боломжтой байна.
7. Прокурор иргэний нэхэмжлэлийг хохирогчийн өмнөөс гаргах үүрэгтэй бөгөөд Хамтарсан баг ('MDT') хохирогч, прокурор зэрэг хэргийн оролцогчдын хамруулж уулзалт зохион байгуулж, прокурорын нэхэмжлэх үнийн дүнг хэлэлцэн тогтоодог.



Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд хохирогч нь эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэхийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй гэж хохирол шаардах эрх зүйн үндэслэлийг тусгайлан заажээ. Одоогоор хүчин төгөлдөр үйлчилж байгаа 10 гаруй хууль тогтоомжид хохирогчид учирсан хохирол, хор уршиг, хохирогчийн эрх зүйн байдал, хохирлыг тогтоох, үнэлэх, нотлох, хохирол нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу “гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах эрхтэй” гэж, мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “шүүхэд мэдүүлэх эрхтэй” гэж, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй” гэж, 511.3 дахь хэсэгт “...сэтгэцэд учруулсан гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгах үүргийг гэм хор учруулсан этгээд хүлээнэ.” гэж зааснаас гадна 2022 оны Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох, хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн үндэслэлийг бүрдүүлсэн. Гэвч иргэний шүүхийн журмаар нөхөн төлбөр нэхэмжлэхэд эрүүгийн хэрэг эцэслэсэн шийдвэрлэгдсэн байх шаардлага тавигдаж байх ба эрүүгийн шүүхээс цагаатгах тогтоол гаргасан бол эдийн хохирлыг иргэний шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой ч сэтгэцэд учирсан хохирлыг барагдуулах боломжгүй байгаа юм.

Цаашлаад Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “Гэмт хэргийн хохирогчид Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн төлбөр олгоно” гэж, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, энэ хуулийн 10.3-т заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгох

зориулалттай байна” гэж хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид улсаас нөхөн олговор олгох эрх зүйн үндэслэлийг бүрдүүлсэн байна. Гэсэн хэдий ч тус сангаас 1/хохирогч нас барсан эсхүл хүнд гэмтэл авсан тохиолдолд 2/гагцхүү эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого зэрэг 3 төрлийн нөхөн төлбөрийг 3/ зөвхөн эрүүгийн шүүх шийдвэр хүчин төгөлдөр болсон бөгөөд шүүхийн шийдвэрт нөхөн төлбөрийн төрөл, хэмжээг заасан гэх шаардлагууд хангагдсан тохиолдолд л нөхөн төлбөр авч болно. Олон улсын болон гадаад улсын туршлагыг харгалзан үзвэл, гэмтлийн зэргээс үл шалтгаалан, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч улсын сангаас олон төрлийн нөхөн төлбөр авах боломжтой байна. Тухайлбал, Франц, Нидерланд, АНУ, Тайвань зэрэг улсад шүүхийн шийдвэр гарахаас өмнө хохирогч улсын сангаас нөхөн олговор авах боломжтой байхаар хуульчилжээ.

*Харьцуулсан судалгааны хүрээнд дүгнэвэл,*

Нэмэлт протоколын 6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Оролцогч улс бүр дотоодын хууль зүйн тогтолцооны хүрээнд хүн худалдаалах хэргийн хохирогчдод учирсан хохиролдоо нөхөн төлбөр авах боломж олгож байх арга хэмжээг харгалзсан нөхцөлийг хангана” гэж, үндэсний хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр авах механизмыг бүрдүүлэхийг гишүүн улс бүрээс шаарддаг. Уг шаардлагыг улс бүр харилцан адилгүй нутагшуулан хэрэгжүүлж байна. Тодруулбал, тус судалгааны хүрээнд АНУ, Франц, Нидерланд, ХБНГУ, Япон, Тайвань, Молдав, Румын, Тайланд зэрэг 9 орны сайн туршлагыг сонгож судлахад дараах үр дүн гарлаа. Үүнд:

**НЭГ.** Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх харилцааг ихэнх улсад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, иргэний хэргийн хэрэг шүүхэд шийдвэрлэх хууль, хүн худалдаалахтай тэмцэх бие даасан хуулиар зохицуулж буй нийтлэг чиг хандлага тогтжээ. Харин АНУ нь Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хуулиас гадна Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах бие даасан хуультай. Гэвч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох харилцааг тусгайлан зохицуулсан хуультай улс эдгээр улсад байхгүй байна. Тайваньд 2023 оны 12 сард Дотоод хэргийн яамнаас “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх нөхөн төлбөр олгох журам”-ыг тусгайлан баталсан нь нарийвчилсан зохицуулалттай гэдгээрээ өвөрмөц онцлогтой байна.

**ХОЁР.** Дийлэнх улсад ЭХХША-ны явцад хүн худалдаалах гэмт

хэргийн хохирогч хохирлоо нөхөн төлүүлэхээр иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй байдгаас гадна иргэний шүүхэд хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах боломжтой. Гэсэн хэдий ч иргэний шүүхэд нэхэмжлэл гаргах нь зардал, чирэгдэл ихтэйгээс гадна шийдвэр гүйцэтгэх ажиллагаа харьцангуй урт хугацаанд үргэлжилдэг зэргээс үүдэн ЭХХША-ны явцад иргэний нэхэмжлэлийг хамтад нь шийдвэрлэх нь практикт нийтлэг байна.

**ГУРАВ.** Дээрх 9 улсад хохирогчид учирсан хохирлыг эдийн болон эдийн бус гэж ангилж байх боловч нөхөн олговрын төрөл, хэмжээ, түүнийг тогтоох, үнэлэх практик улс бүрд харилцан адилгүй байна.

Тухайлбал, АНУ-д сэтгэл санааны хохиролд олгох нөхөн олговрын хэмжээг тогтооход шүүхийн прецедент чухал үүрэг гүйцэтгэж байх боловч тухайлсан хууль тогтоомж байхгүй. Нидерланд улсад, Гаагийн шүүхээс хохирогчийн биеийг албадан үнэлүүлсэн тохиолдолд өдөрт 200 евро төлөхөөр тооцох буй жишиг тогтоосон нь бэлгийн мөлжлөгт өртсөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрхийг хангасан чухал ач холбогдолтой зохицуулалт болжээ. Түүнчлэн, тус улсын Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн сан (Criminal Injuries Compensation Fund)-аас нөхөн олговор олгох аргачлалыг авч үзвэл, хүн худалдаалах гэмт хэргийг үйлдсэн аргаас хамаарч сэтгэгцэд учирсан хохирлыг харилцан адилгүй тогтоосон байна. Тухайлбал, бэлгийн мөлжлөгийн зорилгоор 1-ээс дээш жилийн хугацаанд үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид учирсан сэтгэгцэд учирсан гэмтэл нь 5 дугаар түвшинд хамаарах бөгөөд хохирогч бие махбодын болон сэтгэгцэд учирсан хохирлоо нотлох тохиолдолд 20,000 хүртэлх еврог улсаас авах боломжтой бол хүч хэрэглэж эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хувьд дээрх хэмжээ 5000 евро хүртэл байна. Тайваньд Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх нөхөн төлбөр олгох журмын дагуу хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирогч бие махбод, сэтгэл зүйн гэмтэл авсан тохиолдолд нэг хүнд ногдох 3000 NT\$ нөхөн олговор олгодог. Харин Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 57 дугаар зүйлд Бэлгийн хүчирхийллийн нөхөн төлбөрт 100,000 NT\$-аас 400,000 NT\$ олгодог байна.

Эндээс үзвэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах механизм сайтай гэж тооцогдож байгаа улсуудад хохирлыг үнэлэх аргачлал, нөхөн төлбөрийн төрөл, хэмжээ тодорхой байна. Өөрөөр хэлбэл, хохирол нөхөн төлүүлэх эрхийг бодитой хэрэгжүүлэхийн тулд нөхөн төлбөрийн төрөл, хэмжээг тогтоох, хохирлыг үнэлэх аргачлалыг оновчтой тодорхойлох нь зүйтэй юм.

**ДӨРӨВ.** Насанд хүрээгүй хохирогчид нөхөн олговор олгох

тусгайлсан эрх зүйн зохицуулалт ихэнх улсад байхгүй байна. Харин Тайваний Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуульд асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй насанд хүрээгүй этгээд гэмт хэргийн хохирогч болсон эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь гэмт хэрэгтэн байх тохиолдолд тусгай чиг үүрэг бүхий байгууллага эсхүл төрөөс хүүхдийг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжтой байхаас гадна асран хамгаалагч эсхүл харгалзан дэмжигчгүй хүүхдэд олгох нөхөн төлбөрийг хохирогч хүүхдийг насанд хүрэх хүртэлх хугацаанд тусгайлан итгэмжлэн хадгалж, хуваарьтайгаар эсхүл хэсэгчлэн олгох чиг үүргийн тусгай байгууллагад хүлээлгэж болохоор зохицуулжээ. Түүнчлэн насанд хүрээгүй хохирогчийг насанд хүрснээс хойш 3 жилийн дотор хохирлоо нэхэмжлэх эрхтэй байхаар Румын улсын хуульд заасан онцлогтой байна.

**ТАВ.** Хохирогчид нөхөн олговор авах эрхийн талаар мэдээлэл өгөх тухай үүрэгжүүлсэн заалтыг ихэнх улсад хуульчилжээ. Тухайлбал, Францын ЭХХШТХ-ийн 53.1 болон 75 дугаар зүйлд цагдаагийн мөрдөгч, шүүхийн цагдаа нь хохирогчид гэмт хэргийн улмаас учирсан хохирол, гэмтлийн талаар нөхөн төлбөр нэхэмжлэх эрхтэйг нь мэдээлэх талаар заасан байдаг. Гэтэл Румын улсад Хохирогчийн эрхийг хамгаалах тухай 211/2004 хуульд гэмт хэргийн хохирогчид хохирол нөхөн төлүүлэх эрхийн талаар мэдээлэл өгөхийг хууль сахиулагчид үүрэгжүүлсэн хэдий ч практикт ТББ гүйцэтгэх нь түгээмэл байна. Тайланд улсын хувьд, мөрдөгч, цагдаагийн албан хаагч, прокурор, хамтарсан багийн албан хаагчдаас гадна гэрч, хохирогчийг хамгаалах байрны ажилтанд дээрх үүргийг хүлээлгэдэг. Харин Нидерланд улсын ЭХХШТХ-ийн 51а дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу цагдаа, мөрдөгч, хэрэг бүртгэгч, прокурор зэрэг албан хаагч нь хохирогчийн хүсэлтээр нөхөн төлбөрийн нэхэмжлэл хэрхэн гаргах талаар мэдээлэл өгөх үүрэг хүлээдэг. Эндээс үзвэл, гэмт этгээдийн эсрэг нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах, цаашлаад улсаас үзүүлэх тусламж, үйлчилгээний талаар хохирогчдод заавал мэдээлж байхыг үүрэгжүүлэх нь хохирлоо нөхөн төлүүлэхэд ач холбогдолтой байна.

**ЗУРГАА.** Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хохирлоо төлүүлэх үндсэн нөхцөлийн нэг нь гэмт этгээдийн эд хөрөнгийг цаг алдалгүй хураах явдал гэж үзэж байна. Улс орнуудын туршлагыг судлахад гэмт этгээдийн эд хөрөнгийг 2 зорилгоор хураан авч байгаа нь ажиглагдлаа. Нэгдүгээрт, мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг цааш шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт этгээдийн эд хөрөнгийг хурааж, царцаадаг бол хоёрдугаарт, гэм бурууг тогтоосны дараа нэмэгдэл ял болгон хэрэглэх ба энэ нь хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх бус гагцхүү гэмт хэрэгтнийг шийтгэхэд чиглэж байна. Жишээлбэл, Нидерланд улсын хувьд цаг алдалгүй гэмт хэрэгтний эд хөрөнгийг

хураах үүднээс хүн худалдаалах хэрэгтэй холбоотой гомдол, мэдээлэл ирмэгц санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг заавал эхлүүлж, гэмт хэрэг үйлдэж олсон орлого, ашгийг цааш шилжүүлэхээс сэргийлж мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэрэгтний эд хөрөнгийг хураах практик цөөнгүй байна.

Түүнчлэн аливаа улсын хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох ажиллагаанд, ялангуяа хилийн чанад руу шилжүүлсэн гэмт этгээдийн эд хөрөнгийг хураахад хууль сахиулах байгууллагуудын олон улсын хамтын ажиллагаа чухал үүрэгтэйг олон улсын холбогдох конвенцод онцолжээ.

**ДОЛОО.** Дээрх судалсан 9 улс гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох төрийн тусгай сантай байна. Харин Тайланд улсын хувьд, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох, гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн хүн, хуулийн этгээдэд урамшуулал олгох улсын тусгай сантай байгаа нь онцлог байна.

АНУ-ын хувьд муж улс бүр гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх улсын сантай. Муж улс бүрийн сангийн үйл ажиллагаа нийтэд ил тод байх бөгөөд сангаас олгох санхүүгийн тусламж, нөхөн олговрын төрөл, дээд хэмжээ, хүсэлт гаргах болон хүсэлтийг шийдвэрлэх хугацаа, бүрдүүлэх материал маш тодорхой тусгагдсан. Жишээлбэл, Техас мужийн энэ төрлийн сангаас нөхөн олговор олгохдоо, сэтгэл зүйн зөвлөгөөний зардлыг 60 удаагийн уулзалт хүртэлх төлбөрөөр, олох ёстой байсан цалин хөлсийг долоо хоногт 700 ам.доллороор тооцдог зэргийг нэрлэж болно.

Монгол Улс ч мөн адил Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох эрх зүйн зохицуулалттай. Хэдийгээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох тусгай сантай байх нь чухал боловч сангаас нөхөн олговор олгох үе шат, шаардагдах материалыг тодорхой журамлаж хэрэгжүүлэх нь чухал байна. Иймд Монгол Улсын хувьд Засгийн газрын тусгай сангийн хуулиар бий болгосон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох одоогийн механизмыг идэвхжүүлэх, өмнөх хэсэгт дурдсанаар нөхөн олговор олгох нөхцөлийг өөрчлөх (зөвхөн хохирогч нас барсан эсхүл хүнд гэмтэл учирсан тохиолдолд олгож байна), нөхөн олговрын төрлийг нэмэгдүүлэх, түүний хэмжээг тогтоох, хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх үе шат, дарааллыг тодорхой болгох, түүнчлэн ЭХХША-ын аль ч шатанд төрөөс нөхөн олговор авах боломжийг бүрдүүлэх зэрэг олон асуудал тулгамдаж байна.

**НАЙМ.** Хохирогч хохирлоо нөхөн төлүүлэхэд төрийн байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүрэг нэн чухал байна. Ихэнх улсад хохирогч өөрөө хохирлоо нөхөн төлүүлэх хүсэлт, нэхэмжлэл гаргах эрх зүйн

зохицуулалттай бол Тайланд, Тайвань, Нидерланд зэрэг улсад хохирогчийн өмнөөс прокурор гэмт этгээдээс хохирол нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргаж болдог. Тухайлбал, Тайланд улсад прокурор болон шүүх нь хохирогч нэхэмжлэл гаргаагүй байсан ч хохирогчид учирсан хохирлыг шийдвэрлэх үүрэг хүлээдэг.

Цаашлаад, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллага нь хохирогчийн нөхөн төлбөр авах эрхийг баталгаажуулахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Жишээлбэл, Нидерланд улсад нөхөн олговор төлүүлэх шүүхийн шийдвэр гарсан бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар (CJIB) тодорхой хуваарийн дагуу нөхөн олговрыг төлүүлэх, төлбөрийг хохирогчид шилжүүлэх ажлыг хариуцна. Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 8 сарын дотор төлбөр бүрэн төлөгдөж дуусаагүй тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар (CJIB)-аас үлдэгдэл төлбөрийг хохирогчид урьдчилан шилжүүлж, гэмт этгээдээс шилжүүлсэн төлбөрийг шаардах эрхийг эдлэх “advance payment system” буюу урьдчилан төлбөр төлөх тогтолцоог нэвтрүүлсэн нь хохирогчийн эрхийг хамгаалах дэвшилтэт алхам болжээ.

**ЕС.** ЭХХША-нд цагдаа, прокурор, шүүгчээс гадна ТББ, өмгөөлөгч хохирогчийн эрхийг хамгаалахад чухал үүрэгтэй. Тухайлбал, ХБНГУ-д Weisser Ring ашгийн бус байгууллага нь гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор авах өргөдөл гаргахад нь туслах бөгөөд бусад хэлбэрийн санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Манай улсад ч мөн ТББ энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах нь нийтлэг байдаг ч цаашид энэ чиглэлээр үйл ажиллагааг ТББ-г дэмжих, хамтран ажиллах нь чухал байна.

Түүнчлэн ихэнх улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээг хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагаас үзүүлэх нийтлэг чиг хандлага байна.

**АРАВ.** Нөхөн олговор авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичиг, шийдвэрлэх хугацааг тодорхой тусгаж, нийтэд ил тод мэдээлэх нь төрийн сангаас нөхөн олговор механизм амжилттай хэрэгжихэд чухал нөлөө үзүүлж байна. Өмнө дурдсанаар АНУ-ын муж улсууд, Нидерланд зэрэг улсад төрийн сангаас шаардах баримт бичиг, хүсэлтийг шийдвэрлэх хугацааг нарийн тодорхойлжээ. Жишээлбэл, Нидерланд улсад хохирогч төрийн сангаас нөхөн олговор авах хүсэлт гаргахдаа тус улсын Хохирогчид туслах төвөөс бүрдүүлэх баримт бичгийн хүрээнд үнэ төлбөргүй зөвлөгөө, туслалцаа авах боломжтой. Цаашлаад, хохирогчоос гаргасан дээрх хүсэлтийг хамгийн ихдээ 180 хоногийн дотор шийдвэрлэнэ. Ийнхүү төрийн сангаас хүсэлтийг шийдвэрлэх хугацааг тодорхойлох нь ЭХХША хэт удаан үргэлжилсний улмаас хохирогч нөхөн төлбөрөө авч чадахгүй байхаас сэргийлэхээс гадна хохирогч нөхөн

олговрын тусламжтайгаар амьдралаа дахин шинээр эхлүүлэх зорилгод нийцдэг.

АНУ, Нидерланд улсад тусгай санд гаргасан хохирогчийн хүсэлтийг хангаагүй тохиолдолд уг шийдвэрт гомдол гаргаж болохоор зохицуулжээ. Тайваньд Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх нөхөн төлбөр олгох журмын 12 дугаар зүйлд Дотоод хэргийн яам өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дотор нөхөн төлбөр олгох тухай шийдвэрийн талаар өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэнэ гэж заасан. Харин нэхэмжлэлийг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш хоёр жилийн дотор гаргах ёстой байдаг байдаг.

- Санал 1.** ЭХХШТХ-ийн дагуу хохирогч иргэний нэхэмжлэл гаргахад хохирогч, хохирогчийн өмгөөлөгчөөс гадна прокурорын нотлох баримт бүрдүүлэх чиг үүргийг хуульчлах;
- Санал 2.** ЭХХШТХ-ийн дагуу хохирогч нөхөн олговор авах эрхийн талаар цагдаа, прокурор, шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат болгонд мэдээлэл хүргэх үүргийг хуульчлах;
- Санал 3.** Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэхэд гэмт хэрэгтний хөрөнгийг мөшгөх, царцаах, хураан авах талаар ЭХХШТХ-аар цагдаа, прокурорт үүрэг болгосон заалтыг хуульчлах;
- Санал 4.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн талаар хуульчлахдаа санг бүрдүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө, хандив тусламж, шүүхээс оногдуулсан торгох ялын 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө, гэм буруутай этгээдээс хохирол барагдуулсан төлбөр байна гэжээ. Олон улсын жишгээр тус эх үүсвэрт гэм буруутай этгээдээс гаргуулсан эд хөрөнгө хураах ялын хөрөнгийг оруулдаг байна. Иймд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10.2.3-т эд хөрөнгө хураах ялын хөрөнгийг нэмж оруулах;
- Санал 5.** Тус хуулийн 10.3 дугаар зүйлд хохирогчид нөхөн төлбөр олгох төрлийг эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс түүнтэй адилтгах орлого гэж хязгаарласан учир дутагдалтай байна. Олон улсын эх сурвалж, гадаадын туршлагыг харгалзан, хуурч мэхлэн, хууль бусаар суутгаж байсан төлбөр буюу байрны түрээс, тээвэр, амьжиргааны зардал, татвар зэргээр гэмт этгээдээс “зохиомол өр” үүсгэж байсан суутгалыг нөхөн олгохорт хамааруулах нь зүйтэй. Үүнийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10.3.4. Бусад зардал гэж нээлттэйгээр нэмэх;
- Санал 6.** Хохирогчийг бусдын зүгээс буруутгаж харьцах нь хохирол



нөхөн төлүүлэхэд саад учруулж байна. Иймд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой харьцахдаа хохирогч төвтэй хандлагад суурилах, хохирогчийг өөрөө буруутай тул гэмт хэргийн хохирогч болсон гэж үзэх байдлыг өөрчлөх нь зүйтэй. Иймд ЭХХША-ны явцад мөрдөгч, прокурор, шүүгч хохирогчийг буруутгасан хандлага гаргахгүй байх, хохирогчийн эрхийг хамгаалах, хохирогч төвтэй хандлагыг төлөвшүүлэх талаар сургалтыг явуулах;

**Санал 7.** Олон улсад хохирогчийн нөхөн олговор авах талаар тулгамдаж буй асуудлыг эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт, хууль сахиулах байгууллага, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын үүрэг, төрийн механизмтай холбоотой гэж үзэхийн зэрэгцээ хохирогчийн зарим үйл ажиллагаа нь хохирлоо нөхөн төлүүлэхэд саад болж байгаа талаар дурдсан байна. Тухайлбал, хохирогч өөрийгөө хохирогч гэж үзэхгүй байх, гэмт этгээдийг өмөөрөх (энэнээс муугаар хандаж болох байсан гэх Стокхолмын синдром), эсвэл муу дурсамжаа сэдрээхээс айх зэрэг сэтгэл зүйн сааталд өртсөн байдаг. Иймд хохирогчид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх явцад хохирлоо төлүүлэх талаар зөвлөмжлөх нь зүйтэй байна.

**Санал 8.** Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15.1-т хохирогчийн нэхэмжилж болох нөхөн төлбөрийн хэлбэрийг эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлоор хязгаарласан нь учир дутагдалтай байна. Олон улсын болон гадаадын туршлагаас үзэхэд бие махбодод учирсан хохирол, эд хөрөнгө, олох байсан орлого, эмчилгээний эмнэлгийн зардал, ёс суртахууны хохирол зэрэг өргөн хүрээнд хуульчилжээ. Иймд тус заалтад бусад хохирлын төрлийг тодорхой тусгахаар нэмэлт өөрчлөлт оруулах;

**Санал 9.** Тусгай сангийн хуулиар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хохирол нөхөн төлүүлэх нь эрх зүйн зохицуулалтын хувьд бүрхэгдүүлж байгаа тул Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар нарийвчлан хуульчлах шаардлагатай байна. Түүнчлэн тус хуулийн 15 дугаар зүйлд 15.4 дэх хэсэгт хохирогч хохирлоо нөхөн төлүүлэх талаар тусгайлсан журам батлах тухай заалт нэмэх нь зүйтэй.

## ЭХ СУРВАЛЖ

---

### *Монгол хэл дээрх эх сурвалж:*

#### **Хууль тогтоомж**

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012.
3. ЭХХШтХ, 2017.
4. Эрүүгийн хууль, 2015
5. Иргэний хууль, 2002.
6. ИХХШтХ, 2002.
7. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2020.
8. Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, 2013.
9. “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам”, 2020.

#### **Ном, сурах бичиг, судалгааны тайлан**

1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (Албан хаагчдыг чадавхжуулах сургалтын гарын авлага), 2022.
2. Хохирлын үндэсний тогтолцоо гэмт хэргийн хохирол барагдуулах тогтолцооны харьцуулсан судалгаа, УБ, 2021, 29 дэх тал.
3. Өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага (Хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг), УБ., 2019.

### *Гадаадын хэл дээрх сурвалж:*

#### **Хууль тогтоомж**

1. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, 2000 он, <https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html>
2. Хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба шийтгэх тухай протокол, 2000. <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/protocol-prevent-suppress-and-punish-trafficking-persons>
3. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцыг хэрэгжүүлэх хууль зүйн зааварчилгаа, 2020.
4. [https://www.unodc.org/documents/treaties/Review\\_Mechanism/Review\\_Mechanism\\_2020/Website/Legislative\\_Guide\\_on\\_TiP/TiP\\_LegislativeGuide\\_Final.pdf](https://www.unodc.org/documents/treaties/Review_Mechanism/Review_Mechanism_2020/Website/Legislative_Guide_on_TiP/TiP_LegislativeGuide_Final.pdf)
5. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх аргачлал, 2006 он, <https://www.unodc.org/documents/human-trafficking/HT-toolkit-en.pdf>
6. Хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох тухай Европын конвенц (Европ 1983 оны 116 дугаар гэрээний цуврал), 1983 он, <https://rm.coe.int/1680079751>

7. Хүн худалдаалах ажиллагааны эсрэг Европын Холбооны конвенц, 2005 <https://rm.coe.int/168008371d>
8. Хүн худалдаалахтай тэмцэх тухай аргачлал, 2006, USA, Human Trafficking Laws & Regulations, <https://www.dhs.gov/human-trafficking-laws-regulations>.
9. USA, Trafficking Victims Protection Reauthorization Act, 2003, <https://www.congress.gov/bill/108th-congress/house-bill/2620>.
10. Human Trafficking State Laws, <https://www.ncsl.org/civil-and-criminal-justice/human-trafficking-state-laws>
11. USA, Wages and the Fair Labor Standards Act.
12. 22 U.S. Code § 7105 - Protection and assistance for victims of trafficking <https://www.law.cornell.edu/uscode/text/22/7105>
13. 18 U.S. Code § 983 - General rules for civil forfeiture proceedings, <https://www.law.cornell.edu/uscode/text/18/983>
14. 18 U.S. Code —Crimes and criminal procedure, [https://www.law.cornell.edu/rules/frcrmp/rule\\_32.2](https://www.law.cornell.edu/rules/frcrmp/rule_32.2)
15. 18 U.S. Code § 3525 - Victims Compensation Fund, <https://www.law.cornell.edu/uscode/text/18/3525>
16. Франц улсын Эрүүгийн хууль, 225-4-1 дугаар зүйл. [https://legislationline.org/sites/default/files/documents/df/France\\_Criminal%20Code%20updated%20on%2012-10-2005.pdf](https://legislationline.org/sites/default/files/documents/df/France_Criminal%20Code%20updated%20on%2012-10-2005.pdf)
17. Directive 2011/36/EU OF the European Parliament and of the Council of 5 April 2011 on preventing and combating trafficking in human beings and protecting its victims, and replacing Council Framework Decision 2002/629/JHA., <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:32011L0036>
18. Translation of Article 237f of Dutch Penal Code, <https://eucpn.org/sites/default/files/document/files/NL.pdf>.
19. Aanwijzing slachtofferrechten, <https://wetten.overheid.nl/BWBR0045831/2021-12-01>
20. Dutch Criminal Procedure Law, [https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/nld/1921/criminal\\_procedure\\_code\\_of\\_the\\_netherlands\\_html/Code\\_of\\_Criminal\\_Procedure\\_incorporating\\_amendments\\_up\\_to\\_October\\_2012.pdf](https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/nld/1921/criminal_procedure_code_of_the_netherlands_html/Code_of_Criminal_Procedure_incorporating_amendments_up_to_October_2012.pdf)
21. Criminal Code of Netherland, <https://antislaverylaw.ac.uk/wp-content/uploads/2019/08/Netherlands-Criminal-Code.pdf>
22. Civil Code of Dutch, <http://www.dutchcivillaw.com/legislation/dcctitle6611bb.htm>
23. Criminal code of Germany, [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_stgb/englisch\\_stgb.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html)
24. Crime Victims Compensation Act of Germany- OEG, [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_oeg/englisch\\_oeg.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_oeg/englisch_oeg.html)
25. Act on the Support of Crime Victims by Payment of Crime Victims, etc. [https://elaws.e-gov.go.jp/document?lawid=355AC0000000036\\_20210901\\_503AC0000000036&fbclid=IwAR3ffG8eF-TzXdQyY9iqVnalT9rlvYiYUL4WGynnCBsilOCb\\_9vtX-hlko](https://elaws.e-gov.go.jp/document?lawid=355AC0000000036_20210901_503AC0000000036&fbclid=IwAR3ffG8eF-TzXdQyY9iqVnalT9rlvYiYUL4WGynnCBsilOCb_9vtX-hlko)

26. Benefit payment systems for crime victims, White paper on crime 2001 Part 2/Chap.6/Sec.3/2..  
[https://hakusyo1.moj.go.jp/en/46/nfm/n\\_46\\_2\\_2\\_6\\_3\\_2.html](https://hakusyo1.moj.go.jp/en/46/nfm/n_46_2_2_6_3_2.html)
27. Civil Code of Japan,  
<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3494/en>
28. Penal Code of Japan,  
[https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3581/en#je\\_pt2ch35](https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3581/en#je_pt2ch35)
29. Civil Code of Japan,  
<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3494/en>.
30. Public Prosecutors Office, For victims of crime,  
<https://www.moj.go.jp/content/001348855.pdf>.
31. Human trafficking Prevention act of Taiwan,  
<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080177>
32. Taiwanese Regulations governing the Transfer of Seized Proceeds of Human Trafficking Crime and Compensation of Victims,  
<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080183>.
33. Taiwanese Regulation governing Subsidy for Victims of Human Trafficking  
<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080183>.
34. Taiwanese Regulations governing the Transfer of Seized Proceeds of Human Trafficking Crime and Compensation of Victims,  
<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080183>.
35. Taiwanese Regulation governing Subsidy for Victims of Human trafficking.  
<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080183>
36. Taiwanese Crime Victims Rights Protection Act.  
<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=I0050005>
37. Taiwanese Code of Criminal Procedure,  
<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0010001>.
38. Молдовын Эрүүгийн байцаан шийтгэх хууль,
39. Молдовын Хөдөлмөрийн хууль, .
40. Молдовын Хүн худалдахаас урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх тухай хууль, 4 е дүгээр зүйл.
41. 682/2002 тоот Гэрчийг хамгаалах тухай хууль.
42. 679/2001 тоот хуулийн 19(1), (2) дугаар зүйл.
43. Thailand, The Prevention and Suppression of Human Trafficking Act BE 2551 (2008).
44. The Human Trafficking Criminal Procedure Act BE 2559 (2016).
45. Civil and Commercial Code of Thailand, <https://library.siam-legal.com/thai-law/civil-and-commercial-code-torts-section-438-448/>

### ***Ном, сурах бичиг, судалгааны тайлан***

1. OSCE, National Referral Mechanisms: Joining Efforts to Protect the Rights of Trafficked Persons.
2. Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power | OHCHR.
3. Lee Ann Dunbar, Getting Restitution into the Hands of Trafficking Victims, 2024.

4. Damages in Florida Human Trafficking Lawsuits February 3, 2021 | Attorney, Matthew Dolman, <https://www.dolmanlaw.com/blog/human-trafficking-lawsuit-damages/>
5. Best v. Taylor Mach. Works, 689 NE 2d 1057 - Ill: Supreme Court 1997.
6. The Ryan Law Group, How To Calculate Pain And Suffering In California, <https://theyanlawgroup.com/how-to-calculate-pain-and-suffering-in-california/>
7. Perenich, Caulfield, Avril & Noyes Personal Injury Lawyers, The Two Calculation Methods for Pain and Suffering Damages <https://usalaw.com/personal-injury-resources/how-are-pain-and-suffering-damages-calculated/>
8. Alexandra F. Levy, Federal Human Trafficking Civil Litigation: 15 Years of the Private Right of Action, The Human Trafficking Legal Center (December 2018) <https://www.htlegalcenter.org/wp-content/uploads/Federal-Human-Trafficking-Civil-Litigation-1.pdf>
9. California Victim Compensation Board, Recovery From Human Trafficking, <https://victims.ca.gov/for-victims/victims-of-human-trafficking/>
10. Attorney General of Texas, Eligibility for Crime Victims' Compensation Program, <https://www.texasattorneygeneral.gov/crime-victims/crime-victims-compensation-program/eligibility-crime-victims-compensation-program>
11. Crime Victim Services 2023 Annual Report. <https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/annual-reports/23106-CVS-Annual-Report-2023-4.pdf>
12. Texas Crime Victims' Compensation Program Quick Reference Chart, 2016. [https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/CVC\\_QuickReferenceGuide.pdf](https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/CVC_QuickReferenceGuide.pdf)
13. Texas Crime Victims' Compensation Program Application, <https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/Printed%20CVC%20Application.pdf>
14. Appeals Process of the Crime Victims' Compensation Program (CVC). [www.texasattorneygeneral.gov/crime-victims/crime-victims-compensation-program/appeals-process](http://www.texasattorneygeneral.gov/crime-victims/crime-victims-compensation-program/appeals-process)
15. U.S. Is a Top Destination for Child Sex Trafficking, and It's Happening in Your Community, <https://www.heritage.org/crime-and-justice/commentary/us-top-destination-child-sex-trafficking-and-its-happening-your>
16. Improving Outcomes for Child and Youth Victims of Human Trafficking program, [https://ovc.ojp.gov/funding/opportunities/o-ovc-2022-171313?utm\\_medium=email&utm\\_source=govdeliver](https://ovc.ojp.gov/funding/opportunities/o-ovc-2022-171313?utm_medium=email&utm_source=govdeliver)
17. 2023 Trafficking in Persons Report: United States, <https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/united-states>
18. Hitting Them Where It Hurts: Strategies for Seizing Assets in Human Trafficking Cases By Charlene Whitman, JD, <https://aequitasresource.org/wp-content/uploads/2018/09/Hitting-Them-Where-it-Hurts-Strategies-for-Seizing-Assets-in-Human-Trafficking-Cases.pdf>
19. AEQuitas, Restitution and Asset Forfeiture: A Focus on Human Trafficking Current as of April 2014, <https://aequitasresource.org/wp-content/uploads/2018/09/Restitution-and-Asset-Forfeiture-A-Focus-on-Human-Trafficking.pdf>

20. Human Trafficking Grants & Funding <https://ovc.ojp.gov/program/human-trafficking/grants-funding#grants-funding>
21. Office for Victims of Crime, Current Funding Opportunities, <https://ovc.ojp.gov/funding/current-funding-opportunities>
22. Current Federal Funding Opportunities, <https://www.state.gov/humantrafficking-federal-funding/>
23. U.S. Department of Justice, Current Funding Opportunities, [https://www.ojp.gov/funding/explore/current-funding-opportunities?\\_gl=1\\*2vn4w8\\*\\_gcl\\_au\\*OTk2NDY4MDI3LjE3MTEExNzA4MTk.#4-0](https://www.ojp.gov/funding/explore/current-funding-opportunities?_gl=1*2vn4w8*_gcl_au*OTk2NDY4MDI3LjE3MTEExNzA4MTk.#4-0)
24. Services Available To Victims of Human Trafficking, A Resource Guide for Social Service Providers, <https://www.acf.hhs.gov/sites/default/files/documents/otip/traffickingservices.pdf>
25. National trafficking institute, The Current State of Restitution for Survivors of Human Trafficking, <https://traffickinginstitute.org/the-current-state-of-restitution-for-survivors-of-human-trafficking/>
26. The Federal Human Trafficking Report (FHTR) 2020 is authored by Lindsey Lane, Senior Legal Counsel, Angela Gray, Senior Project Attorney, Alicen Rodolph, Project Attorney, and Brittany Ferrigno, Legal and Development Research Manager, <https://traffickinginstitute.org/wp-content/uploads/2023/06/2022-Federal-Human-Trafficking-Report-WEB-Spreads-compressed.pdf>
27. Франц улсын хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын тайлан (2023).
28. Хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын үнэлгээ, ангилал. <https://www.knowyourcountry.com/human-trafficking>
29. U.S. Department of State, 2023 Trafficking in Persons Report: Netherlands, <https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/netherlands/>
30. Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.26, <https://documentation.lastradainternational.org/lsidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSuc N84AqZCI8I S 6DOdC4MEkg4OVofA>
31. Marijn Heemskerk, Compensation for victims of human trafficking in the Netherlands, 2013, <https://documentation.lastradainternational.org/lsidocs/3087-Compensation%20for%20Victims%20of%20Human%20Trafficking%20in%20The%20Netherlands.pdf>, p.10
32. Chapter B8/3 of the Aliens Act Implementation Guidelines 2000 (Vreemdelingen circulaire 2000 or Vc 2000) See the introduction of B8/3 scheme, <https://repository.wodc.nl/bitstream/handle/20.500.12832/3285/3349-evaluatie-van-de-wijziging-van-de-B8-3-regeling-summary.pdf?sequence=6&isAllowed=y>
33. FairWork, Compensation for victims of human trafficking in The Netherlands, 2013. <https://documentation.lastradainternational.org/doc-center/3087/compensation-for-victims-of-human-trafficking-in-the-netherlands>

34. GRETA, Reply from the Netherlands to the Questionnaire for the evaluation of the implementation of the Council of Europe Convention on Action against Trafficking in Human Beings by the Parties, Third evaluation round, 2022. <https://rm.coe.int/reply-from-the-netherlands-to-the-questionnaire-for-the-evaluation-of-/1680a6615d>, p.12
35. List of injuries, [www.schadefonds.nl](http://www.schadefonds.nl).
36. Application for Crime Victim Compensation <https://www.schadefonds.nl/wp-content/uploads/2020/02/AANVRG-victim-ENG-19-v01-01-2020.pdf>
37. GRETA (2018) Report Concerning the Implementation of the Council of Europe Convention on Action against Trafficking in Human Beings by the Netherlands, pp. 35-36.
38. The Violent Crime Compensation Fund, <https://www.schadefonds.nl/schadefonds/>
39. Toelichting letsellijst, 2021. <https://www.schadefonds.nl/wp-content/uploads/2021/08/Letsellijst-20210801.pdf>
40. ECLI:NL:RBGEL:2013:1486, <https://documentation.lastradainternational.org/Isidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf>
41. ХБНГУ-ын Хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын төлөв байдлын тайлан (2023). <https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/germany/>
42. German NGO network against Trafficking in Human beings, Legal Framework in Germany. <https://www.kok-gegen-menschenhandel.de/en/human-trafficking/legal-framework-in-germany>
43. European Commission, Institutional, legal and policy framework to address Trafficking in Human Beings in Germany. [https://home-affairs.ec.europa.eu/policies/internal-security/organised-crime-and-human-trafficking/together-against-trafficking-human-beings/eu-countries/germany\\_en](https://home-affairs.ec.europa.eu/policies/internal-security/organised-crime-and-human-trafficking/together-against-trafficking-human-beings/eu-countries/germany_en)
44. Justice at last European Action for Compensation for Victims of crime working paper, [https://www.kok-gegenmenschhandel.de/fileadmin/user\\_upload/3239Justice at Last Working Paper - Legal assessment Compensation practices La Strada International 2018 - Liliana Sorrentino.pdf](https://www.kok-gegenmenschhandel.de/fileadmin/user_upload/3239Justice_at_Last_Working_Paper_-_Legal_assessment_Compensation_practices_La_Strada_International_2018_-_Liliana_Sorrentino.pdf)
45. Petra Follmar, Heike Rabe, Human Trafficking in Germany: Strengthening Victim's Human Rights, p.68 <https://documentation.lastradainternational.org/Isidocs/Human%20trafficking%20in%20Germany%20-%20Strengthening%20victims'%20human%20rights.pdf>
46. European Commission, Institutional, legal and policy framework to address Trafficking in Human Beings in Germany. [https://home-affairs.ec.europa.eu/policies/internal-security/organised-crime-and-human-trafficking/together-against-trafficking-human-beings/eu-countries/germany\\_en](https://home-affairs.ec.europa.eu/policies/internal-security/organised-crime-and-human-trafficking/together-against-trafficking-human-beings/eu-countries/germany_en).

47. What should you do if you are affected by trafficking in human beings, [https://www.hilfe-info.de/WebS/hilfeinfo/EN/Leaflets/29-merkblatt\\_menschenhandel.html](https://www.hilfe-info.de/WebS/hilfeinfo/EN/Leaflets/29-merkblatt_menschenhandel.html)
48. ХБНГУ-ын Хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын төлөв байдлын тайлан (2023). <https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/germany/>
49. Япон улсын Хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын тайлан (2023).
50. Benefit payment systems for crime victims, White paper on crime 2001 Part 2/Chap.6/Sec.3/2. [https://hakusyo1.moj.go.jp/en/46/nfm/h\\_46\\_2\\_2\\_6\\_3\\_2.html](https://hakusyo1.moj.go.jp/en/46/nfm/h_46_2_2_6_3_2.html)
51. Metropolitan Police Department, Victims of crime [https://www.keishicho.metro.tokyo.lg.jp/multilingual/english/safe\\_society/become\\_a\\_victim/you\\_victim.files/physical\\_crime\\_english.pdf](https://www.keishicho.metro.tokyo.lg.jp/multilingual/english/safe_society/become_a_victim/you_victim.files/physical_crime_english.pdf)
52. Efforts to Recover the Victims' Damages and to Provide them with Economic Support, <https://www.npa.go.jp/hanzaihigai/whitepaper/english/2020/pdf/chapter1.pdf>
53. Public Prosecutors Office, For victims of crime, <https://www.moj.go.jp/content/001348855.pdf>.
54. Mainichi Japan, Japan's crime victim relief system fails to meet reality, June 14, 2023, <https://mainichi.jp/english/articles/20230614/p2a/00m/0op/007000c>
55. New Trends in Victim Support Scheme in Japan, Victims and Criminal Justice: Asian Perspective, pp.107-180, 2003, Tatsuya Ota, NCJ-202214. <https://www.ojp.gov/ncjrs/virtual-library/abstracts/new-trends-victim-support-scheme-japan-victims-and-criminal-justice>
56. Trafficking in human beings learning from Asian and European experiences. [https://www.kas.de/documents/252038/253252/7\\_dokument\\_dok\\_pdf\\_40567\\_2.pdf/c7cc3be7-a796-e7fd-df83-8c787bc98b40?version=1.0&t=1539660130033](https://www.kas.de/documents/252038/253252/7_dokument_dok_pdf_40567_2.pdf/c7cc3be7-a796-e7fd-df83-8c787bc98b40?version=1.0&t=1539660130033)
57. 2023 Trafficking in Persons Report: Taiwan, <https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/taiwan/>
58. БНМУ-ын Дээд шүүхийн бага хурлын шийдвэр, Хүний худалдаа болон хүүхдийн худалдаатай холбоотой хуулийг хэрэглэх талаар, 2004 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн №37 тоот.
59. Free Access to Justice, 20- 1 дүгээр зүйл.
60. Эрүүгийн шүүн таслах ажиллагаанд хохирогчийн оролцооны талаар суурь шийдвэрийн 7 дугаар зүйл.
61. С.Сојосару, Н. Wiseman, Хүний худалдаа – 2004 – 2005 оны 9 дүгээр сард Молдовад шүүн тасалсан хэргүүдийг задлан шинжлэх нь ” ( 2006 оны 6 сар хуудас 28).
62. The Council of Europe's Group of Experts on Action against Trafficking in Human Beings (GRETA).
63. Council of Europe, Romania urged to effectively prosecute human traffickers and ensure access to compensation for their victims, <https://www.coe.int/en/web/portal/-/romania-urged-to-effectively-prosecute-human-traffickers-and-ensure-access-to-compensation-for-their-victims>
64. GRETA, Report submitted by the authorities of Romania on measures taken to comply with Committee of the Parties Recommendation CP/Rec(2021)05 on



- the implementation of the Council of Europe Convention on Action against Trafficking in Human Beings, <https://rm.coe.int/report-submitted-by-the-authorities-of-romania-on-measures-taken-to-co/1680aba92d>
65. Европын сайд нарын 25 дугаар бага хуралд Румын Хууль зүйн сайдын тавьсан илтгэл [www.coe.int/t/dgl/legalcoopertion/minjist/](http://www.coe.int/t/dgl/legalcoopertion/minjist/)
  66. Румыны ЭБШХ-ийн 998 – 1002 зүйлд хууль бус үйлдлийн учирсан хохирлыг хариуцах үүргийг тогтоожээ.
  67. 2008 оны 12 дугаар сард Барселонд болсон Хүний эрхийн семинарт Румын улсын прокурорын хийсэн мэдээлэл.
  68. Хохирогчийн хамгааллын талаарх судалгаа [www.antitrfic.ro](http://www.antitrfic.ro) сайтыг үзнэ үү.
  69. ЮНИСЕФ-ийн илтгэл хуудас 42.
  70. U.S. Department of State, 2023 Trafficking in Persons Report: Thailand, <https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/thailand>
  71. Thailand's Country Report on Anti-Human Trafficking Response. 2016. [https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/thailands\\_country\\_report\\_01.pdf](https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/thailands_country_report_01.pdf)
  72. Seehanat Prayoonrat, An Overview of Asset Forfeiture System in Thailand, [https://www.unodc.org/roseap/uploads/archive/documents/2009/02/TOCAML/O/Overview of Asset Forfeiture System in Thailand 3.pdf](https://www.unodc.org/roseap/uploads/archive/documents/2009/02/TOCAML/O/Overview%20of%20Asset%20Forfeiture%20System%20in%20Thailand%203.pdf)
  73. Royal Thai Government's Country Report on Anti-Human Trafficking Efforts, 2021. <https://aseanactpartnershiphub.com/wp-content/uploads/2022/02/Thailands-Country-Report-on-Anti-Human-Trafficking-Efforts-2021.pdf>
  74. Human Rights and Development Foundation, Compensation for Victims of Trafficking in Persons, 2019 [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf).
  75. Bureau of Anti-Trafficking in Women and Children and Japan International Cooperation Agency, MDT Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking. [https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt\\_guideline\\_practical\\_version.pdf](https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt_guideline_practical_version.pdf).
  76. Human Rights and Development Foundation, Compensation for Victims of Trafficking in Persons, 2019.

**“ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ, НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХОХИРОГЧИД НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТАЛААР ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГЫГ СУДАЛЖ, ӨӨРИЙН УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИСТОЙ АРГА, ХЭЛБЭРИЙГ ТОДОРХОЙЛОХ, САНАЛ ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛАХ” СУДАЛГААНЫ ХАВСРАЛТ<sup>296</sup>**

1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, насанд хүрээгүй хохирогчид нөхөн олговор олгож буй эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах

**Судлах зүйл: 1. Удиртгал хэсэг буюу хүн худалдаалах гэмт хэргийн талаарх эрх зүйн зохицуулалт: үйлдлийн төрөл, оногдуулах ял, хохирогчийн эрх, үзүүлэх тусламж зэрэг**

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>АНУ-ын 50 муж улсад хүн худалдаалах гэмт хэргийг хүнд гэмт хэрэгт хамааруулсан (2003 онд Вашингтоноос эхэлсэн).</p> <p>АНУ-ын код (US.Code)-ийн 1584 дүгээр зүйлд Албадан боолчлох зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийг, 1589 дүгээр зүйлд Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийг, 1590 дүгээр зүйлд Насанд хүрсэн хүнийг худалдаалах, боолчлох, албадан эрхшээлдээ байлгах, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг, 1591 дүгээр зүйлд Хүүхдийг бэлгийн зорилгоор эсхүл хүчээр, залилан мэхэлж, албадлага хэрэглэж худалдах гэмт хэргийг тус тус хуульчилсан байна.</p> <p>Тухайлбал, 1584 дүгээр зүйлд зааснаар хүнийг санаатайгаар албадан боолчлолд байлгасан эсхүл хүнийг худалдсан бол албадан боолчлох зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг гэж үзэж торгох, хорин жилээс илүүгүй хугацаагаар хорих эсхүл аль алинаар шийтгэнэ. Гэмт хэрэг</p>	<p>Нидерланд улс нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой тус улсын шаардлагыг бүрэн хангасан (Tier 1) орны нэг юм.<sup>297</sup> Нидерланд улс нь Европын Холбооны гишүүн улс тул дотоод хууль тогтоомж нь Европын холбооны хууль тогтоомжид нийцэх бөгөөд Европын холбооноос гаргасан дүрэм, журам зэрэг нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийн эрхийг хамгаалах, нөхөн төлбөр олгох зэрэг харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тус улсад, 2014 онд энэ төрлийн гэмт хэрэг 52 бүртгэгдэж нийт 55 хохирогч тогтоогдож, 86 нэхэмжлэл гаргаж, шүүхээс 67 нэхэмжлэлийг бүрэн эсхүл хэсэгчлэн хангасан байна.<sup>298</sup></p> <p>Европын холбооны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тухай 2011 оны</p>	<p>Тайланд улс нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой тус улсын шаардлагыг бүрэн хангаагүй боловч ихээхэн дэвшил гаргасан (Tier 2) орны нэг юм.<sup>309</sup></p> <p>Тайланд нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 онд баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”, түүний нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”, Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгээс баталсан “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх конвенц” зэрэгт нэгдэн орсноос гадна бүс нутгийн улсууд, тухайлбал Камбож, Мьянмар, Вьетнам зэрэг улстай 2 талт олон улсын гэрээ байгуулжээ.</p> <p>Тайландын хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хууль эрх зүйн орчин нь дараах</p>

<sup>296</sup> Сайн туршлага бүхий 3 улсыг сонгон авч хүснэгтлэн хавсаргав.

<sup>297</sup> U.S. Department of State, 2023 Trafficking in Persons Report: Netherlands, <https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/netherlands/>

<sup>298</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.59

[https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSUC\\_N84AqZCl8I\\_S\\_6DOdC4MEKq4OVoFA](https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSUC_N84AqZCl8I_S_6DOdC4MEKq4OVoFA)

<sup>309</sup> U.S. Department of State, 2023 Trafficking in Persons Report: Thailand, <https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/thailand>

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>үйлдэхдээ хүний амь нас хохироосон, эсхүл хүн хулгайлах, хүн хулгайлахыг завдсан, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, бэлгийн хүчирхийлэл үйлдэхийг завдсан, амь насыг нь хөнөөхийг завдсан үйлдлээр үйлдсэн бол шүүгдэгчийг торгох, бүх насаар хорих ялаар эсхүл аль алинаар шийтгэнэ. Мөн 1589 дүгээр зүйлд хүний хөдөлмөр, үйлчилгээг дор дурдсан аргуудын аль нэгийг буюу хослуулан ашиглаж, мэдсээр байж олж авсан бол албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг гэж үзнэ. Үүнд:</p> <p>(1) хүч хэрэглэх, хүчээр заналхийлэх, эрх чөлөөг нь хязгаарлах, эрх чөлөөг нь хязгаарлахаар заналхийлэх замаар;</p> <p>(2) хүний бие махбодод ноцтой хохирол учруулах, эсхүл ноцтой хохирол учруулахаар заналхийлэх замаар;</p> <p>(3) хууль, шүүхийн үйл явцыг урвуулан ашиглах, заналхийлэх замаар; эсхүл</p> <p>(4) хэрэв шаардсан ажил, үйлчилгээг хийгээгүй бол тухайн хүн эсхүл өөр хүн ноцтой хохирол амсах эсхүл бие махбодыг нь хязгаарлах шийтгэл оногдуулна гэж ойлгуулах зорилготой аливаа схем, төлөвлөгөө, загвараар.</p> <p>1590 дүгээр зүйлд зааснаар хүнийг мөлжих зорилгоор аливаа хүнийг элсүүлсэн, байршуулсан, тээвэрлэсэн эсхүл ямар нэгэн аргаар олж авсан бол хүнийг худалдаалах, боолчлох, албадан эрхшээлдээ байлгах, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэг гэж</p>	<p>2011/36/EU тоот журмаар<sup>299</sup> энэ төрлийн гэмт хэргийн ойлголт, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх механизмыг зохицуулсан. Тус журмын 2 дугаар зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолтыг авч үзвэл, хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээн авах үйлдлийг хэлнэ гэжээ.<sup>300</sup> Тус үйлдлийг хүүхдийн эсрэг (18 хүртэлх насны) үйлдсэн бол дээр заасан аргыг ашигласан байхыг шаардахгүй бөгөөд гэмт хэрэгт тооцно. Үүнээс үзэхэд, гэмт хэргийн ойлголт, тодорхойлолт, объектив үйлдлийн хувьд олон улсын эрх зүйн зохицуулалт болох НҮБ-ын Үндэстэн дамнасан Гэмт хэрэгтэй тэмцэх конвенцын нэмэлт протокол болох Хүнийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдах гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх, уг гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэгтнүүдийг шийтгэх протоколын зохицуулалттай ижил.</p> <p>Европын холбооны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тухай 2011 оны 2011/36/EU тоот журмын 4 дүгээр зүйлд гэмт хэрэгтэнд оногдуулах ял шийтгэлийн доод</p>	<p>үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ.</p> <p>Нэгдүгээрт, 2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хууль<sup>310</sup> хоёрдугаарт, 2016 оны Хүн худалдаалах гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль юм.<sup>311</sup></p> <p>2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хууль нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гол эрх зүйн эх сурвалж юм. Тус хуулиар хүн худалдаалах гэмт хэрэг, түүнтэй тэмцэх тогтолцоо, хохирогчид үзүүлэх хамгаалалт, тусламж, үйлчилгээ, нөхөн төлбөр олгох асуудалтай холбогдох харилцааг зохицуулсан.</p> <p>Тус хуулийн 6 дугаар зүйлд зааснаар “хүн худалдаалах” гэдэгт нэгдүгээрт, хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг арилжаалах, худалдах, худалдан авах, тээвэрлэх, зөөвөрлөх, илгээх, саатуулах, хорих, нуух, хүлээн авах үйлдлийг, хоёрдугаарт хүүхдийг арилжаалах, худалдах, худалдан авах, тээвэрлэх, зөөвөрлөх, илгээх, саатуулах, хорих, нуух, хүлээн авах үйлдлийг хэлнэ</p>

<sup>299</sup> Directive 2011/36/EU OF the European Parliament and of the Council of 5 April 2011 on preventing and combating trafficking in human beings and protecting its victims, and replacing Council Framework Decision 2002/629/JHA.,

<https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:32011L0036>

<sup>300</sup> Article 2, Directive 2011/36/EU OF the European Parliament and of the Council of 5 April 2011 on preventing and combating trafficking in human beings and protecting its victims, and replacing Council Framework Decision 2002/629/JHA.

<sup>310</sup> The Prevention and Suppression of Human Trafficking Act BE 2551 (2008).

<sup>311</sup> The Human Trafficking Criminal Procedure Act BE 2559 (2016).

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>үзэж, торгох эсхүл 20 жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсхүл аль алинаар шийтгэнэ. Энэ зүйлийг зөрчсөний улмаас хүн нас барсан эсхүл тухайн үйлдлийг хийхдээ хүн хулгайлсан, хулгайлахыг завдсан, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, бэлгийн хүчирхийлэл үйлдэхийг завдсан, амь насыг нь хөнөөхийг завдсан гэмт хэрэгт холбогдсон бол торгох эсхүл бүх насаар нь хорих эсхүл аль алинаар шийтгэнэ гэж, 1591 дүгээр зүйлд Хүүхдийг бэлгийн зорилгоор эсхүл хүчээр, залилан мэхэлж, албадлага хэрэглэж худалдах гэмт хэргийг зохицуулсан бөгөөд 25 жилээс ихгүй хорих ял эсхүл торгох ял ногдуулахаар тусгасан байна.</p> <p>Дээрх АНУ-ын кодоос гадна муж бүр Үндсэн хууль, Эрүүгийн хууль, хууль сахиулах байгууллага бүхий өөр өөрийн эрх зүйн тогтолцоотой учраас муж бүр хүн худалдаалах гэмт хэргийг харилцан адилгүй зохицуулжээ. Тухайлбал, АНУ-ын Калифорни мужийн 2005 онд батлагдсан Эрүүгийн хууль (Penal code)-ийн 8 дугаар хэсгийн 8 дугаар бүлгийн 236 дугаар зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг “албадан хөдөлмөрлүүлэх зорилгоор бусдын хувийн эрх чөлөөг хассан, зөрчсөн этгээдийг хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, улсын хорих ангид 5, 8, 12 жил хорих, таван зуун мянган доллароос (500,000 доллар) илүүгүй торгох ял шийтгэнэ” гэж зохицуулжээ.</p> <p>Дээр дурдсанаас гадна хүн худалдаалах гэмт хэргийн талаар бусад эрх зүйн зохицуулалтууд үйлчилдэг. АНУ-ын Дотоод аюулгүй байдлын яам (DHS) нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй</p>	<p>хэмжээг тогтоосон. 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн этгээдэд ногдуулах ялын дээд хэмжээ нь хамгийн багадаа 5 жил, тус гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн, эсхүл зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн, эсхүл хохирогчийн амь насанд хохирол учруулсан эсхүл хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан нөхцөлд хамгийн багадаа 10 жил байхаар тусгахыг Гишүүн улс бүрд үүрэг болгосон. Мөн хуулийн этгээдэд ногдуулах эрүүгийн хариуцлага зайлшгүй байх талаар тусгаснаас гадна хуулийн этгээдэд ногдуулах ял шийтгэлийн төрлийг тусгасан байна.</p> <p>Мөн Гишүүн улс бүр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг бие бялдар, сэтгэл зүй болон нийгэмд эзлэх байр суурийн хувьд нөхөн сэргээх арга хэмжээг авах үүрэг хүлээсэн. Тухайлбал, орон байраар хангах, хохирогчдод ойлгогдох хэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, эмнэлгийн, сэтгэл зүйн болон материаллаг туслалцаа үзүүлэх, хөдөлмөрлөх, боловсрол эзэмших боломжоор хангах гэх мэт. Цаашлаад Гишүүн улс бүр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр олгох боломж, тогтолцоог дотоодын хууль тогтоомждоо тусгах үүрэг хүлээсэн.</p> <p><b>Дотоодын хууль тогтоомжийг нарийвчлан авч үзвэл,</b> Нидерландын Эрүүгийн хуулийн 237f зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг заасан. Тус зүйлд гэмт хэргийн сэдэл, зорилго, объектив үйлдэл, арга, хэрэгслийг тодорхойлсон байдал нь Палермогийн</p>	<p>гэжээ.<sup>312</sup></p> <p>Хүүхдийн эсрэг тухайн үйлдлийг үйлдсэн тохиолдолд өмнөх хэсэгт заасан арга, хэлбэр, зорилгыг шаардахгүй байхаар тусгайлсан хуульчилсан гэж үзэж болохоор байна.</p> <p>Тус хуулийн 7 дугаар зүйлд гэмт хэргийн бусад оролцогчийн төрлийг тусгажээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэхэд тусалсан, өдөөн хатгасан гэх зэрэг үйлдэлд хүн худалдаалах гэмт хэрэгтэй адил эрүүгийн хариуцлага ногдуулахаар хуульчилжээ. Цаашлаад хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхэд бэлтгэсэн тохиолдолд ногдуулах эрүүгийн хариуцлагын доод хэмжээг уг гэмт хэргийг үйлдсэн этгээдэд ногдуулах эрүүгийн хариуцлагын 1/3-тэй тэнцүү байхаар, уг гэмт хэргийг үйлдэхээр завдсан бол 1/ 2-иас ихгүй тусгасан байна. Гэмт хэргээс үйлдэхээс сайн дураараа татгалзах тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй талаар тусгасан нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн зохицуулалттай ижил байна. Цаашлаад, нийтийн албан тушаалтан тус гэмт хэргийг үйлдэх тохиолдолд эрүүгийн хариуцлагыг 2 дахин нэмэгдүүлэх байдлаар эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхээр заасан нь онцлог байна.</p> <p>Тус хуулийн 52 дугаар зүйлд эрүүгийн хариуцлагыг тусгасан байх бөгөөд энэ гэмт хэргийг үйлдсэн этгээдэд 4-10 жилийн хорих ял, эсхүл 80000-200000 Тайланд бат-тай тэнцэх торгох ял ногдуулна. Гэмт хэргийг 15 насанд хүрсэн боловч 18 насанд хүрээгүй этгээдийн эсрэг үйлдсэн бол 6-10 жил хорих ял, 120000-</p>

<sup>312</sup> Article 6, The Prevention and Suppression of Human Trafficking Act BE 2551 (2008), <https://www.mol.go.th/wp-content/uploads/sites/2/2021/02/ANTI-HUMAN-TRAFFICKING-ACT.pdf>

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>тэмцэх хүрээнд гаргасан жагсаалтаас дурдвал:</p> <p>2000 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль</p> <p>1984 оны Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тухай хууль</p> <p>2015 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын төлөөх шударга ёсны тухай хууль</p> <p>1982 оны Хохирогч ба гэрчийг хамгаалах тухай хууль, Pub. L. дугаар 97-291, 96 Стат. 1248 (1982)</p> <p>1984 оны Гэмт хэргийн хохирогчдын тухай хууль, Pub. L. № 98-473, 98 Стат. 2170 (1984)</p> <p>Эрүүгийн шүүхийн тогтолцоонд гэмт хэргийн хохирогч, гэрчтэй харьцах холбооны удирдамж, 18 U.S.C. § 1512 (1984)</p> <p>1990 оны Хүүхдийн хүчирхийллийн хохирогчдын тухай хууль, Pub. L. No 101-647 (1990)</p> <p>1990 оны Хохирогчийн эрх ба нөхөн төлбөрийг олгох тухай хууль, 34 U.S. § 20141 (2006)</p> <p>2004 оны Гэмт хэргийн хохирогчдын эрхийн тухай хууль, 18 U.S.C. § 3771 (2006 &amp; III дугаар 2009)</p> <p>АНУ-ын Хууль зүйн яам, Ерөнхий прокурорын хохирогч болон гэрчүүдэд туслах заавар (2023) U.S.C. § 1232, Хүүхэд худалдаалахтай тэмцэх хүчин чармайлтыг нэмэгдүүлэх зэрэг.</p> <p>Дотоод аюулгүй байдлын яам нь хүн худалдаалах гэмт хэргээс гадна залилан, хар</p>	<p>протокол, Европын холбооны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тухай 2011 оны 2011/36/EU тоот журамтай адил. Гэсэн хэдий ч гэмт хэрэг үйлдэгдэнэ гэдгийг мэдсээр байж ийнхүү гэмт хэрэг үйлдэгдэх орчин нөхцөлийг үүсгэхээр хохирогчийг албадах, өдөөх, ятган үнэмшүүлэх үйлдэл нь мөн хүн худалдаалах гэмт хэрэгт тооцогдоно.<sup>301</sup> Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг бодитоор үйлдэгдээгүй боловч гэмт хэргийг үйлдэхээр хохирогчийг албадах, ятган үнэмшүүлэх замаар гэрээ, хэлцэл байгуулсан зэрэг үйлдэл үүнд хамаарна.<sup>302</sup> Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг 12 жил хүртэлх хорих ял эсхүл 5 дугаар түвшний торгуулийн ялаар шийтгэнэ.<sup>303</sup></p> <p>Гэмт хэргийг 2 буюу түүнээс дээш этгээд хамтарч үйлдсэн бол, гэмт хэргийг 18 нас хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол, гэмт хэргийг үйлдэхдээ хохирогчийг хүчирхийлсэн бол 15 жил хүртэлх хорих ял эсхүл 5 дугаар түвшний торгуулийн ялаар шийтгэнэ.<sup>304</sup></p> <p>Гэмт хэргийг үйлдэхдээ хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учруулж эсхүл амь насыг заналхийлсэн бол 18 хүртэлх ялаар эсхүл 5 дугаар түвшний торгуулийн ялаар, хохирогчийн амь насыг хохироосон бол 30 хүртэлх жил эсхүл 5 дугаар түвшний торгуулийн ялаар тус тус</p>	<p>200000 Тайланд бат, 15 нас хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол 8-15 жилийн хорих ял, 160000-300000 Тайланд баттай тэнцэх торгох ял тус тус ногдуулахаар тусгасан байгаа нь онцлог байна.</p> <p>Түүнчлэн хуулийн этгээдийн ашгийн төлөө үйлдсэн бол хуулийн этгээдэд торгох ял, эрх бүхий этгээдэд хорих ял эсхүл торгох ял ногдуулахаар хуульчилжээ.<sup>313</sup></p> <p>2016 оны Хүн худалдаалах гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй хамааралтай ээдрээ бүхий эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд шүүхийн үйл ажиллагааны үр ашиг, үр өгөөжийг нэмэгдүүлэх, цаашлаад шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэх боломжийг олгоход чиглэсэн гэж үздэг.<sup>314</sup></p> <p>Цаашлаад Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль тогтоомж нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжийн нэг хэсэгт тооцогддог.<sup>315</sup> Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 14.9 дэх хэсэгт зааснаар хүн худалдаалах гэмт хэргээр дамжуулж мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй нөхцөлд Мөнгө угаахтай тэмцэх газар (AMLO) нь хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, сэжигтэн яллагдагчийн хөрөнгийг хураах бүрэн эрхтэй байхаар зохицуулжээ.</p>

<sup>301</sup> Translation of Article 237f of Dutch Penal Code, <https://eucpn.org/sites/default/files/document/files/NL.pdf>.

<sup>302</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.26 [https://documentation.lastradainternational.org/Isidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSucc\\_N84AqZCI8I\\_S\\_6DOdC4MEkq4OVofA](https://documentation.lastradainternational.org/Isidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSucc_N84AqZCI8I_S_6DOdC4MEkq4OVofA)

<sup>303</sup> Translation of Article 237f of Dutch Penal Code, <https://eucpn.org/sites/default/files/document/files/NL.pdf>.

<sup>304</sup> Мөн тэнд.

<sup>313</sup> Translation of Article 237f of Dutch Penal Code, <https://eucpn.org/sites/default/files/document/files/NL.pdf>.

<sup>314</sup> [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf), p.13

<sup>315</sup> If there are reasonable grounds to believe that the offence of trafficking in persons involves money laundering, the enquiry officials must make an immediate report of their findings to the Anti-Money Laundering Office (AMLO): Office of the Prime Minister's Regulation on Coordination in the Implementation of the Anti-Money Laundering Act of 2009 and the Amendment of 2011, Gazette Vol 118, Дам эшлэв. [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf), p.13

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>тамхины наймаа, хүн хууль бусаар хил нэвтрүүлэх, мөнгө угаах, визний залилан, хүүхдийн бэлгийн хүчирхийлэл, муж хоорондын биеэ үнэлэлт, хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах зэрэг гэмт хэрэгт эрүүгийн мөрдөн байцаалт явуулдаг.</p> <p>Монгол Улсын хувьд хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой нарийвчилсан нэг хууль буюу 2012 онд батлагдсан “Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль” хүчин төгөлдөр үйлчилж байна. Харин АНУ-ын хувьд холбогдолтой эрх зүйн акт олон төрлөөр байдаг нь сайн жишиг болж байна. Иймд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалахтай холбоотой нарийвчилсан хууль журмыг батлах замаар эрх зүйн орчныг сайжруулах боломж байна.</p>	<p>шийтгэхээр хуульд тусгажээ.<sup>305</sup></p> <p>Түүнчлэн Хууль зүйн туслалцааны тухай хуулийн дагуу хүнд эсхүл хүчиндэх гэмт хэргийн хохирогч хуульд заасан санхүүгийн байдлын шалгуурыг хангасан эсэхээс үл хамааран Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн сан (Criminal Injuries Compensation Fund)-гаас нөхөн төлбөр авах шалгуурыг хангасан бол үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах боломжтой байдаг. Хөдөлмөрийн мөлжлөг хийх зорилгоор үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч дээрх хуулийн дагуу хууль зүйн туслалцаа авахын тулд хуульд заасан санхүүгийн байдлыг хангасан байх ёстой. Зарим судлаачид бэлгийн мөлжлөгтэй адил хөдөлмөрийн мөлжлөгийн хохирогчдод ч мөн хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.<sup>306</sup></p> <p>Мөн хохирогчийн хүсэл зоригийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргээс бусад тохиолдолд хууль зүйн туслалцаа үнэгүй үзүүлдэггүй байна.<sup>307</sup></p> <p>Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон гадаадын иргэнд Нидерланд улсад оршин суух эрхийг тодорхой хугацаанд олгож болох бөгөөд энэ нь тухайн иргэнд гэмт хэрэгтний эсрэг гомдол гаргах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, нөхөн</p>	<p>2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хуульд хохирогчдыг хамгаалах, дэмжих олон төрлийн арга хэмжээг тусгасан. Тухайлбал, хохирогчийн хувийн нууцыг хамгаалах, эрхийнхээ талаар мэдээлэл авах, нийгмийн харилцаанд урьдын адил оролцоход чиглэсэн тусламж авах эрх, гэмт хэрэгт яллахаас хамгаалах, хохирогчийн эрх зүйн байдал, гэрч, хохирогч гэрчийг хамгаалах харилцааг нийтлэг байдлаар зохицуулсан. Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдлын яам /The Ministry of Social Development and Human Security/-аас хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүргийг ерөнхийлөн хариуцдаг.</p> <p>Эмчилгээ хийлгэх, нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдах, нөхөн төлбөр нэхэмжлэх эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн бол хохирогчид тус улсад оршин суух зөвшөөрлийг авахад нь эрх бүхий албан тушаалтнаас хуульд зааснаар хохирогчид тусламж үзүүлэхээр тусгасан байна.<sup>316</sup></p>

<sup>305</sup> Мөн тэнд.

<sup>306</sup> Marijn Heemskerk, Compensation for victims of human trafficking in the Netherlands, 2013.

<https://documentation.lastradainternational.org/lisidocs/3087-Compensation%20for%20Victims%20of%20Human%20Trafficking%20in%20The%20Netherlands.pdf> , p.10

<sup>307</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.26

[https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSUC\\_N84AqZCl8l\\_S\\_6DOdC4MEKq4OVofA](https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSUC_N84AqZCl8l_S_6DOdC4MEKq4OVofA)

<sup>316</sup>Article 37, The Prevention and Suppression of Human Trafficking Act BE 2551 (2008), <https://www.mol.go.th/wp-content/uploads/sites/2/2021/02/ANTI-HUMAN-TRAFFICKING-ACT.pdf>

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
	<p>төлбөр авах эрхийг хангахад чиглэсэн байна.<sup>308</sup> Прокурорын газар (the Public Prosecution Service)-аас гадаадын иргэн гэмт хэргийн хохирогч болсон бөгөөд цаашид Нидерланд улсад тодорхой хугацаанд оршин суух шаардлагатай талаар Цагаачлалын албанд (the Immigration and Naturalisation Service)-д мэдэгдсэн тохиолдолд орших суух зөвшөөрөл олгодог.</p>	

<sup>308</sup> Chapter B8/3 of the Aliens Act Implementation Guidelines 2000 (Vreemdelingen-circulaire 2000 or Vc 2000) See the introduction of B8/3 scheme at <https://repository.wodc.nl/bitstream/handle/20.500.12832/3285/3349-evaluatie-van-de-wijziging-van-de-B8-3-regeling-summary.pdf?sequence=6&isAllowed=y>

**Судлах зүйл: 2. Хохирогчид нөхөн олговор олгох эрх зүйн зохицуулалтын салбар буюу эрүү, иргэн, хөдөлмөрийн хуулийн журмаар нөхөн олговор олгох ажиллагааны онцлог, зохицуулалт**

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>Хүн худалдаалах гэмт хэргийг үйлдсэн, үйлдэхийг дэмжсэн, ашиг тусыг нь хүртсэн этгээдийн эсрэг дараах тохиолдолд иргэний нэхэмжлэл гаргаж болно.</p> <p>Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон; Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон насанд хүрээгүй хүүхдийн эцэг эх; Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас гэр бүлийн гишүүнээ алдсан хүн.</p> <p>Конгресс 2003 онд Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах тухай хуулийг<sup>317</sup> баталсан бөгөөд энэ нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг "элсүүлэх, нуух, тээвэрлэх, тухайн нөхцөл байдлаар хангах, олж авах, дэмжих, ятгах" зэргээр хүн худалдаалах үйл ажиллагаанд оролцсон бүх хүмүүсийн эсрэг холбооны шүүхэд иргэний нэхэмжлэл гаргах боломжийг олгодог.</p> <p>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх төвийн нийтэлсэн тайланд дурдсанаар, сүүлийн 15 жилийн хугацаанд холбооны шүүхэд иргэний нэхэмжлэлээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирлыг нэхэмжилсэн хэргийн тоо тогтмол өссөн байна. 2017 оныг 2004 онтой харьцуулахад 6 дахин ихэссэн<sup>318</sup>.</p> <p>АНУ-ын хууль тогтоогчид хүн худалдаалах гэмт</p>	<p>Тус улсад Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох талаар бие даасан хууль байхгүй. Тус гэмт хэргийн хохирогч иргэний болон эрүүгийн шүүхэд хандах замаар нөхөн төлбөрөө нэхэмжлэх боломжтой. Хөдөлмөрийн байцаагчид хандаж болох боловч одоогоор хөдөлмөрийн байцаагч хохирлыг барагдуулах боломжгүй, өөрөөр хэлбэл гагцхүү гэмт хэрэгтэнд торгууль ногдуулдаг.</p> <p><u>Иргэний журмаар хохирол төлүүлэх ажиллагаа</u></p> <p>Хохирогчийн нэхэмжлэлийг эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлээгүй тохиолдолд хохирогч иргэний шүүхэд нэхэмжлэл гаргах бүрэн боломжтой. Гэсэн хэдий ч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хувьд иргэний шүүхэд нэхэмжлэл гаргах нь зардал, чирэгдэл ихтэй шийдэл байж болох талаар тэмдэглэжээ.<sup>320</sup></p> <p><u>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хохирол нөхөн төлүүлэх</u></p> <p>2013 оны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх заавар (the Human Trafficking Guidelines (2013)-т<sup>321</sup> хохирогч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний нэхэмжлэгчээр оролцох боломжтой бөгөөд хэрвээ хохирогч нөхөн төлбөр шаардах</p>	<p>2005 оноос өмнө хохирогч хохирлоо гагцхүү иргэний шүүхэд хандаж нөхөн төлүүлэх боломжтой байсан бол 2005 онд Эрүүгийн хуульд орсон өөрчлөлтийн дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэл гаргах боломжтой болсон.</p> <p>Хохирогч нөхөн төлбөрөө эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эсхүл иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх замаар гэмт хэрэг үйлдсэн этгээдээс нэхэмжлэх боломжтой.</p> <p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нөхөн төлбөр шаардах үндэслэл нь нэгдүгээрт, 2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хууль<sup>329</sup>, 2016 оны Хүн худалдаалах гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль<sup>330</sup>, хоёрдугаарт Эрүүгийн хууль байх боломжтой. Хохирогч өөрт учирсан эдийн болон эдийн бус хохирлыг дээр заасан материаллаг хэм хэмжээг үндэслэн шаардаж болох боломжтойгоос гадна гэмт хэрэг үйлдэхдээ хохирогчийг эрүүдэн шүүсэн, хорьсон, эрүүл мэндэд нь хохирол учруулсан, хүнлэг бус хандсан тохиолдолд punitive damage<sup>331</sup> буюу шийтгэх нөхөн</p>

<sup>317</sup> Trafficking Victims Protection Reauthorization Act, 2003, <https://www.congress.gov/bill/108th-congress/house-bill/2620>

<sup>318</sup> Human Trafficking Civil Cases & Personal Injury Lawsuits, [https://www.enjuris.com/blog/resources/human-trafficking-civil-lawsuits/?fbclid=IwAR3mFZV32GPd6xNAqin9BetSLykKQvqiX2ZQ8zEPGzHF-ETQKGzniZi7JM\\_aem\\_AeFMqL5gnWzsHlqtqgqVpPpWKW6Y\\_7vGNI3WY4ehXW9RkdSIthADI-IRVF1aB1ZPDXDhAGikJPYAgj6hsoH6fs76L](https://www.enjuris.com/blog/resources/human-trafficking-civil-lawsuits/?fbclid=IwAR3mFZV32GPd6xNAqin9BetSLykKQvqiX2ZQ8zEPGzHF-ETQKGzniZi7JM_aem_AeFMqL5gnWzsHlqtqgqVpPpWKW6Y_7vGNI3WY4ehXW9RkdSIthADI-IRVF1aB1ZPDXDhAGikJPYAgj6hsoH6fs76L)

<sup>320</sup> FairWork, Compensation for victims of human trafficking in The Netherlands, 2013. <https://documentation.lastradainternational.org/doc-center/3087/compensation-for-victims-of-human-trafficking-in-the-netherlands>

<sup>321</sup> Aanwijzing slachtofferrechten, <https://wetten.overheid.nl/BWBR0045831/2021-12-01>

<sup>329</sup> The Prevention and Suppression of Human Trafficking Act BE 2551 (2008).

<sup>330</sup> The Human Trafficking Criminal Procedure Act BE 2559 (2016).

<sup>331</sup> Section 14 of the TIP Criminal Procedure Act.



АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>хэргийн хохирогчдыг шүүх эрх мэдлийн хүрээнд хамгаалах хэд хэдэн эрүүгийн хамгаалалт, иргэний эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан. Хууль тогтоогчид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод санхүүгийн хувьд дэмжлэг үзүүлэх дараах механизмуудыг бий болгосон.</p> <p>- ЭХХША-ны явцад нөхөн төлбөр гаргуулах боломжтой. Эрүүгийн процессын явцад хүн худалдаалах гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдээс хохирогчид учирсан хохирлыг төлөхийг шаардаж болно.</p> <p>- Иргэний эрх зүйн хамгаалалтыг ашиглаж болно. Өөрөөр хэлбэл, хохирогчид учирсан хохирлыг иргэний журмаар нөхөн сэргээх боломжийг олгодог. Мужийн хуулиудад гэмт хэрэгтний эсрэг гаргаж болох иргэний нэхэмжлэлийн талаар тусгасан байдаг.</p> <p>-Тус улсын Хөдөлмөрийн шударга стандартын тухай хуулийн дагуу цалин хөлсөө тооцож, эрүү, иргэний шүүхээр нэхэмжилж болно.</p> <p>Холбооны Засгийн газраас санхүүжүүлэх олон хөтөлбөрийн дагуу хохирогч олон төрлийн үйлчилгээнд хамрагдах боломжтой. Тухайлбал, орон байраар хангуулах, эмнэлгийн үйлчилгээ авах, зөвлөгөө, үйлчилгээ авах гэх мэт.</p> <p>Монгол Улсын зохицуулалтыг авч үзвэл Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шүүхээс хохирлыг нөхөн төлүүлж болохоос</p>	<p>хүсэлтэй байгаа талаар илэрхийлсэн тохиолдолд прокурорын газраас хохирогчид ийнхүү нөхөн төлбөрөө амжилттай авахад шаардагдах туслалцааг боломжит хэлбэрээр үзүүлнэ гэж тусгажээ.</p> <p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл (injured party claim) гаргаж болох бөгөөд энэхүү нэхэмжлэлийг эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлэж болно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 51f зүйлд энэ төрлийн нэхэмжлэлийг заасан.<sup>322</sup> Шүүх нэхэмжлэлийг хүлээн авах үндэслэлтэй эсэх талаар дүгнэлт гаргаж, эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд нөхөн төлбөрийн хэмжээг мөн шийдвэрлэдэг. Шүүхээс баримтлах нөхөн төлбөрийн жишиг үнийн тариф байхгүй.</p> <p>2011 оныг хүртэл эрүүгийн шүүхээс эрүүгийн хэрэгтэй хамт иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэх эсэхийг шийдвэрлэхдээ, тухайн иргэний нэхэмжлэл нь эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдэхүйц энгийн шинж чанартай биш бол хүлээн авахаас татгалздаг байсан ба хүн худалдаалах гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг нэхэмжлэх ихэнх тохиолдол үүнд хамаарч байсан бол, 2011 оны нэмэлт, өөрчлөлтийн дараагаар тухайн нэхэмжлэл нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэт их хүндрэл (a disproportionate burden) үүсгэхээс бусад тохиолдолд татгалзахгүй байх</p>	<p>төлбөрийг<sup>332</sup> мөн шаардах боломжтой.<sup>333</sup></p> <p>Хохирогчийн нөхөн төлбөр авах асуудал нь хохирогчоор тогтоолгохтой салшгүй холбоотой гэж үзэх бөгөөд хохирогчийг тогтоох үр дүнтэй механизмыг сайжруулах зохицуулалт 2013 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах заавар (Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking)<sup>334</sup> болон 2016 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тогтоох ажиллагааны үр дүнтэй байдлыг дээшлүүлэх заавар (Guidelines to Enhance Efficiency of Human Trafficking Victim Identification)<sup>335</sup>-т тусгагдсан. Тус зааврын дагуу хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдээллийг авсан даруй холбогдох байгууллагууд Хамтарсан баг ('MDT')-ийг байгуулж, гэмт хэргийн ул мөрийг бэхжүүлэх чиглэлээр (initial fact finding) ажиллаж эхэлдэг. MDT-с аливаа этгээдийг хохирогч гэж үзсэн бол Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдлын яамнаас орон байраар хангаж, хуульд заасан туслалцааг үзүүлнэ.</p> <p>2008 оны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хуулийн 35 дугаар зүйлд зааснаар хохирогч нөхөн төлбөр нэхэмжлэх хүсэлтэй байгаа бол прокурор түүний өмнөөс нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг нотлох үүрэгтэй байдлаар зохицуулсан байна. Цаашлаад ийнхүү нэхэмжлэл гаргаагүй тохиолдолд шүүх өөрийн санаачилгаар хохирол нөхөн төлүүлэхээр шийдвэрлэх эрхтэй байдгаараа онцлогтой байгаа нь Монгол Улсын</p>

<sup>322</sup> Dutch Criminal Procedure Law,

[https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/nld/1921/criminal\\_procedure\\_code\\_of\\_the\\_netherlands\\_html/Code\\_of\\_Criminal\\_Procedure\\_incorporating\\_amendments\\_up\\_to\\_October\\_2012.pdf](https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/nld/1921/criminal_procedure_code_of_the_netherlands_html/Code_of_Criminal_Procedure_incorporating_amendments_up_to_October_2012.pdf)

<sup>332</sup> Article 14, <https://oia.coi.go.th/th/file/get/file/20190212acd9b5de108f0158aa87de8daf24f01b161433.PDF>

<sup>333</sup> [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf)

<sup>334</sup> [https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt\\_guideline\\_practical\\_version.pdf](https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt_guideline_practical_version.pdf)

<sup>335</sup> Дам эшлэв. [https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/thailands\\_country\\_report\\_01.pdf](https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/thailands_country_report_01.pdf)

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>гадна шүүхийн шийдвэр гарсны дараа иргэний журмаар тусад нь нөхөн төлүүлэх боломжийг олгосон. Мөн түүнчлэн Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн дагуу хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг авч болохоор хуульчилсан. АНУ-ын тухайд дээрх журмуудаар хохирлыг нөхөн төлүүлэх зохицуулалт байна<sup>319</sup>.</p>	<p>зарчмыг баримтлах болсон.<sup>323</sup></p> <p>Цаашлаад иргэний нэхэмжлэгчээр оролцох болсон боловч шүүх хуралдаанд оролцох боломжгүй эсхүл оролцож чадаагүй тохиолдол практикт гардаг тул ийм тохиолдолд прокурор иргэний нэхэмжлэгчийн өмнөөс нөхөн төлбөр шаардаж болох талаар нарийвчлан тусгажээ. Хэдийгээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, холбогдох заавар, журамд дээр зааснаар хохирогчийн нөхөн төлбөр нэхэмжлэх эрхийг баталгаажуулсан байх боловч нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах талаар тусгай журам тогтоогоогүй. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэглэгдэнэ.</p> <p>ЭХХША-ны явцад нөхөн төлбөр гаргуулах дараагийн нэг арга нь нөхөн төлбөрийн албадлагын арга хэмжээ (compensation measure) юм. Энэ нь торгуулийн ял биш боловч, прокурор хүсэлтээр эсхүл шүүгчийн санаачилгаар хохирогчид учирсан нөхөн төлбөрийг гаргуулахад чиглэсэн албадлагын арга хэмжээний төрөл бөгөөд хохирогчид нэмэлт зардал чирэгдэл үүсгэхгүй байх давуу талтай.<sup>324</sup> Нидерланд улсын Эрүүгийн хуулийн 36f зүйлд энэ төрлийн албадлагын арга хэмжээг зохицуулжээ.<sup>325</sup> Өөрөөр хэлбэл, энэ төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэх тохиолдолд хохирогчид учирсан нөхөн төлбөрийг цуглуулах нь хохирогчийн бус төрийн үүрэгт хамаарна. Гэвч шүүхээс нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг (injured party claim)-г хэрэгсэхгүй болгосон</p>	<p>эрх орчноос ялгаатай байна.</p> <p>Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар ийнхүү хохирогчид нөхөн төлбөр олгохоор шийдвэр гарсан тохиолдолд шийдвэрийн биелэлтийг хангуулахад туслах зорилгоор Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдлын яамнаас хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлдэг нь хохирогч бодитоор нөхөн төлбөрөө авахад чухал ач холбогдолтой байна.<sup>336</sup></p> <p>Өмнө дурдсан Хамтарсан баг ('MDT') хохирогч, прокурор зэрэг хэргийн оролцогчдын хамруулж уулзалт зохион байгуулж, прокурорын нэхэмжлэх үнийн дүнг хэлэлцэн тогтоодог. Гэвч хохирогч Эрүүгийн хуульд зааснаар дээрх дүнгээс илүү гарсан нөхөн төлбөрийн хэсгийг нэхэмжлэх эрхтэй бөгөөд ингэх тохиолдолд тухайн нөхөн төлбөрийн хэсэгт хамаарах нотлох, мэтгэлцэх чиг үүргийг хохирогч, түүний өмгөөлөгч хэрэгжүүлэх үүрэгтэй болно. Хэдийгээр хохирогчийн нөхөн төлбөр нэхэмжлэх эрхийн баталгааг хангах зорилгоор дээр дурдсанаар олон төрлийн дэмжлэг үзүүлэх боловч яллагдагчийг цагаатгасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд хохирогчийн нөхөн төлбөр шаардах эрхийг хэрэгжүүлэхэд томоохон хүндрэл учирдаг талаар судлаачид тэмдэглэжээ.</p> <p>Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг</p>

<sup>319</sup> Human Trafficking State Laws, <https://www.ncsl.org/civil-and-criminal-justice/human-trafficking-state-laws>

<sup>323</sup> Marijn Heemskerk, Compensation for victims of human trafficking in the Netherlands, 2013. <https://documentation.lastradainternational.org/lisidocs/3087-Compensation%20for%20Victims%20of%20Human%20Trafficking%20in%20The%20Netherlands.pdf>, p.11

<sup>324</sup> Marijn Heemskerk, Compensation for victims of human trafficking in the Netherlands, 2013.

<https://documentation.lastradainternational.org/lisidocs/3087-Compensation%20for%20Victims%20of%20Human%20Trafficking%20in%20The%20Netherlands.pdf>, p.9

<sup>325</sup> Criminal Code of Netherland, <https://antislaverylaw.ac.uk/wp-content/uploads/2019/08/Netherlands-Criminal-Code.pdf>

<sup>336</sup> Human Rights and Development Foundation, Compensation for Victims of Trafficking in Persons, 2019 [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf)

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
	<p>тохиолдолд энэ төрлийн албадлагын арга хэмжээг авахгүй бөгөөд хохирогч үндэслэлгүй хөрөнгөжих ёсгүй.</p> <p>Албадлагын арга хэмжээг биелүүлээгүй тохиолдолд хорих ялаар солих боломжтой ч энэ нь гэмт хэрэгтний хохирол нөхөн төлөх үүргийг дуусгавар болгохгүй.</p> <p>Нөхөн төлбөр төлөх албадлагын арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэхэд урьдчилан төлөх систем (advance payment system) чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Тухайлбал, нөхөн төлбөр төлөх албадлагын арга хэмжээ авсан шийдвэр хүчин төгөлдөр болсноор хойш гэмт хэрэг үйлдсэн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэл хариуцсан газар (the Central Judicial Collection Agency (CJIB)-т тохирсон хуваарийн дагуу нөхөн төлбөрийг төлөх үүрэгтэй бөгөөд тус газраас нөхөн төлбөрийг хүлээн авмагц хохирогчид шилжүүлэх ажлыг хариуцна. Нөхөн төлбөр төлөх албадлагын арга хэмжээ авсан шийдвэр хүчин төгөлдөр болсноор хойш 8 сарын дотор төлбөр бүрэн төлөгдөж дуусаагүй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэл хариуцсан газар (the Central Judicial Collection Agency (CJIB)-аас үлдэгдэл төлбөрийг хохирогчид шилжүүлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдээс үлдэгдэл төлбөрийг шаардах эрхийг шилжүүлж авч болно.<sup>326</sup> Энэхүү аргыг “advance payment system” буюу урьдчилан төлбөр төлөх тогтолцоо гэж нэрлэх бөгөөд 2011 оны 1 сараас энэ системийг нэвтрүүлсэн нь дэвшилтэт алхам болсон.</p> <p>Нэхэмжлэлийг эрүүгийн болон иргэний</p>	<p>үүсгэх замаар буюу Иргэний хууль тогтоомж дахь гэм хорын зохицуулалтад үндэслэн хохирол нэхэмжлэх боломжтойгоос гадна Хөдөлмөрийн тухай хууль / Labour Protection Act/-д зааснаар олгогдоогүй цалин хөлсөө шаардах боломжтой. Гэвч иргэний хэргийн хүрээнд төрийн туслалцаа төдийлөн байдаггүй тул улсын тэмдэгтийн хураамж төлөх, цаашлаад иргэний шүүхийн шийдвэрийн биелэлтийн хувь эрүүгийн шүүхийн биелэлтээс харьцангуй доогуур байдаг зэрэг олон хүндрэл нэхэмжлэгч хохирогчид учирдаг тул эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд энэ төрлийн нөхөн төлбөрийг хамтад нь шийдвэрлүүлэхийг зөвлөсөн байна.</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу улсын байцаагч эсхүл хөдөлмөрийн шүүхэд хандан олгогдох ёстой цалин хөлсөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, хамгийн ихдээ 1 жилд ногдох цалин хөлсөө нэхэмжлэх боломжтой. Хүн худалдаалах гэмт хэргийн хувьд, холбогдох төрийн байгууллага хохирогчид нөхөн төлбөрийн хэмжээг тооцоход нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг хүлээдэг. Хөдөлмөрийн шүүхээр шийдвэрлэгдэх маргаан нь эрүүгийн хэргээс тусдаа шийдвэрлэгдэх боломжтой юм. Улсын байцаагч гомдол хүлээн авснаар хохирогч, ажил олгогч, бусад этгээдтэй ярилцлага хийх зэргээр шалгах ажиллагааг эхлүүлдэг.</p> <p>Улсын байцаагч үндэслэлтэй гэж үзвэл 30 хүртэлх хоногийн хугацаанд цалин хөлсийг олгох даалгаврыг ажил олгогчид өгнө. Гэвч хүн худалдаалах гэмт хэргийн үед гэмт хэрэг</p>

<sup>326</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.30  
[https://documentation.lastradainternational.org/lisdocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSuc\\_N84AqZCl8l\\_S\\_6DOdC4MEkg4OVofA](https://documentation.lastradainternational.org/lisdocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSuc_N84AqZCl8l_S_6DOdC4MEkg4OVofA)

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
	<p>хэргийн шүүхээр шийдвэрлэх аль ч тохиолдолд гэмт хэрэгтний үйлдэл болон хохирол хоёрын хооронд шалтгаант холбоо байхыг мөн учирсан хохирлыг нотлохыг шаардана.</p> <p><u>Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хохирол нөхөн төлүүлэх</u></p> <p>Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (the Minimal Wage Act), Ажлын цаг (the Working Hours Act), and Хамтын гэрээ (Collective Labour Agreement) зэргийг зөрчсөн гэж үзэх тохиолдолд цалин хөлсөө нэхэмжлэх боломжтой. Харин Гадаадын иргэний хөдөлмөрийн тухай хууль (Foreign Nationals Employment Act)-ын 23 дугаар зүйлд зааснаар гадаадын иргэнийг 6 ба түүнээс дээш сарын хугацаанд хууль бусаар ажиллуулсан гэж үзэх тохиолдолд уг хугацаанд авах байсан цалин хөлсөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нэхэмжлэх боломжтой.<sup>327</sup></p> <p>Хөдөлмөрийн мөлжлөг хийх зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд энэ нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдохоос гадна Хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчсөн захиргааны зөрчлийн шинжийг бүрэн агуулдаг. Тус улсын NLA буюу Үндэсний хөдөлмөрийн байгууллагад харьяалагдах хөдөлмөрийн улсын байцаагч торгууль оногдуулж болох бөгөөд хариуцагч хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд захиргааны журмаар шүүхэд хандах боломжтой.<sup>328</sup> Хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчсөн захиргааны зөрчилд ногдуулсан торгуулийг хохирогчийн эрхийг</p>	<p>үйлдсэн этгээд ихэнх тохиолдолд хохирогчтой нүүр тулан уулзах, аливаа байдлаар нөлөөлөх зорилгоор улсын байцаагчийн шийдвэрт гомдол гаргаж, шүүхэд хандан эвлэрүүлэн зуучлах боломж эрэлхийлдэг талаар тэмдэглэжээ.<sup>337</sup></p>

<sup>327</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.31

[https://documentation.lastradainternational.org/lisdocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSUC\\_N84AqZCIBI\\_S\\_6DOdC4MEKq4OVofA](https://documentation.lastradainternational.org/lisdocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSUC_N84AqZCIBI_S_6DOdC4MEKq4OVofA)

<sup>328</sup> The Netherlands Labour Authority, Fining procedure, <https://www.nl-labourauthority.nl/topics/fining-procedure>

<sup>337</sup> Human Rights and Development Foundation, Compensation for Victims of Trafficking in Persons, 2019 [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf), p.25.

<b>АНУ</b>	<b>НИДЕРЛАНД</b>	<b>ТАЙЛАНД</b>
	хамгаалах, түүнд учирсан хохирлыг нөхөн төлөхөд зарцуулахыг зарим судлаачид зөвлөжээ.	

### Судлах зүйл. 3. Нөхөн олговор олгох талаар тусгай хууль, журамтай эсэх

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах талаар олон төрлийн хууль, эрх зүйн актууд АНУ-ын хэмжээнд үйлчилдэг. Тэдгээрээс 2003 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль (TVPA) нь гол эх сурвалж юм.</p> <p>Гэвч холбооны улсын хувьд нөхөн төлбөр олгох харилцааг нарийвчлан зохицуулсан нийтлэг хэм хэмжээ байхгүй байна.</p> <p>АНУ-ын хувьд хүн худалдаалах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах, бууруулахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх талаар тусгайлсан олон төрлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг нь хохирогчийн эрхийг хамгаалдаг сайн жишиг болж байна.</p>	<p>Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох талаар бие даасан хууль байхгүй.</p> <p>2013 оны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх заавар (the Human Trafficking Guidelines (2013)-т <sup>338</sup> хохирогч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний нэхэмжлэгчээр оролцох боломжтой бөгөөд хэрвээ хохирогч нөхөн төлбөр шаардах хүсэлтэй байгаа талаар илэрхийлсэн тохиолдолд прокурорын газраас хохирогчид ийнхүү нөхөн төлбөрөө амжилттай авахад шаардагдах туслалцааг боломжит хэлбэрээр үзүүлнэ гэж тусгажээ. Цаашлаад иргэний нэхэмжлэгчээр оролцох болсон боловч шүүх хуралдаанд оролцох боломжгүй эсхүл оролцож чадаагүй тохиолдол практикт гардаг тул ийм тохиолдолд прокурор иргэний нэхэмжлэгчийн өмнөөс нөхөн төлбөр шаардаж болох талаар нарийвчлан тусгажээ.</p> <p>Хэдийгээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, холбогдох заавар, журамд дээр зааснаар хохирогчийн нөхөн төлбөр нэхэмжлэх эрхийг баталгаажуулсан байх боловч нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах талаар тусгай журам тогтоогоогүй. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэглэгдэнэ.</p>	<p>Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох талаар бие даасан хууль байхгүй.</p> <p>Гэвч 2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хуульд хохирогч нөхөн төлбөр нэхэмжлэх хүсэлтэй тохиолдолд төрийн байгууллага, мөрдөн байцаагч, прокурор, бусад албан тушаалтан ямар үүрэг хүлээх талаар зааснаас гадна 33 дугаар зүйлд зааснаар нөхөн төлбөр авах процессын талаарх нарийвчилсан журам, зааврыг Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдал хариуцсан сайд батлахаар заасан. 2013 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах заавар (Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking) <sup>339</sup> -т нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах шат дараалал, бүрдүүлэх материалыг заасан боловч нөхөн төлбөр үнэлэх тооцох талаар зохицуулалт байхгүй.</p> <p>Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдал хариуцсан яам болон Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны агентлаг (JICA) нарын хамтарсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалахад Хамтарсан баг (MDT)-ийг чадавхжуулах” төслийн хүрээнд “Хамтарсан багийн үйл ажиллагааны заавар (MDT Operational Guideline)” <sup>340</sup> -ын эхний хэвлэлийг 2011 онд боловсруулж, түүнийг үйл</p>

<sup>338</sup> The Human Trafficking Guidelines, <https://wetten.overheid.nl/BWBR0045831/2021-12-01>

<sup>339</sup> 2013 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах заавар, [https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pg00001vw2db-att/mdt\\_guideline\\_practical\\_version.pdf](https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pg00001vw2db-att/mdt_guideline_practical_version.pdf)

<sup>340</sup> Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
		<p>ажиллагаандаа баримталж эхэлжээ.<sup>341</sup> Тус зааварт Хамтарсан багийн бүхий л үйл ажиллагаанд баримтлах хууль тогтоомжид заасан шаардлагыг ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлаар тусгаж өгсөн. Мөн тус зааварт хохирогч нөхөн төлбөр нэхэмжлэх процессын талаар дэлгэрэнгүй тусгасан байна. Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах шат дараалал, бүрдүүлэх баримт бичиг зэргийг 2 дугаар хэсэгт өгүүлнэ.</p>

<sup>341</sup> 2013 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах заавар, [https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt\\_guideline\\_practical\\_version.pdf](https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt_guideline_practical_version.pdf)

**Судлах зүйл. 4. Цагдаа, прокурор, шүүгч бусад этгээд хохирогчид нөхөн төлбөр олгох талаар мэдээлэл өгөхийг үүрэгжүүлсэн зохицуулалттай эсэх**

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>АНУ-ын код журам (US.Code)-ийн 7105 дугаар зүйлийн b хэсгийн 2 дахь хэсэгт хохирогчийн мэдээлэл авах эрхийг “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид өөрсдийн эрх, орчуулгын үйлчилгээний талаарх мэдээлэл авах боломжтой. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид боломжийн хэрээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг, холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй эсвэл хүн худалдаалахтай тэмцэх хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг авах боломжийг олгох ёстой.”<sup>342</sup> гэж хуульчлан баталгаажуулж өгсөн байна.</p>	<p>Тус улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 51a дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу цагдаа, мөрдөгч, хэрэг бүртгэгч, прокурор зэрэг албан хаагч нь хохирогчийн хүсэлтээр нөхөн төлбөрийн нэхэмжлэл хэрхэн гаргах талаар мэдээлэл өгөх үүрэг хүлээдэг. Мөн хуулийн 51h зүйлийн дагуу мөрдөн байцаалтын шатанд хохирогч болон яллагдагч нарт нөхөн төлбөрийн талаар эвлэрэх боломжтой талаар мөн, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар мэдээлэл өгдөг.</p>	<p>2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хууль<sup>343</sup>-ийн 34 дүгээр зүйлд зааснаар мөрдөн байцаагч, прокурор нь хохирогчид нөхөн төлбөр нэхэмжлэх боломжтой талаар мэдээлэл өгөх, хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх үүрэг хүлээнэ.</p> <p>Цаашлаад Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдлын яамны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч туслалцаа үзүүлэх дүрэмд (Order on Assistance to Victims of Trafficking) -т зааснаар хамгаалах байрны ажилтан нь хохирогчийн эрх, тэр дундаа нөхөн төлбөр авах эрхийн талаар мэдээлэл өгөх үүрэг мөн хүлээдэг.</p>

<sup>342</sup> 22 U.S. Code § 7105 - Protection and assistance for victims of trafficking, <https://www.law.cornell.edu/uscode/text/22/7105>

<sup>343</sup> The Prevention and Suppression of Human Trafficking Act BE 2551 (2008).



**Судлах зүйл. 5. Нөхөн төлбөр буюу хохирлын хэлбэр: эдийн ба эдийн бус (ёс суртахууны хохирол), хохирлын хэр хэмжээ, олгох хязгаар**

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>Эдийн ба эдийн бус хохирлыг тооцож олгоно. Эдийн хохиролд алдагдал, олон ёстой байсан орлого хамаарна. Хуульд заасан тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд эдийн бус хохирлыг шаардах боломжтой.<sup>344</sup> Өмнө өгүүлснээр хохирогчид олгох нөхөн төлбөрийн талаар тусгай журам байхгүйгээс гадна Тусгай зохицуулалт байхгүй. Насанд хүрээгүй бол эцэг, эх нь энэ төрлийн нэхэмжлэл гаргах эрхтэй.</p> <p>Эдийн хохирлыг нотлогдох хэмжээгээр олгох боломжтой. Эдийн хохиролд хохирогчоос гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй орох байсан орлогыг хохиролд тооцно. Иймд хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн тохиолдолд авах ёстой байсан цалин хөлс үүнд хамаарах бөгөөд цалин хөлсний доод хэмжээгээр нэхэмжилнэ. Харин Гадаадын иргэний хөдөлмөрийн тухай хууль (Foreign Nationals Employment Act)-ын 23 дугаар зүйлд зааснаар гадаадын иргэнийг 6 ба түүнээс дээш сарын хугацаанд хууль бусаар ажиллуулсан гэж үзэх тохиолдолд уг хугацаанд авах байсан цалин хөлсөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нэхэмжлэх боломжтой.<sup>345</sup> Эдийн бус хохирлыг тооцох нарийвчилсан аргачлал байхгүй.</p>	<p>Эдийн ба эдийн бус хохирлыг тооцож олгоно. Эдийн хохиролд алдагдал, олон ёстой байсан орлого хамаарна. Хуульд заасан тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд эдийн бус хохирлыг шаардах боломжтой.<sup>351</sup></p> <p>Цаашлаад эдийн ба эдийн бус хохиролд нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн бөгөөд шүүхийн шийдвэрт заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан хүү (statutory interest)-г шаардаж боломж бий.<sup>352</sup> Иргэний хуулийн 6:119 дүгээр зүйлд хугацаа хэтрүүлсний хохирол нэхэмжлэх урьдач нөхцөлийг мөнгөн хөрөнгийн үүргийн гүйцэтгэлийг хугацаа хэтрүүлснээс үүсэх хохирол нь</p> <p>үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй хугацаа дахь төлөгдөөгүй хэсэгт харгалзах</p> <p>хуульд заасан хүүгээс бүрдэнэ гэж заасан. Уг заалтын дагуу төлөгдөх ёстой байсан боловч хугацаа хэтрүүлсэн аливаа төлбөрийг хүүгийн хамт шаардах боломжтой.</p>	<p>Эдийн ба эдийн бус хохирлыг тооцож нэхэмжилж болно. Үүнд оршуулгын зардал, эмчилгээний зардал, олох ёстой байсан цалин хөлс, орлого, нэр хүндэд учирсан хохирол зэрэг хамаарна.<sup>353</sup></p> <p>Тус улсын сангаас 2017 онд 5.6 сая Тайланд бат, 2018 онд 6.4 сая Тайланд бат олгосон байна.</p> <p>2022 онд тус сангаас 1657 хохирогчид, 142 мянга гаруй ам.доллартой тэнцэхүйц санхүүгийн туслалцаа үзүүлсэн байна.</p>

<sup>344</sup> Civil Code of Dutch, <http://www.dutchcivillaw.com/legislation/dcctitle6611bb.htm>

<sup>345</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.31  
[https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZKLn8o5ru9C-xQNLswSSSuc\\_N84AqZC8l\\_S\\_6DOdC4MEkq4OVofA](https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZKLn8o5ru9C-xQNLswSSSuc_N84AqZC8l_S_6DOdC4MEkq4OVofA)

<sup>351</sup> Civil Code of Dutch, <http://www.dutchcivillaw.com/legislation/dcctitle6611bb.htm>

<sup>352</sup> Civil Code of Dutch, <http://www.dutchcivillaw.com/legislation/dcctitle6611bb.htm>

<sup>353</sup> Civil and Commercial Code of Mongolia, <https://library.siam-legal.com/thai-law/civil-and-commercial-code-torts-section-438-448/>

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>Гэмт хэрэгтнээс шаардах нөхөн төлбөрийн хэмжээнд хязгаарлалт байхгүй. Шүүх нотлох баримтыг үндэслэн нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг хэсэгчлэн эсхүл бүрэн хангах эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхтэй. ЭХХША-ны явцад хохирлын хэр хэмжээг тогтоолгохоор шинжээч томилох боломжтой.<sup>346</sup></p> <p>Эдийн ба эдийн бус хохирлоос гадна, Гаагийн шүүхээс хохирогчийн биеийг нь албадан үнэлүүлсэн тохиолдолд өдөрт 200 евро төлөхөөр тооцох жишиг тогтоосон.<sup>347</sup></p> <p>Эдийн ба эдийн бус хохиролд нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн бөгөөд шүүхийн шийдвэрт заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан хүү (statutory interest)-г шаардаж боломж бий.<sup>348</sup> Иргэний хуулийн 6:119 дүгээр зүйлд хугацаа хэтрүүлсний хохирол нэхэмжлэх урьдач нөхцөлийг мөнгөн хөрөнгийн үүргийн гүйцэтгэлийг хугацаа хэтрүүлснээс үүсэх хохирол нь үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй хугацаа дахь төлөгдөөгүй хэсэгт харгалзах хуульд заасан хүүгээс бүрдэнэ гэж заасан. Уг заалтын дагуу төлөгдөх ёстой байсан боловч хугацаа хэтрүүлсэн аливаа төлбөрийг хүүгийн хамт шаардах боломжтой.</p> <p>Хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хохирогч Хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу авах ёстой байсан цалин хөлсөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож нэхэмжилнэ.</p> <p>Улсын сангаас нөхөн олговор олгоход 6 шатлал бүхий жишиг тарифыг үндэслэдэг</p>		

<sup>346</sup>Article 51i, Code of Criminal Procedure,

[https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/nld/1921/criminal\\_procedure\\_code\\_of\\_the\\_netherlands\\_html/Code\\_of\\_Criminal\\_Procedure\\_incorporating\\_amendments\\_up\\_to\\_October\\_2012.pdf](https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/nld/1921/criminal_procedure_code_of_the_netherlands_html/Code_of_Criminal_Procedure_incorporating_amendments_up_to_October_2012.pdf)

<sup>347</sup> GRETA, Reply from the Netherlands to the Questionnaire for the evaluation of the implementation of the Council of Europe Convention on Action against Trafficking in Human Beings by the Parties, Third evaluation round, 2022. <https://rm.coe.int/reply-from-the-netherlands-to-the-questionnaire-for-the-evaluation-of-1680a6615d>, p.12

<sup>348</sup> Civil Code of Dutch, <http://www.dutchcivillaw.com/legislation/dcctitle6611bb.htm>

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>бөгөөд нөхөн олговор нь хохирогчийн бие физиологийн болон сэтгэцийн эрүүл мэндэд учирсан хохирол <sup>349</sup>, түүний улмаас үүссэн зардал, эмчилгээний зардал, олох ёстой байсан орлого зэргийг хамарна.<sup>350</sup> Сангаас олгох нөхөн олговрыг тооцох аргачлалын талаар төрийн тусгай сангийн талаарх хэсэгт нарийвчлан өгүүлнэ.</p>		

<sup>349</sup> List of injuries, [www.schadefonds.nl](http://www.schadefonds.nl).

<sup>350</sup> Application for Crime Victim Compensation, <https://www.schadefonds.nl/wp-content/uploads/2020/02/AANVRG-victim-ENG-19-v01-01-2020.pdf>

## Судлах зүйл. 6. Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, үнэлэх

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p><i>Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, үнэлэх тухайд</i></p> <p>Шийтгэлийн нөхөн төлбөр (punitive damage) 18 U.S.C. § 1595</p> <p>Шийтгэлийн нөхөн төлбөрийг шүүхийн жишгээр тогтоож байна.</p> <p>Дитуллио э. В.Боем хэргийн тухайд 2008 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуульд шийтгэлийн нөхөн төлбөр шаардах үндэслэлийг тавьсан. Энэ хэрэгт есдүгээр тойргийн шүүхээс тус зохицуулалтыг ашигласан. Шүүгдэгчийг эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 2005 онд хүчирхийлэл үйлдэхийг завдсан хэрэгт буруутгаж, 135 сарын хорих ялаар шийтгэсэн. Шийтгэлийн нөхөн төлбөрийн хэмжээг хохирол нөхөн төлүүлсэн хэмжээтэй тэнцүү байхаар тогтоосон. Гэсэн хэдий ч зарим шүүх үүнээс хамаагүй илүү дүнгээр шийдвэр гаргасан. Рое э. Ховардын хэргийн хувьд тангарагтнууд “Хэрэв нэхэмжлэгч нь хариуцагчийн үйлдэл зүгээр ч нэг үндэслэлгүй бус хорлонтой, болгоомжгүй байсныг нотлох баримтаар нотолсон тул” шийтгэлийн нөхөн төлбөр олгохыг даалгасан. Тангарагтны шүүгчид нөхөн төлбөрийг хоёр дахин нэмэгдүүлэн нийт 3,000,000 долларыг шийтгэлийн нөхөн төлбөрт олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>Хөдөлмөрийн шударга стандартын тухай хуулийн дагуу тооцох хохирол (FLSA)</p> <p>Шүүхүүд 18-аас доош насны хохирогчтой</p>	<p>Гэмт хэрэгтнээс шаардах нөхөн төлбөрийн хэмжээнд хязгаарлалт байхгүй. Шүүх нотлох баримтыг үндэслэн нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг хэсэгчлэн эсхүл бүрэн хангах эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхтэй. ЭХХША-ны явцад хохирлын хэр хэмжээг тогтоолгохоор шинжээч томилох боломжтой.<sup>367</sup></p> <p>Хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хохирогч Хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу авах ёстой байсан цалин хөлсөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож нэхэмжилнэ.</p>	<p>Гэмт хэрэгтнээс шаардах нөхөн төлбөрийн хэмжээнд хязгаарлалт байхгүй. Шүүх нотлох баримтыг үндэслэн нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг хэсэгчлэн эсхүл бүрэн хангах эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхтэй.</p> <p>Хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хохирогч Хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу авах ёстой байсан цалин хөлсөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож нэхэмжилнэ.</p>

<sup>367</sup>Article 51i, [https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/nld/1921/criminal\\_procedure\\_code\\_of\\_the\\_netherlands\\_html/Code\\_of\\_Criminal\\_Procedure\\_incorporating\\_amendments\\_up\\_to\\_October\\_2012.pdf](https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/nld/1921/criminal_procedure_code_of_the_netherlands_html/Code_of_Criminal_Procedure_incorporating_amendments_up_to_October_2012.pdf)

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>албадан хөдөлмөр, албадан боолчлолын хэргүүдийн хохирлыг тооцохдоо Хөдөлмөрийн шударга стандартын хуулийг тогтмол ашигладаг. §1595. Уг хуулийн дагуу 1 цагийн хөдөлмөрийн хөлс 7.95 ам доллар байх бөгөөд илүү цагаар ажилласан цагийг тооцохдоо 1-1.5 дахин нэмэгдүүлнэ.<sup>354</sup> Гэвч нэхэмжлэгч, хариуцагчийн хооронд хөдөлмөрийн харилцаа үүссэн тохиолдолд л дээрх хууль үйлчилнэ.</p> <p>Сэтгэл санааны хохирол</p> <p>Сэтгэл санааны хохирлыг тооцоход өдрөөр тооцох (per diem method) арга болон нэмэгдүүлэх арга (multiplier method) зэрэг 2 үндсэн аргыг ашиглах нь бий. Эхний арга нь тодорхой дүнгээр сэтгэл санааны шаналалд автсан өдөр бүрээр тооцдог. Тухайлбал, Калифорни мужид хуульч нар хохирогчийн өдөрт олгох сэтгэл санааны хохирлын хэмжээг 100-200 ам доллароор үнэлдэг байна.<sup>355</sup> Хоёр дахь аргын хувьд эдийн хохирлыг 1.5-5 дахин нэмэгдүүлж олгох арга юм.<sup>356</sup></p> <p>Шүүхүүд сэтгэл санааны хохирлыг тооцохын тулд сэтгэл санааны зовуурийн үргэлжлэх хугацаа, хэр хэмжээ болон "ижил төрлийн хэргийн нөхөн төлбөрийн дүн"-г харгалзан үздэг. Муж улсуудын хувьд нийгмийн харилцаанд хэвийн оролцож чадахгүй болсон өдрийн тоогоор 171-800 долларын хооронд нөхөн төлбөр тооцож олгох тогтолцоо байна. Зарим шүүхүүд нэг удаагийн төлбөрийг олгуулахаар шийдвэрлэх нь бий<sup>357</sup>.</p>		

<sup>354</sup> Wages and the Fair Labor Standards Act, [https://www.dol.gov/agencies/whd/flsa#:~:text=The%20Fair%20Labor%20Standards%20Act%20\(FLSA\)%20establishes%20minimum%20wage%2C.%2C%20State%2C%20and%20local%20governments](https://www.dol.gov/agencies/whd/flsa#:~:text=The%20Fair%20Labor%20Standards%20Act%20(FLSA)%20establishes%20minimum%20wage%2C.%2C%20State%2C%20and%20local%20governments)

<sup>355</sup> The Ryan Law Group, How To Calculate Pain And Suffering In California, <https://theyanlawgroup.com/how-to-calculate-pain-and-suffering-in-california/>

<sup>356</sup> Perenich, Caulfield, Avril & Noyes Personal Injury Lawyers, The Two Calculation Methods for Pain and Suffering Damages, <https://usalaw.com/personal-injury-resources/how-are-pain-and-suffering-damages-calculated/>

<sup>357</sup> Alexandra F. Levy, Federal Human Trafficking Civil Litigation: 15 Years of the Private Right of Action, The Human Trafficking Legal Center (December 2018), <https://www.htlegalcenter.org/wp-content/uploads/Federal-Human-Trafficking-Civil-Litigation-1.pdf>

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>Жишээлбэл, Иллинойс мужийн Дээд шүүх 1997 оны Best and Taylor Machine Works-ийн хэрэгт эдийн бус хохирлыг 500,000 ам.доллараар тогтоосон байна.</p> <p>Гэмт хэргийн хохирогчид төрөөс санхүүгийн туслалцаа үзүүлэх сангийн үйл ажиллагаа тус улсад сайн хөгжсөн. Муж улс гэмт хэргийн хохирогч нөхөн олговор олгох сантай байх бөгөөд түүнээс олгох дээд хэмжээ, аргачлал нь харилцан адилгүй. Тухайлбал Калифорни муж 70000 ам доллар хүртэлх нөхөн олговрыг олгодог.<sup>358</sup></p> <p>АНУ-ын муж улс бүр гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох улсын сан, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилладаг. Тухайлбал, Техас мужийн хувьд Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тухай хуулийн дагуу Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөр (Crime Victims' Compensation Program)<sup>359</sup> 1997 оноос хойш хэрэгжсэн бөгөөд тус муж улсад үйлдэгдсэн эсхүл тус муж улсын иргэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон бөгөөд гэмт хэргийн улмаас бие махбод, сэтгэцийн эрүүл мэндэд хохирол учирсан бол гэмт хэрэг үйлдэгдсэнээс 3 жилийн дотор дээр дурдсан муж улсын хөтөлбөрөөс нөхөн олговор авахаар хүсэлт гаргаж болно. Тус хөтөлбөрийн дагуу хэд хэдэн гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор, санхүүгийн туслалцаа үзүүлдэг бөгөөд түүний нэг нь хүн худалдаалах гэмт хэрэг юм. 2023 онд тус сангаас хүн худалдаалах гэмт хэргийн 70 <sup>360</sup> хохирогч нөхөн олговор олгох хүсэлтийг ирүүлснээс 12 хохирогчид нийт 21,269.09 ам.долларын нөхөн олговор</p>		

<sup>358</sup> California Victim Compensation Board, Recovery From Human Trafficking, <https://victims.ca.gov/for-victims/victims-of-human-trafficking/>

<sup>359</sup> Attorney General of Texas, Eligibility for Crime Victims' Compensation Program, <https://www.texasattorneygeneral.gov/crime-victims/crime-victims-compensation-program/eligibility-crime-victims-compensation-program>

<sup>360</sup> Crime Victim Services 2023 Annual Report. <https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/annual-reports/23106-CVS-Annual-Report-2023-4.pdf>

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>олгожээ.<sup>361</sup> Хөтөлбөрийн дагуу дараах нөхөн олговрыг хохирогчид эсхүл түүнийг гэр бүлийн гишүүнд олгоно. Үүнд:<sup>362</sup></p> <p>Оршуулгын зардал. Үүнд оршуулах ажиллагааны зардалд 6500 ам доллар хүртэл, унааны зардалд 6500 ам доллар хүртэл, оршуулгын улмаас ажилдаа явж чадаагүй 10 хүртэлх өдрийн цалин хөлсийг 1400 ам доллар хүртэл.</p> <p>Эмнэлгийн зардлыг учирсан хэмжээгээр.</p> <p>Сэтгэл зүйн зөвлөгөөний зардлыг 60 удаагийн уулзалт хүртэлх төлбөрөөр.</p> <p>Олох ёстой байсан цалин хөлс долоо хоногт 700 ам.доллараар тооцно.</p> <p>Тэжээгчээ алдсаны тэтгэмжийг долоо хоногт 700 ам доллар хүртэл.</p> <p>Асаргааны зардлыг долоо хоногт 100 ам.доллар, нийт 52 долоо хоног хүртэл.</p> <p>Гэмт хэргийн газрыг цэвэрлэх зардлыг 2000 доллар хүртэл.</p> <p>Нотлох баримтаар хураагдсан эд юмсын үнэ 1000 доллар хүртэл.</p> <p>Түрээс, нүүлгэн шилжүүлэлтийн зардал. Гагцхүү бэлгийн хүчирхийлэл эсхүл хууль бусаар мөрдөх гэмт хэргийн тохиолдолд нүүлгэн шилжүүлэлтэд 2000 хүртэл, түрээсийн төлбөрт 3 сарын нийтдээ 1800 доллар хүртэл.</p> <p>Өмгөөлөгчийн хөлс. Үүнд энэхүү сангаас нөхөн төлбөр авахаар хүсэлт гаргах хүсэлт</p>		

<sup>361</sup> Crime Victim Services 2023 Annual Report. <https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/annual-reports/23106-CVS-Annual-Report-2023-4.pdf>

<sup>362</sup> Texas Crime Victims' Compensation Program Quick Reference Chart, 2016. [https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/CVC\\_QuickReferenceGuide.pdf](https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/CVC_QuickReferenceGuide.pdf)

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>боловсруулах үйлчилгээ авсны төлбөрийг 300 ам доллар хүртэл.</p> <p>Тээврийн зардал. Үүнд эмчилгээ хийлгэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох гэх мэт шалтгааны улмаас үүссэн тээврийн зардлыг бодит хэмжээгээр.</p> <p>Хөдөлмөрийн чадвараа алдсаны улмаас шаардлагатай болсон орчны засварын үнэ. Тухайлбал орон гэрт хийсэн шаардлагатай засвар.</p> <p>Хөдөлмөрийн чадвараа алдсаны улмаас шаардлагатай болсон туслах хэрэгслийн үнэ. Тухайлбал тэргэнцрийн үнэ зэргийн үнийг 75000 доллар хүртэл.</p> <p>Хөдөлмөрийн чадвараа алдсаны улмаас үүссэн сургалт, зөвлөгөө, үйлчилгээний зардал (75000 доллар хүртэл)</p> <p>Хөдөлмөрийн чадвараа алдсаны улмаас алдсан олох ёстой байсан цалин хөлс. 7 хоногт 500 доллар, нийт 75000 доллар.</p> <p>Хөдөлмөрийн чадвараа алдсаны улмаас үүссэн байнгын эмчилгээ, үйлчилгээний зардал. Тухайлбал, гэрээр хийх эмчилгээний зардал, сувилагчийн зардлыг 75000 доллар хүртэл нөхөн олгоно.</p> <p>Нөхөн олговрын хүсэлтийг <sup>363</sup> Улсын ерөнхий прокурорын газрын Гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх хэлтэс хүлээн авна. Хүсэлт гаргаж буй зардал бүрд бүрдүүлэх материалыг нарийн тодорхой заасан байдаг.<sup>364</sup> Нөхөн олговор олгохоос татгалзсан шийдвэрт</p>		

<sup>363</sup> Texas Crime Victims' Compensation Program Application, <https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/Printed%20CVC%20Application.pdf>

<sup>364</sup> Texas Crime Victims' Compensation Program Quick Reference Chart, 2016. [https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/CVC\\_QuickReferenceGuide.pdf](https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/CVC_QuickReferenceGuide.pdf)



АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
гомдол гаргах боломжтой. <sup>365</sup> Тус хөтөлбөрийн хүрээнд сэтгэцийн өвчин, шаналалд нөхөн олговор олгохгүй гэж заасан байна. <sup>366</sup>		

<sup>365</sup> Appeals Process of the Crime Victims' Compensation Program (CVC).  
[www.texasattorneygeneral.gov/crime-victims/crime-victims-compensation-program/appeals-process](http://www.texasattorneygeneral.gov/crime-victims/crime-victims-compensation-program/appeals-process)

<sup>366</sup> Texas Crime Victims' Compensation Program Application,  
<https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/crime-victims/Printed%20CVC%20Application.pdf>

## Судлах зүйл. 7. Насанд хүрээгүй хохирогчид тусгайлсан эрх зүйн зохицуулалттай эсэх

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>2018 онд АНУ-д хүн худалдаалах гэмт хэргийн талаас илүү хувь нь (51.6%) нь зөвхөн хүүхдүүдтэй холбоотой бэлгийн мөлжлөгийн хүн худалдаалах хэргүүд байжээ<sup>368</sup>. АНУ-ын код болон 2008 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуульд насанд хүрээгүй хохирогчидтой гэмт хэргийг хянах, хохирогчид дэмжлэг үзүүлэх хэд хэдэн заалтууд байдаг. Гэхдээ нөхөн төлбөр өгөх, хохирол барагдуулах тал дээр тухайлсан хууль байдаггүй.</p> <p>2022 оны санхүүгийн жилд Хууль зүйн яамнаас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх тусламжийн хөтөлбөрийг АНУ даяар зохион байгуулж хүүхдийн албадан хөдөлмөр эрхлэлтийн хохирогчдыг дэмжих үйлчилгээнд 1.3 сая долларын, хүүхдийн бэлгийн гэмт хэргийн хохирогчийн асуудлыг шийдвэрлэхэд 6.3 сая долларын, хохирогч хүүхдүүдэд үзүүлэх үр дүнг сайжруулахад бараг 5.5 сая долларын<sup>369</sup> дэмжлэгийг үзүүлсэн байна.</p> <p>Мөн өмгөөлөгчид хүүхдийн хөдөлмөр эрхэлдэг төрийн байгууллагуудаас хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн хохирогчдыг илүү сайн илрүүлж, дэмжихийг шаардахын тулд холбооны хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахын зэрэгцээ бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсвэл өртөх эрсдэл өндөр байгаа хүүхдүүдэд анхаарлаа хандуулахыг уриалж</p>	<p>Тусгай зохицуулалт байхгүй. Насанд хүрээгүй бол эцэг, эх нь энэ төрлийн нэхэмжлэл гаргах эрхтэй.</p>	<p>Тусгай зохицуулалт байхгүй. Насанд хүрээгүй бол эцэг, эх нь энэ төрлийн нэхэмжлэл гаргах эрхтэй.</p>

<sup>368</sup> U.S. Is a Top Destination for Child Sex Trafficking, and It's Happening in Your Community, <https://www.heritage.org/crime-and-justice/commentary/us-top-destination-child-sex-trafficking-and-its-happening-your>

<sup>369</sup> Improving Outcomes for Child and Youth Victims of Human Trafficking program, [https://ovc.ojp.gov/funding/opportunities/o-ovc-2022-171313?utm\\_medium=email&utm\\_source=govdelivery](https://ovc.ojp.gov/funding/opportunities/o-ovc-2022-171313?utm_medium=email&utm_source=govdelivery)

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
байна. <sup>370</sup>		

---

<sup>370</sup> 2023 Trafficking in Persons Report: United States, <https://www.state.gov/reports/2023-trafficking-in-persons-report/united-states>

## Судлах зүйл. 8. Гэмт хэрэгтний эд хөрөнгийг хураах эрх зүйн зохицуулалт

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>Эд хөрөнгө хураах нь үндсэндээ иргэний<sup>371</sup> болон эрүүгийн журмаар<sup>372</sup> гэсэн хоёр хэлбэртэй байдаг. Иргэний журмаар эд хөрөнгийг хураах нь ялаас шалтгаалахгүй бөгөөд ихэнхдээ эрүүгийн хэрэг үүсгээгүй тохиолдолд ч биелүүлж болно. Нотлох баримтын стандарт нь доогуур байдаг. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотойгоор иргэний журмаар эд хөрөнгийг хураахыг тусгайлан заасан АНУ-ын 12 муж улс байдаг. Иргэний журмаар эд хөрөнгийг хураах тусгай журам нь муж бүрд харилцан адилгүй. Иргэний журмаар эд хөрөнгийг хураахын тулд прокуророос тогтоол гаргах, өмчлөгчид мэдэгдэх, хариуцагч хариу өгөх, шийдвэрийг сонсох шаардлагатай.</p> <p>Харин эрүүгийн журмаар эд хөрөнгө хураах нь зөвхөн ял шийтгэл хүлээсний дараа л авах боломжтой бөгөөд түүнийг ял оногдуулах болон эд хөрөнгө хураах асуудлыг тус бүрд нь шүүх хуралдааны үеэр нэхэмжилдэг ба хураах эд хөрөнгө нь эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсэг байсныг нотлох шаардлагатай. Прокурорууд гэмт хэрэгтний эд хөрөнгийг эрүүгийн журмаар хураан авах замаар олж авах боломжтой. Эрүүгийн журмаар эд хөрөнгийг хураах нь эрүүгийн гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө шүүхээр шийтгүүлсэн хүнд оногдуулах ялын нэг хэсэг юм.</p> <p>Шүүхийн шийдвэр гарсны дараа хураан</p>	<p>Тус улсын Эрүүгийн хуульд зааснаар хохирогчид учруулсан гэм хорыг арилгах, нөхөн төлөх зорилгоор гэмт хэрэгтний гэмт хэргийн улмаас олсон орлогыг хураах албадлагын арга хэмжээ авах боломжтой. Гэсэн хэдий ч энэхүү ажиллагаа нь гэмт хэрэгт гэм буруутай эсэхийг шийдвэрлэх шүүх ажиллагаатай зэрэгцэн хийгдэх ёстой гэж үздэг. Өөрөөр хэлбэл гэмт хэрэгтний гэмт хэргийн улмаас олсон ашиг, орлогыг тодорхойлох, гаргуулах, хураахтай холбогдуулан санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлдэг.</p> <p>Гэмт хэрэгтэн эд хөрөнгөө бусад этгээд рүү шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор мөрдөн байцаалтын явагдаж байх үед эд хөрөнгийг хураах, битүүмжлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжтой. Ийнхүү санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэрэгтний эд хөрөнгийн хураан авах нь хохирогчийн нөхөн төлбөр авах эрхийн баталгааг хангаад зогсохгүй тус ажиллагааны явцад үйлдэгдсэн эсхүл цуглуулсан бичиг баримт, эд хөрөнгө хураан авах ажиллагааны тайлан зэрэг нь хохирогчид учирсан хохирлыг нотлоход чухал ач холбогдолтой байдаг.</p> <p>2012 оны Эд хөрөнгийг хураах заавар (the Guidelines on Forfeiture)-т зааснаар хохирогч нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах хүсэлтэй байх тохиолдолд цагдаагийн байгууллагаас хохирогчтой зөвлөлдөж, хохирогчийн</p>	<p>Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 14.9 дэх хэсэгт зааснаар хүн худалдаалах гэмт хэргээр дамжуулж мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй нөхцөлд Мөнгө угаахтай тэмцэх газар (AMLO) нь хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, сэжигтэн яллагдагчийн хөрөнгийг хураах бүрэн эрхтэй байхаар зохицуулжээ. Тухайлбал, 2021 онд Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх газраас хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой 12 хэргийн хүрээнд эд хөрөнгийг хураах арга хэмжээг авчээ.<sup>376</sup> Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хөрөнгийг хураах нь хохирогчийн нөхөн төлбөр авах эрхийн баталгааг хангахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.</p> <p>Эрүүгийн хуулийн 32, 33 дугаар зүйлд зааснаар шүүх хөрөнгө хураан авах албадлагын арга хэмжээг авах эрхтэй.<sup>377</sup></p>

<sup>371</sup> 18 U.S. Code § 983 - General rules for civil forfeiture proceedings, <https://www.law.cornell.edu/uscode/text/18/983>

<sup>372</sup> 18 U.S. Code —Crimes and criminal procedure, [https://www.law.cornell.edu/rules/frcrmp/rule\\_32.2](https://www.law.cornell.edu/rules/frcrmp/rule_32.2)

<sup>376</sup> Royal Thai Government's Country Report on Anti-Human Trafficking Efforts, 2021. <https://aseanactpartnershiphub.com/wp-content/uploads/2022/02/Thailands-Country-Report-on-Anti-Human-Trafficking-Efforts-2021.pdf>

<sup>377</sup> Seehanat Prayoonrat, An Overview of Asset Forfeiture System in Thailand, [https://www.unodc.org/roseap/uploads/archive/documents/2009/02/TOCAML0/Overview\\_of\\_Asset\\_Forfeiture\\_System\\_in\\_Thailand\\_3.pdf](https://www.unodc.org/roseap/uploads/archive/documents/2009/02/TOCAML0/Overview_of_Asset_Forfeiture_System_in_Thailand_3.pdf)

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>авах шийдвэр гаргахад эдгээр хөрөнгийг хаана хуваарилахыг хуулиар зааж өгдөг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэгэн адил эд хөрөнгө, борлуулалтаас олсон орлого нь хохирогчид нөхөн төлөх, улсын бүртгэлтэй хохирогчийн санд эсхүл мөрдөн байцаалт, яллах ажиллагаанд оролцдог төрийн байгууллагын үйл ажиллагаанд зарцуулагдаж болно.<sup>373</sup></p> <p>Эрүүгийн эд хөрөнгийг хураах нь тухайн нөхцөл байдал, харьяаллын хууль тогтоомжоос хамааран ял оногдуулах эсвэл хураах тухай тусдаа шүүх хурлын үеэр тогтоогддог. Эрүүгийн эд хөрөнгийг хураах хууль тогтоомжийн гол зорилго нь шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэнийх нь төлөө шийтгэх явдал юм. Эд хөрөнгийн хэмжээ нь шүүгдэгчийн гэм буруутайд тооцогдсон тодорхой гэмт хэрэгтэй холбоотой байх ёстой. Шүүхийн шийдвэр гарсны дараа хураан авах шийдвэр гаргахад эдгээр хөрөнгийг хаана хуваарилахыг хуулиар зааж өгдөг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэгэн адил эд хөрөнгө, борлуулалтаас олсон орлого нь хохирогчид нөхөн төлөх, улсын бүртгэлтэй хохирогчийн санд эсвэл мөрдөн байцаалт, яллах ажиллагаанд оролцдог төрийн байгууллагуудад зарцуулагдаж болно<sup>374</sup>.</p> <p>АНУ-ын дараах 16 муж нь хүн худалдаалах гэмт хэргийн улмаас эд хөрөнгийг хураах талаар тусгайлсан хуультай. Эдгээр нь Алабама, Калифорни, Коннектикут, Колумбийн дүүрэг, Хавай, Иллинойс, Мэрилэнд,</p>	<p>нэхэмжлэлийн дүн гэмт хэрэг олсон орлогоос их байх тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хөрөнгийг хураах шаардлага байгаа эсэх талаар дүгнэлт гаргана.</p>	

<sup>373</sup> Hitting Them Where It Hurts: Strategies for Seizing Assets in Human Trafficking Cases By Charlene Whitman, JD, <https://aequitasresource.org/wp-content/uploads/2018/09/Hitting-Them-Where-it-Hurts-Strategies-for-Seizing-Assets-in-Human-Trafficking-Cases.pdf>

<sup>374</sup> Hitting Them Where It Hurts: Strategies for Seizing Assets in Human Trafficking Cases By Charlene Whitman, JD, <https://aequitasresource.org/wp-content/uploads/2018/09/Hitting-Them-Where-it-Hurts-Strategies-for-Seizing-Assets-in-Human-Trafficking-Cases.pdf>

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>Массачусетс, Миссисипи, Нью Хэмпшир, Хойд Каролина, Пенсильвани, Род Айленд, Өмнөд Каролина, Гуам, Холбоо болно. Харин дараах 20 мужид хүн худалдаалах гэмт хэргийн улмаас эд хөрөнгийг хураах талаар ерөнхий зохицуулалт үйлчилдэг байна. Үүнд: Флорида, Жеоржиа, Индиана, Айова, Канзас, Луизиана, Мэн, Мичиган, Миннесота, Миссури, Невада, Нью Жерси, Нью Йорк, Охайо, Орегон, Теннесси, Техас, Юта, Вашингтон, Америкийн Самоа зэрэг юм.<sup>375</sup></p>		

<sup>375</sup> AEQuitas, Restitution and Asset Forfeiture: A Focus on Human Trafficking Current as of April 2014, <https://aequitasresource.org/wp-content/uploads/2018/09/Restitution-and-Asset-Forfeiture-A-Focus-on-Human-Trafficking.pdf>

**Судлах зүйл. 9. Хохирогчид нөхөн олговор олгох тусгай сан (засгийн газрын гм)**

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>Төрөөс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид санхүүгийн туслалцаа үзүүлэхдээ Засгийн газрын болон бусад яамнаас хэрэгжүүлдэг хөтөлбөрийн дагуу санхүүжилт олгодог.</p> <p>Тус улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид санхүүгийн туслалцаа үзүүлэхэд олон төрлийн хөтөлбөр, сан зэрэгцэн ажилладгаас Засгийн газрын гэмт хэргийн хохирогчийн сан болон Хууль зүйн яамны хохирогчийн хамгаалах албаны санг онцолж байна.</p> <p>Засгийн газрын Гэмт хэргийн хохирогчийн сан<sup>378</sup></p> <p>АНУ-ын Холбооны хэмжээнд 1984 батлагдсан Гэмт хэргийн хохирогчийн тухай хууль (Victims of Crime Act (VOCA) нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд уг хуульд 1988, 1993-1997, 1999-2002 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Уг хуулиар гэмт хэргийн хохирогчийн сан байгуулах, санг бүрдүүлэх, санхүүжүүлэх, хуваарилах, гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох зардал, нөхөн төлбөр олгох эрх зүйн үндэслэл, олгох журам, уг ажлыг зохион байгуулах зэрэг асуудлыг хуульчилсан байна. Энэхүү хуульд зааснаар Холбооны хэмжээнд АНУ-ын Хууль зүйн яамны Гэмт хэргийн хохирогчийн алба нь тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх, сангийн мөнгөн хөрөнгийг хуваарилах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг</p>	<p>Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн сан (Criminal Injuries Compensation Fund) гэх улсын тусгай сан байх бөгөөд энэхүү сангаас олон улсын гэрээ, конвенцод нөхөн төлбөр олгохоор тусгасан хэд хэдэн хүнд гэмт хэрэг (үүнд хүчиндэх, бэлгийн мөлжлөг зэрэг гэмт хэрэг хамаарна) -ийн хохирогч нөхөн төлбөр авах боломжтой.</p> <p>Сангаас нөхөн олговор олгох нийтлэг үндэслэл нь гэмт хэрэг Нидерланд улсад үйлдэгдсэн байх шаардлагатай. Сангаас олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээ нь эдийн хохиролд 20000, эдийн бус хохиролд 15000, нийтдээ 35000 евро байдаг байна. Хохирогчид учруулсан хохирлын хэр хэмжээгээр нь үндсэн 6 дэд хязгаарт багтаан нөхөн төлбөр олгодог. Тухайлбал, хүч хэрэглэхээр заналхийлж эсхүл хүч хэрэглэн удаан хугацааны туршид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон бол 2 дугаар зэрэгт хамаарч, 2500 евро олгох бол хүчиндэх болон бэлгийн мөлжлөгийг хамтад нь үйлдсэн тохиолдолд 10000 евротой тэнцэх нөхөн төлбөр олгодог гэжээ. Бусад төрлийн мөлжлөгийг гагцхүү хүч хэрэглэн үйлдсэн байх тохиолдолд сангаас нөхөн төлбөр олгохоор зохицуулсан байна. Сангаас нөхөн төлбөр олгох үндсэн шаардлага нь хохирогч бусад эх үүсвэрээс нөхөн төлбөр аваагүй байх явдал юм. Гэсэн хэдий ч эрүүгийн хэрэг шийдвэрлэх явцад нөхөн төлбөрийн нэхэмжлэл (injured party claim) гаргасан нь сангаас нөхөн төлбөр авахаар хүсэлт гаргах эрхийг үгүйсгэхгүй. Хохирогч гэмт</p>	<p>Тус улсад хэд хэдэн төрлийн хохирогчид нөхөн олговор олгох тусгай сан бий. Үүнд:</p> <p><b>2008 оны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хуульд заасан Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг сан (Anti-TIP Fund)</b></p> <p>Дурдсан хуулийн 42 дугаар зүйлийн дагуу үүсгэн байгуулагдсан Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг сангийн хөрөнгө нь Тайланд улс дахь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд зарцуулагдана. Тухайлбал, шүгэл үлээгч, мэдээлэгч зэрэгт олгох мөнгөн шагнал зэргийг тус сангаас олгодог.</p> <p>Харин хохирогчийн эрхийг хамгаалах зорилгоор дараах төрлийн зардлыг тус сангаас төлнө. Үүнд:<sup>389</sup></p> <p>Амьжиргааны зардал - Нэг хүнд нэг удаа 3000 Тайланд бат, нэг жилд нэг хүнд 3-аас илүүгүй олгож болно.</p> <p>Эмнэлгийн зардал – Эмчилгээний бодит зардалд 30,000 Тайланд батаас ихгүй. Үүнд эмчилгээний үеийн унаа, хоол багтсан. Эм тарианд жилд 3-аас илүүгүй, нэг удаа 2,000 Тайланд батаас ихгүй. Эмнэлгийн зардал заасан хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд эмнэлгийн дүгнэлтийн дагуу шаардлагатай тохиолдолд нэмэлт олговор олгож болно</p> <p>Бие физиологи болон сэтгэцийн эрүүл мэндийг нөхөн сэргээх эмчилгээний зардал - 20,000 Тайланд батаас ихгүй.</p>

<sup>378</sup> Human Trafficking Grants & Funding, <https://ovc.ojp.gov/program/human-trafficking/grants-funding#grants-funding>

<sup>389</sup> Human Rights and Development Foundation, Compensation for Victims of Trafficking in Persons, 2019 [https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF\\_Final-victim-compensation.pdf](https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf).

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>хариуцан ажилладаг ажээ.</p> <p>1984 оны Гэмт хэргийн хохирогчийн тухай хуулиар (VOCA) Гэмт хэргийн хохирогчдын сан<sup>379</sup> (Сан) байгуулагдсан. Сан нь татварын мөнгөөр бус, холбооны хэргүүдийн торгох ял, шийтгэлээс санхүүждэг.<sup>380</sup> Конгресс жил бүрийн санхүүжилтийн дээд хязгаарыг тогтоодог.</p> <p>Тус сангаас санхүүжүүлдэг хөтөлбөр, үйл ажиллагаанаас дурдвал:<sup>381</sup></p> <p><i>Бүх төрлийн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх цогц үйлчилгээний хөтөлбөр:</i></p> <p>Энэхүү хөтөлбөр нь хүн худалдаалах гэмт хэргийн бүх хэлбэрийн хохирогчдод үзүүлэх туслах үйлчилгээний чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилготой юм.</p> <p><i>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагааг сайжруулах хөтөлбөр:</i></p> <p>Хууль сахиулах байгууллага болон хохирогчийн үйлчилгээний аль аль нь бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг олж тогтоох, тэднийг цогц үйлчилгээнд хамруулах зорилготой ба хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон талт ажлын хэсгийг хөгжүүлэх, сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор санхүүжилт хүсдэг.</p>	<p>хэрэгтнээс нөхөн төлбөр авсан тохиолдолд санд буцаан төлөх нөхцөлөөр сангаас нөхөн төлбөрөө гаргуулан авч болдог байна. Сангаас нөхөн төлбөр авах хүсэлтийг 180 хоногт шийдвэрлэдэг нь нөхөн төлбөр авахаар шүүхэд хандахаас илүү хурдан хугацаанд нөхөн төлбөр авах боломжийг олгодог.<sup>385</sup></p> <p>Сангаас нөхөн төлбөр авахаар хүсэлт гаргасан хохирогчдын 90 орчим хувь нь нөхөн төлбөр авч чаддаг талаар тэмдэглэжээ.<sup>386</sup> Тус сангаас гэмт хэргийн улмаас учирсан хохиролд олгох нөхөн олговрыг хамгийн бага хэмжээгээр олгож байгааг анхаарч үзэх нь зүйтэй бөгөөд үүнээс дээд хэмжээний хохирол учирсан гэж үзсэн эрүү, иргэний шүүхэд хандах боломжтой юм. Учир нь төрийн тусгай сангаас олгох нөхөн төлбөр нь татвар төлөгчдийн төлсөн татвараас төлөгдөх тул хохирлыг бүрэн барагдуулахад чиглээгүй, гагцхүү хохирогчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, нийгмийн амьдралд эргэн хэвийн оролцох, ирээдүйн итгэл өгөхөд чиглэгдсэн.</p> <p>Сангийн тухай хуульд зааснаар гэмт хэрэг үйлдэгдсэнээс 10 жилийн дотор Сангаас нөхөн олговор авахаар хүсэлт гаргах боломжтой.<sup>387</sup> Шүүхийн шийдвэр гарахаас өмнө хохирогч улсын санд хүсэлт гаргах замаар нөхөн олговор авч болно. Сангаас нөхөн олговор олгосны дараа шүүхийн шийдвэрээр шүүгдэгчээс нөхөн төлбөр гаргуулахаар шийдвэрлэсэн бол хохирогч энэ талаар Санд даруй мэдэгдэнэ.</p>	<p>Олох ёстой байсан орлого – Өдрийн 300 Тайланд батаас илүүгүйгээр тооцож нэг жил хүртэлх хугацаанд ногдох. Өргөн хэрэглээ - 3000 батаас хэтрэхгүй үнээр, жилд гурваас илүүгүй удаа. Байрны зардал – Шаардлагатай хэмжээгээр. Боловсрол, сургалтын төлбөр. Нөхөн олговор шаардах, шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, шүүх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зардал. Эх оронд нь буцаах зардал. Хууль тогтоомжид олгохоор заасан бусад зардал.</p> <p><b>2001 оны Хохирогчид нөхөн олговор олгох, яллагдагчаар буцаан нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу нөхөн олговор олгох (Compensation under the 2001 Victim Compensation and Restitution for the Accused Person Act)</b></p> <p>Энэхүү санг гэмт хэргийн улмаас учирсан хохиролд нөхөн олговор олгох үндсэн сан гэж нэрлэж болно. 2022 онд тус сангаас 48,717 ам.долларын нөхөн төлбөр олгожээ.</p> <p>Тус сангаас эмчилгээний зардал, олох ёстой байсан орлого болон нас барсны нөхөн олговор олгоно.</p> <p><b>Дээрх сангаас гадна Хууль ёсны сангийн</b></p>

<sup>379</sup> 18 U.S. Code § 3525 - Victims Compensation Fund, <https://www.law.cornell.edu/uscode/text/18/3525>

<sup>380</sup> Мөн тэнд.

<sup>381</sup> Office for Victims of Crime, Current Funding Opportunities, <https://ovc.ojp.gov/funding/current-funding-opportunities>

<sup>385</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.32

[https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSUC\\_N84AqZCI8I\\_S\\_6DOdC4MEKq4OVofA](https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSUC_N84AqZCI8I_S_6DOdC4MEKq4OVofA)

<sup>386</sup> GRETA (2018) Report Concerning the Implementation of the Council of Europe Convention on Action against Trafficking in Human Beings by the Netherlands, pp. 35-36.

<sup>387</sup> The Violent Crime Compensation Fund, <https://www.schadefonds.nl/schadefonds/>.



АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p><i>Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг насанд хүрээгүй хүүхэд, гэр бүлийн шүүхийн хариу арга хэмжээг сайжруулах:</i></p> <p>Энэхүү хөтөлбөрийн зорилго нь бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн зорилготой хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод өсвөр насны хүүхэд, гэр бүлийн шүүхийн тогтолцооноос үзүүлэх үйлчилгээг сайжруулахад оршино.</p> <p><i>Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслах инновац хөтөлбөр:</i></p> <p>Энэхүү хөтөлбөр нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод зориулсан хөтөлбөр, үйлчилгээний хийдлийг арилгахын тулд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх болон хохирогчийн үйлчилгээний салбараас бий болсон шинэлэг санаануудыг судалж, хэрэгжүүлэхэд чиглэдэг.</p> <p><i>Бэлгийн мөлжлөгийн зорилготой хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчдын чиглэлээр боловсруулсан стратеги:</i></p> <p>Энэхүү хөтөлбөрийн зорилго нь бэлгийн мөлжлөгийн зорилготой хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчдыг гэмт хэрэгт хохирох явдлыг таслан зогсоох, хохирогч төвтэй, мэдээлэл, нотолгоонд суурилсан хариу арга хэмжээг дэмжих зорилгоор хохирогч үйлчилгээний хөтөлбөрийг хөгжүүлэх, өргөжүүлэх, бэхжүүлэхэд оршино.</p> <p><i>Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод олгох орон сууцны тусламж:</i></p> <p>Хөтөлбөр нь хүн худалдаалах гэмт хэргийн</p>	<p>Хохирогч үндэслэлгүй хөрөнгөжих боломжгүй тул илүү нөхөн олговор сангаас авсан бол зөрүүг эргүүлэн өгнө.</p> <p>Нөхөн төлбөр олгох шийдвэрийг Сангийн Зөвлөл шийдвэрлэх бол хүсэлт хүлээн авах, төлбөрийг шилжүүлэх чиг үүргийг Сангийн Агентлаг хариуцдаг.<sup>388</sup></p>	<p><b>тухай хуулийн дагуу олгох нөхөн олговор</b>(Compensation under the 2015 Justice Fund Act), <b>Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх сан</b> (The Anti-Money Laundering Fund established under the 1999 Anti-Money Laundering), <b>Гэрчийг хамгаалах тухай хуульд заасан дэмжлэг</b> (Support under the 2003 Witness Protection Act) зэргийг нэрлэж болно. Хэдийгээр дээр дурдсан төрийн сан, тусламжаас зохих нөхөн олговор, туслалцааг авах боломжтой боловч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид төдийлөн хүсэлт гаргадаггүй байна.</p>

<sup>388</sup> The Violent Crime Compensation Fund, <https://www.schadefonds.nl/schadefonds/>.

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>бүх хэлбэрийн хохирогчдод шилжилтийн үеийн орон сууц, богино хугацааны орон сууцны тусламжийг үзүүлэхэд чиглэнэ.</p> <p><i>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх сургалт, техникийн туслалцааны хөтөлбөр:</i></p> <p>Энэхүү хөтөлбөр нь хүн худалдаалах гэмт хэргийн талаар сургалт, туслалцаа, үйлчилгээ үзүүлэх, туслах хэрэгсэл, нөөцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх салбарыг дэмжихэд чиглэсэн.</p> <p><i>Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхэд, залуучуудад үзүүлэх үр дүнг сайжруулах хөтөлбөр</i></p> <p><i>Гэмт хэргийн хохирогчдод хандах эрх зүйн боломжийг нэмэгдүүлэх хөтөлбөр</i></p> <p><i>Хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчдод зориулсан нэгдсэн үйлчилгээ</i></p> <p><i>Охидыг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх</i></p> <p><i>Бэлгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон Америкийн хотын индианчууд болон Аляскийн уугуул иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх хөтөлбөр:</i></p> <p><i>Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ хөтөлбөр зэрэг.</i></p> <p>Цаашлаад төрийн захиргааны төв байгууллага бүр хүн худалдаалах гэмт хэргийн тодорхой чиглэлийг хариуцаж ажиллах бөгөөд үүнд холбогдох үйл ажиллагааг санхүүжүүлэх зарчмаар ажиллана.<sup>382</sup> Тухайлбал, <b>Хууль зүйн яамны Хохирогчийг хамгаалах сан</b><sup>383</sup> -гийн</p>		

<sup>382</sup> Current Federal Funding Opportunities, <https://www.state.gov/humantrafficking-federal-funding/>

<sup>383</sup> U.S. Department of Justice, Current Funding Opportunities,

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p><b>талаар авч үзвэл:</b></p> <p>Хууль зүйн яам (DOJ) нь АНУ-ын хэмжээнд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод зориулсан хөтөлбөрүүдийг хөгжүүлэх, өргөжүүлэх, бэхжүүлэх зорилгоор буцалтгүй тусламжийн санхүүжилт олгодог. Уг хөтөлбөрүүд нь хохирогчийг хамгаалах цогц, мэргэшсэн үйлчилгээ, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хэсэг, сургалт, техникийн туслалцаа, судалгаа шинжилгээг санхүүжүүлдэг. Дараах бүтцээр дамжуулан тендер, хөтөлбөр зарлаж санхүүжүүлнэ.</p> <p>Гэмт хэргийн хохирогчдод зориулсан алба (OVC)</p> <p>Хууль зүйн туслалцааны товчоо (BJA)</p> <p>Насанд хүрээгүй хүмүүсийн хууль эрх зүйн болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алба (OJJDP)</p> <p>Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх алба (OVW)</p> <p>Хууль зүйн үндэсний хүрээлэн (NIJ)</p> <p>Үүнээс гадна АНУ-ын дараах яамдууд нь хүн худалдаалах гэмт хэргийн талаар төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг дангаараа болон хамтран хэрэгжүүлдэг байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- АНУ-ын Эрүүл мэнд, хүний үйлчилгээний яам (HHS)</li> <li>- АНУ-ын Хөдөө аж ахуйн яам (USDA)</li> <li>- АНУ-ын Орон сууц, хот байгуулалтын яам (HUD)</li> </ul>		

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<ul style="list-style-type: none"> <li>- АНУ-ын Хууль зүйн яам (USDOJ)</li> <li>- АНУ-ын Хөдөлмөрийн яам (DOL)</li> <li>- АНУ-ын Нийгмийн Хамгаалалтын Захиргаа (SSA)</li> <li>- АНУ-ын Боловсролын яам (ED)<sup>384</sup></li> </ul> <p>Монгол Улсын хувьд 2012 оны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн дагуу Засгийн газар, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн байгууллага зэрэг нь үүрэг хүлээж байгаа хэдий ч АНУ-тай адил хүн худалдаалах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх тал дээр хөтөлбөр, арга хэмжээ авч хэрэгжүүлэх чиг үүрэг тусгагдаагүй байна.</p>		

<sup>384</sup> Services Available To Victims of Human Trafficking, A Resource Guide for Social Service Providers, <https://www.acf.hhs.gov/sites/default/files/documents/otip/traffickingservices.pdf>

## Судлах зүйл. 10. Эрх зүйн зохицуулалтын сайн туршлагаас

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>АНУ-ын тухайд хүн худалдаалах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх зохицуулалтын тухайд дараах сайн туршлага бүхий зохицуулалттай байна.</p> <p>АНУ-ын кодын 1584 дүгээр зүйлд Албадан боолчлох зорилгоор худалдах гэмт хэргийг, 1589 дүгээр зүйлд Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийг, 1590 дүгээр зүйлд Насанд хүрсэн хүнийг худалдаалах, боолчлох, албадан эрхшээлдээ байлгах, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг, 1591 дүгээр зүйлд Хүүхдийг бэлгийн зорилгоор эсвэл хүчээр, залилан мэхэлж, албадлага хэрэглэж худалдах гэмт хэргийг тус тусад нь зохицуулж нарийвчилж авч үзсэн.</p> <p>Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль (TVPA), Хохирогчийн эрхийн хамгаалалттай холбоотой тус тусдаа хуулиудыг боловсруулан батлуулсан ба эдгээр нь холбогдох харилцааг зохицуулж хохирогчийн хохирлоо барагдуулах, нөхөн төлбөр авах эрхийг хангаж байна.</p> <p>Муж улс бүр улсын сангаас олгох нөхөн олговрын төрөл, тэдгээрийн тооцох аргачлалыг тогтоосон байна.</p> <p>Холбооны улсаас нэг бус хэд хэдэн эх үүсвэрээр дамжуулан, тухайлбал Засгийн газар, Хууль зүйн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам зэрэг, хүн худалдаалах гэмт</p>	<p>Нидерланд улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нөхөн төлбөр авах эрхийг баталгаатай эдлүүлэхээр дараах хэд хэдэн арга хэрэгслийг ашиглаж буй нь бусад улсаас онцлогтой, дэвшилттэй байна. Үүнд:</p> <p>“Advance payment system” буюу урьдчилан төлбөр төлөх тогтолцоо - Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор хойш гэмт хэрэг үйлдсэн этгээд шүүхийн шийдвэрээр хохирогчид төлөх болсон нөхөн төлбөрийг тохирсон хугацаанд өгөөгүй бөгөөд 8 сар энэхүү төлбөрийн зөрчил нь үргэлжилсэн бол тус улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэл хариуцсан газар (the Central Judicial Collection Agency (CJIB)-т аас үлдэгдэл төлбөрийг хохирогчид олгодог.<sup>390</sup></p> <p>2013 оны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх заавар (the Human Trafficking Guidelines (2013)-т<sup>391</sup> хохирогч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний нэхэмжлэгчээр оролцох хүсэлтэй байгаа талаар илэрхийлсэн тохиолдолд прокурорын газраас хохирогчид ийнхүү нөхөн төлбөрөө амжилттай авахад шаардагдах туслалцааг боломжит хэлбэрээр үзүүлэх үүрэгтэй гэж, хохирогч шүүх хуралдаанд оролцох боломжгүй эсхүл оролцож чадаагүй тохиолдолд прокурор иргэний нэхэмжлэгчийн өмнөөс нөхөн төлбөр шаардаж болох талаар нарийвчлан тусгажээ.</p>	<p>Тайланд улсын бусад улсаас онцлогтой бөгөөд эрх зүйн сайн туршлагыг дурдвал:</p> <p>Тайландын хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хууль тогтоомж нь 2008 оны Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хууль болон 2016 оны Хүн худалдаалах гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэх ажиллагаанд баримтлах бие даасан хуультай байгаа нь онцлог байна.</p> <p>Гэмт хэрэгтэн гэмт хэрэг үйлдэхдээ хохирогчийг эрүүдэн шүүсэн, хорьсон, эрүүл мэндэд нь хохирол учруулсан, хүнлэг бус хандсан тохиолдолд punitive damage<sup>392</sup> буюу шийтгэх нөхөн төлбөр шаардаж болно.</p> <p>Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар ийнхүү хохирогчид нөхөн төлбөр олгохоор шийдвэр гарсан тохиолдолд шийдвэрийн биелэлтийг хангуулахад туслах зорилгоор Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдлын яамнаас шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн явцад хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлдэг нь хохирогч бодитоор нөхөн төлбөрөө авахад чухал ач холбогдолтой байна. Шүүх, цагдаагийн байгууллага, прокурорын албан хаагчдаас гадна Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдлын яамны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч туслалцаа</p>

<sup>390</sup> Jeltsje Cusveller, Compensation for victims of human trafficking: Inconsistencies, impediments and improvements, 2015, p.30  
[https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSUC\\_N84AqZCI8I\\_S\\_6DOdC4MEKq4OVofA](https://documentation.lastradainternational.org/lisidocs/3226-Compensation%20for%20victims%20of%20human%20trafficking%20-%20Cusveller.pdf?fbclid=IwAR1P8oZkLn8o5ru9C-xQNLswSSSUC_N84AqZCI8I_S_6DOdC4MEKq4OVofA)

<sup>391</sup> 2013 оны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх заавар, <https://wetten.overheid.nl/BWBR0045831/2021-12-01>

<sup>392</sup> Section 14 of the TIP Criminal Procedure Act.

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>хэрэгтэй тэмцэх, хохирогчийн эрхийг хамгаалахад чиглэсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг байна. Харин муж улс бүрээс төсвөөс гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох боломжтой бөгөөд харилцан ялгаатай байна.</p>	<p>Цаашлаад эдийн ба эдийн бус хохиролд нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн бөгөөд шүүхийн шийдвэрт заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Иргэний хуулийн 6:199 дүгээр зүйлд заасан хуульд заасан хүү (statutory interest)-г шаардаж боломжтой.</p> <p>Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх зэргээр хохирогчийн хүсэл зоригийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн бол тус улсын Хууль зүйн туслалцаа үзүүлэх төвөөс хохирогчийн санхүүгийн байдлыг үл харгалзан үнэ төлбөргүй хууль зүйн бүхий л төрлийн үйлчилгээ үзүүлнэ.</p>	<p>үзүүлэх дүрэмд (Order on Assistance to Victims of Trafficking) -г зааснаар хамгаалах байрны ажилтан нь хохирогчийн эрх, тэр дундаа нөхөн төлбөр авах эрхийн талаар мэдээлэл өгөх үүрэг мөн хүлээдэг.</p> <p>Мөнгө угаахтай тэмцэх газар (AMLO) нь хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, сэжигтэн яллагдагчийн хөрөнгийг хураах бүрэн эрхтэй байхаар зохицуулсан нь шүүхийн шийдвэр гараагүй байх үед гэмт хэрэг үйлдсэн хөрөнгийг хураах, царцаах ажиллагааг шуурхай хэрэгжүүлэх үндэс болж байна.</p> <p>Тус улсад хэд хэдэн төрлийн хохирогчид нөхөн олговор олгох тусгай сан бий. Тухайлбал Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг сангаас санхүүгийн туслалцаа авах боломжтойгоос гадна 2001 оны Хохирогчид нөхөн олговор олгох, яллагдагчаар буцаан нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу нөхөн олговор улсаас авах боломжтой байна.</p> <p>Прокурор иргэний нэхэмжлэлийг хохирогчийн өмнөөс гаргах үүрэгтэй бөгөөд Хамтарсан баг ('MDT') хохирогч, прокурор зэрэг хэргийн оролцогчдын хамруулж уулзалт зохион байгуулж, прокурорын нэхэмжлэх үнийн дүнг хэлэлцэн тогтоодог.</p>

### Судлах зүйл. 11. Бусад

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
	<p>Хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллах хуульчдыг мэргэшүүлэхэд Хууль зүй дотоод хэргийн яам, Хохирогчийн эрхийг хамгаалах төв (“Slachtofferhulp Nederland”), Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах хуульчдын сүлжээ (Landelijk Advocaten Netwerk Zeden Slachtoffers or “LANZS”), Гэм хорын эрх зүйн хуульчдын холбоо (Vereniging van Letselschade Advocaten or “LSA “), Хууль зүйн туслалцааны зөвлөл (Raad voor rechtsbijstand), Нидерландын Хуульчдын холбоо (Nederlandse Orde van Advocaten or “NOvA”) нар хамтран ажилладаг.</p>	

## Судлах зүйл. 12. Дүгнэлт

АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
<p>АНУ-ын код журамд хүн худалдаалах гэмт хэргийн зорилго, хэлбэр бүрээр нь тусгайлан гэмт хэрэгт тооцсон. Тухайлбал, 1584 дүгээр зүйлд Албадан боолчлох зорилгоор худалдах гэмт хэргийг, 1589 дүгээр зүйлд Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийг, 1590 дүгээр зүйлд Насанд хүрсэн хүнийг худалдаалах, боолчлох, албадан эрхшээлдээ байлгах, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг, 1591 дүгээр зүйлд Хүүхдийг бэлгийн зорилгоор эсвэл хүчээр, залилан мэхэлж, албадлага хэрэглэж худалдах гэмт хэргийг тус тусад нь зохицуулсан байна. Ийнхүү тус тусад нь хуульчилснаас улбаалан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх цогц ажиллагаа нь олон чиглэлээр бүрдэж байна.</p> <p>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бие даасан хууль байхаас гадна Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах бие даасан хуультай.</p> <p>АНУ-д гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг өргөн хүрээнд авч үзэж байх ба цаашлаад үйлдлийн хэр хэмжээ, ноцтой байдлыг үндэслэж шийтгэлийн нөхөн төлбөр (punitive damage)-ийг гаргуулахаар шийдвэрлэх нь бий.</p> <p>Холбооны улсаас нэг бус хэд хэдэн эх үүсвэрээр дамжуулан, тухайлбал Засгийн газар, Хууль зүйн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам зэрэг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчийн эрхийг хамгаалахад чиглэсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг. Өөрөөр хэлбэл, холбооны</p>	<p>Нидерланд улс нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч өөрт учирсан хохирлыг эрүү, иргэнийн шүүхээр болон хөдөлмөрийн хуулийн дагуу шийдвэрлүүлэх боломжтойгоос гадны улсын сангаас нөхөн олговор авах бүрэн боломжтой байна. Ихэнх тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний нэхэмжлэлийг хамтад нь шийдвэрлэж байх бөгөөд энэ нь хохирогчид үүсэх санхүү, цаг хугацааны дарамтыг бууруулахад чиглэсэн.</p> <p>Улсын сангаас олгох нөхөн олговрыг тооцох, үнэлэх аргачлал тодорхой бөгөөд эрүүгийн хэргийг эцэслэн шийдвэрлэхээс өмнө тус сангаас нөхөн олговор боломжтой байгаа нь хохирогчийн эрхийг хамгаалахад чухал ач холбогдолтой байна. Харин эрүү, иргэний шүүхээр хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэхдээ эдийн болон эдийн бус хохирлыг олгохоор шийдвэрлэдэг боловч эдийн бус хохиролд шүүхээс нөхөн төлбөр гаргуулахаар шийдвэрлэхдээ хэмжээг хэрхэн тооцож буй нь тодорхойгүй бөгөөд харилцан адилгүй байна.</p> <p>Шүүхийн шатанд прокурорын үүрэг оролцоо ихээхэн байх бөгөөд цагдаагийн албан хаагч, прокурор нь хохирогчид нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах боломжтой талаар мэдээлэл үүргийг хүлээдэг нь энэ төрлийн нэхэмжлэл гаргах эрхээ хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлж байна.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд гэмт хэрэгтэн шүүхийн шийдвэрээр олгохоор үүрэг хүлээсэн нөхөн төлбөрийг олгоогүй тохиолдолд</p>	<p>Тайланд улсын хувьд хэдийгээр хүн худалдаалах гэмт хэргийн гаралт өндөртэй боловч түүнтэй тэмцэх тогтолцоог харьцангуй сайн бүрдүүлжээ. Тухайлбал хохирогч эрүү, иргэн, хөдөлмөрийн шүүхээр дамжуулж хохирлоо нэхэмжлэх боломжтой бөгөөд хохирогчийн өмнөөс ЭХХША-ны явцад нэхэмжлэл гаргах үүргийг прокурорт хүлээлгэсэн онцлог талтай байна.</p> <p>Хохирогчид нөхөн төлбөр амжилттай нэхэмжлэх гол үндэслэл нь нотолгоо гэж үзэж, хохирогчоор тогтоох, гэмт хэргийн ул мөрийг бэхжүүлэхэд тус улсын холбогдох яам, байгууллагаас анхаарлаа хандуулдаг.</p> <p>Цаашлаад энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох улсын олон эх үүсвэр байх бөгөөд Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг сан гэх бие даасан сан байгаа нь дэвшилттэй байна.</p> <p>Тус улсын хувьд хохирогч эдийн болон эдийн бус хохирлоо нэхэмжлэх боломжтой боловч эдийн бус хохирлыг гаргуулсан тохиолдолд цөөн байгааг анхаарах нь зүйтэй.</p>



АНУ	НИДЕРЛАНД	ТАЙЛАНД
улсаас хохирогчид шууд нөхөн олговор олгохгүй. Харин муж улс бүрд энэ төрлийн сан хөгжжээ.	урьдчилсан байдлаар улсаас үлдэгдэл төлбөрийг өгч байгаа нь хохирогч, ялангуй гадаад улсын харьяалалтай хохирогч удаан хугацаанд санхүүгийн хүндрэл орохоос сэргийлж байна.	